



Страсбург, 2020.04.22

2022CDL-PI(2020)004

ХУУЛИАР АРДЧИЛАЛ ТОГТООХ ЕВРОПЫН КОМИСС
(ВЕНЕЦИЙН КОМИСС)

**ҮНДСЭН ХУУЛИЙН ШҮҮХИЙН ТАЛААРХ
ВЕНЕЦИЙН КОМИССЫН
САНАЛ, ТАЙЛАН, СУДАЛГААНЫ ЭМХЭТГЭЛ
(ШИНЭЧИЛСЭН)**

МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн

2023

Страсбург, 2020.04.22

2022CDL-PI(2020)004

ХУУЛИАР АРДЧИЛАЛ ТОГТООХ ЕВРОПЫН КОМИСС
(ВЕНЕЦИЙН КОМИСС)

**ҮНДСЭН ХУУЛИЙН ШҮҮХИЙН ТАЛААРХ
ВЕНЕЦИЙН КОМИССЫН САНАЛ,
ТАЙЛАН, СУДАЛГААНЫ ЭМХЭТГЭЛ
(ШИНЭЧИЛСЭН)**

МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн
2023 он

Хуулиар ардчилал тогтоох Европын комисс (Венецийн комисс)

ҮНДСЭН ХУУЛИЙН ШҮҮХИЙН ТАЛААРХ ВЕНЕЦИЙН КОМИССЫН
САНАЛ, ТАЙЛАН, СУДАЛГААНЫ ЭМХЭТГЭЛ
(ШИНЭЧИЛСЭН)

МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн Венецийн комиссоос өгсөн зөвшөөрлийн дагуу энэ тайланг монгол хэл рүү орчуулж эрхлэн гаргав.

Санхүүжүүлсэн: Нээлттэй нийгэм форум ТББ

Орчуулсан: МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний гэрээт ажилтан, хууль зүйн магистр С.БАТ-ОРШИХ (Бүлэг 1-6, 8-9)

Монгол Улсын Дээд шүүхийн судлаач-туслах, хууль зүйн магистр А.БОДЬБИЛЭГ (Бүлэг 7)

Хянасан: МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнгийн захирал, Хууль зүйн сургуулийн профессор, хууль зүйн доктор О.МӨНХСАЙХАН

МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний гэрээт ажилтан, хууль зүйн магистр, хуульч Н.ЭНХЦЭЦЭГ

Техникийн баг:

МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний гэрээт ажилтан, хууль зүйн магистр С.БАТ-ОРШИХ

МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнгийн дадлагажигч, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн оюутан Т.ЭМҮЖИН

Анхны хэвлэл

Монгол орчуулгын эрх © 2023 МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэн

Бүх эрх хуулиар хамгаалагдсан болно. Энэхүү бүтээлийг МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнгийн зөвшөөрөлгүйгээр бүтнээр нь буюу хэсэгчлэн цахим, цаасан, аудио болон бусад хэлбэрээр хэвлэх, хувилах, тараах болон бусад ямар нэг хэлбэрээр олшруулах, түгээхийг хориглоно.

ГАРЧИГ

1	Оршил	9
2	Үндсэн хуулийн шүүхийн төрөл	11
3	Эх сурвалж	16
4	Шүүхийн бүрэлдэхүүн	19
	4.1 Тэнцвэртэй бүрэлдэхүүн	19
	4.1.1 Үндэстний цөөнхийг шударгаар төлөөлөх	22
	4.1.2 Шүүгчид тавигдах шаардлага	22
	4.1.3 Нас	27
	4.2 Хавсарч үл болох ажил, албан тушаал	29
	4.3 Томилох / Сонгох арга зам	31
	4.3.1 Сонгуулын дийлэнх олонхын саналаар сонгох	38
	4.3.2 Процедур	43
	4.4 Бүрэн эрхийн хугацаа	45
	4.4.1 Шүүгчийн бүрэн эрхийн хугацаа	45
	4.4.2 Шүүгчийг дахин сонгох, томилох	46
	4.4.3 Гишүүнчлэл тасралтгүй байх	47
	4.5 Бүрэн эрхийг дуусгавар болгох / түдгэлзүүлэх	52
	4.6 Хариуцлага	55
	4.6.1 Сахилгын хариуцлага	55
	4.6.2 Халдашгүй байдал	57
	4.7 Шүүхийн ерөнхийлөгч (дарга)	61
	4.8 Шүүхийн бие даасан байдал	64
	4.9 Шүүхийн дотоод бүтэц – танхимууд	72
	4.10 Ерөнхий нарийн бичгийн дарга, ажилтан, мэргэжилтэн	75
5	Шүүхэд хандах эрх	76
	5.1 Төрийн байгууллагаас хандах	76
	5.1.1 Парламентын цөөнх	76
	5.1.2 Омбудсмен	77
	5.1.3 Шүүх (урьдчилсан хүсэлт)	80

5.2	Хувь хүний гомдол, мэдээлэл	83
5.2.1	Үндсэн хуулийн иж бүрэн гомдол	84
5.2.2	Үндсэн хуулийн хэм хэмжээний (норматив) гомдол	88
5.2.3	Эрх сэргээх арга хэмжээг шавхах	89
5.2.4	Хууль зүйн үнэ төлбөргүй туслалцаа	90
5.2.5	Гомдол хүлээн авах	91
5.2.6	Үндсэн хуулийн болон Ердийн шүүх хоорондын харилцаа ...	93
5.2.7	Иргэний мэдээлэл (Акцио популарис)	95
5.3	Эрхийг үр дүнтэй сэргээх арга хэмжээ	97
5.3.1	Процедурын үргэлжлэх хугацаа	97
6	Шүүхийн харьяалал	99
6.1	Хууль тогтоомжийн дэд актад тавих хяналт	105
6.2	Хууль тогтоомжийн урьдчилсан хяналт	106
6.3	Олон улсын гэрээний урьдчилсан хяналт	108
6.4	Хуулийн дэд актад тавих хяналт	109
6.5	Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт	110
6.6	Ард нийтийн санал асуулгын асуулт	111
6.7	Хууль тогтоомжийг Үндсэн хуулийн хяналтаас гаргах	112
6.8	Олон улсын шүүхийн шийдвэрийг дотоодод хэрэгжүүлэх	113
6.9	Төрийн байгууллага хоорондын эрх хэмжээний зөрчилдөөн	116
7	Маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа	118
7.1	Ашиг сонирхлын зөрчил- шүүгчийг хэргээс татгалзан гаргах	118
7.2	Хуульчаар заавал төлөөлүүлэх	122
7.3	Талуудын эрх	122
7.4	Хэргийн хуваарилалт	123
7.5	Шүүгчдийн панел (зөвлөл) болон мэргэшсэн туслахууд	125
7.6	Нийт шүүгчдийн хуралдаан болон Танхимууд хоорондын харилцаа	126
7.7	Амаар/ бичгээр хянан шийдвэрлэх ажиллагаа	127
7.8	Тусгай (эсэргүүцэх) санал	130
7.9	Түр түдгэлзүүлэх шийдвэр	135

7.10	Маргааныг нэгтгэх	136
7.11	Гомдлоос татгалзах	137
7.12	Мэтгэлцэх зарчим	138
7.13	Нотлох баримтыг үнэлэх	139
7.14	Агуулгаар дахин сэргээсэн маргаан (Дахин гомдол гаргах)	139
7.15	Шийдвэрийг зарлах	140
7.16	Маргааны дараалал	141
7.17	Маргааныг хойшлуулах	142
7.18	Шийдвэр гаргах ирц болон олонх	143
7.19	Шийдвэрт гарын үсэг зурах	144
8	Шийдвэрийн үр дагавар	146
8.1	Шүүхийн шийдвэрийг нийтлэх	146
8.2	Ex tunc v. ex nunc үр дагавар	149
8.3	Хэргийг дахин сэргээх ердийн шүүхийн үүрэг	157
8.4	Үндсэн хуулийн шүүхийн чиг үүрэг	160
8.5	Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийг биелүүлэх	161
8.6	Үндсэн хуулийн шүүхийн тайлбарыг дагаж мөрдөх үүрэг	167
8.7	Үндсэн хуулийн шүүхээс маргааныг дахин сэргээх	171
9	Үндсэн хуулийн шүүхийн хэвлэл мэдээлэлтэй харилцах харилцаа ...	175
	Хавсралт – Эшилсэн материалууд	176

Венецийн комисс

ӨМНӨТГӨЛ

Монгол Улс 1992 онд ардчилсан Үндсэн хуулиа баталж, Үндсэн хуулийн хяналт буюу Үндсэн хуулийн шүүхийн тогтолцоог анхлан бий болгосон. Улмаар, Монгол Улсын Их Хурал 1992 оны 5 дугаар сарын 8-ны өдөр Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийг, 1997 оны 5 дугаар сарын 1-ний өдөр Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийг тус тус баталсан билээ. Гэвч, эдгээр материаллаг болон процессын хуулиудыг өнөөгийн нийгмийн хөгжил, өөрчлөлтөд нийцүүлж шинэчлэх зайлшгүй шаардлага бий болоод байна.

УИХ-ын 2021 оны 12 дахь тогтоолоор баталсан Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай болон Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулиудын шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж өргөн мэдүүлэхээр тусгасан. УИХ-ын Хууль зүйн байнгын хорооноос 2021 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр эдгээр хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах, УИХ-д өргөн мэдүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсэг дэргэдээ хуулийн төслийг боловсруулахад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх дэд хэсгүүдийг ажиллуулж байна.

Хуулиар ардчилал тогтоох Европын комисс (Венецийн комисс) нь ардчилал, хууль дээдлэх ёсыг төлөвшүүлэх, хүний эрхийг хангах чиглэлээр олон арван удирдамж, гарын авлага, тайлан гаргадаг. Венецийн Комиссоос “Үндсэн хуулийн шүүх”-ийн талаар өмнө нь гүйцэтгэсэн тайлан, судалгаа, мөн гишүүн орнуудын тухайлсан асуудлаар зөвлөсөн саналыг нэгтгэсэн эмхэтгэлээ 2020 онд шинэчлэн хэвлэсэн юм. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай болон Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулиудын шинэчилсэн найруулгын төсөлд Үндсэн хуулийн шүүхийн сайн туршлага, чиг хандлагыг тусгах үүднээс Ажлын хэсгийн ахлагч, УИХ-ын гишүүн Ц.Мөнх-Оргил энэ эмхэтгэлийг орчуулах захиалгыг МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнд өгсөн юм. Үүний дагуу тус хүрээлэн “Үндсэн хуулийн шүүхийн талаарх Венецийн комиссын санал, тайлан, судалгааны эмхэтгэл (шинэчилсэн)”-ийг Венецийн комиссын зөвшөөрлөөр монгол хэлнээ хөрвүүлэн хэвлэж байгаадаа баяртай байна.

Үндсэн хуулийн шүүх бол Үндсэн хуулийг бодит тохиолдолд хэрэглэдэг, түүнийг чандлан сахиулдаг институт буюу үндсэн хуульт ёсны баталгаа мөн. Манай улсын хувьд Үндсэн хуулийн шүүхийг Үндсэн хуулийн цэц гэсэн оноосон нэртэйгээр анх байгуулснаас хойш 30 гаруй жил болж байна. Энэ хугацаанд Үндсэн хуулийн цэцийн зүгээс Монгол Улсын Үндсэн хуулийн

биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрхээ чамлахааргүй амжилттай хэрэгжүүлсээр ирсэн. Гэвч, өнөөдөр Үндсэн хуулийн цэцийн хараат бус, бие даасан, мэргэшсэн байдлыг улам бэхжүүлэх, маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг Үндсэн хуулийн шүүхийн жишгээр процессжуулах тэргүүтэй тулгамдсан асуудал хуулийн болон практикийн шийдлээ хүлээж байна.

Венецийн комиссын энэ эмхэтгэл нь агуулгын хувьд Үндсэн хуулийн шүүхийн төрөл, эх сурвалж, бүрэлдэхүүн болон Үндсэн хуулийн шүүхэд гаргах гомдол, түүний бүрэн эрх, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа, шийдвэрийнх нь үр нөлөө, хэвлэл мэдээлэлтэй харилцах харилцаа зэрэг олон чухал сэдвийг хамарсан. Нөгөө талаас, энэ эмхэтгэлд дурдагдах санал, тайлан, судалгаа нь тодорхой нэг улсын Үндсэн хуулийн шүүхтэй холбогдож үүссэн бодит асуудал, нөхцөл байдлыг үнэлэх замаар боловсруулагдсан. Тиймээс, Үндсэн хуулийн шүүхийн талаарх өргөн цар хүрээтэй тус эмхэтгэл нь Монгол Улсын Үндсэн хуулийн цэцтэй холбогдсон тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, Үндсэн хуулийн цэцийн үйл ажиллагааг улам хараат бус, шударга, үр нөлөөтэй, төвийг сахисан, мэргэшсэн болгон төгөлдөржүүлэх, Үндсэн хуулийн цэцийн тухай хууль тогтоомжийг шинэчлэхэд хувь нэмэр болно гэдэгт итгэлтэй байна.

“Үндсэн хуулийн шүүхийн талаарх Венецийн комиссын санал, тайлан, судалгааны эмхэтгэл (шинэчилсэн)”-ийг орчуулах зөвшөөрөлөгсөн Венецийн комисст, ялангуяа түүний дэд нарийн бичгийн дарга Шнүц Рудолф Дүрр (Schnutz Rudolf DьRR, Deputy Secretary of the Venice Commission)-т талархаж буйгаа илэрхийлье. Түүнчлэн, уг эмхэтгэлийн орчуулгыг санхүүжүүлсэн Нээлттэй нийгэм форум, ялангуяа түүний захирал П.Эрдэнэжаргал болон Засаглалын хөтөлбөрийн менежер Д.Энхцэцэг нарт гүн талархаж байна. Мөн, уул эмхэтгэлийн 1-6, 8-9 дүгээр бүлгийг орчуулсан МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнгийн гэрээт эрдэм шинжилгээний ажилтан, хууль зүйн магистр С.Бат-Орших, 7 дугаар бүлгийг орчуулсан Монгол Улсын Дээд шүүхийн судлаач туслах, хууль зүйн магистр А.Бодьбилэг, орчуулгыг хянасан тус хүрээлэнгийн гэрээт эрдэм шинжилгээний ажилтан, хууль зүйн магистр, хуульч Н.Энхцэцэг, техникийн редактораар ажилласан тус хүрээлэнгийн гэрээт эрдэм шинжилгээний ажилтан, хууль зүйн магистр С.Бат-Орших, тус хүрээлэнгийн дадлагажигч Т.Эмүжин нарт талархал илэрхийлье.

О.МӨНХСАЙХАН

МУИС-ийн Үндсэн хуулийн эрх зүйн хүрээлэнгийн захирал,

Хууль зүйн сургуулийн профессор, хууль зүйн доктор

1 ОРШИЛ

Энэхүү эмхэтгэл нь Үндсэн хуулийн шүүх (constitutional justice)-ийн талаарх Венецийн комиссын онолын байр суурийг тоймлон харуулах зорилгоор тус сэдвийн хүрээнд тус комиссын зүгээс өмнө нь гаргаж байсан санал, тайлан, судалгаануудын товч хэсгүүдийг нэгтгэн цэгцэлсэн бүтээл юм.

Энэхүү эмхэтгэл нь Үндсэн хууль болон Үндсэн хуулийн шүүхийн талаарх хууль санаачлагчид, судлаачид, түүнчлэн дээрх хуулиудын талаар санал, шүүмж гаргах Венецийн комиссын гишүүдийн хувьд лавлагаа эх сурвалж хэлбэрээр ашиглагдах учиртай.

Венецийн комиссын зүгээс хийж гүйцэтгэж, судалж ирсэн асуудлуудыг [уншигчдад] хялбархан хүргэх зорилгоор тус эмхэтгэлийг бүтцийн хувьд сэдэвчилсэн байдлаар хийсэн.

Энэхүү эмхэтгэл нь анх 2006 онд “Үндсэн хуулийн шүүхийн талаарх гарын авлага” (CDL-JU(2006)029) нэртэйгээр хэвлэгдэж байсан. Тус гарын авлага нь Венецийн комиссын шинээр баталсан санал, тайлан, гүйцэтгэсэн судалгаануудын товч хэсгүүдээр тогтмол шинэчлэгдсээр ирсэн.

Энэхүү эмхэтгэлд дурдагдах Венецийн комиссоос өгсөн аливаа санал (*opinion*) бүр тухайлсан нэг улстай холбоотой. Тиймээс Комиссын зүгээс гаргасан холбогдох зөвлөмжийг тухайн улсын Үндсэн хуулийн нөхцөл байдалтай нь уялдуулан авч үзэх хэрэгтэй.

Энэхүү эмхэтгэлд дурдагдах Венецийн комиссоос гаргасан тайлан (*report*) болон судалгаа (*study*) бүр Венецийн комиссын бүх гишүүн хийгээд ажиглагч улсуудад үйлчлэх ерөнхий стандартыг бий болгоход чиглэгдсэн. Тиймээс тус комиссын тайлан, судалгаанд дурдагдсан зөвлөмжүүд нь илүү ерөнхийлсөн шинжтэй байх болно. Гэхдээ эдгээр зөвлөмжүүд нь тухайлсан Үндсэн хуулийн хяналтын тогтолцоонуудад төвлөрсөн байж болох бөгөөд зарим зөвлөмж нь зөвхөн тэдгээр тогтолцоонд хамаарна гэдгийг тэмдэглэн хэлэх нь зүйтэй.

Энэхүү эмхэтгэлд дурдагдах бүх санал, тайлан, судалгаануудын товч эшлэлүүдийг Венецийн комиссын гаргасан илүү дэлгэрэнгүй бичвэр бүхий анхдагч шийдвэр, судалгаануудын тухайлсан контекстийн хүрээнд авч үзэж ойлгох ёстой. Тиймээс эшлэл бүрд холбогдох анхдагч шийдвэр, судалгааныхаа яг аль хэсэгт (хэддүгээр хуудас, цогцолборт) байгааг заах

Венецийн комисс

лавлагааг багтаасан. Энэ нь уншигчдад холбогдох эшлэлүүдийг комиссоос гаргасан илүү дэлгэрэнгүй бичвэр бүхий анхдагч шийдвэр, судалгаануудын тухайлсан контекстийнх нь хүрээнд авч үзэж ойлгох боломжийг олгоно.

Венецийн комиссын байр суурь шинэ санал, тайлан, судалгаанууд батлагдах цаг мөч бүрд, мөн түүнчлэн холбогдох туршлага хуримтлагдахын хирээр өөрчлөгдөж, хөгжих боломжтой. Тодорхой асуудлын талаарх Комиссын байр суурийг бүрэн дүүрэн ойлгохын тулд өөрийн сонирхож буй сэдвийн талаарх бүлгийг бүрэн уншихыг зөвлөж байна.

Хэрвээ зарим эшлэл дутуу, илүүц эсвэл буруу гарчгийн дор бичигдсэн гэж үзвэл та Венецийн Комиссын Нарийн бичгийн газарт дараах цахим шуудангийн хаягаар мэдэгдэнэ үү: venice@coe.int.

2 ҮНДСЭН ХУУЛИЙН ШҮҮХИЙН ТӨРӨЛ

“(...) [Үндсэн хуулийн] энэ бүлгээр байнгын ажиллагаа бүхий Үндсэн хуулийн шүүхийг бий болгожээ. Энэ нь эрх зүйн тогтолцооны үндсэн хуульд нийцсэн байдал (constitutionality)-ыг тухайлсан хийгээд байнгын ажиллагаа бүхий хараат бус шүүхийн байгууллагаар хамгаалах гэсэн шинэ ардчилсан улс орнуудад зонхилж буй практиктай бүрэн нийцэж байна. Үүнийг сайшаахаас өөр аргагүй. (...)”

CDL-INF(1997)002 Украйны Үндсэн хуулийн талаарх санал, хуудас 10.

“Үндсэн хуулийн шүүхийг ердийн шүүхээс тусад нь байгуулах нь магадгүй Европт хамгийн өргөн тархсан загвар юм. Нөгөөтээгүүр, Үндсэн хуулийн хяналтыг хэрэгжүүлдэг шүүхийг, хэдийгээр тус шүүх нь бусад шүүхийг хянах эрхтэй байж болох ч, шүүх эрх мэдлийн нэг хэсэг гэж үзэж болно. Гэвч энэ нь, Үндсэн хуулийн шүүх өөрийнхөө хараат бус байдлын баталгаа болон бүрэн эрхийнхээ хувьд шүүхийн хамгийн дээд байгууллагад олгогддог хүндэтгэлээ олоод авчихсан гэх нөхцөл дээрээс харвал, бодит амьдрал дээрх ач холбогдол бүхий асуудал гэхээс илүүтэйгээр (шүүхийн) ангиллын талаарх догматик асуудал гэж ойлгогдож байна. Энэ утгаараа Үндсэн хуулийн шинэчилсэн төсөл нь өмнөх төсөлд тусгагдсан шиг Үндсэн хуулийн шүүхийн “гишүүн” гэхээс илүүтэй шүүгчдийн талаар ярьж байгаа нь сайшаалтай. Үүнийг 88.2 дугаар зүйлд Үндсэн хуулийн шүүхийн “шүүхийн чиг үүрэг” гэсэн заалтыг нэмж оруулах замаар улам тодотгож болох юм.”

CDL-AD(2005)005 Гүрж улс дахь шүүхийн шинэчлэлтэй холбогдох Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд өгсөн санал, цогцолбор 14.

“Гэхдээ Үндсэн хуулийн шүүхийг байгуулах нь ардчилал, хүний эрхийн хамгаалалт, хууль дээдлэх ёс руу шилжиж буй шилжилтийн үеийн нийгэмд хурдасгуур болдог. Үндсэн хуулийн шүүх нь Үндсэн хуульд заасан хувь хүний эрхийг хамгаалахаас гадна, төрийн эрх мэдэл Үндсэн хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд байгаа эсэхийг хянаж, тэдгээрийн хоорондын зөрчлийг шийдвэрлэдэг. Үндсэн хуулийн шүүхийн легитм чанар болон дээр дурдсан чиг үүргээ хэрэгжүүлэх чадвар нь түүний тэнцвэртэй, ил тод бүрэлдэхүүнээс ихээхэн хамаардаг. Ийм бүрэлдэхүүн нь Үндсэн хуулийн шүүхийн хараат бус байдалд итгэх итгэлийг янз бүрийн ашиг сонирхол бүхий оролцогчид, цаашлаад олон нийтэд олгодог. Зөвхөн нэг талын эрх ашигт үйлчилдэг гэж харагдахуйцаар Үндсэн хуулийн шүүхийг байгуулах нь тухайн шүүхийн

шийдвэрүүд хэдийгээр үндэслэл сайтай байсан ч үнэ цэнийг бууруулах болно.”

CDL-AD(2009)014 Палестин улсын Үндсэн хуулийн дээд шүүхийн тухай хуулийн талаарх санал, цогцолбор 48.

“Ардчилал, хууль дээдлэх ёс, хүний эрхийг хамгаалахад Үндсэн хуулийн шүүхийн үүрэг чухал болохыг Венецийн комисс дахин сануулахыг хүсэж байна. Тухайн улс орны Үндсэн хуулийн шүүхүүд бол Үндсэн хуулийн бичвэрийг тайлбарлаж, үндсэн хуулийн холбогдох хэм хэмжээний талаарх аль болох сайн тайлбарыг цаг тухайд нь хийх замаар эрх бүхий албан тушаалтнуудын дур зоргоос урьдчилан сэргийлдэг байгууллага юм.»

CDL-AD(2010)044 Украин улс дахь Үндсэн хуулийн нөхцөл байдлын талаарх санал, цогцолбор 52.

“Дэлхийн 2-р дайнаас хойш Европт үндсэн хуулийн шүүхүүд нь ихэвчлэн ардчилалд шилжих явцад байгуулагдсан. Тухайлбал, эхлээд Герман, Италид, дараа нь Испани, Португалид, эцэст нь Төв болон Зүүн Европт байгуулагдсан. Тэдгээр шүүхүүдийн зорилго нь өмнөх дэглэмээс үлдсэн (өв) уламжлалыг даван туулах, мөн тэдгээр дэглэмийн улмаас зөрчигдсэн хүний эрхийг хамгаалах явдал байсан. Парламентад ямар нэгэн хяналт тавьдаггүй эрх мэдлийн төвлөрсөн зарчмын оронд эрх мэдэл хуваарилах тогтолцоог нэвтрүүлсэн. Энэхүү шинэ тогтолцоо нь Парламентын эдэлж байсан хамгийн дээд эрх мэдэл бүхий чиг үүрэг (энэ нь коммунист намын бүрэн хяналтад байдаг байсан)-ийн оронд, төрийн өөр өөр байгууллагуудын хоорондын хяналт, тэнцлийн зарчимд суурилж байв. Үүний үр дүнд Парламент хүртэл Үндсэн хуулийн хамгийн дээд эрх бүхий байдлыг дээдлэх ёстой болсон бөгөөд үүнийг бусад байгууллагууд, ялангуяа Үндсэн хуулийн шүүх хянах боломжтой болсон. Үндсэн хуулийн шүүх бол үндсэн хуульд ардчиллын хяналт, тэнцлийн гол бүрэлдэхүүн хэсэг юм. Үндсэн хуулийн шүүхийн ач холбогдол нь эрх баригчид өөрсдийн дийлэнх олонхдоо дулдуйдаж, төрийн бараг бүхий л байгууллагад өөрийн улс төрийн үзэл баримтлалд талтай албан тушаалтнуудыг томилох боломжтой болсон үед улам бүр нэмэгддэг.”

CDL-AD(2013)014 Шүүгчийн хараат бус байдлыг бэхжүүлэх Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн тухай хуулийн төсөл (тайлбар, хүснэгт багтсан) болон Украины Үндсэн хуулийн ассамблейгаас өргөн мэдүүлсэн Үндсэн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 76.

“Илүү формал түвшинд, Үндсэн хуульдаа Үндсэн хуулийн шүүхэд зориулсан хэсэг/бүлэгтэй байх нь тус шүүхийн онцлог шинжийг, ялангуяа энэ нь давж заалдах шатны шүүх биш гэдгийг тодорхой болгох болно (...).”

CDL-AD(2014)027 Бүгд Найрамдах Армени улсын Үндсэн хуулийн шинэчлэлийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалын судалгаанд өгсөн санал, цогцолбор 75.

“... Энэ утгаараа ихэнх улс орнууд Үндсэн хуулийн хяналтыг хэрэгжүүлэхийн тулд тусдаа Үндсэн хуулийн шүүхийг бий болгосныг тэмдэглэх нь зүйтэй. Үндсэн хуулийн шүүх бол ерөнхийдөө үндсэн хуульт ардчиллын гол бүрэлдэхүүн хэсэг гэж ойлгогддог. Венецийн комиссын зүгээс Үндсэн хуулийн шүүх байгуулах ёстой гэсэн ерөнхий шаардлагыг тулгадаггүй хэдий ч, ийм байгууллагыг тусдаа институт болгон байгуулахыг ерөнхийд нь зөвлөдөг бөгөөд энэ нь тухайн улс оронд хууль дээдлэх ёсыг хэрэгжүүлэхэд хөдөлгүүр болсоор ирснийг дурдах нь зүйтэй.

Ийм шүүх байгаа тохиолдолд холбогдох Үндсэн хууль бүр ерөнхийдөө Үндсэн хуулийн шүүхийн харьяалал, тус шүүхэд гомдол гаргах эрх бүхий холбогдогч, тус шүүхийн үйл ажиллагаа үндэслэн явагдах ёстой үндсэн хуулийн зарчмуудыг тусгадаг. Харин процедурын асуудлаарх илүү тодорхой хэм хэмжээнүүд дараа нь процедурын хууль (laws of procedure) болон маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны дэг (rules of procedure)-ээр тогтоогддог. Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны дэгийг ерөнхийдөө Үндсэн хуулийн шүүх өөрөө боловсруулдаг. Үүний зэрэгцээ тус шүүхийн институтийн бие даасан байдлыг үндсэн хуулиараа баталгаажуулах хэрэгтэй. Үндсэн хуулийн шүүхийн/танхимын “зохион байгуулалт болон үйл ажиллагааны журам”-ыг ердийн хуулиар тогтооно гэдэг (шинэ 93 дугаар зүйл, 4 дэх цогцолбор) нь Үндсэн хуулийг тайлбарлах эрх бүхий гол байгууллага болохынхоо хувьд гүйцэтгэх болон хууль тогтоох эрх мэдлээс бүрэн хараат бус байх ёстой Үндсэн хуулийн шүүхийн/танхимын институтийн статусыг алдагдуулахад хүргэнэ. Гэхдээ Үндсэн хуулийн шүүхийн/танхимын бүрэлдэхүүн, түүний гүйцэтгэх үүргийн талаарх зарим аспектуудыг [Үндсэн хуулийн] шинэчлэгдсэн 97 дугаар зүйлд зааж өгсөн хэвээр байгаа бөгөөд энэ нь тус шүүх/танхим Киргизийн шүүхийн тогтолцоонд онцгой статустай хэвээр байна гэсэн үзлийг дэмжиж байгааг дурдах нь зүйтэй.”

CDL-AD(2016)025 Бүгд Найрамдах Киргиз улсын “Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 47–48.

“Европын Аюулгүй Байдал Хамтын Ажиллагааны Байгууллага (ЕАБХАБ) болон Европын Зөвлөлийн бүс нутагт үндсэн хуулийн хяналтын янз бүрийн загварууд байдаг хэдий ч, энэхүү хяналт нь зарчмын хувьд хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлээс ангид байх хэрэгтэй. Түүнчлэн ардчилсан тогтолцоо нь гүйцэтгэх засаглал, хууль тогтоох эрх мэдлээс гадна шүүх эрх мэдэл гэсэн гурван тэнцүү эрх мэдлийн хуваарилалт дээр суурилдаг бөгөөд сүүлийн хоёр нь хяналтын тусгай чиг үүргийг хэрэгжүүлдэг. Ардчилсан институтүүдийн цогц үйл ажиллагаа, хүний эрхийн болон хууль дээдлэх ёсны хамгаалалтад оруулж буй Үндсэн хуулийн шүүхийн чухал ач холбогдлын талаас авч үзвэл, Үндсэн хуулийн шүүхийг/танхимыг гүйцэтгэх болон хууль тогтоох эрх мэдлийн удаах байгууллага болгож хувиргах нь санаа зовоосон үйл явдал болох болно.»

CDL-AD(2016)025 Бүгд Найрамдах Киргиз улсын “Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 56.

“Үндсэн хуульд нийцсэн байдлын талаарх Үндсэн хуулийн шүүхийн иж бүрэн хяналт нь Үндсэн хуулийг дээдлэн сахих хамгийн үр дүнтэй арга бөгөөд энэ нь доор дэлгэрэнгүй дурдсан хэд хэдэн аспектыг багтаадаг. Нэгт, гомдол гаргах эрх, чадамж (*locus standi*)-ийн асуудал маш чухал: Үндсэн хуульд нийцсэн эсэхийг шалгах хүсэлтийг зөвхөн хууль тогтоох эсвэл гүйцэтгэх засаглалд үлдээх нь хэрэг маргааны тоог, улмаар шалгалтын хүрээг эрс хязгаарлаж болзошгүй юм. Тиймээс, ядаж л Европын хувьд, ихэнх улс орнуудад хувь хүний Үндсэн хуулийн шүүхэд гомдол гаргах эрх хөгжсөн. Ийнхүү гомдол гаргах нь шууд болон шууд бус (энгийн шүүхэд гаргасан эсэргүүцэл, гомдол нь үндсэн хуулийн шүүхийн харьяалан шийдэх асуудал байх гэх замаар) байж болно. Хоёрт, үндсэн хуулийн хяналтад оруулах актуудын төрөлд хязгаарлалт байх ёсгүй: (ерөнхий) хэм хэмжээний болон тусгайлсан (захиргааны эсвэл шүүхийн) актуудад хяналт хийх боломжтой байх ёстой. Гэхдээ, хувь өргөдөл гаргагчийн хувьд бол түүний хувийн ашиг сонирхол хөндөгдсөн байх ёстой гэсэн шаардлага тавигддаг байж болно. (...)

Үндсэн хуулийн шүүхийн легитм чанар хийгээд түүний шийдвэрийг нийгэм хүлээн зөвшөөрөх эсэх нь тус шүүхээс нийгмийн олон янзын үнэт зүйлсийг (хэдийгээр тухайн үнэт зүйлс нь ерөнхийдөө нийтлэг үнэт зүйлсдээ зохицох байдлаар солигдож байдаг хэдий ч) хэрхэн авч үзэж байгаагаас ихээхэн шалтгаалдаг. Тиймээс, олон янзын мэдрэмжүүдийг хүндэтгэх

явдлыг хангасан тэнцвэртэй байдал нь эдгээр шүүхийн бүрэлдэхүүний талаарх журамд чандлан тусгагдах ёстой. “Дийлэнх олонх гэдэг бол улс төрийн зөвшилцлийг илэрхийлэх бөгөөд энэ нь аль ч нам, эвсэл ийм олонх болоогүй үед тэнцвэртэй бүрэлдэхүүнийг хангах арга зам юм.»

CDL-AD(2016)007 Хууль дээдлэх ёсны шаардлагын жагсаалт, цогцолбор 109, 112.

3 ЭХ СУРВАЛЖ

“Үндсэн хуулийн шүүх бүрийн үйл ажиллагаагаа явуулах хуулийн үндэслэл нь ихэнхдээ тухайн улсын дотоодын хуулийн тогтолцооны хэм хэмжээний шатлал дахь өөр өөр байр суурь бүхий гурван төрлийн зохицуулалтаас бүрддэг. Тэд үндсэн хуулийн шүүхийн талаарх бүрэн, бүтэн хуулийн зохицуулалтыг бий болгох процесст өөр өөр чиг үүргүүдийг гүйцэтгэдэг.

Энэ гурвалсан хэсгийн хамгийн «дээд талд» нь ихэнхдээ шүүхийн харьяалал, давж заалдах эрх эдлэх оролцогч талууд, түүнчлэн Үндсэн хуулийн шүүхийн үйл ажиллагааг үндэслэн явуулах ёстой үндсэн хуулийн зарчмуудыг тогтоох Үндсэн хууль байдаг. Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулиуд нь үндсэн хуулийн эдгээр зарчмуудыг илүү тодорхой хэм хэмжээ болгодог. Эцэст нь, маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны дэг нь энэхүү гурвалсан шатны дараагийн буюу эцсийн шатыг бүрдүүлдэг. Тэд шүүхийн өдөр тутмын үйл ажиллагааны практик хэсгийг зохицуулдаг. Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны дэгийг Үндсэн хуулийн шүүх өөрөө боловсруулж, өргөн барих хэрэгтэй.”

CDL-AD(2004)023 Азербайжан улсын Үндсэн хуулийн шүүхийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны дэгийн талаарх санал, цогцолбор 5-6.

“Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны дэгээ батлах замаар Үндсэн хуулийн шүүх нь Үндсэн хууль болон Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулиар тогтоосон хэмжээ хязгаарын хүрээнд өөрийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар тодорхой бүрэн эрх эдэлж, хууль тогтоогчийн хөндлөнгийн оролцоогүйгээр өөрийн туршлагадаа үндэслэн тэдгээр дүрмүүдийг өөрчлөх боломжтой байх хэрэгтэй.”

CDL-AD(2004)023 Азербайжан улсын Үндсэн хуулийн шүүхийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны дэгийн талаарх санал, цогцолбор 9.

“(…) Үндсэн хуульд, хуулиар зохицуулах асуудал болон шүүхийн дүрэмд хамаарах асуудлуудыг ялгаж салгахын зэрэгцээ, Шүүхийн дотоод зохион байгуулалт, үйл ажиллагааны талаарх хэм хэмжээний актыг батлах тухай тодорхой дурдах хэрэгтэй.”

CDL-AD(2005)015 Украин улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд өгсөн санал, цогцолбор 47.

“Европын ихэнх улс оронд үндсэн хуулийн шүүхийн талаарх үндсэн хуулийн заалтуудыг цаашид улам гүнзгийрүүлж тусгайлсан хууль эсвэл үндсэн хуулиар хөгжүүлдэг. Тэгвэл эсрэгээрээ Бүгд найрамдах [Македони] улсад үндсэн хуулийн шүүхийн талаар тусгайлсан хууль байдаггүй.

Үндсэн хуулийн 113 дугаар зүйлд “Үндсэн хуулийн шүүхийн ажиллах арга барил болон маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны дэгийг шүүхийн актаар зохицуулна” гэж заасан байдаг. Одоогийн байдлаар үндсэн хуулийн шүүхийн үйл ажиллагаа, бүрэн эрхийг зохицуулсан цорын ганц эрх зүйн акт бол 1992 оны Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны дэг юм. Венецийн комиссын зүг энэхүү нөхцөл байдлыг ихээхэн хууль бус гэж үзэж байна. Комиссын зүгээс, шүүгчийн статус, шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үндсэн нөхцөл, шийдвэрийн хууль зүйн үр дагавар гэх мэт асуудлуудыг зохицуулсан Үндсэн хуулийн шүүхийн тухай тусдаа хууль батлах нь зүйтэй гэж үзэж байна. Ийм хуулийн талаарх заалт Үндсэн хуульд тусгагдах хэрэгтэй, өөрөөр хэлбэл 113 дугаар зүйлд холбогдох шинэ цогцолборыг нэмж тусгах ёстой гэсэн үг. Гэхдээ, ийм хууль батлах нь Үндсэн хуулийн шүүх өөрийн үйл ажиллагааны арга барилыг зохицуулах, Шүүхийн дүрмийн хүрээнд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны дэгээ боловсруулах бүрэн эрхэд нөлөөлөх ёсгүй юм.”

CDL-AD(2014)026 “Хуучин Югославын Бүгд Найрамдах Македон Улс”-ын, ялангуяа, Шүүхийн зөвлөл, Үндсэн хуулийн шүүхийн бүрэн эрх, санхүүгийн тусгай бүсийн тухай Үндсэн хуулийн долоон нэмэлт, өөрчлөлтөд өгсөн санал, цогцолбор 80.

“Одоогийн Үндсэн хуульд органик хуулийн хамрах хүрээ өргөн байна. Органик хуулиудын үндсэн шинж чанар нь танхим бүрийн одоогийн гишүүдийн үнэмлэхүй олонхын саналаар батлагдах ёстой (76-р зүйл). (...) Органик хуулиудын талаарх зохицуулалтын салбаруудын жагсаалтад Үндсэн хуулийн шүүхийн зохион байгуулалт болон үйл ажиллагааны талаар тодорхой дурдсан нь сайшаалтай. (...)”

CDL-AD(2014)010 Румины Үндсэн хуулийн шинэчлэлийн талаарх хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 135.

“Хуулийн төслийн 15 дугаар зүйлд “Армены Бүгд Найрамдах улсын Үндсэн хууль”-аар тодорхойлсон цаг хугацааны хязгаарлалтууд, мөн “Үндсэн хууль болон бусад хууль”-д тодорхойлсон арга барилын талаар дурдсан. Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй «2002 оны 2-р сарын 20-ны

өдрийн Үндэсний ассамблейн маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны дэг (2016 оны 3-р сарын 16-ны өдрийн нэмэлт, өөрчлөлттэй)”-д цаг хугацааны хязгаарлалт болон бусад процедурын зохицуулалт байхгүй. Үндсэн хуулийн шүүхийн онцгой статус болон хуулийн тодорхой байдлын үүднээс уг асуудалд холбогдох дүрмүүдийг “Үндэсний ассамблейн маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны дэг” -ыг ишлэхээс илүүтэй хуулийн төсөлд нь шууд тусгах нь зүйтэй.

CDL-AD(2017)011 Армен - Үндсэн хуулийн шүүхийн талаарх Үндсэн хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 22.

“Энэ хуулийн төсөлд нэлээдгүй ажиглагдаж байгаа нэг асуудал бол холбогдох заалтуудаа маш нарийвчилсан байдлаар тусгасан явдал юм. Тэдгээрийн зарим нь, жишээлбэл энэхүү хуулийн төсөл шиг Үндсэн хуулийн хувьд бол хэт нарийвчилсан шинжтэй байна. Харин иймэрхүү нарийвчилсан шинжтэй заалтууд нь нэмэлт, өөрчлөлт оруулахад харьцангуй хялбар байдаг маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны дэгийн хувьд бол байж болох юм.

CDL-AD(2017)011 Армен - Үндсэн хуулийн шүүхийн талаарх Үндсэн хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 100-101.

“Мэдээж, Үндсэн хуулийн шүүхийг шүүх эрх мэдлийн талаарх бүлэгт оруулах нь, ялангуяа тус шүүх нь бусад шүүхийн шүүгчдээс бүрдэж байгаа (103.3 дугаар зүйл) бол шударга ёсны хэрэг юм. Гэхдээ аливаа хууль Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх талаар дүгнэлт гаргах тусдаа чиг үүрэг бүхий бие даасан байгууллага болохынхоо хувьд Үндсэн хуулийн шүүхийг өөр бүлэгт оруулсан ч болох юм.”

CDL-AD(2019)003 Люксембургийн Үндсэн хуулийн шинэчилсэн төсөлд өгсөн санал, цогцолбор 110.

4 ШҮҮХИЙН БҮРЭЛДЭХҮҮН

4.1 ТЭНЦВЭРТЭЙ БҮРЭЛДЭХҮҮН

“Нийгэм гэдэг нь философийн, ёс суртахууны, нийгмийн, улс төрийн, шашны, хуулийн чиглэлийн зэрэг олон янзын чиг хандлагын илэрхийлэл болсон орчин бөгөөд олон ургалч үзлийг өөртөө зайлшгүй агуулж байдаг. Үндсэн хуулийн шүүх нь өөрийн бүрэлдэхүүнээрээ ашиг сонирхлын ялгаа бүхий бүлгүүдээс хараат бус байх нөхцөлөө баталгаажуулж, энэхүү олон ургалч үзэл бүхий байдалд сайтар анхаарсан шүүхийн шийдвэрүүдийг бий болгоход хувь нэмрээ оруулах ёстой. Үндсэн хуулийн шүүхийн легитим шинж хийгээд түүний шийдвэрүүдийг нийгэм хүлээн зөвшөөрөх эсэх нь тус шүүхээс нийгмийн янз бүрийн үнэт зүйлсийг (хэдийгээр тухайн үнэт зүйлүүд нь ерөнхийдөө нийтлэг үнэт зүйлсдээ зохицох байдлаар солигдож байдаг хэдий ч) хэрхэн авч үзэж байгаагаас ихээхэн шалтгаалдаг. Тиймээс, ялгаа бүхий мэдрэмжүүдийг хүндэтгэх нөхцөлийг хангасан тэнцвэрт байдлыг эдгээр шүүхийн бүрэлдэхүүний дүрэмд чандлан тусгах ёстой.

Үндсэн хуулийн шүүхүүд нь зарим шийдвэрээрээ тухайн улс дахь тодорхой эрх мэдэл бүхий этгээдийн үйл ажиллагааг хязгаарлаж байгаа мэт харагдаж болно. Үндсэн хууль нь ихэнхдээ эрх мэдлийн хуваарилалт буюу төрийн байгууллагуудын хоорондын харилцааны талаарх асуудлаар дүгнэлт гаргах бүрэн эрхийг Үндсэн хуулийн шүүхэд олгодог. Хэдийгээр Үндсэн хуулийн шүүх эдгээр харилцааны зохицуулалтыг голчлон хангаж байдаг ч, өөрийн бүтцээрээ эдгээр төрийн эрх бүхий этгээд буюу байгууллага тус бүрийн талаар тэнцвэртэй байр суурийг илэрхийлдэг байх нь зүйтэй болов уу.

Энэхүү тэнцвэрт байдлыг бий болгох явдал нь Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийн хараат бус хийгээд бие даасан байдлыг хамгаалах асуудлаар хязгаарлагдаж байдаг. Хамтын зарчим, өөрөөр хэлбэл хувь гишүүн тусгай санал гаргах эсэхээс үл хамаарч бүлгээрээ шийдвэр гаргадаг явдал нь энэ талаарх суурь баталгааг бий болгодог. Үндсэн хуулийн шүүхийн бүрэлдэхүүний талаарх дүрмүүд нь тухайн улсад өөр өөр урсгал бүхий үзлүүд зэрэгцэн оршиж байгааг илэрхийлсэн байж болох ч, шүүхийн хараат бус байдлын баталгаа хийгээд Үндсэн хуулийн шүүгчийн чухал чиг үүрэгтэй байнга дагалдаж явдаг үүрэг хариуцлагын өндөр мэдрэмж нь шүүхийн

шүүгчдийг бодит байдал дээр тодорхой нэгэн ашиг сонирхлыг төлөөлж, нэг тал руу хэлбийсэн үйл ажиллагаа явуулж байж болзошгүй гэсэн тэдний талаарх хардлагын бүх үндэслэлийг үгүйсгэхүйцээр ажиллах нөхцөл боломжийг үр дүнтэйгээр хангаж байдаг.”

CDL-STD(1997)020 Үндсэн хуулийн шүүхийн бүрэлдэхүүн – Шинжлэх ухаан болон Ардчиллын техник, но. 20 (1997), хуудас 21.

“Үндсэн хуулийн шүүхийн бүрэлдэхүүний шалгуурт үндэс угсаа, хэл шинжлэлийн болон бусад зүйлсийг оруулах нь ийм элементүүдийг шүүхийн шийдвэр гаргах үйл явцад оруулахаас эрс ялгаатай гэдгийг анхнаасаа онцлон тэмдэглэх хэрэгтэй. Шүүхийн бүрэлдэхүүнийг нийгмийн бүрэлдэхүүнтэй зүйрлэх замаар, олон ургалч үзэл бүхий бүтэцтэй байх ийм шалгуур нь тусгаар тогтносон ард түмний төлөөлөл болох парламентаас баталсан хууль тогтоомжийг хүчингүй болгоход шаардлагатай легитим шинжийг шүүхэд олгоход чухал хүчин зүйл болж чадна.”

“Үндсэн хуулийн шүүхийн бүрэлдэхүүн нь үндэс угсаа, газар зүйн, хэл зүйн зэрэг нийгмийн бүрэлдэхүүний аспектиудыг тусгах боломжтой, эсхүл тусгах хэрэгтэй хэдий ч, нэгэнт томилогдсоны дараа шүүгч бүр тэгш саналын эрх бүхий зөвлөлдөн шийдвэр гаргах институт болох шүүхийн нэг гишүүн болж, тодорхой нэг бүлгийн төлөөлөгч бус хувь шүүгчийнхээ үүднээс хараат бусаар үйл ажиллагаагаа явуулна.”

CDL-AD(2005)039 Босни Герцеговина улсын Үндсэн хуулийн шүүхэд санал хураах талаар өргөн барьсан журамд өгсөн санал, цогцолбор 3, 13.

“Өргөн баригдсан нэмэлт, өөрчлөлтөд Үндсэн хуулийн шүүх тэнцвэрт бүрэлдэхүүнтэй байхаар тусгасан ба Үндсэн хуулийн шүүхийн 18 гишүүн нь Үндсэн хуульд заасан өндөр ур чадвар бүхий нэр дэвшигчдийн дундах өрсөлдөөний үндсэн дээр явуулсан сонгон шалгаруулалтын дараа Ерөнхийлөгч, Дээд Рад болон Шүүгчдийн Их Хурлаас томилогдоно. Урьдчилсан дүгнэлтэд дурдсанчлан, энэхүү бүрэлдэхүүний талаарх саналыг дэмжүүштэй.”

CDL-AD(2015)027 2015 оны 9-р сарын 4-ний өдөр Үндсэн хуулийн комиссоос батлагдсан шүүхийн талаарх Украины Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд өгсөн санал, цогцолбор 24.

“Үндсэн хуулийн шүүхийн бүрэлдэхүүнийг тэнцвэртэй байлгахад туслах механизмыг бий болгох талаар Венецийн комиссоос тогтмол зөвлөж байна. Комисс 1997 оны тайландаа олон ургалч үзэл гэж юу гэсэн үг болохыг ийнхүү

тайлбарласан: “Үндсэн хуулийн шүүх нь өөрийн бүрэлдэхүүнээрээ өөр өөр ашиг сонирхол бүхий бүлгүүдийн хараат бус байдлыг баталгаажуулж, энэхүү олон ургалч үзэлд анхаарсан шүүхийн шийдвэрүүдийг бий болгоход хувь нэмэр оруулах ёстой.” Энд шүүгчдийн хараат бус байдал болон тэдгээрийн олон ургалч үзлийг дээдлэх явдлыг чухалчилж байгаа бөгөөд шүүгчид тодорхой бүлгийн эрх ашгийн “төлөөлөгч” гэх утгаар огт дурдаагүй болно.”

[...]

“Парламентын гишүүд улс төрийн намуудын үзэл санааг хууль ёсоор төлөөлдөг бол Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийн чиг үүрэг үүнээс тэс өөр зүйл юм. Үндсэн хуулийн шүүгчид өөрсдийг нь сонгосон, томилсон этгээдэд “хариу барихгүй байх үүрэг” хүлээдэг. Тэд аль нэг намаас нэр дэвшиж, тухайн намын парламентын гишүүдээс сонгогдож болох ч, тэр намыг хэзээ ч төлөөлж болохгүй. Шүүгчийн хувьд тэд хараат бус бөгөөд Үндсэн хуульд үнэнч байх ёстой болохоос өөрийг нь сонгосон хүмүүстээ биш юм.”

CDL-AD(2016)001 Польшийн Үндсэн хуулийн шүүхийн тухай 2015 оны 6-р сарын 25-ны өдрийн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтөд өгсөн санал, цогцолбор 116, 119.

“[...] Тиймээс, Зүүн Европын олон оронд хэрэгжиж буй Ерөнхийлөгч, хууль тогтоогч болон шүүх Үндсэн хуулийн шүүхийн бүрэлдэхүүнийг томилоход оролцдог загварыг нэвтрүүлэхээр төлөвлөж байна. Ерөнхийлөгч болон Ассамблей нь шүүгчид шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг Шүүгчийг томилох зөвлөлөөс (Justice Appointments Council) гаргасан жагсаалтаас сонгох ёстой. Зарчмын хувьд энэ нь улс төрийн заль мэх хийх хүрээг хязгаарладаг тул эерэг өөрчлөлт гэж тооцогдож байна. Тиймээс үүнийг талархан хүлээж авах хэрэгтэй.»

CDL-AD(2015)045 Шүүхийн талаарх Албанийн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд өгсөн түр дүгнэлт, цогцолбор 23.

“Улсын дээд шүүх болон Захиргааны хэргийн шүүхийн хамтарсан зөвлөмжийн дагуу (103 дугаар зүйлийн 3 дахь хэсэг) Үндсэн хуулийн шүүх нь Дээд шүүхийн дарга, Захиргааны хэргийн шүүхийн дарга, давж заалдах шатны шүүхийн хоёр шүүгч болон Засгийн газраас томилогдсон таван шүүгчээс бүрдсэн хэвээр байгаа бөгөөд энэ нь чиг үүргийн хувьд Гранд Дүк (the Grand Duke)-ийг албан ёсоор орлож байна. Бусад харьяаллын шүүхүүдээс шүүгчдийг ийнхүү оруулах нь хязгаарлагдмал тооны оршин суугчид, шүүгч, түүнчлэн хянан шийдвэрлэх хэргийн тооноос шалтгаалж байгаагаар зөвтгөгдөж байна.»

CDL-AD(2019)003 Люксембургийн Үндсэн хуулийн шинэчилсэн төсөлд өгсөн санал, цогцолбор 111.

4.1.1 Үндэстний цөөнхийг шударгаар төлөөлөх

“Өөр нэг чухал асуудал бол цөөнхийг Үндсэн хуулийн шүүхээр хамгаалах явдал юм. 1991 оны 12-р сарын 4-ний Бүгд Найрамдах Хорват Улсын Үндсэн хуулийн хүний эрх, үндсэн эрх чөлөө болон Үндэстний эсхүл үндэстний цөөнхийн талаарх заалтад хүн амын 8-аас дээш хувийг бүрдүүлдэг цөөнх нь дээд шүүхэд төлөөлүүлэх ёстой гэж заасан байдаг. Дээд шүүх гэдэг нь үндсэндээ Үндсэн хуулийн шүүхийг багтаах ёстой.”

CDL-INF(2001)002 Үндсэн хуулийн шүүхийн талаарх Бүгд Найрамдах Хорват улсын Үндсэн хуулийн зохицуулалтад өгсөн санал, цогцолбор 11.

“Үндсэн хуулийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийн 6 дугаар зүйлд одоо мөрдөгдөж буй хуулийн “төрийн хэл” гэсэн нэр томъёоны оронд “албан ёсны хэл” болон “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэл” гэсэн нэр томъёог оруулсан. Энэ нь үндсэн хуулийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг төрийн хэлээс өөр хэлээр явуулах боломжийг олгож, хэлний эрхийг төрийн эрх бүхий байгууллага, албан хаагчид дээдлэх явдлыг нэмэгдүүлж байгаа тул сайшаах хэрэгтэй.”

CDL-AD(2008)029 Киргизийн (1) Үндсэн хуулийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (2) Үндсэн хуулийн шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 39.

4.1.2 Шүүгчид тавигдах шаардлага

“Үндсэн хуулийн шүүхийн шүүгчдэд тавигдах шаардлагад шүүхийн чадварлаг бүрэлдэхүүнийг хангахын тулд хууль зүйн мэргэшлийн шаардлагыг ихэнх тохиолдолд тусгадаг. Нөгөөтээгүүр, хууль зүйн хувьд хэт мэргэшсэн байхыг шаардах нь зарим үндсэн хуулийн шүүхийн бүрэлдэхүүний олон талт байдлыг алдагдуулж болзошгүй юм. Гэсэн хэдий ч, тодорхой хэмжээнд олон талт байдлыг хүсэх явдал болон тодорхой мэргэжил эсхүл цөөнхийн бүлгийг шүүхэд төлөөлүүлэх боломжийг олгохын тулд квот бий болгох явдал хоёрыг хоорондох ялгааг авч үзэх хэрэгтэй. Холбооны улс болон олон хэлтэй нийгэмд тэгш бус байдал, эсхүл ялгаварлан гадуурхалтыг арилгахын тулд тэнцвэртэй төлөөллийг эрэлхийлэх нь ихэвчлэн албан ёсны буюу формал шинжтэй байдаг. Учир нь эдгээр нь өөр өөр бүрэлдэхүүнт бүлгүүдийн тэгш төлөөлөл болон хуульд тэгш хамрагдах зэрэг эмзэг асуудлуудыг хөндөж байдаг.

CDL-STD(1997)020 Үндсэн хуулийн шүүхийн бүрэлдэхүүн – Шинжлэх ухаан болон Ардчиллын техник, no. 20 (1997), хуудас 10.

“Үндсэн хуулийн шүүхийн гишүүдийн дийлэнх нь шүүхээс сонгогдож байгаа нь шүүхийн хараат бус байдалд сайнаар нөлөөлнө. Гэсэн хэдий ч Европын бусад үндсэн хуулийн шүүхтэй харьцуулахад энэ хувь хэмжээ ер бусын өндөр байна. Энэ нь Үндсэн хууль болон бусад хуулиудын тайлбар нь зарим талаараа ялгаатай байж болох тул Үндсэн хуулийн шүүхийн ашигладаг тайлбарын аргад нөлөөлж болзошгүй. Тиймээс, хууль зүйн багш нарын төлөөллийг нэмэгдүүлэх нь зүйтэй байж болох юм.”

CDL-AD(2004)024 Үндсэн хуулийн шүүхийн талаарх Туркийн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд өгсөн санал, цогцолбор 18.

“Нэмэлт, өөрчлөлт орсон 5.5 зүйлийн төсөлд Үндсэн хуулийн шүүхийн шүүгчид нэр дэвшигчид шүүгч эсхүл прокуророор 12 жил ажилласан байх шаардлага тавьсан. Энэ заалтын зорилго нь Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийн мэргэшлийн түвшин болон түүний хараат бус байдлыг нэмэгдүүлэхэд оршиж байгаа болов уу. Гэхдээ, үүний үр дүнд зөвхөн карьер шүүгч, эсхүл прокурорууд л Үндсэн хуулийн шүүхийн шүүгч болох боломжтой байх магадлалтай. Дахин хэлэхэд, энэ нь ердийн шүүхээс өөр бүрэлдэхүүн бүхий тусгай шинжтэй Үндсэн хуулийн шүүхийн логиктой зөрчилдөж байна.”

CDL-AD(2006)006 Румын улсын Үндсэн хуулийн шүүхийн зохион байгуулалт, чиг үүргийн тухай №47/1992 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан хоёр хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 16-17.

“Мэргэжлээрээ 15 жил ажилласан байх шаардлага нь Үндсэн хуулийн шүүхэд залуу шүүгчид сонгогдох боломжийг бүрмөсөн хаах эрсдэлтэй байна. Энэ нь ялангуяа шинэ ардчилсан нийгэмд маш хор хөнөөлтэй байж болзошгүй.”

CDL-AD(2008)015 Украины Үндсэн хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 80.

“Шүүгчийн шалгаруулалт хууль, эсхүл эрх бүхий байгууллагаас урьдчилан тогтоосон объектив шалгуурт суурилж явагдах ёстой бөгөөд, энэ нь үндсэндээ мерит буюу чадвар дээр тулгуурлах хэрэгтэйг онцлон тэмдэглэх нь зүйтэй. Шүүгч, хуульч, профессор зэрэг зөвхөн хуулийн мэргэжлийн хүмүүс Үндсэн хуулийн шүүхийн гишүүн болохоос гадна, эдийн засаг, эсхүл улс төрийн шинжлэх ухааны салбарын хүмүүс ч гэсэн Шүүхийн гишүүн болох боломжтой. Үүнийг бусад Үндсэн хуулийн шүүх, түүнтэй адилтгах байгууллагуудад ч харж болно”.

CDL-AD(2011)040 Туркийн Үндсэн хуулийн шүүхийн байгуулал, процедурын тухай хуулийн талаарх санал, цогцолбор 21.

“Шүүгчид нэр дэвшигчдийн сонгон шалгаруулалт нь уралдаант хэлбэрээр явагдах бөгөөд энэ нь шүүхийн талаарх олон улсын болон Европын хуулийн стандартууд дахь шилдэг туршлагад нийцэж байгаа тул сайшаалтай байна.

CDL-AD(2013)014 Шүүгчийн хараат бус байдлыг бэхжүүлэх Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн тухай хуулийн төсөл (тайлбар, хүснэгт багтсан) болон Украины Үндсэн хуулийн ассамблейгаас өргөн мэдүүлсэн Үндсэн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 27.

“Гэхдээ, улс төрийн оролцоо, тэр дундаа улс төрийн намын гишүүн байх нь ардчиллын чухал бүрэлдэхүүн хэсэг учраас шүүгчид нэр дэвшигчид тавьсан дор хаяж 10 жил улс төрийн намын гишүүн байж болохгүй гэсэн шалгуур нь хэтэрхий хатуу санагдаж байна. Үндсэн хуулийн шүүх нь бүрэн эрхт ард түмний төлөөлөл болох парламентаас баталсан хууль тогтоомжийг хүчингүй болгох гэсэн үндсэн хуулийн онцгой легитим чанартай байдаг. Энэхүү легитим чанарыг эдлэхийн тулд Үндсэн хуулийн шүүх нь ихэвчлэн тухайн нийгмийнхээ бүрэлдэхүүнийг өөртөө тусгасан байдлаар буюу тэнцвэртэй байдлаар бүрэлддэг. Энэ утгаараа Үндсэн хуулийн шүүхийн шүүгчид нэр дэвшигчийг томилогдохоосоо өмнө арван жил ямар нэг намын харьяалалгүй байхыг шаардах нь хэтийдсэн мэт санагдаж байна.»

CDL-AD(2015)024 Тунисийн Үндсэн хуулийн шүүхийн институтийн тухай хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 17.

“1997 онд Венецийн комиссын зүгээс хийсэн Үндсэн хуулийн шүүхийн бүрэлдэхүүний талаарх судалгаагаар үндсэн хуулийн шүүгчид тавигдах шаардлага нь олон төрөлтэй буюу өргөн хүрээтэй байгааг харуулсан:

“Төсөөлж байсанчлан, хэд хэдэн хариултууд үндсэн хууль зөрчсөн эсэх хяналтыг үндсэн хуулийн шүүх хэрэгжүүлдэг үү эсвэл дээд шүүх хэрэгжүүлдэг үү гэдгээс хамаарч өөр өөр байна. Энэ нь ялангуяа шүүгчийн томилгооны шаардлагад хамаатай байх бөгөөд хэрэв Дээд шүүх бол ихэнх тохиолдолд бүхэлдээ хуульчдаас бүрдэж байна (Аргентин, Канад, Дани, Эстони, Грек, Исланд, Ирланд, Мальта, Норвег). Финлянд онцгой тохиолдолд хамаарч байна: тэрээр Дээд шүүх болон Захиргааны хэргийн дээд шүүх нь зарим тохиолдолд бүрэлдэхүүнээ өөрчилдөг. Жишээ нь, цэргийн хэргийг Дээд шүүх дээр хэлэлцэхэд хоёр генерал шүүхийн шийдвэр

гаргахад оролцдог. Харин, усны эрхийн болон патентын хэргүүдийг Захиргааны хэргийн дээд шүүх дээр хэлэлцэхэд инженерийн мэргэжилтнүүд шүүхийн шийдвэр гаргахад оролцдог. Шведийн Дээд шүүхийн тогтолцоо мөн бага ялимгүй ялгаатай байна: Дээд шүүхийн бүх гишүүд хуульч байх ёстой, харин Захиргааны хэргийн дээд шүүхийн шүүгчдийн гуравны хоёр нь л хуульчийн мэргэшлийн шаардлагыг хангасан байх ёстой. Өөр нэг онцгой тохиолдол бол Швейцарын Холбооны шүүх (мөн энгийн харьяаллын хувьд давж заалдах шатны эцсийн шат болдог) бөгөөд энд шүүгчдээс хууль зүйн боловсролтой байхыг шаарддаггүй. Гэхдээ бодит байдал дээр Холбооны шүүхийн шүүгчид бүгд хуульч байдаг. Японы Дээд шүүхийн хувьд, арван таван шүүгчийн тав хүртэлх нь мэргэжлийн хуульчийн мэргэшилтэй байх шаардлагагүй. Хуульчдыг илүүд үздэг ерөнхий хандлага Үндсэн хуулийн олон шүүхүүдэд ажиглагдаж байна (Албани, Австри, Болгар, Герман, Итали, Латви, Литва, Польш, Португал, Румын, Орос, Бүгд Найрамдах Словак буюу «хуучин Югославын Бүгд Найрамдах Македон Улс»). Гэхдээ, наад зах нь зарим үндсэн хуулийн шүүхүүд хүний туршлагыг аль болох өргөн хүрээнд хамтад нь харгалзан үзэх болон шүүхийн хэт мэргэшсэн байдлаас зайлсхийхийн тулд хуульч бус хүмүүсийг шүүхийн гишүүн болгохыг шууд байдлаар зөвшөөрч байна (Армен, Франц, Лихтенштайн, Турк). Гэвч, бодит байдал дээр эдгээр шүүхүүд ихэвчлэн хуульчдаас бүрддэг. Бельгийн хувьд, шүүгчдийн тал хувь нь парламентын гишүүн асан байх ёстой ч дийлэнх олонх нь хуульчид байдаг.

Хууль зүйн хувьд мэргэшсэн байдал шаардагдсан тохиолдолд хүлээгдэж буй холбогдох туршлага нь шүүхийн байгууллагад олон жил ажилласан туршлагаас (Албани, Эстони) эхлээд аливаа төрлийн хуульчийн мэргэжлээр ажилласан туршлага (Аргентин, Босни-Герцеговина, Болгар, Канад, Хорват, Чех, Гүрж, Унгар, Латви, Литва, Норвег, Румын, Орос, Бүгд Найрамдах Словак, Словени, Испани, “хуучин Югославын Бүгд Найрамдах Македон Улс”, Украин) хүртэл харилцан адилгүй байна. Бельгид парламентын гишүүн асан бус шүүгчид нь улсынхаа хамгийн дээд түвшний шүүхийн шүүгчид, хуулийн эрдэмтэд эсвэл тус шүүхийн нөөцийн буюу туслах шүүгч байх ёстой. Зарим улсад бусад шүүхийн шүүгчээс Үндсэн

хуулийн шүүхэд авах талаар квот байдаг (Герман, Португал), эсхүл нэр дэвшигч нь шүүгчийн эсвэл хуульчийн мэргэжлийн аль нэг туршлагатай байх, гэхдээ туршлагын хугацаа нь ерөнхийдөө шүүгчийнх бусад хуульчдынхаасаа богино байна. Жишээ нь, Канад, Ирланд, Италийг нэрлэж болох ба Японд 18 жилийн шаардлагыг тавьдаг. Үүнтэй төстэйгөөр Финляндад дээд шатны шүүхэд томилогдоход шаардагдах шүүхэд ажилласан байх туршлага нь хуулийн профессор эсвэл нэр хүндтэй өмгөөлөгчийн туршлагаар нэмэгдвэл урт хугацаа шаардахгүй. Австрид, Үндсэн хуулийн шүүхийн дарга, дэд ерөнхийлөгч, гурван байнгын болон гурван орлон гүйцэтгэгч гишүүнийг (Холбооны Засгийн газраас санал болгосон) шүүгчид, өндөр албан тушаалтнууд болон их сургуулийн хуулийн профессор нарын дундаас сонгох ёстой.”

Зарим улсад хүний туршлагыг аль болох өргөн хүрээнд хамтад нь харгалзан үзэх болон шүүхийн хэт мэргэшсэн байдлаас зайлсхийхийн тулд Үндсэн хуулийн шүүхийн бүрэлдэхүүнд хуульч бус хүмүүсийг ч багтааж болохоор байна. Гэхдээ, бодит байдал дээр эдгээр шүүхүүд ихэвчлэн хуульчдаас бүрддэг.

Словакийн Үндсэн хуулийн 134.3 заалт Бүгд Найрамдах Словак улсыг хууль зүйн туршлага шаарддаг боловч, шүүхийн тухайлсан туршлага шаарддаггүй улсуудын бүлэгт баттай оруулсан байдаг.

Практикт Европын үндсэн хуулийн шүүхийн олон шүүгчид үндсэн хуулийн профессорууд байдаг ч, Словакийн Үндсэн хууль зэрэг Европын үндсэн хуулиуд нь ийм тухайлсан мэргэшлийг шаарддаггүй.

Үндсэн хуулийн шүүхийн гишүүдийн хоёр дахь түгээмэл гарваль нь ердийн шүүхийн шүүгч нар байдаг бөгөөд тэд ердийн шүүхийн ажлынхаа шинж чанараас шалтгаалаад үндсэн хуулиар тусгайлан мэргэшээгүй байдаг. Үнэндээ, Үндсэн хуулийн шүүх нь янз бүрийн хуулийн салбар, тухайлбал хүний эрхийн асуудал маш их тулгардаг салбарын нэг болох эрүүгийн эрх зүй зэрэг салбараас ирэх туршлагыг өөртөө байлгахуйц олон талт бүрэлдэхүүнийг илүүд үзэх нь олонтоо.

CDL-AD(2017)001 Бүгд Найрамдах Словак улс - Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийн томилгоотой холбоотой асуултуудын талаар өгсөн санал, цогцолбор 52-56.

“Хуулийн төсөлд Үндсэн хуульд байхгүй нэмэлт шаардлага, тэр дундаа нэр дэвшигч нь мэргэжлийн болон ёс суртахууны өндөр чадвартай байх ёстой гэсэн заалт оруулсан. Энэ бол эерэг зүйл. Цаашилбал, нэр дэвшигч нь Армен хэлийг эзэмшсэн эсэхээ нотлох баримтаа өгөх ёстой. Үндсэн хуульд оруулсан, гэхдээ хуулийн төсөлд нэмж тайлбарлаагүй “Мэргэжлийн өндөр чадвар” гэсэн шалгуурыг бодит байдал дээр нарийн тодорхойлоход хэцүү байж болох хэдий ч энэ бол байж болох зүйл. Энэхүү томъёоллын зорилго нь Үндсэн хуулийн шүүхийн шүүгчдийг хууль зүйн тусгай буюу “улам өндөр” мэдлэгтэй болгоход чиглэж байгаа юм. Ийм төрлийн заалтууд бусад улсуудад ч байдаг.”

CDL-AD(2017)011 Армен - Үндсэн хуулийн шүүхийн талаарх Үндсэн хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 12-13.

4.1.3 Нас

“Насны доод хязгаарын шаардлагыг мэргэжлийн болон амьдралын туршлагыг баталгаажуулахын тулд хэд хэдэн улсад ашигладаг. Энэхүү саналд насны доод хязгаарыг 45-аас 50 нас хүртэл нэмэгдүүлэхээр тусгасан. Энэ нь бидний мэдэж байгаагаар Европ дахь насны доод хязгаарт тавьсан хамгийн дээд шаардлага бөгөөд хэтийдсэн шаардлага байж болох юм. Нэмэлт, өөрчлөлт оруулсан 147 дугаар зүйлд тэтгэврийн насыг 67 болгож нэмэгдүүлнэ. Үнэхээр энэ зохицуулалтын зорилго нь Үндсэн хуулийн шүүхийн гишүүн байх хугацаандаа олж авсан мэдлэг, туршлагаас авах ашгийг хамгийн ихээр хүртэх байсан бол, тэтгэврийн насыг илүү нэмэгдүүлэх, тухайлбал, нэлээд түгээмэл буюу 70 нас хүртэл нэмэгдүүлэх боломжтой байсан. Бүрэн эрхийн хугацаа харьцангуй урт (12 жил), насны дээд хязгаар харьцангуй бага (дээрх саналын дагуу 67 нас), мөн насны доод хязгаарын шаардлага өндөр (50 нас) зэргээс үзэхэд боломжит нэр дэвшигчдийн хүрээг үндэслэлгүйгээр хязгаарласан байж болох юм.”

CDL-AD(2004)024 Үндсэн хуулийн шүүхийн талаарх Туркийн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд өгсөн санал, цогцолбор 25.

“Шүүгчийн тэтгэвэрт гарах насны хязгаарыг тогтоосон нь Европын олон улс, тухайлбал Албани, Армени, Австри, Босни Герцеговина, Хорват, Унгар, Ирланд, Япон, Латви, Норвег, Португал, ОХУ-ын практикт нийцэж байна. Энэхүү насны хязгаарыг мөн Туркийн Үндсэн хуулийн шүүхийн талаарх Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд өгсөн Венецийн комиссын өмнөх 296/2004 (CDLAD(2004)024)-ийн 25 дахь цогцолборт санал болгосон:

“...Нэмэлт, өөрчлөлт оруулсан 147 дугаар зүйлд тэтгэврийн насыг 67 болгож нэмэгдүүлнэ. Үнэхээр энэ зохицуулалтын зорилго нь Үндсэн хуулийн шүүхийн гишүүн байх хугацаандаа олж авсан мэдлэг, туршлагаас авах үр өгөөжийг хамгийн ихээр хүртэх байсан бол, тэтгэврийн насыг илүү нэмэгдүүлэх, тухайлбал, нэлээд түгээмэл буюу 70 нас хүртэл нэмэгдүүлэх боломжтой байсан.”

CDL-AD(2007)036 Азербайжан улсын Үндсэн хуулийн шүүхийн тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдэд өгсөн санал, цогцолбор 14.

“Венецийн комисс насны доод хязгаарыг 50 насаар тогтоох нь хэтийдсэн хэрэг гэж үзэж байгаа ч, үүнийг 40 насаар тогтоох нь амьдралын туршлага, төлөвшлийн талаас авч үзэхэд үндэслэлтэй байгаа бөгөөд энэ нь боломжит нэр дэвшигчдийн хүрээг шаардлагатай хэмжээнээс илүү хязгаарлахгүй гэж үзэж байна.”

CDL-AD(2009)042 Латвийн Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд өгсөн санал, цогцолбор 11.

“127-р зүйлд шинээр томилогдсон шүүгчид 30 нас хүрсэн байх (одоогийн зохицуулалтаар 25 нас байгаа), 5 жилийн ажлын туршлагатай байх (одоогийн зохицуулалтаар 3 жил байгаа) тухай санал орсон. Эдгээр заалтууд үндэслэлтэй гэж санагдаж байна. Мөн шүүгчид нэр дэвшигчдийн сонгон шалгаруулалт нь уралдаант журмаар явагдаж байхаар Үндсэн хуульд тусгах юм. Энэ нь хүсэмжит заалт болох нь харагдаж байна. Гэхдээ яг ямар туршлага хэрэгтэй байгаа нь тодорхойгүй байна.”

CDL-AD(2013)014 Шүүгчийн хараат бус байдлыг бэхжүүлэх Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн тухай хуулийн төсөл (тайлбар, хүснэгт багтсан) болон Украины Үндсэн хуулийн ассамблейгаас өргөн мэдүүлсэн Үндсэн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 27.

“Шүүгч нь сонгогдохдоо 35-65 настай байх (8.3-р зүйл), бүрэн эрхийн хугацаа 10 жил (9.1-д) байх ёстой гэдгээс үзвэл шүүгчийн насны дээд хязгаар 75 байхаар байна. Ерөнхийдөө, Үндсэн хуулийн шүүхийн гишүүний насны дээд хязгаарыг 70 нас гэж үздэг. Үүнийг хэрэгжүүлэхийн тулд хуулийн төсөлд шүүгч болох насны дээд хязгаарыг 60 нас гэж тогтоох юм уу, эсхүл насны дээд хязгаарыг 70 нас гэж тогтоож шүүгчийн бүрэн эрх нь 10 жилээс нь өмнө дуусгавар болгож болохоор байна. Сүүлийн хувилбар нь илүү хэрэгжих боломжтой мэт санагдаж байна.»

CDL-AD(2014)017 Тажикстаны Үндсэн хуулийн шүүхийн талаарх Үндсэн хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 15.

“Урьдчилсан дүгнэлтэд Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийн насны доод хязгаарыг 40-аас 45 болгон нэмэгдүүлэх талаар зарим нэг эргэлзээ төрж байна. Шинэчилсэн нэмэлт, өөрчлөлтөөр насны доод хязгаарыг 40 гэж буцааж байгаа бөгөөд Венецийн комиссын зүгээс энэ шийдлийг сайшааж байна. Венецийн комисс нь гадаадад эрдэм шинжилгээний болон мэргэжлийн ажил эрхэлж байсан эрдэмтэд, шүүгчдийг сонгон шалгаруулалтад оруулах боломжгүй болгосон “оршин суусан байх 20 жилийн шаардлага”-ын талаар эргэлзэж байгаагаа дахин илэрхийлж байна.»

CDL-AD(2015)027 2015 оны 9-р сарын 4-ний өдөр Үндсэн хуулийн комиссоос батлагдсан шүүхийн талаарх Украины Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд өгсөн санал, цогцолбор 26.

“Үндсэн хуулийн шүүхийн шүүгч Гүрж улсын “35 нас” хүрсэн иргэн байж болно (Төслийн 60.2 зүйл) гэсэн заалт нь улсын хамгийн дээд шүүхийн ийм чухал албан тушаалд нэлээд залуудахаар байна. Илүү урт хууль зүйн туршлагыг шаардах нь илүү сайн байх болно.”

CDL-AD (2017) 013 Гүрж - Үндсэн хуулийн шинэчилсэн төсөлд өгсөн санал, цогцолбор 77.

4.2 ХАВСАРЧ ҮЛ БОЛОХ АЖИЛ, АЛБАН ТУШААЛ

“Үндсэн хуулийн шүүхийн шүүгчдэд ихэвчлэн өөр ажил, албан тушаал хавсарч хийхийг зөвшөөрдөггүй. Энэ ерөнхий дүрэм нь шүүгчийг шүүхийн үйл ажиллагаанаас гаднах үйл ажиллагаанд оролцоноос үүдэлтэй нөлөөллөөс хамгаалах зорилготой юм. Заримдаа Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийн албан тушаал болон өөр ажил хоорондоо харшилж байгаа байдал нь тухайн цаг үедээ тухайн шүүгчид өөрт нь ч хүртэл анзаарагдахгүй байж болно. Тийнхүү харшлах байдлын талаарх хатуу заалтуудыг анхнаасаа оруулснаар иймэрхүү ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх боломжтой болно.”

“Харшлах нөхцөлийн талаарх хатуу шаардлагуудын нэг шүүмжлэл бол эдгээр шаардлагууд нь үндсэн хуулийн шүүхийн бүрэлдэхүүнийг тэтгэвэрт гарах нийгмийн бүлгийн гишүүдээс бүрдүүлэх хандлагатай байдаг гэх зүйл юм (...).”

CDL-STD(1997)020 Үндсэн хуулийн шүүхийн бүрэлдэхүүн – Шинжлэх ухаан болон Ардчиллын техник, no. 20 (1997), хуудас 15-16.

“Шүүгчийн шүүхээс гадуурх үйл ажиллагаанаас үүсэж болзошгүй аливаа нөлөөллөөс шүүгчийг ангид байлгахын тул дүрмүүд нь харьцангуй хатуу байх ёстой.”

CDL-STD(1997)020 Үндсэн хуулийн шүүхийн бүрэлдэхүүн – Шинжлэх ухаан болон Ардчиллын техник, no. 20 (1997), хуудас 21.

“13-р зүйлд Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийг тодорхой тохиолдолд (шүүгч нь тухайн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны холбогдогч, холбогдогч аль нэг талын хууль ёсны төлөөлөгч байх; холбогдогч талтай цусан төрлийн холбоо, гэрлэлтийн холбоотой байх, өөр шүүхийн шийдвэр байгаа бол гэх мэт) оролцуулахаас татгалзаж болно гэж заасан.

Эдгээр “харшлах” тохиолдлууд нь Үндсэн хуульд заагаагүй ч Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийн шударга байдлын чухал баталгаа учраас талархан хүлээж авч байна. Харшлах нөхцөл байдал үүссэн байж болохуйц тохиолдолд шүүгч өөрөө татгалзах нь нийтлэг байдаг. Өөрийн татгалзлыг 14 дүгээр зүйлд шууд зааж өгч болно. Түүнчлэн тус зүйлд шүүгчээс татгалзсан, эсхүл шүүгч өөрөө татгалзаагүй тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас шүүгчийг татгалзаж болохгүй”.

CDL-AD(2014)033 Монтенегрогийн Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 23.

11.6 дугаар зүйлд Үндсэн хуулийн шүүхийн шүүгч хэзээ ч “шүүх болон бусад хууль сахиулах байгууллагад хууль ёсны төлөөлөл” (өөрийн ойр дотнын хүмүүсийн эрх ашгийн төлөө байсан ч)-ийн үйл ажиллагаа явуулж болохгүй гэж өөрчлөлт оруулах хэрэгтэй.

CDL-AD(2014)017 Тажикстаны Үндсэн хуулийн шүүхийн талаарх Үндсэн хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 17-18.

“Гэхдээ, хуулийн төслийн 11.3 дугаар зүйл Үндсэн хуулийн шүүхийн шүүгч болохоос өмнөх хоёр жилд аливаа улс төрийн үйл ажиллагаанаас татгалзсан байх шаардлагыг өргөтгөж, (а) улс төрийн нам, эсхүл түүнтэй адилтгах байгууллагад гишүүн болон ямар нэгэн албан тушаал хашиж байсан, (б) төрийн болон орон нутгийн захиргааны байгууллагад нэр дэвшсэн буюу сонгогдсон, эсвэл (в) улс төрийн кампанит ажил болон бусад улс төрийн үйл ажиллагааг зохион байгуулсан, санхүүжүүлэхэд оролцож байсан хүнийг шүүгч болох боломжгүй болгосон. Венецийн Комисс Үндсэн

хуулийн шүүхийн шүүгчдийг улс төрийн сэдлээс ангид байлгах хүчин зүтгэлийг сайшааж байгаа ч, иргэдийн улс төрийн үйл ажиллагаа бол олон ургалч ардчиллын гол цөмд багтдаг бөгөөд үүнийг дэмжих хэрэгтэй. Үүнд, бүр ирээдүйд Үндсэн хуулийн шүүхийн шүүгч болох магадлалтай хүн байсан ч, улс төрийн намуудын дундах улс төрийн үйл ажиллагаа багтана.

Шүүхийн шударга байдлын хамгаалалт болон ардчилсан нийгэм дэх улс төрийн идэвхтэй оролцооны үнэ цэнэ гэсэн хоёр чухал зарчмыг өөр хооронд нь зохицолдуулах ёстой. Венецийн комиссын үзэж байгаагаар, намын энгийн гишүүнчлэлийг хасах нь бол ойлгомжтой, гурван жилийн хугацаанд улс төрийн чанартай үйл ажиллагаа явуулахгүй байх үүрэг хүртэл эдгээр зарчмуудын тэнцвэрийг хангаж чадаагүй байна. Энэхүү хязгаарлалтыг арилгах асуудлыг авч үзэх хэрэгтэй.”

CDL-AD(2016)034 Украин - Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 30–32.

“Үндсэн хуулийн шүүхийн шүүгч мөн улс төрийн үйл ажиллагаа явуулж болохгүй (Үндсэн хуулийн 164.7 дугаар зүйл). “Улс төрийн үйл ажиллагаа” гэж юуг ойлгох вэ гэдгийг энэ хуулийн төсөлд тодорхой тусгах ёстой.”

CDL-AD(2017)011 Армен - Үндсэн хуулийн шүүхийн талаарх Үндсэн хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 17.

4.3 ТОМИЛОХ / СОНГОХ АРГА ЗАМ

“Сонгуулийн тогтолцоо нь илүү ардчилсан төлөөллийг хангахад чиглэгдсэн бололтой. Гэхдээ, энэ тогтолцоо нь улс төрийн тохиролцоонд тулгуурладаг ба хэрэв сул орон тоо гарсан тохиолдолд хамгаалалт олгохгүй бол Үндсэн хуулийн шүүхийн институтийн тогтвортой байдалд аюул учруулж болзошгүй юм.”

CDL-STD(1997)020 Үндсэн хуулийн шүүхийн бүрэлдэхүүн – Шинжлэх ухаан болон Ардчиллын техник, но. 20 (1997), хуудас 7.

“Ерөнхийлөгч нь шууд сонгодог дагнасан томилгооны тогтолцооноос энэхүү сонгох буюу томилох эрхийг төрийн эрх мэдлийн гол 3 салбарт олгодог холимог тогтолцоо руу шилжих нь өмнөх тогтолцооныхоо амжилттай туршлага дээр үндэслэсэн байгаагийн зэрэгцээ, илүү ардчилсан легитм чанартай байна.”

CDL-AD(2004)024 Үндсэн хуулийн шүүхийн талаарх Туркийн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд өгсөн санал, цогцолбор 19.

“Үндсэн хуулийн дагнасан шүүхтэй орнуудад парламент шүүгчийн томилгоонд ихэвчлэн оролцдог. Үүний зорилго нь нийгэм дэх олон янзын чиг хандлагыг аль болох тусгасан Үндсэн хуулийн шүүхийн тэнцвэртэй бүрэлдэхүүнийг хангахад оршино (Үз.Үндсэн хуулийн шүүхийн бүрэлдэхүүн, ардчиллын шинжлэх ухаан болон техникийн тухай Венецийн комиссын тайлан, № 20). Гүйцэтгэх засаглалаас томилогддог тогтолцоо нь нийтлэг эрх зүй (common law)-ийн уламжлалтай орнуудад (жишээлбэл, Кипр) илүү түгээмэл байдаг. Үндсэн хуулийн шүүх нь маш эмзэг асуудлуудаас авхуулаад өргөн хүрээний асуудлыг шийдвэрлэх учраас түүний бүрэлдэхүүнийг, ялангуяа эхнийх нь, шүүх бол шударга арбитрч гэсэн итгэлийг нийгэмд төрүүлэхүйц байдлаар бүрдүүлэх ёстой.”

CDL-AD(2009)014 Палестины Үндсэн хуулийн дээд шүүхийн тухай хуулийн талаарх санал, цогцолбор 13.

“Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Үндсэн хуулийн дагуу Үндсэн хуулийн шүүхийн шүүгчдийг 3 өөр сувгаар сонгон шалгаруулдаг. Тухайлбал, Украины Ерөнхийлөгч, Украины Дээд Рада болон Украины Шүүгчдийн Конгресс тус бүр зургаан шүүгчийг Украины Үндсэн хуулийн шүүхэд томилдог. Төсөлд зааснаар Үндсэн хуулийн шүүхийн шүүгчдийг Ерөнхийлөгчийн өргөн мэдүүлснээр, Украины Дээд Радын нийт гишүүдийн гуравны хоёрын саналаар томилохоор байна. Өөр нэг тохиолдолд, Венецийн комисс Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийг Ерөнхийлөгч шууд томилдог дагнасан тогтолцооноос эрх мэдлийн гол 3 салбараас сонгох буюу томилдог холимог тогтолцоонд шилжсэнийг сайшаан хүлээн авсан. Учир нь энэ тогтолцоо бол илүү ардчилсан легитм чанартай юм. Харин эсрэгээрээ буюу дээрх тогтолцоог халж, Ерөнхийлөгч нэр дэвшигчдийн дундаас санал болгож, парламент сонгодог тогтолцоо руу шилжихийг, хэдийгээр иймэрхүү шийдэл нь бусад орнуудад хүлээн зөвшөөрөгдөж, ашиглагдаж байгаа ч гэсэн, сайшаахгүй байна. Түүнчлэн, Украины өнөөгийн нөхцөлд байдлаас үзвэл, энэхүү санал болгож буй систем нь гацаанд амархан орж болзошгүй байх бөгөөд санал оруулах монополт байдал нь Ерөнхийлөгчид маш их эрхийг олгож байна.»

CDL-AD(2009)024 Украины Ерөнхийлөгчийн өргөн мэдүүлсэн Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 97.

“Шүүхийн бүх шүүгчдийг Ерөнхийлөгчийн санал болгосноор парламентаас сонгодог тогтолцоо нь “Шүүхийн бүрэлдэхүүнийг тэнцвэртэй болгохгүй”. Тодруулбал, “Хэрвээ ерөнхийлөгч олонхын намын аль нэгнээс нь гарч ирсэн бол, шүүхийн бүх шүүгчид улмаар тухайн олонх намын талд элэгтэй байх магадлалтай. Шүүхийн бүх шүүгчдийг парламентаас сонгоход дор хаяж дийлэнх олонхын санал авах шаардлагатай.» Ерөнхийлөгчөөс сонгодог сонгуулийн тогтолцоог Шүүхийн өөрийнх нь мэдэлд үлдээх нь зүйтэй гэж Венецийн комисс мөн онцолж байна.”

CDL-AD(2011)010 Монтенегрогийн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хуулийн төсөл, түүнчлэн Шүүхийн тухай хууль, Улсын Прокурорын тухай хууль, Шүүхийн зөвлөлийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хуулиудын төсөлд санал, цогцолбор 27.

“Томилгооны талаар ямар ч тодорхой шалгуур байхгүйгээр дээрх процесст Ерөнхийлөгч, Парламент хоёрыг оролцуулах нь Шүүгчдийн оролцоо хийгээд шүүгчдийн сонгон шалгаруулалтын талаарх Шүүхийн зөвлөл дэх эсэргүүцлээс үл хамааран, томилгоог гарцаагүй улстөржүүлэхээр харагдаж байна. Шүүгчийн албан тушаалд нэр дэвшигчийг парламент сонгоогүй тохиолдолд Ерөнхийлөгч шинэ өрсөлдөөнт сонгон шалгаруулалтын үндсэн дээр шинэ нэр дэвшигчийг өргөн мэдүүлнэ.”

CDL-AD(2011)017 Киргизийн “Шүүгчийн статусын талаарх” Үндсэн хуульд өөрчлөлт оруулах танилцуулгад өгсөн санал, цогцолбор 37.

“Нэмэлт өөрчлөлтөөр 85 дугаар зүйлээс Парламентад шүүгчийг бүх насаар нь сонгох бүрэн эрхийг олгосон заалтыг хассан. Харин үүний оронд парламентын бүрэн эрх нь Украины Ерөнхийлөгчийн санал дээр үндэслэн ерөнхий харьяаллын шүүхийн тогтолцоо, шүүх байгуулах, өөрчлөн зохион байгуулах, татан буулгах асуудлыг шийдвэрлэхээр болсон. Энэхүү нэмэлт, өөрчлөлт нь 106(23) дугаар зүйлд (Ерөнхийлөгч) “Шүүхийн дээд зөвлөлийн хүсэлтийн дагуу шүүгчдийг албан тушаалд нь томилж, чөлөөлнө” гэж орсон өөрчлөлтийн логик үр дагавар юм. Венецийн комисс энэхүү Ерөнхийлөгчийн ёслолын шинжтэй эрх мэдлийг сайшааж байна.

Хуулийн 85 болон 106 дугаар зүйлд орсон эдгээр өөрчлөлтүүд нь эрх мэдлийн хуваарилалтын зарчимд нийцэж байгаа бөгөөд шүүхийн хараат бус байдлыг хангах зорилготойгоор хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн тэнцвэр, хамтын ажиллагааг бататгаж байна. Шүүхийн бүтцийг бий болгох, шүүгчдийг томилгоог хийхэд Дээд шүүхийн санал дээр үндэслэн оролцож

байгаа Парламент болон Ерөнхийлөгчийн бүрэн эрх нь шүүх эрх мэдэлд үзүүлэх улс төрийн нөлөөлөл хийгээд намын шахалтыг хязгаарлахад чиглэсэн.

(...)

Өөр нэг асуудал бол шүүгчийг томилох эрх бүхий байгууллагатай холбогдоно. Венецийн комисс “Энгийн (үндсэн хуулийн бус) шүүхийн шүүгчийн томилгоо нь Парламентын санал хураалтаар шийдвэрлэхэд тохиромжгүй асуудал гэдгийг онцолсон. Учир нь нэр дэвшигчийн объектив чадваруудаас илүү улс төрийн үзэл бодлыг харгалзах байдал давамгайлж авч үзэх аюулыг арилгаж чадахгүй юм. Шүүгчийн томилгоо дахь Парламентын оролцооноос зайлсхийхийн тулд Үндсэн хуулийн 128 дугаар зүйлд өөрчлөлт оруулах шаардлагатай гэдгийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй.”¹

Энэхүү саналыг харгалзан үзсэн бөгөөд нэмэлт, өөрчлөлтүүд 106 болон 128 дугаар зүйлд «Шүүгчийн томилгоог хязгааргүй хугацаагаар Улсын дээд шүүхийн саналын дагуу Украины Ерөнхийлөгч хийнэ» гэсэн шинэ зохицуулалтыг санал болгож байна. Одоогийн Үндсэн хуулиар шүүгч томилох бүрэн эрхийг Ерөнхийлөгч (5 жилийн хугацаагаар) болон Парламент (хязгааргүй хугацаагаар) хамтдаа хуваалцан хэрэгжүүлж байна. Шинэ саналын дагуу, Парламентын оронд шийдвэрийг Ерөнхийлөгч гаргах бөгөөд Ерөнхийлөгч шүүгчийг Улсын дээд шүүхийн заавал биелүүлэх шинжтэй саналын үндсэн дээр хугацаагүйгээр томилохоор болсон. Энэхүү заалтаар дээрх Ерөнхийлөгчийн гүйцэтгэх үүрэг нь ёслолын шинжтэй болсон бөгөөд энэ нь сайшаалтай хэрэг юм”.

CDL-AD(2013)014 Шүүгчийн хараат бус байдлыг бэхжүүлэх Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн тухай хуулийн төсөл (тайлбар, хүснэгт багтсан) болон Украины Үндсэн хуулийн ассамблейгаас өргөн мэдүүлсэн Үндсэн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 11-13, 28-29.

“6 дугаар зүйлд Үндсэн хуулийн шүүхийн шүүгчдийг сонгох талаар зохицуулсан Үндсэн хуулийн шинэ дүрмүүд тогтоож хүчин төгөлдөр болсон. Монтенегро улсын Ерөнхийлөгч болон “Парламентын холбогдох ажлын хэсэг” (хамтад нь “санал оруулагч нар” гэх) нэр дэвшигчдийн сонгон шалгаруулалтын тухай нийтэд зарладаг. Үндсэн хуулийн 153 дугаар зүйлд

¹ Украины Шүүхийн тухай болон Шүүгчдийн статусын тухай хуулиудын төсөлд өгсөн санал, Венецийн комиссын 70 дах их хурлаар батлагдсан (Венец, 2007 оны 3 сарын 16-17), CDL-AD(2007)003, цогцолбор 29-г үз.

зааснаар шүүгчдийн сонгон шалгаруулалтад оролцох нэр дэвшигч нь 40 нас хүрсэн, хуульчийн мэргэжлээр 15 жил ажилласан “нэр хүндтэй хуульч” байх ёстой. Нэр дэвшигчдийн жагсаалтыг санал оруулагч нар өөрсдийн цахим хуудсандаа нийтэлж, арав хоногоос доошгүй хугацаанд олон нийтэд нээлттэй байлгах ёстой. Сонгон шалгаруулалтад оролцоход тавигдах шаардлагыг хангасан нэр дэвшигчдээс санал оруулагч нар ярилцлага авах бөгөөд, санал оруулагч (бичгэн) нотлох баримт болон дээрх ярилцлага дээр тулгуурлан Парламентад үндэслэл бүхий санал бэлтгэж өгдөг. Уг санал нь “Цөөнхийн болон бусад цөөнх үндэстний пропорциональ төлөөлөл, жендерийн тэнцвэртэй төлөөлөл”-ийг харгалзан үзэх ёстой. Хувь нэр дэвшигч нь нэр дэвшүүлэгчийн аль алиных нь нийтийн зарлалд өргөдөл гаргаж болно. Ийм тохиолдолд санал оруулагч нар саналаа нэгтгэх ёстой.

Нэг хүн Үндсэн хуулийн шүүхийн Ерөнхийлөгч, эсхүл шүүгчээр нэг удаа сонгогдож болно. Парламент дахь анхны санал хураалтад Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийг нийт депутатуудын гуравны хоёрын, хоёр дахь санал хураалтад нийт депутатуудын тавны гурвын олонхын саналаар сонгоно. Үндсэн хуулийн шүүхийн даргыг Үндсэн хуулийн шүүхийн шүүгчид бүрэлдэхүүн дундаасаа өөрсдөө сонгодог. Энэхүү механизм нь ил тод байдлыг баталгаажуулж, олон нийтийн Үндсэн хуулийн шүүхэд итгэх итгэлийг нэмэгдүүлж байгаа ч цаашид улам сайжруулах боломжтой. 2013 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн зорилго нь Үндсэн хуулийн шүүхийн бүрэлдэхүүнийг тэнцвэртэй байдлыг хангах явдал байв. Тиймээс Үндсэн хуулийн шүүхийн тухай хуульд “Парламентын эрх бүхий ажлын хэсэг”-ын бүрэлдэхүүнд улс төрийн бүх намын төлөөллийг оролцуулахаар тодорхой зааж өгөхийг зөвлөсөн.

Үндсэн хуулийн 153 дугаар зүйлд заасан “нэр хүндтэй хуульч” гэж хэн бэ гэдгийг жишээлбэл, 15-аас доошгүй жилийн ажлын туршлагатай хуулийн профессор, өндөр хэмжээний энгийн болон захиргааны албан хаагч, хуульч гэх мэтээр тодорхой зааж өгөх нь зүйтэй. Мөн 6 дугаар зүйлд сул орон тоо гарахаас хэдий хугацааны өмнө сонгон шалгаруулалтын зарлалыг нийтэд зарлавал тохиромжтой талаарх эцсийн хугацааг зааж өгөх хэрэгтэй. Төслийн 10.3 зүйлд Шүүх нэр дэвшүүлэгчид удахгүй тэтгэвэрт гарах байдлын талаар зургаан сарын өмнө мэдэгдэх ёстой гэж заасан боловч, санал оруулагч дээрх мэдээллийн дагуу арга хэмжээ авах сүүлийн хугацаа зааж өгөөгүй.”

CDL-AD(2014)033 Монтенегрогийн Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 12-16.

“Хачирхалтай нь, хороодын нийт гишүүдийн тоонд тавигдах шаардлага байхгүй байх бөгөөд гишүүдийн үлдсэн хагасыг сонгон шалгаруулах шалгуур үзүүлэлт зохицуулагдаагүй. Тиймээс шүүгчийн мэргэжлийн ур чадвараас өөр зүйлд тулгуурласан үзүүлэлтээр хүмүүсийг сонгох эрсдэлтэй байна. Түүнчлэн шүүхийн нээлттэй сул орон тоо тус бүр дээр эдгээр хороод нь солигдохгүй байнгын байх уу, эсхүл ad hoc хэлбэрээр байгуулагдах уу гэх талаар ч мөн дүрэм байхгүй. Хуулийн төсөлд комиссын гишүүдийн хоёр дахь талын мэргэшлийн зэрэг, мөн ямар нэгэн дарамт шахалтаас зайлсхийхийн тулд хороод хэрхэн байгуулагдах талаар тодорхой зохицуулалтуудыг оруулах хэрэгтэй.”

CDL-AD(2016)034 Украин - Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 14.

“Зарчмын хувьд, шүүгчдийн томилгоо болон мэргэжлийн карьертай холбоотой асуудлууд, тэр дундаа шүүх эрх мэдлийн хамгийн дээд албан тушаалд очих томилгооны асуудлын талаарх бүх шийдвэрүүд, хуульд заасан урьдчилан тодорхойлсон объектив шалгуурыг баримталсан мерит буюу чадварын тогтолцоо, мөн нээлттэй хийгээд ил тод журам дээр суурилах хэрэгтэй. Бүгд Найрамдах Киргиз улсын үндсэн хуулийн шүүхийн шүүгчийг оролцуулаад ердийн шүүхийн шүүгчдийн томилгооны процесс, албан тушаал ахиулах асуудал дах бие даасан шүүхийн зөвлөл эсвэл түүнтэй адилтгах бие даасан өөрийн зохион байгуулалт бүхий байгууллагуудын оролцоо, шийдвэрлэх нөлөөлөл нь ерөнхийдөө шүүх эрх мэдлийн хараат бус байдлыг хамгаалахад тохиромжтой арга гэж бодогдож байна. ЕАБХАБ/Ардчилсан Институт болон Хүний эрхийн төлөөх оффисын Киевийн зөвлөмжид (2010) зөвлөсний дагуу, шүүгчийн эцсийн томилгоо ерөнхийлөгчийн мэдэлд байгаа тохиолдолд түүний томилох энэхүү эрх нь хараат бус сонгон шалгаруулах байгууллагаас дэвшүүлсэн нэр дэвшигчдээр хязгаарлагдах ёстой. Ийм нэр дэвшигчийг томилохоос татгалзах нь зөвхөн маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны дэгд үндэслэсэн байх ёстой бөгөөд (агуулгын хувьд) үндэслэлтэй байх шаардлагатай. Өөр нэг боломжит хувилбар бол сонгон шалгаруулалт хийх байгууллагад түүний дийлэнх олонхын саналаар Ерөнхийлөгчийн хоригийг хүчингүй болгох эрхийг олгох явдал юм. Үндсэн хуулийн шүүхийн танхимын шүүгчдийн томилгооны тогтолцооны талаар

Ерөнхийлөгчид ихээхэн эрх мэдлийг олгосон дээрх санал нь эрх мэдлийн хуваарилалт болон үр дүнтэй хяналт, тэнцвэрийг хангах талаасаа ихээхэн асуудалтай байна. Дээд шүүхийн шүүгчдийн томилгоотой холбоотой төстэй коментууд мөн хамаарна (Дээр 4.2 дэд хэсгийг харна уу). Дээд шүүх болон Үндсэн хуулийн шүүхийн танхимын шүүгчдийг томилох журмыг илүү нээлттэй, ил тод байдлыг хангахуйцаар (энэ нь Шүүгчдийн зөвлөлийн оролцоог нэмэгдүүлэх асуудлыг хамарна) өөрчлөлт оруулахыг хүчтэй зөвлөж байна.”

CDL-AD(2016)025 Бүгд Найрамдах Киргиз Улсын “Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн танилцуулга”-ын тухай хуулийн төсөлд өгсөн нэгдсэн санал, цогцолбор 52.

“12 дугаар зүйлд Үндсэн хуулийн шүүхийн гишүүдийг Ерөнхийлөгчийн шийдвэрээр томилно гэж заасан. Хэдийгээр энэ нь хуулиар олгогдсон эрх мэдэл байсан ч, энэ дүрэм бусад хоёр байгууллагаас сонгогдсон нэр дэвшигчдийг бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь Ерөнхийлөгчийн зүгээс саад учруулах эрсдэлийг (жишээлбэл, тэдний чадварын талаар эсэргүүцэл дэвшүүлэх замаар) агуулж байна. Тиймээс, бусад хоёр байгууллагаас хийсэн нэр дэвшигчийн сонгон шалгаруулалт нь Ерөнхийлөгчийн шийдвэргүйгээр шууд тангараг өргөхөөр үргэлжлэх хэрэгтэй.”

[...]

14 дүгээр зүйлд Үндсэн хуулийн шүүхийн гишүүд Ерөнхийлөгчийн өмнө тангараг өргөнө гэж заасан. Энэ нь Ерөнхийлөгчид Шүүхийн гишүүд албан тушаалдаа орохоос урьдчилан сэргийлэх, хойшлуулах боломжийг олгодог. Арай өөрөөр буюу нэр дэвшигчид өөрсдийг нь сонгосон байгууллагын өмнө тангараг өргөх боломжтой юм.”

CDL-AD(2015)024 Тунисийн Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн төслийн талаарх санал, цогцолбор 25, 27.

“Шүүгч, Прокурорын зөвлөлийн гишүүдийг томилох арга замын талаарх өөрчлөлтүүд нь Үндсэн хуулийн шүүхэд тооцоолоогүй сөрөг үр дагавар үзүүлэхээр байна. Шүүгч, Прокурорын зөвлөл нь Давж заалдах шатны шүүх болон Төрийн зөвлөлийн гишүүдийн сонгуулийг хариуцдаг. Хоёр шүүхийн аль аль нь холбогдох албан тушаал тус бүрд гурван нэр дэвшигчийг Ерөнхийлөгчид санал болгох замаар (Ерөнхийлөгч томилгоог хийдэг) Үндсэн хуулийн шүүхийн хоёр гишүүнийг сонгох эрхтэй байдаг. Тиймээс Гүйцэтгэх засаглалын Үндсэн хуулийн шүүхэд үзүүлэх нөлөө нэмэгдсэн байна.”

CDL-AD(2017)005 2017 оны 1 дүгээр сарын 21-ний өдөр Үндэсний Их Хурал баталж, 2017 оны 4 дүгээр сарын 16-ны өдөр бүх нийтийн санал асуулгад оруулах Туркийн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд өгсөн санал, цогцолбор 121.

“Энэ хуулийн төслийн зарим заалтыг нэлээд нарийвчлан авч үзвэл, Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийг томилох тухай Үндсэн хуулийн зүйл заалтыг /Үндсэн хуулийн 166.9/ нэмэн дэлгэрүүлсэн заалт байхгүй байгааг гайхаж магадгүй. Тухайлбал, Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийг Үндэсний Их Хурал сонгох талаар; Үндсэн хуулийн шүүх нь есөн шүүгчээс бүрдэх ба тэдгээрийн гурвыг нь Ерөнхийлөгчийн санал оруулснаар, гурвыг нь Засгийн газрын санал оруулснаар, гурвыг нь Шүүхийн Ерөнхий Ассамблейн санал оруулснаар сонгох (Үндсэн хуулийн 166.1 дугаар зүйл) талаар юу ч байхгүй. Эдгээр томилгооны журмыг Үндсэн хуульд тодорхойлохгүй орхисон тэр хэмжээгээр Үндсэн хуулийн шүүхийн тухай хуульд тодорхойлох хэрэгтэй.”

CDL-AD(2017)011 Армен - Үндсэн хуулийн шүүхийн талаарх Үндсэн хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 14.

4.3.1 Сонгуулийн дийлэнх олонхын саналаар сонгох

“Үндсэн хуулийн шүүхийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах, Үндсэн хуулийн шүүхийн шүүгчдийг томилох журам нь Үндсэн хуулийн шүүн таслах ажиллагааны хувьд, мөн түүнчлэн Үндсэн хууль дээдлэх ёс бүхий найдвартай тогтолцоог хадгалахад хамгийн чухал бөгөөд эмзэг асуудлын нэг юм. Үндсэн хуулийн шүүхийн шүүгчдийн хараат бус байдал болон тэдгээрийн томилгооны процесст төрийн янз бүрийн байгууллага, улс төрийн хүчнийг оролцуулж байх боломжийг хангаж байх зайлшгүй хэрэгтэй. Ингэж чадвал, шүүгчид нь аль нэг улс төрийн хүчний хэрэглүүр гэж ойлгогдохгүй юм. Тухайлбал, Германы Үндсэн хуулийн шүүхийн тухай хуульд (Bundesverfassungsgerichtsgesetz) шүүгчдийг парламентын гуравны хоёрын олонхын саналаар сонгох журмыг заасан байдаг нь ийм учиртай. Энэхүү шаардлага нь Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийн албан тушаалд нэр дэвшиж буй этгээдийн талаар сөрөг хүчинтэй тохиролцох явдлыг хангах зорилготой. Тус дүрмийг хэрэгжүүлж буй Германы энэхүү туршлага бол хүлээлтэд их хүрч байгаа. Германы Үндсэн хуулийн шүүхийн талаарх олон нийтийн ихээхэн хүндлэл нь тус шүүхийн шүүгчдийг томилох дээрх журмаас шалтгаалдаг. Хуулийн төсөлд шүүгчдийг нэр дэвшүүлэх ажиллагаанд өргөн хэмжээний улс төрийн хүрээллийг хамруулах талаар тусгавал зохимжтой байх болов

уу. Одоогийн байдлаар Үндсэн хуульд ч, Үндсэн хуулийн шүүхийн тухай хуульд ч Парламентаас сонгогдох хоёр шүүгчдийг томилоход дийлэнх олонхын саналыг тусгаагүй байна.”

CDL-AD(2004)043 Бүгд Найрамдах Молдова улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай саналд өгсөн санал (Үндсэн хуулийн шүүхэд хувь хүний гаргасан гомдлыг нэвтрүүлэх), цогцолбор 18-19.

“Парламент шүүгчдийг энгийн олонхын саналаар сонгодог учраас шүүгчдийн сонгуулийн өмнөх журам нь шүүгчдийн мэргэжлийн өндөр түвшнийг хангаж байх үүднээс аль болох ил тод байх ёстой.”

CDL-AD(2008)030 Монтенегро улсын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 19.

“[Үндсэн хуулийн] шүүхийн гишүүдийг сонгох бүх шатны санал хураалтад дийлэнх олонхын санал авагдах хэрэгтэй.”

CDL-AD(2011)040 Туркийн Үндсэн хуулийн шүүхийн байгуулал, процедурын тухай хуулийн талаарх санал, цогцолбор 24.

“[Шүүгчдийн] сонгуулийн арга хэлбэр, ялангуяа гацаанаас сэргийлэх механизмуудын талаар Үндсэн хуулийн хэлэлцэгдэж буй гурван зүйл заалтад алтернатив саналууд орсон.

Венецийн комиссын зүгээс төрийн байгууллагуудын үйл ажиллагааг баталгаажуулахын тулд гацаанаас сэргийлэх механизмуудыг бий болгохын чухлыг ахин дахин онцолж байсан. Дийлэнх олонхын санал бол олонх нь цөөнхтэй зөвшилцөхийг шаарддаг тул парламентад өргөн хэмжээний зөвшилцөл бий болох нөхцөлийг хангахыг зорьдог. Ийм учраас хамгийн эмзэг салбаруудад, тэр дундаа төрийн байгууллагад алба хаах албан тушаалтнуудын сонгуульд ерөнхийдөө дийлэнх олонхын саналыг шаардаж байдаг. Гэхдээ, дийлэнх олонхын саналд хүрэх гэсэн шаардлага нь аливаа мухардлыг бий болгож, үүнийг цаг тухайд нь зохих ёсоор шийдвэрлэхгүй бол, холбогдох байгууллагуудын үйл ажиллагааг саажилтад оруулах эрсдэлтэй. Гацаанаас сэргийлэх механизм нь ийм мухардлаас зайлсхийх зорилготой. Гэсэн хэдий ч гацаанаас сэргийлэх механизмын үндсэн үүрэг бол тус механизмаас зайлсхийхийн төлөө олонх болон цөөнхийг аль алиныг нь зөвшилцөлд хүргэхээр тулгах замаар анхны процедурыг хэвийн болгох явдал юм. Үнэндээ дийлэнх олонхын саналууд нь, гацаанаас сэргийлэх механизмууд тэнцвэрийг буцааж засаж байхад, парламентын цөөнхийн

байр суурийг бэхжүүлж байдаг. Ийм механизмууд нь юун түрүүнд дийлэнх олонхын саналын үндсэн дээр зөвшилцөлд хүрэхэд саад болохгүй байхаар ажиллах хэрэгтэй нь ойлгомжтой. Хэрвээ гацаанаас сэргийлэх механизм нь олонх болон цөөнхийн аль алинд нь тааламжгүй байх юм бол энэ нь зөвшилцлийг дэмжих үр дүнтэй процесс байж болох юм.

Венецийн комиссын зүгээс, гацаанаас сэргийлэх тохиромжтой, үр дүнтэй механизмуудыг бий болгоход их бэрхшээлтэй гэдгийг сайтар ойлгодог. Учир нь бүх зүйлд тохирохуйц цор ганц модель буюу загвар байдаггүй. Боломжит нэг хувилбар нь дараа дараагийн шатны санал хураалтуудад шаардлага бүхий олонхын саналын тоог өөрөөр, илүү буурсан байдлаар тогтоож болох юм. Гэвч, энэ тохиолдолд олонх дараагийн шатны санал хураалтад өөрийн нэр дэвшигчээ ялна гэдгийг мэдэх учраас эхний шатанд зөвшилцөлд хүрэх гэж тийм ч их хичээхгүй байх гэсэн сул талтай. Бусад хувилбарууд, магадгүй арай илүү нь, санал хураалтын пропорциональ аргыг ашиглах, янз бүрийн институтын оролцогчдыг оролцуулах эсвэл төрийн байгууллагуудын хооронд шинэ харилцаа холбоог тогтоох зэрэг ордог. Улс бүр өөр өөрийн гэсэн хэлбэрийг бодож олох ёстой.»

CDL-AD(2013)028 Монтенегрогийн Үндсэн хуулийн шүүх, Улсын дээд прокурор, Шүүхийн зөвлөлтэй холбоотой Үндсэн хуулийн гурван заалтад нэмэлт, өөрчлөлт оруулах төсөлд өгсөн санал, цогцолбор 5-8.

“Одоо үйлчилж буй Үндсэн хуулийн дагуу Үндсэн хуулийн шүүхийн шүүгчдийг Ерөнхийлөгчийн санал болгосноор, ямар нэгэн дийлэнх олонхын санал шаардахгүйгээр Парламентаас тодорхой бүрэн эрхийн хугацаатайгаар сонгож, чөлөөлдөг. Энэ талаар Венецийн комисс өмнө нь, ийм арга хэлбэр бүхий сонгууль нь Үндсэн хуулийн шүүхийн хараат бус байдалд ноцтой хохирол учруулж байна гэж мэдэгдэж байсан. Учир нь тус сонгууль нь Үндсэн хуулийн шүүхийн тэнцвэртэй бүрэлдэхүүнийг хамгаалаагүй, түүнчлэн энэ нь олон улсын стандартуудтай нийцэхгүй байгаа юм. Тиймээс Венецийн Комиссын зүгээс, хэрэв Үндсэн хуулийн шүүхийн шүүгчдийг Парламентаас сонгох бол шүүгчдийг сонгох сонгууль нь гацаанаас сэргийлэх механизмын хамтаар Парламентын гуравны хоёрын саналаар сонгодог байх, мөн Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийн бүрэн эрх хугацаагүй байх хэрэгтэй гэж зөвлөж байсан (CDLAD). (2007)047, §§ 122,123; CDL-AD(2012)024, §35). Мөн Комиссын зүгээс, [шүүгчдийг] “зөвхөн парламентаас сонгодог” загвар нь ардчилсан өндөр легитим чанарыг хангадаг хэдий ч, Үндсэн хуулийн

шүүхийн шүүгчдийг төрийн янз бүрийн институтуудээс томилох нь шүүгчдийн тодорхой хэсгийг улс төрийн хүчнүүдээс томилох явдлаас сэргийлдэг давуу талтай гэдгийг дурдаж байсан (CDL-AD 2012)009, § 8).

Хуулийн төслийн 153 дугаар зүйлд Үндсэн хуулийн шүүгчдийг Монтенегро улсын Ерөнхийлөгч (хоёр нэр дэвшигчийг) болон парламентын холбогдох хорооны (таван нэр дэвшигчийг) саналыг үндэслэн Парламент гуравны хоёрын олонхын саналаар томилж, чөлөөлөхөөр заасан байна. Венецийн Комиссын зүгээс идэвхтэй санал болгосоор ирсэнчлэн, энэхүү дийлэнх олонхын саналын шаардлага нь тун сайшаалтай юм.

Гацааны эсрэг механизмын хувиар хоёр дахь шатны санал хураалтыг хоёр хувилбартайгаар санал болгож байна: а) Парламентын нийт гишүүдийн олонхын саналаар эсхүл б) Парламентын тавны гурвын саналаар. Венецийн комисс хоёр дахь хувилбарыг илүү гэж үзэж байна. Учир нь эхний хувилбар нь Парламентын олонх цөөнхтэйгөө тохиролцоонд хүрэхэд түлхэц болохгүй, мөн эрх баригч намд хамаарал бүхий таван гишүүнийг сонгох боломж үлдээх болно.

CDL-AD(2013)028 Монтенегрогийн Үндсэн хуулийн шүүх, Улсын дээд прокурор, Шүүхийн зөвлөлтэй холбоотой Үндсэн хуулийн гурван заалтад нэмэлт, өөрчлөлт оруулах төсөлд өгсөн санал, цогцолбор 21-23.

“148-р зүйлд Дээд Радаас томилогдсон [Үндсэн хуулийн шүүхийн] 6 гишүүнийг дийлэнх олонхын саналаар сонгох талаар тусгаагүй. [Дийлэнх олонхын саналаар сонгохгүй байх] энэхүү боломжит нөхцөлийн талаар Украины Үндсэн хуулийн комисс анхааралдаа авах хэрэгтэй. Учир нь Украинд Ерөнхийлөгч нь улс төрийн хувьд төвийг сахисан институт биш, түүнчлэн улмаар арван хоёр шүүгчийг нэг улс төрийн олонхоос сөрөг хүчинд ямар ч үг хэлэх бололцоогүйгээр сонгох нөхцөл байдал үүсэж магадгүй юм. Гэхдээ, Венецийн комисс Украины өнөөгийн улс төрийн нөхцөл байдалд дийлэнх олонхын саналыг авах нь хүндрэлтэй байгааг ухамсарлаж байна.»

CDL-AD(2015)027 2015 оны 9-р сарын 4-ний өдөр Үндсэн хуулийн комиссоос батлагдсан шүүхийн талаарх Украины Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд өгсөн санал, цогцолбор 25.

“Харьцуулан үзэхэд, шүүгчийг сонгоход шаардагдах олонхын санал нь нэгээхэн асуудал болж байна. Бүгд Найрамдах Словак улс болон бусад зарим оронд шүүгчдийг Парламентаас энгийн олонхын саналаар сонгодог хэдий ч, Үндсэн хуулийн шүүгчдийг дийлэнх олонхын саналаар сонгох

нь шүүгчийн сонгуулийн үйл явцыг улс төрөөс ангид байлгах боломжийг олгодог. Учир нь дийлэнх олонхын саналыг шаардах нь сөрөг хүчин ч гэсэн сонгуулийн үйл явцад чухал байр суурь эзлэх нөхцөлийг бүрдүүлдэг. Дийлэнх олонхын санал нь олонх болон сөрөг хүчний хооронд мухардмал байдал бий болгох болзошгүй нь үнэн боловч үүнийг гацаанаас сэргийлэх тодорхой механизмаар даван туулж болно.

Харьцуулсан үүднээс авч үзвэл, Бүгд Найрамдах Словак улсын Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийн албан тушаалд нэрдэвшигчдийг сонгох сонгуульд гацаанаас сэргийлэх зохих механизмын хамтаар дийлэнх олонхын саналыг нэвтрүүлэх талаар нухацтай авч үзэхийг Венецийн комисс зөвлөж байна.»

CDL-AD (2017)001 Бүгд Найрамдах Словак Улсын Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийн томилгоотой холбоотой асуултын талаарх санал, цогцолбор 58-59.

“...Үндсэн хуулийн шүүхийн гурван шүүгчийг Парламентаас энгийн олонхын саналаар сонгодог асуудалд (125 дугаар зүйлийг Үндсэн хуулийн 78.1 зүйлтэй харьцуул) анхаарал хандуулах хэрэгтэй. Европын үндсэн хуулийн туршлагаас үзэхэд, зөвхөн олонхын сонгосон сонголт бус улс төрийн намуудын олон ургалч үзэл баримтлалаар дэмжигдсэн сонголт хийх боломжийг хангах үүднээс Үндсэн хуулийн шүүхийн шүүгчдийг Парламентаас дийлэнх олонхын саналаар сонгох явдал ихэнхдээ дэмжигддэг. Энэ нь Ерөнхийлөгч, Парламент хоёр улс төрийн ижил өнгөтэй, мөн шүүгчдийн 2/3-ыг нэгэн зэрэг томилж болох үед онцгой ач холбогдолтой. Үндсэн хуулийн шүүхийн шүүгчдийг үе шаттайгаар солих тухай шилжилтийн зохицуулалтаас үзвэл (179.1 зүйлийг үз) энэ эрсдэл нь ердийн нөхцөлд тийм ч өндөр биш юм...”

CDL-AD(2016)009 Албанийн шүүхийн талаарх Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн шинэчилсэн төсөлд өгсөн эцсийн дүгнэлт, 37-р зүйл.

“Дийлэнх олонх буюу олонхын саналын гуравны хоёрт хүрэх нь хэцүү бөгөөд энэ нь заримдаа, ялангуяа улс төрийн хүчнүүдийн дунд ардчилсан зөвшилцөлд хүрэх хангалттай соёл байхгүй тохиолдолд гацалт, мухардалд хүргэж болзошгүйг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Ийм нөхцөл байдлаас зайлсхийхийн тулд “гацаанаас сэргийлэх механизм”-ийг, тухайлбал гурав дахь санал хураалт амжилтгүй болсны дараа шаардлагатай олонхын саналын тоог тавны гурав болгон бууруулах, /эсвэл хэд хэдэн амжилтгүй санал хураалтын дараа төвийг сахисан өөр байгууллагуудаар нэр дэвшигчдийг томилох зэрэг аргуудыг нэвтрүүлэх хэрэгтэй.”

CDL-AD(2015)024, Тунисийн Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн төслийн талаарх санал, цогцолбор 21.

“Үндсэн хуулийн шүүхийн гурван шүүгчийг (нийт 9 шүүгч) Парламентын нийт гишүүдийн олонхын саналаар сонгоно. Хуулийн төсөлд [шүүгчийг] нэр дэвшүүлэх журамд улс төрийн өргөн хүрээллийг хамруулах талаар тусгавал зохимжтой байна. Парламентаас сонгогдох гурван шүүгчийг томилохдоо дийлэнх олонхын саналыг шаардахаар тусгах нь зүйтэй болов уу. Мөн Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийг Парламентаас томилох журамд аливаа гацааг арилгах тохиромжтой механизмыг оруулж болох юм. Үндсэн хуулийн шүүхийн шүүгчдийн мэргэжлийн өндөр түвшнийг хангахын тулд сонгуулийн өмнөх үйл ажиллагаа аль болох ил тод байх ёстой.”

CDL-AD(2017)013, Гүрж - Үндсэн хуулийн шинэчилсэн төсөлд өгсөн санал, цогцолбор 74.

“Өмнөх зөвлөмжийн дагуу хуулийн төслийн 60.2 зүйлд Үндсэн хуулийн шүүхийн гурван шүүгчийг Парламентаас дийлэнх олонхын саналаар сонгох шаардлагыг нэвтрүүлсэн: “Гурван шүүгчийг Парламент бүрэн бүрэлдэхүүний тавны гурвын саналаар сонгоно (...)”. Энэ нь сайшаалтай юм.»

CDL-AD(2017)023 Гүржийн парламентын хоёр дахь хэлэлцүүлгээр баталсан Үндсэн хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд өгсөн санал, цогцолбор 43.

4.3.2 Процедур

“Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийг томилох журмыг зөрчсөн эсэх шийдвэр (14.7.7-р зүйл)-ийг ердийн шүүх биш, Үндсэн хуулийн шүүх өөрөө (тухайн шүүгчийн оролцоогүйгээр) гаргах хэрэгтэй. Ер нь, 14.1 дүгээр зүйлд заасан гишүүнчлэлийг цуцлах бүх үндэслэл нь дор хаяж Үндсэн хуулийн шүүхийн өөрийнх нь албан ёсны шийдвэр эсхүл тогтоолд хянагддаг байх хэрэгтэй.”

CDL-AD(2006)017 Армен улсын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөд өгсөн санал, цогцолбор 20.

“Үндсэн хуулийн шүүхийн шинэ шүүгчдийг томилох журам (Үндсэн хуулийн 134 дүгээр зүйл) нь гурван үе шатаас бүрдэнэ:

- а) Үндэсний зөвлөлөөс сул орон тоо бүрд хоёр дахин их нэр дэвшигчийг сонгох
- б) Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч эдгээр нэр дэвшигчдээс жинхэнэ шүүгч болох хүнийг сонгох

- в) Бүгд найрамдах улсын Ерөнхийлөгчид тангараг өргөснөөр шүүгч шүүхийн албан тушаалдаа орох”

“Венецийн комисс Бүгд Найрамдах Словак улсад Үндсэн хуулийн шүүгчийн бүрэн эрхийн хугацаа бүрэн эрхийнх нь сүүлчийн өдрөөр дуусгавар болдог болохыг анзаарсан (1993 оны Хуулийн § 12.1). Үндсэн хуульд заасан бүрэн эрхээ богиносгохгүйн тулд шинэ шүүгчид өмнөх шүүгчдийн бүрэн эрхийн хугацаа дууссаны дараа л тангараг өргөх боломжтой байдаг. Нөгөөтээгүүр, бүрэн эрхийн хугацааг сунгах ямар ч боломж байхгүй гэж харагдаж байгаа тул (Словакийн Үндсэн хуульд, Үндсэн хуулийн шүүгчид шинэ томилгоо хийгдэх хүртэл албан тушаалдаа хэвээр үлдэх талаар дефолт механизм байхгүй) нэн даруй тангараг өргөхгүй л бол Үндсэн хуулийн шүүхийн суудал хоосон хэвээр үлдэж, Шүүхийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж болзошгүй.

Ийм нөхцөл байдлаас зайлсхийхийн тулд, с) шат буюу томилогдох процесс -томилогдсон шүүгчийн бүрэн эрхийн хугацаа эхлэх мөч болох тангараг өргөх (1993 он Хуулийн § 11.2) ёслол нь өмнөх шүүгч нарын бүрэн эрхийн хугацаа дуусгавар болонгуут шууд хэрэгжиж эхлэх хэрэгтэй.

CDL-AD(2014)015 Бүгд Найрамдах Словак улсын Ерөнхийлөгчийн шилжилтийн үеийн Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийг томилох журамд өгсөн санал, цогцолбор 17, 21-22.

“Ерөнхийлөгч Үндсэн хуулийн шүүгчдэд нэр дэвшигчдийг Үндэсний Ассамблейгаар сонгох ажиллагаанд оролцох боломжгүй байгааг, ялангуяа Ерөнхийлөгч нэр дэвшигчдийн сонголд төлөөлөл болж оролцохгүй байгааг Комисс тэмдэглэж байна. Үүний оронд Ерөнхийлөгч Киска Үндэсний ассамблейгаас сонгогдсон нэр дэвшигчидтэй ярилцлага хийдэг өөрийн зөвлөлдөх хороог бий болгожээ.

Ерөнхийлөгчийг нэр дэвшигчидтэй холбоотой болзошгүй асуудлуудын талаар эртнээс дуу хоолойгоо хүргэх боломжийг олгохын тулд, Ерөнхийлөгч буюу түүний төлөөлөгчид Үндэсний ассамблейн өмнө хийдэг сонголуудад идэвхтэй оролцож, нэр дэвшигчдээс асуулт асуух хэрэгтэй. Мэдээжийн хэрэг сонгууль нь нэр дэвшигчдийг нууц санал хураалтаар үргэлжлүүлэн сонгох Үндэсний Ассамблейн бүрэн эрх хэвээр байх болно. Энэ нь Ерөнхийлөгч болон Үндэсний Ассамблей хоёрын хооронд үл ойлголцол үүсэхээс эртнээс сэргийлж чадна. Иймэрхүү хамтын ажиллагааг, Венецийн комиссоос хэд хэдэн удаа зөвлөсөн шиг, төрийн байгууллагуудын хоорондын үнэнч хамтын ажиллагааны сайн жишээ гэж үзэж болно.»

CDL-AD (2017)001 Бүгд Найрамдах Словак Улсын Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийн томилгоотой холбоотой асуултын талаарх санал, цогцолбор 49-50.

Үндсэн хуулийн шүүх нь үндсэн хуулийн шүүгчийн томилгооны асуудлын хүрээнд холбогдох Үндсэн хуулийн зөрчлийг тогтоож болох хэдий ч, өөрийгөө шүүгч нарыг томилох эрх бүхий байгууллага болгож болохгүй. Энэхүү шүүгчдийн томилгоо нь мэдээж Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрхэд хэвээр үлдэнэ.»

CDL-AD (2017)001 Бүгд Найрамдах Словак Улсын Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийг томилохтой холбоотой асуултын талаарх санал, цогцолбор 70.

“Үндсэн хуульд нарийвчилсан заалт байхгүй байгаа талаар Венецийн Комисс “Венецийн комиссын стандартад шүүх эрх мэдлийн томилгооны журмыг Үндсэн хуульд нарийвчлан тусгах тухай шаардлага байхгүй” гэдгийг дурдсан. Гэхдээ, Финляндын Үндсэн хуулийн талаар “Шүүгчдийг томилох нь тэдний бие даасан, хараат бус байдлыг хангахад чухал ач холбогдолтой тул томилгооны журмыг Үндсэн хуульдаа нарийвчлан зохицуулах нь зүйтэй” гэж Венецийн Комисс мөн дүгнэсэн.

CDL-AD(2016)034, Украин - Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 10.

Нэр дэвшигчдийг санал болгох Ерөнхийлөгч болон Парламентын хорооны аль алиных нь саналыг олон нийтэд санал болгосны үндсэн дээр гаргах ёстой. Энэ нь тухайн процедурын ил тод байдлыг нэмэгдүүлж, улмаар Үндсэн хуулийн шүүхэд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлж байгаа учраас сайшаалтай.”

CDL-AD(2013)028 Монтенегрогийн Үндсэн хуулийн шүүх, Улсын дээд прокурор, Шүүхийн зөвлөлтэй холбоотой Үндсэн хуулийн гурван заалтад нэмэлт, өөрчлөлт оруулах төсөлд өгсөн санал, цогцолбор 25-26.

4.4 БҮРЭН ЭРХИЙН ХУГАЦАА

4.4.1 Шүүгчийн бүрэн эрхийн хугацаа

“Эрх барьж буй нам бүх шүүгчийг өөрийн хүссэнээр томилдог байхаас зайлсхийх хэрэгтэй. Тиймээс, Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийн бүрэн эрхийн хугацаа Парламентын бүрэн эрхийн хугацаатай давхцахгүй байх хэрэгтэй. Үүнийг хэрэгжүүлэх нэг арга бол шүүгчийн албаны хугацааг

уртаар эсхүл тэтгэвэрт гарах нас хүртэл хугацаагаар тогтоох явдал юм. Эхний тохиолдолд, дахин зөвхөн нэг удаа, эсхүл огт томилох боломжтой байх хэрэгтэй; (...)”

CDL-STD(1997)020 Үндсэн хуулийн шүүхийн бүрэлдэхүүн – Шинжлэх ухаан болон Ардчиллын техник, но. 20 (1997), хуудас 21.

“9 дүгээр зүйлд Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийн бүрэн эрхийн хугацааг 10 жил байхаар заасан байдаг (Дам утгаараа Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгчийн хувьд ч гэсэн ижилхэн). Шүүгчдийн хараат бус байдлыг хамгаалахын тулд шүүгчдийн дахин томилгоог байхгүй болгох нь илүү дээр (ядаж энэ хуулийн төсөл батлагдсаны дараа шинээр томилогдсон шүүгчдийн хувьд л, түр зуурын зүйл заалтаар дахин томилгоог зөвшөөрөх хэрэгтэй. Ингэж чадвал одоо алба хашиж буй шүүгчдийн бүрэн эрхийн хугацаанд нөлөө үзүүлэхгүй). Гэхдээ, энэ нь нийтлэг стандарт бол биш юм. Бүрэн эрхийн хугацааг уртасгах, эсвэл шүүгчдийг тэтгэвэрт гарах хүртэл хугацаагаар сонгож болно. Энэ асуудлын талаар Үндсэн хуульд зохицуулалт байхгүй бөгөөд үүнийг Үндсэн хуулийн төсөлд оруулах боломжтой.”

CDL-AD(2014)017 Тажикстаны Үндсэн хуулийн шүүхийн талаарх Үндсэн хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 14.

4.4.2 Шүүгчийг дахин сонгох, томилох

“Дахин томилгоо нь шүүгчийн хараат бус байдлыг алдагдуулж болзошгүй. Гэсэн хэдий ч, урт хугацаанд алба хашсаны дараа зөвхөн нэг удаа дахин томилгоо хийх боломж нь онц сайн шүүгчдийг үргэлжлүүлэн ажиллуулах нөхцөлийг бий болгоход таатай байж болох юм (...)”

CDL-STD(1997)020 Үндсэн хуулийн шүүхийн бүрэлдэхүүн – Шинжлэх ухаан болон Ардчиллын техник, но. 20 (1997), хуудас 14.

“Хэн нэгэн, нэг ижил хүн Үндсэн хуулийн шүүхийн шүүгчээр дахин сонгогдож болох эсэх талаар Үндсэн хууль, хуулийн төслийн аль алинд ч байхгүй байна. Ийнхүү дахин сонгогдох явдлыг хориглоогүй байгаа нь шүүгчийн хараат бус байдлыг алдагдуулж болзошгүй.”

CDL-AD(2008)030 Монтенегро улсын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 20.

“Үндсэн хуулийн шүүхийн бүрэлдэхүүний талаарх судалгаандаа шүүгчдийн бүрэн эрхийн хугацааны хувьд Венецийн комисс урт хугацааны, дахин сонгогдохгүй байхыг эсвэл хамгийн ихдээ нэг удаа л дахин сонгогдох

боломжтой байхыг илүүд үзсэн. Шүүгчийг дахин сонгохгүй байх нь Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийн хараат бус байдлыг улам бүр нэмэгдүүлдэг.”

CDL-AD(2009)042 Латвийн Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд өгсөн санал, цогцолбор 14.

“12 жил болгон сунгагдаж байгаа Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийн бүрэн эрхийн хугацааны талаар хэлэхэд, Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийн хараат бус байдлыг улам нэмэгдүүлэх үүднээс Үндсэн хуулийн шүүхийн тухай хуульд шүүгч дахин сонгогдохгүй байх талаар боломжтой бол шууд тусгах нь зүйтэй.”

CDL-AD(2011)016 Унгарын шинэ Үндсэн хуулийн талаарх санал, хуудас 95.

“Венецийн комиссын зөвлөмжийн дагуу, хуулийн төслийн 153 дугаар зүйлд Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийн арван хоёр жилийн бүрэн эрхийг дахин сунгах боломжгүйг заасан.”

CDL-AD(2013)028 Монтенегрогийн Үндсэн хуулийн шүүх, Улсын дээд прокурор, Шүүхийн зөвлөлтэй холбоотой Үндсэн хуулийн гурван заалтад нэмэлт, өөрчлөлт оруулах төсөлд өгсөн санал, цогцолбор 24.

4.4.3 Гишүүнчлэл тасралтгүй байх

“(…) Ямар нэгэн томилгоо хийгдээгүй тохиолдолд шүүхийн институтын тогтвортой байдлыг хангах үүднээс өгөгдмөл (default) механизмуудыг ажиллуулах хэрэгтэй. Боломжит бүтэлгүйтэл бүрийг засаж залруулах тусгай зүйл заалтууд шаардлагагүй бөгөөд үүнийг ердөө эрх хэмжээний зөрчилдөөнийг арилгах чадамж бүхий үндсэн хуулийн тогтолцоогоор шийдэх боломжтой байдаг. Гэсэн хэдий ч, тодорхой сонголтын (Герман, Португал, Испани) эсвэл хагас сонголтын (Болгар) томилгооны өгөгдмөл (default) механизмууд хэдий нь байдаг. Тэрээр шүүхийн тогтвортой байдлын ач холбогдол нь үндсэн хуулийн шүүгчдийг томилж чадахгүй байх боломжтой улс төрийн бүтэлгүйтэл энэхүү тогтвортой байдалд нөлөөлөхөөс сэргийлнэ. Энэхүү урьдчилан тааварлагдаагүй нөхцөл байдлыг институт болж хувирахгүйн тулд онцгой тохиолдол гэж үзэх хэрэгтэй.»

CDL-STD(1997)020 Үндсэн хуулийн шүүхийн бүрэлдэхүүн – Шинжлэх ухаан болон Ардчиллын техник, no. 20 (1997), хуудас 15.

“Томилгооны журамд нэр дэвшүүлэх эрх бүхий этгээдийн эс үйлдэхүйг урьдчилан харж, шүүгчийн бүрэн эрхийн хугацааг түүний залгамжлагчийг томилох хүртэл сунгах зохицуулалтыг тусгасан байх хэрэгтэй. Хэрэв энэ

эрх бүхий этгээдийн эс үйлдэл удаан хугацаанд үргэлжилсэн тохиолдолд шийдвэр гаргахад шаардлагатай ирцийн хэмжээг бууруулж болно.”

CDL-STD(1997)020 Үндсэн хуулийн шүүхийн бүрэлдэхүүн – Шинжлэх ухаан болон Ардчиллын техник, no. 20 (1997), хуудас 22.

“Өөр нэг чухал (...) асуудал бол Парламентаас шинэ шүүгчийг сонгох журам юм. Энэ журамд одоо алба хашиж буй шүүгчид түүний дараагийн залгамжлагч албан ёсоор сонгогдох хүртэл ажлаа үргэлжлүүлэн хийх боломжийг олгосон журмын заалт, эсхүл одоо алба хашиж буй шүүгчийн бүрэн эрх нь дуусахаас тодорхой хугацааны өмнө шинэ шүүгчийг сонгох ажиллагааг эхлүүлж болно гэсэн заалт хэрэгтэй.”

CDL-INF(2001)002 Үндсэн хуулийн шүүхийн талаарх Бүгд Найрамдах Хорват улсын Үндсэн хуулийн зохицуулалтад өгсөн санал, цогцолбор 17.

“Үндсэн хуулийн шүүх эрх мэдлийн тогтвортой үйл ажиллагааг хангах, хамгаалах үүднээс Венецийн Комисс (...) (б) зөвхөн хууль тогтоомжийн өөрчлөлтөөр: (...) түүний залгамжлагч албан тушаалд орох хүртэл одоогийн шүүгчийг албан тушаалд нь үлдээх;” нөхцөлийг бий болгохыг зөвлөж байна.

CDL-AD(2006)016 Украины Үндсэн хуулийн шүүхийн тасралтгүй үйл ажиллагааг хангахын төлөөх Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийн шинэчлэлд өгсөн санал, цогцолбор 21(b).

“Зарим улсад Үндсэн хуулийн шүүхийн сул суудалд улс төрийн шалтгаанаар хугацаанд нь нөхөн томилдоггүй. Үүний улмаас ирц бүрдээгүй тул шүүх хуралдаж чадахгүйд хүрсэн нэг тохиолдол бий. Үндсэн хуулийн шүүхийн үйл ажиллагааг тасралтгүй явуулахын тулд шүүхийн гишүүд тэдний залгамжлагчид томилогдох хүртэл бүрэн эрхээ үргэлжлүүлсээр байх хэрэгтэй.”

CDL-AD(2006)017 Армен улсын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөд өгсөн санал, цогцолбор 22, 31(2).

“14.2 дугаар зүйлээр оруулсан шүүгч 15 жилийн бүрэн эрхийн хугацаагаа дууссанаас хойш эсхүл 70 насны хязгаарт хүрснээс хойш түүний оронд шинэ шүүгч томилогдох хүртэл албан тушаалдаа хэвээр үлдэх боломжтой болсон зохицуулалтыг Венецийн комисс сайшааж байна. Энэ нь Үндсэн хуулийн шүүхийн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах бөгөөд Венецийн комиссын Украины Үндсэн хуулийн шүүхийн тасралтгүй үйл ажиллагааг хангахын төлөөх Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийн боломжит шинэчлэлд өгсөн №377/2006 санал (CDL-AD(2006)016)-д

дурдсан зарчимтай нийцэж байна. Энэхүү саналын 13 дугаар цогцолборт ингэж дурдсан: “Хамгаалалт нь шүүгчид өөрийн бүрэн эрхийн хугацаа дууссаны дараа түүний залгамжлагч албан тушаалдаа орох хүртэл ажлаа үргэлжлүүлэхийг зөвшөөрсөн заалтаар бий болж болно. Ийм механизм одоогоор Болгар, Герман, Латви, Литва, Португал, Испанид хэрэгжиж байна. Ийм тогтолцоо нь томилгооны процесс явагдах үед гарах холбогдох санал зөрөлдөөний улмаас үүссэн гацаа нь Шүүхийн үйл ажиллагааг мухардалд оруулахаас урьдчилан сэргийлдэг. Энэ нь дээр дурдсан улсуудад хэрэгжиж байгаагчлан, Украинд ч гэсэн шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар ийм шийдлийг оруулж болохоор харагдаж байна. Гэхдээ, энэ нь эрүүл мэндийн эсхүл нас барсан шалтгаанаар шүүгч ажлаа гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд хангалттай шийдэл болохгүй.»

CDL-AD(2007)036 Азербайжан улсын Үндсэн хуулийн шүүхийн тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдэд өгсөн санал, цогцолбор 16.

Бусад улсуудад өмнө нь тулгарч байсан асуудлуудаас харахад, ажлаа хүлээлгэн өгөх гэж буй шүүгчийг түүний залгамжлагч нь ажилдаа орох хүртэл албан тушаалаа үргэлжлүүлж байх талаар зүйл заалт оруулах хэрэгтэй байж болох юм.

CDL-AD(2008)029 Киргизийн (1) Үндсэн хуулийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (2) Үндсэн хуулийн шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 12.

“Шүүгчийн бүрэн эрх дуусгавар болсны дараа тухайн орон тоо нь удаан хугацаагаар сул үлдэхгүй байх нь хамгийн чухал. Европын цөөн хэдэн улсад парламент шинэ шүүгчдийн томилгоог их удааж, хоцроож байсан бөгөөд үлдсэн шүүгчдийн ирц хангалтгүй байснаас шүүх нэг жил хагас гаруй хугацаанд ажиллагаагүй болж байсан нэг тохиолдол бий. Иймд, 10 дугаар зүйлд шүүгчийг түүний залгамжлагч албан тушаалд орох хүртэл албан тушаалд нь хэвээр үлдээнэ гэж заасан.

CDL-AD(2008)030 Монтенегро улсын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 25.

“Түүнчлэн, шүүхийн институтийн тогтвортой байдал болон аливаа институтийн гацаанаас зайлсхийхийн тулд Шүүхийн гишүүнчлэлийн тасралтгүй байдлыг хангах нь зайлшгүй юм. Үүнийг, Үндсэн хуулийн шүүхийн

тухай хуулийн 11.3 дугаар зүйлд аль хэдийн дурдсанчлан шүүгчийн бүрэн эрхийг түүний залгамжлагч албан ёсоор томилогдох хүртэл сунгах замаар хийж болно. Шинэ шүүгчийг томилох цаад хугацааг тогтоох болон өмнөх шүүгчийн бүрэн эрхийн хугацааг сунгах зэрэг аргуудыг хослуулсан хосолмол аргыг сайшааж байна.”

CDL-AD(2009)042 Латвийн Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд өгсөн санал, цогцолбор 15.

“Үндсэн хуулийн шүүхийн гишүүнчлэлийн тасралтгүй байдлыг хангахын тулд бүрэн эрхийн хугацаа нь дууссан гишүүн шүүгчийг түүний залгамжлагч ажилдаа орох хүртэл албан үүрэгт нь хэвээр үлдээх хэрэгтэй.”

CDL-AD(2011)040 Туркийн Үндсэн хуулийн шүүхийн байгуулал, процедурын тухай хуулийн талаарх санал, цогцолбор 27.

“15 дугаар зүйлд Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийг түүний бүрэн эрхийн хугацаа дуусах үед өндөр насны тэтгэвэр тогтоолгох болоогүй бол тус шүүхэд зөвлөхөөр үргэлжлүүлэн ажиллахыг зөвшөөрдөг. Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийн бүрэн эрхийн хугацаа дууссанаас хойш түүнийг тодорхой хугацаанд ажиллуулах санхүүгийн баталгааг олгож байхыг зөвлөж байна. Энэ нь шүүх эрх мэдлийн хараат бус байдалд эерэг нөлөөтэй. Гэхдээ, санал болгож буй энэхүү шийдэл нь нэмэлт зохицуулалтгүйгээр хамгийн оновчтой шийдэл мөн эсэх тухай асуулт байна. Дээрх дүрэм нь Үндсэн хуулийн шүүхийн шүүгчээр ажиллаж байсан хүн түүний бүрэн эрхийн хугацаа дууссаны дараа ч Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрт шийдвэрлэх нөлөө үзүүлж болзошгүй үр дүнг авч ирнэ. Дээрээс нь, өмнөх албан тушаалынх нь үүднээс үзвэл, шинээр сонгогдсон шүүгчид, тэр байтугай Ерөнхий нарийн бичгийн дарга нартай холбоотой доод албан тушаалд байх нь зөвшөөрөгдөх эсэх нь эргэлзээтэй юм. Эдгээр асуудлуудаас зайлсхийхийн тулд Үндсэн хуулийн шүүхийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны дэгд Үндсэн хуулийн шүүхийн шүүгчээр ажиллаж байсан хүмүүсийн албан тушаал (the position)-ыг тусгайлан зохицуулах нь зүйтэй.”

CDL-AD(2014)033 Монтенегрогийн Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 24.

“Үргэлжилж буй хэрэг маргаан дахь шүүгчийн оролцоог хангаж, тухайн хэргийг эцэслэн шийдвэрлэх боломжийг түүнд олгохын тулд түүний дуусгавар болсон бүрэн эрхийн хугацааг сунгах нь Үндсэн хуулийн шүүхийн үр дүнтэй байдлыг хангах зорилготой. Энэ нь заавал шинэ шүүгч албан тушаалаа

хүлээн авч чадахгүй байна гэсэн үг биш. Бүрэн эрхийн хугацааг сунгах энэ асуудлыг хэрэг маргааныг шүүхийн хуралдаанаар нэгэнт хэлэлцэж эхэлсэн тохиолдлоор хязгаарлаж болох юм.”

Нөгөөтээгүүр, Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийн бүрэн эрхийн хугацааг чанд буюу хатуу баримталдаг тогтолцоонд шүүгчдийн залгамж аюулд орж болохыг туршлага харуулж байна. Хэд хэдэн улсад, шинэ шүүгчийн томилгоо/сонголт хойшлогдож, заримдаа хэт удаан хугацаагаар саатаж байсан. Зарим тохиолдолд үлдсэн шүүгчдийн тоо шаардлагатай ирцэд хүрэлцэхгүй, шүүх хуралдаанаа хийх боломжгүй болж байсан. Тиймээс, Венецийн Комисс өмнөх шүүгчид зөвхөн шинэ шүүгчид албан тушаалдаа орсны дараа ажлаа хүлээлгэх өгөхийг зарчмын хувьд зөвлөж байна...»

CDL-AD(2016)017, Гүрж - Үндсэн хуулийн шүүхийн тухай органик хууль болон Үндсэн хуулийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөд өгсөн санал, цогцолбор 19–20.

“..., Комиссын зүгээс, тангараг өргөх талаар өгөгдмөл (default) механизм байх ёстой гэж зөвлөсөн. Үндсэн хуулийн шүүхийн өмнө тангараг өргөхийг хүлээн зөвшөөрснөөр энэ асуудал шийдэгдэж байгааг Комисс халуун дотноор хүлээн авч байна. 9 Ажлаа хүлээлгэн өгч байгаа шүүгчдийг тэдний залгамжлагчид албан тушаалд очих хүртэл албан тушаалдаа үлдэхийг мөн адил санал болгосон. Сүүлийн зөвлөмж нь бүрэн хүчинтэй хэвээр байна. Хуулийн төслийн 16.2 дахь заалтын шийдэл хэтэрхий хязгаарлагдмал байна. Энэ нь үлдсэн шүүгчдийн тоо шаардагдах ирцийг хангаж байгаа тохиолдлуудад л хамаарахаар байна. Хэрэв одоо өөр шүүгч шүүгчээр ажиллах боломжгүй хэмжээнд хүндээр өвдсөн эсхүл нас барсан бол шүүх хуралдаанаа хийх боломжгүй болохоор байна. Шүүгчид гурван сарын хугацаа дууссан ч гэсэн тэдний залгамжлагчид ажилдаа орох хүртэл албан тушаалдаа хэвээр үлдэх хэрэгтэй. Энэхүү шийдэл нь магадгүй Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахыг шаардаж болох юм.”

CDL-AD(2016)034, Украин - Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 14.

“Үүнээс гадна, Үндсэн хуулийн шүүхийн институтийн тогтвортой байдал болон аливаа аливаа институтийн гацаанаас зайлсхийхийн тулд, default механизмыг ажиллуулах хэрэгтэй. Үүний хамгийн чухал зүйл нь шүүгчийн бүрэн эрх дууссаны дараа тухайн орон тоо хэт удаан хугацаагаар сул үлдэхгүй байх явдлыг хангах юм. Үндсэн хуулийн шүүх дэх шүүгчийн сул

орон тоог нөхөхтэй холбоотой маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны дэг нь шүүгчийг нэр дэвшүүлэх эрх бүхий этгээдийн эс үйлдэхүйг урьдчилан харах хэрэгтэй. Нэг бол одоогийн шүүгчийг түүний залгамжлагч албан ёсоор томилогдох хүртэл ажлаа үргэлжлүүлэн хийхийг зөвшөөрсөн журам (энэ шийдэл нь магадгүй Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахыг шаардаж болох юм), эсхүл одоогийн шүүгчийн бүрэн эрхийн хугацаа дуусахаас дор хаяж гурван сарын өмнө шинэ шүүгчийн томилох ажиллагааг эхлүүлж болох тухай тусгайлан заасан зүйл заалттай байх хэрэгтэй.”

CDL-AD(2017)011 Армен - Үндсэн хуулийн шүүхийн талаарх Үндсэн хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 23.

4.5 БҮРЭН ЭРХИЙГ ДУУСГАВАР БОЛГОХ / ТҮДГЭЛЗҮҮЛЭХ

“Суурь хууль болон Шүүгчийн эрх зүйн байдал, цалин хөлсний тухай хуулийн түр заалтуудын 12 дугаар зүйлд заасны дагуу насны дээд хязгаарыг тэтгэврийн настай нэгтгэж, тэтгэврийн насанд хүрсэн хүн бүр тэтгэвэрт гарах болсон. Харин “Төрийн зарим албан тушаалтны” (эдгээрт Улсын Ерөнхий прокурор, Аудитын шүүхийн дарга, Үндсэн хуулийн шүүхийн шүүгчид хамаарахаар байна) хувьд насны дээд хязгаарыг 70 насаар барих зохицуулалтад хамаарахгүй онцгой нөхцөлүүд тусгагдсан.”

CDL-AD(2012)001 Унгарын Шүүгчийн эрх зүйн байдал, цалин хөлсний тухай 2011 оны CLXII хууль, Шүүхийн зохион байгуулалт, удирдлагын тухай 2011 оны CLXI хуулиудын талаарх санал, цогцолбор 102.

“14 дүгээр зүйлд шүүгчдийг эгүүлэн татах хэд хэдэн үндэслэлийг заасан. Тухайн тохиолдол бүрд, шүүгчийг Ерөнхийлөгчийн санал болгосноор Парламент эгүүлэн татна. Тухайлбал, шүүгч нас барах нь цэвэр факт бөгөөд үүнийг хуулийн талаас “эгүүлэн татах” гэж үзэх шаардлагагүй. Ажлаас гарах болон бүрэн эрхийн хугацаа дуусгавар болхийн хувьд ч гэсэн адилхан. (Харин) бусад нь, тухайн шүүгч шүүгчийн албан тушаалд харшлах үйл ажиллагаа явуулсан эсэх (14.5-р зүйл), шүүгчийн нэр төр, алдар хүндийг гутаасан үйлдэл хийсэн эсэх (14.7-р зүйл) зэрэг шүүгчийн зан үйлийн үнэлгээг шаарддаг.

Иймэрхүү тохиолдлуудад улс төрийн байгууллага (Парламент, Ерөнхийлөгч) шүүгчийг эгүүлэн татахаас өмнө шүүхийн байгууллага буюу Үндсэн хуулийн шүүх, эсхүл Дээд шүүхийн аль хамаарах нь энэ асуудлыг шийдэх хэрэгтэй. 14.11 дүгээр зүйлд шүүгчийг өөр ажилд шилжүүлсний

дараа эгүүлэн татах талаар тусгасан. Гэвч, эгүүлэн татах гэх үндэслэлээр шүүгчийг бүрэн эрхийнх нь хугацаанд өөр албан тушаалд шилжүүлэхээс татгалзах хэрэгтэй. Бүрэн эрхийнхээ хугацаанд шүүгч нь ажлаас гарах өргөдлөө урьдчилсан байдлаар өгөөгүй бол, тэр ч байтугай энэ нь өөрийнх нь хүсэлт байсан ч, түүнийг өөр албан тушаалд шилжүүлэн томилж болохгүй.

Хуулийн 14.7 дугаар зүйлд уламжлал, ёслол, зан үйлтэй холбоотой хууль тогтоомжийн зөрчил нь мөн шүүгчийг эгүүлэн татах үндэслэлийн нэг байхаар заасан. Ялангуяа энэ хуулиар гэр бүлийг бүхлээр нь сүйрүүлдэг хэт нүсэр том хурим, оршуулгын ёслолыг хориглосон харагдаж байна. Иймэрхүү хууль нь ерөнхийдөө Тажикийн нийгэмд утга учиртай байж болох ч, энэ нь Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийг огцруулах үндэслэл байж болохгүй.”

CDL-AD(2014)017 Тажикстаны Үндсэн хуулийн шүүхийн талаарх Үндсэн хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 22-24.

“10 дугаар зүйлд шүүгч ажлаас халагдах хүсэлтээ гаргаж болох бөгөөд уг хүсэлтийг гаргасан өдрөөс хойш 30 хоногийн дотор Парламент шүүгчийн бүрэн эрхийг дуусгавар болгох талаар шийдвэр гаргана гэж заасан. Энэхүү 30 хоногийн хугацаа дууссаны дараа Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийн бүрэн эрхийн хугацаа дуусгавар болох ёстой. Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийг огцруулах асуудалд Парламент оролцох хэрэггүй. Шүүгчийг өөрийнх нь хүсэл зоригт харшилж, албан тушаал нь үлдэхийг албадаж болохгүй. Шүүгчийн бүрэн эрх 30 хоногийн дараа автоматаар дуусгавар болох хэрэгтэй.

Хуулийн төслийн 10.3 дугаар зүйлд заасны дагуу Үндсэн хуулийн шүүх шүүгчийн бүрэн эрхийн хугацаа дуусахаас зургаан сарын өмнө, эсхүл өндөр насны тэтгэвэрт гарах нөхцөл бүрдэхээс өмнө тухайн шүүгчдийг анх сонгоход санал оруулж байсан этгээдэд мэдэгдэх ёстой. Үндсэн хуулийн 154 дүгээр зүйлд заасны дагуу хуулийн төсөлд шүүгчийн бүрэн эрх дуусгавар болох шалтгаан болон журмыг тусгасан (10-12 дугаар зүйл). Гэвч тус төсөлд санал оруулагдсан нэр дэвшигч давтан санал хураалтад ч сонгогдоогүй тохиолдолд ямар үр дагавар бий болох талаар тусгаагүй. Шинэ шүүгч сонгогдоогүйгээс шүүгчийн орон тоо сул байх нөхцөл байдлаас зайлсхийхийн тулд, хуульд Үндсэн хуулийн шүүхийн (өмнөх) шүүгчийн бүрэн эрхийн хугацаа дууссан ч, шинэ шүүгч ажлаа хүлээн авах хүртэл албан үүргээ үргэлжлүүлэн гүйцэтгэх тухай тодорхой зааж өгөх хэрэгтэй.

11 дүгээр зүйлд шүүгчийг “албан үүргээ гүйцэтгэхэд тохирохгүй” гэж үзэх зөрчлийн төрөл, тэдгээрийн хүнд хөнгөний түвшин; “ажил үүргээ бүрмөсөн гүйцэтгэх чадамжгүй байдал” гэж ямар нөхцөл байдлыг хэлэх вэ гэдгийг, шүүгч “өөрийн улс төрийн итгэл үнэмшлээ олон нийтэд нээлттэй илэрхийлэх” нөхцөл, арга хэлбэрүүдийг тодорхойлох хэрэгтэй. Хуульд нийцсэн байх зарчим буюу хууль ёсны зарчим нь Үндсэн хуулийн шүүхээс огцруулах саналыг өргөн мэдүүлэх талаар Парламентад хэт их эрх мэдэл олголгүйгээр огцруулах зэрэг маш ноцтой шийтгэл ногдуулах урьдчилсан нөхцөлийг маш нарийн хийгээд тодорхой зааж өгөхийг шаарддаг.

12 дугаар зүйлд Үндсэн хуулийн шүүгчид эрүүгийн хэрэг үүсгэсэн үед тухайн шүүгчийг албан тушаалаас нь түдгэлзүүлж болно; тус шийдвэрийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны субъект болсон шүүгчийн оролцоогүйгээр нийт шүүгчдийн олонхын саналаар гаргах ёстой гэж заасан. Түдгэлзүүлэх асуудлыг Үндсэн хуульд заагаагүй хэдий ч, энэ нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа онц ноцтой гэмт хэрэгтэй холбоотойгоор явагдсан тохиолдолд нэлээд түгээмэл авагддаг арга хэмжээ юм.”

CDL-AD(2014)033 Монтенегрогийн Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 19-22.

“Шүүгчийн бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсны дараа гурван сарын дотор түүний залгамжлагчийг томилох үүргийг хуулийн төсөлд тусгасан (13.2, 14.3, 15.3 дугаар зүйл). 2005 оны туршлагаас харахад, энэхүү богино хугацаа нь урт хугацаанд сул орон тоо гарахгүй байх баталгаа болж магадгүй юм. Энэ нь тактикийн шалтгаанаар, тухайлбал, Их танхим, Сенат, Удирдах зөвлөлийн гишүүдийн олонход нөлөөлөхийн тулд шинэ шүүгчдийн томилгоо хойшлогдохоос урьдчилан сэргийлэх зорилготой. Тиймээс үүнийг сайшааж байна. Гэхдээ энэ гурван сарын дараа юу болох талаар хуулийн төсөлд дурдаагүй байна. Байж болох нэг шийдэл бол сонгон шалгаруулалтын хорооноос хамгийн өндөр үнэлгээ авсан хүн Шүүхэд тангараг өргөх боломжтой байхаар зохицуулах юм. Өөр нэг шийдэл бол гурван сарын хугацаа дууссаны дараа улс төрийн байгууллага, тухайлбал Ерөнхийлөгч болон Рада нь шинэ шүүгч томилох эрхээ алддаг байхаар зохицуулж болно. Үүний дараагаар Украины Шүүгчдийн Конгресс нь улс төрийн бус байгууллага болохын хувьд Ерөнхийлөгч эсвэл Радийн оронд шүүгчийг сонгох эрхтэй байхаар болж болно. Шүүгчдийн их хурал шүүгчийг сонгоогүй тохиолдолд энэ шийдэл ажиллахгүй нь ойлгомжтой хэдий ч,

гэхдээ энэ магадлал бага байх байх. Эдгээр шийдлүүд нь Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахыг шаардаж магадгүй.»

CDL-AD(2016)034, Украин - Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 22–23.

“(...) Үндсэн хуулийн шүүх шүүгчийн бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон, эсвэл тэтгэвэрт гарах насанд хүрсэн тухай улсын Ерөнхийлөгч, Засгийн газар, Шүүхийн ерөнхий зөвлөлийн аль нэгд (Үз. Хуулийн төслийн 13.5 дугаар зүйл), дор хаяж шүүгчийн бүрэн эрхийн хугацаа дуусахаас 3 сарын өмнө, бичгээр мэдэгдэх талаар бодолцож болох юм.

CDL-AD(2017)011 Армен - Үндсэн хуулийн шүүхийн талаарх Үндсэн хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 22.

4.6 ХАРИУЦЛАГА

4.6.1 Сахилгын хариуцлага

“Шүүгчийн сахилгын дүрэм болон түүнийг оногдуулах дүрэмд шүүхийн өөрийнх нь заавал биелүүлэх шинж бүхий санал хураалтын асуудлыг багтаах хэрэгтэй. Шүүгч хийгээд шүүхийн даргыг огцруулах хариуцлага оногдуулах аливаа дүрэм маш хязгаарлагдмал байх хэрэгтэй.”

CDL-STD(1997)020 Үндсэн хуулийн шүүхийн бүрэлдэхүүн – Шинжлэх ухаан болон Ардчиллын техник, no. 20 (1997), хуудас 21.

“16-р зүйлд Шүүхийн бусад гишүүдэд сахилгын үр дагавар үүсгэж болзошгүй нэг буюу хэд хэдэн гишүүний эсрэг нэхэмжлэлийг шийдвэрлэх боломжийг бүрдүүлсэн цогц зохицуулалтыг тусгасан. Бүх тохиолдолд, ялангуяа нэгээс олон шүүгчтэй холбогдсон тохиолдолд шүүхийн бусад гишүүдийн зүгээс хэрхэн зөв зохистой шийдвэр гаргаж болохыг ойлгоход бага зэрэг хэцүү байна. Хэргийг жижиг түр хороонд шилжүүлэхийн оронд (Үз. Дээрх 11 дүгээр зүйл), сахилгын арга хэмжээ авах илүү том хэмжээний байгууллагыг шаардлагатай байж магадгүй юм.”

CDL-AD(2009)014 Палестины Үндсэн хуулийн дээд шүүхийн тухай хуулийн талаарх санал, цогцолбор 20.

“Үндсэн хуулийн шүүхийн гишүүнийг шүүхээс хасах боломж бүхий Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан “тохирохгүй байдал (unworthiness)” гэсэн нэр томъёоны тодорхой бус байдлыг тэнцвэржүүлэхийн тулд, тухайлбал шүүхээс хасах тухай шийдвэрийг дор хаяж бусад шүүгчдийн

гуравны хоёрын олонхоор, эсхүл бүүр нийт шүүгчдийн нэгдмэл саналаар гаргах гэх мэт процедурын баталгааг бий болгох хэрэгтэй..»

CDL-AD(2012)009 Унгарын Үндсэн хуулийн шүүхийн тухай 2011 оны CLI хуулийн талаарх санал, цогцолбор 54(2).

“Парламентын зөвшөөрөлгүйгээр шүүгчийг баривчлах, эсхүл цагдан хорьж болохгүй гэсэн одоогийн заалт нь Улсын дээд шүүх (HCJ)-ийн зөвшөөрөлгүйгээр тэгж болохгүй гэсэн заалтаар солигдоно. Энэ нь одоогийн заалтыг нэлээд сайжруулж байгааг харуулж байна. Гэхдээ ямар үндэслэлээр зөвшөөрөл олгох, эсхүл татгалзах шалгуурыг заагаагүй байна. Венецийн Комиссын зүгээс, шүүгчдэд зөвхөн чиг үүргийн халдашгүй байх эрх (functional immunity) л байх ёстой, өөрөөр хэлбэл шүүгч шүүх эрх мэдлээ хэрэгжүүлэх явцад хийсэн үйлдлийнхээ хүрээнд халдашгүй эрхтэй байх, эсхүл шүүхийн хараат бус байдлыг хууль бус баривчилгааны аюулаас хамгаалахад зайлшгүй шаардлагатай хүрээнд халдашгүй байдал байх хэрэгтэй гэсэн байр суурийг байнга илэрхийлсээр ирсэн:

“...Шүүгчид зөвхөн чиг үүргийн хувьд халдашгүй байдалтай байх хэрэгтэй, өөрөөр хэлбэл, зөвхөн шүүгчийн чиг үүргээ гүйцэтгэхдээ хийсэн хууль ёсны үйлдлийнхээ хувьд хэрэг мөрдөн шалгах ажиллагаанаас чөлөөлөгдөнө гэсэн үг. Тиймээс, авлига, хээл хахууль, түүнтэй адилтгах гэмт хэргүүдийг хууль ёсны шүүхийн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ үйлдсэн үйлдэл гэж үзэх боломжгүй нь ойлгомжтой юм.”

Прокуророос шүүгчийг хилс хэрэгт буруутгасан илэрхий шинж тэмдэг байгаа л эс бол, шүүгчийн холбогдох үйлдлүүдийг хараат бус шүүхийн хяналтаас хасаж болохгүй (доорхыг харах). Шүүгчийг эрүүгийн гэмт хэрэг, тухайлбал авлигын гэмт хэргийн тохиолдлуудад, үйлдсэн гэм буруутай гэж үзэх хангалттай үндэслэл байгаа бол шүүгчид дархан эрхийг эдлүүлж болохгүй бөгөөд Улсын дээд шүүхээс түүний дархан эрхийг цуцлах хэрэгтэй. Шүүгчийн халдашгүй дархан эрхийг цуцлах эсэхийг Улсын дээд шүүх шийдэх чиг үүрэгтэй байх нь үндэслэлтэй. Гэхдээ, үүнийг хэзээ хийх талаарх шалгуурыг тодорхой зааж өгөх хэрэгтэй.»

(...)

“Түүнчлэн, Парламентаас шийдвэр гарч шүүхийн дахин зохион байгуулалт (зэрэг) (гэхдээ шүүх дэх зөвхөн дотоод дахин зохион байгуулалт биш) хийгдээгүй (Үз., дээрх 85 дугаар зүйл) бол шүүгчийг зөвхөн түүний

өөрийнх нь хүслээр шилжүүлж болно. Энэ тусгай тохиолдлыг тус заалтад тусгах хэрэгтэй.”

CDL-AD(2013)014 Шүүгчийн хараат бус байдлыг бэхжүүлэх Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн тухай хуулийн төсөл (тайлбар, хүснэгт багтсан) болон Украины Үндсэн хуулийн ассамблейгаас өргөн мэдүүлсэн Үндсэн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 19-20, 30.

“Одоогийн 97 дугаар зүйлийн 5 дахь цогцолборт шүүгчийг хугацаанаас нь өмнө огцруулах нөхцөл байдлын талаар дурдаагүй хэдий ч, шинэ 95 дугаар зүйлийн 2 болон 3 дахь цогцолборт энэ тухай заасан. Үүнийг ерөнхийд нь сайшааж байна. Үүний зэрэгцээ, 95 дугаар зүйлийн 2 дахь цогцолборт «гэм буруугүйн шаардлага»-ыг зөрчсөнийг шүүгчийг огцруулах үндэслэл болгосон. Бүгд Найрамдах Киргиз улсын Үндсэн хуулийн Шүүгчийн эрх зүйн байдалтай холбогдох хэсэгт «гэм буруугүй» гэсэн нэр томъёог Үндсэн хуульд заасан шүүгчид хамаарах хэд хэдэн шаардлага, хориглолтыг зөрчөөгүйг хэлнэ гэж тодорхойлсон байдаг ч, эдгээрийн зарим нь нэлээд бүрхэг байдлаар тусгагдсан байна (Мөн үз. цогцолбор 74-с хойших). Ер нь ЕАБХАБ/АИХЭО болон Венецийн Комиссын зүгээс, шүүгчийг хугацаанаас нь өмнө огцруулахад үүнийг тодорхой болон бодитой шалгуур, түүнчлэн нээлттэй болон ил тод журамд үндэслэсэн байх хэрэгтэйг ахин дахин хэлсээр байна. Иймд бусад хууль тогтоомжид шүүгчийг хугацаанаас нь өмнө огцруулах үндэслэлийг тодорхой болон чанд хатуу байдлаар заагаагүй бол холбогдох заалтууд нь шүүгчийн бүрэн эрхийн аюулгүй байдал, цаашлаад шүүхийн хараат бус байдлыг алдагдуулж болзошгүй.”

CDL-AD(2016)025, Бүгд Найрамдах Киргиз Улсын “Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн танилцуулга”-ын талаарх хуулийн төсөлд өгсөн нэгдсэн санал, цогцолбор 55.

4.6.2 Халдашгүй байдал

“Шүүх эрх мэдэл, тэр дундаа Үндсэн хуулийн шүүх өөрт байгаа хэрэг маргааныг бодит байдалд үндэслэн, хуулийн дагуу шударгаар шийдвэрлэх үүрэгтэй учраас, шүүх эрх мэдэлд шууд болон шууд бус замаар хэн ч, ямар ч шалтгаанаар зүй бусаар нөлөөлөх, ятгах, дарамтлах, заналхийлэх, хөндлөнгөөс оролцох ёсгүй. Шүүхийн хараат бус байдлын зарчим нь шүүх хуралдааныг шударгаар явуулах, талуудын эрхийг хамгаалах нөхцөлийг шүүх эрх мэдэлд олгохын зэрэгцээ, шүүх эрх мэдлээс тус нөхцөлийг хангаж байхыг шаарддаг. Шүүгчид өөрсдийн ухамсар, хэргийн бодит нөхцөл

байдал, холбогдох хууль тогтоомжийн дагуу хэргийг шударгаар шийдвэрлэх эрх чөлөөтэй байх хэрэгтэй. Үр ашигтай, хараат бус, шударга шүүх эрх мэдэл бол хууль дээдлэх ёс, нийгмийн ардчилсан зарчмуудыг хангах суурь багануудын нэг гэдэг нь дамжиггүй. Венецийн комиссын өмнөх дүгнэлт, тайлангуудад дурдсанчлан, шүүх эрх мэдлийн хараат бус байдал бол бүх улс оронд (тухайн улс ямар тогтолцоотой байхаас үл шалтгаалж) хамаарах асуудал бөгөөд аливаа ардчилсан тогтолцоо, эрх мэдлийн хуваарилалтыг чандлан сахихад зайлшгүй шаардлагатай. Энэ бол хууль дээдлэх ёс, ардчиллын хийгээд хүний эрхийг хамгаалах үндсэн баталгаа мөн. Шүүх эрх мэдлийн хараат бус байдал нь эрх мэдлийн бусад салбар, шүүх эрх мэдэл доторх бусад байгууллага, бусад шүүгчид болон бусад этгээдүүдийн зохисгүй хөндлөнгийн оролцооноос ангид шударга ёсыг тогтоох, ийнхүү харагдах нөхцөлийг баталгаажуулдаг.

Түүнчлэн, хараат бус шүүх эрх мэдэл гэдэг бол шүүгч нар өөрсдийн ажилдаа хариуцлагатай байна гэсэн үг. Энэ утгаараа, ССЈЕ-ын 2014 оны №17 дүгнэлтэд тусгагдсан шүүгчдийн үндсэн чиг үүргийг судалж үзэхэд, шүүгчид хууль дээдлэх ёсыг сахидаг бүхий л ардчилсан нийгэмд нэн чухал үүрэг гүйцэтгэдэг нь тодорхой байна. Тухайлбал, шүүгчид бүх хүний эрх, эрх чөлөөг тэгш хамгаалах ёстой. Шүүгчид үр дүнтэй, боломжит зардал бүхий маргаан хянан шийдвэрлэх арга хэмжээг авч, хэрэг маргааныг цаг тухайд нь, хараат бусаар шийдвэрлэх ёстой бөгөөд зөвхөн хуульд захирагдана. Тэд шийдвэртээ үнэмшихүйц үндэслэлүүдийг гаргаж өгөх ёстой бөгөөд, шийдвэрээ тодорхой хийгээд ойлгомжтой байдлаар бичих ёстой. Хэрэв шүүх эрх мэдэл урвуулан, эсхүл буруугаар ашиглагдвал зорилгодоо хүрч чадахгүй. Чиг үүргээ хэрэгжүүлэх явцдаа авлига авах зэрэг гэмт хэрэг үйлдсэн шүүгчид эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас чөлөөлөгдөхөөр маргах эрхгүй. Цаашилбал, Үндсэн хуулийн шүүхийн шүүгч гэлтгүй хэн ч эрүүгийн гэмт хэрэг үйлдэж болзошгүй тул чиг үүргийн халдашгүй байдал нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоогүй тохиолдолд шүүгчийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас чөлөөлөхгүй. Шүүгчид бусад хүмүүсийн нэгэн адил үйлдсэн гэмт хэрэгтээ, тухайлбал, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсоны улмаас зам тээврийн осол гаргасан бол шийтгэлээ хүлээх хэрэгтэй.»

CDL-AD(2019)028 Бүгд Найрамдах Молдова Улс – Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийн эрүүгийн хариуцлагын тухай Amicus Curiae - санал, дүгнэлтийн товч, цогцолбор 20-24.

“Шүүгчийн шүүн таслах ажиллагааны хариуцлагын тухайд, Шүүгчийн эрүүгийн хариуцлагын тухай Бүгд Найрамдах Молдова Улсын Үндсэн хуулийн шүүхэд өгсөн *Amicus Curiae* - санал, дүгнэлтэд (2017) болон уг асуудлаарх Венецийн комиссын бусад дүгнэлтэд нэгэн адил дурдсанчлан, шүүгчид хууль тайлбарлах, холбогдох баримтыг олж тогтоох, нотлох баримтыг үнэлэх явдалд нь хариуцлага хүлээлгэдэг байхаар бол, ийм хариуцлага нь зөвхөн шууд санаатай болон илт хайхрамжгүй хандсан тохиолдолд л оноодог байх ёстой. Шууд санаа агуулаагүй шүүхийн алдаа болон хуулийн тайлбарын ялгаатай байдлын төлөө шүүгчдэд хариуцлага хүлээлгэх ёсгүй. Энэ нь зөвхөн санаатайгаар эрх мэдлээ зориуд урвуулан ашигласан, эсхүл давтан, ноцтой буюу илт хайхрамжгүй байдлын улмаас бий болсон зөрчил нь сахилгын арга хэмжээ, эрүүгийн эсхүл иргэний эрх зүйн хариуцлага хүлээлгэх үндэслэл болох ёстой гэсэн үг юм.28

Тиймээс, шүүгч хэрэг хянан шийдвэрлэхдээ хууль тайлбарлах, холбогдох факт эсхүл нотлох баримтыг үнэлэх үйл ажиллагааных нь төлөө иргэний, эрүүгийн эсхүл сахилгын хариуцлага хүлээлгэх үндэслэл болох ёсгүй, энэ нь ердийн хайхрамжгүй байдлын (*ordinary negligence*) хувьд ч мөн адил.

Гэсэн хэдий ч, Европын стандартууд шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх явцад гаргасан шүүгчдийн үйлдэлд эрүүгийн хариуцлага оногдуулахыг зөвшөөрдөг. Гэхдээ, доор дурдсанчлан, ийнхүү хариуцлага оногдуулах шийдвэрийн босго нь маш өндөр байдаг бөгөөд үүнийг CM/Rec (2010/12) зөвлөмжийн тайлбар бичигт мөн дурдсан байдгийг тэмдэглэх нь зүйтэй: “Шүүгч шүүхийн чиг үүргээ хэрэгжүүлэх үедээ хариуцлага хүлээх тохиолдол нь түүний үйлдсэн гэм буруу нь зөвхөн илт санаатай байсан тохиолдлоор л хязгаарлагдах хэрэгтэй.”

Дээр дурдсан хэсгийг ердийн шүүгчдэд зориулж бэлтгэсэн. Гэсэн хэдий ч хуулийн ерөнхий зарчмууд, олон улсын баримт бичгүүдэд тодорхойлогдсон зарчмууд, өмнөх Венецийн комиссын саналууд, ССJE-ийн саналууд, Европын тогтсон стандартуудыг харгалзан үзвэл дээрхийг Үндсэн хуулийн шүүхийн шүүгчдэд хамааруулж болохгүй гэх шалтгаан байхгүй байна.

CDL-AD(2019)028 Бүгд Найрамдах Молдова Улс – Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийн эрүүгийн хариуцлагын тухай *Amicus Curiae* - санал, дүгнэлтийн товч, цогцолбор 25-27.

“Дүгнэж хэлэхэд, Үндсэн хуулийн шүүхийн шүүгчдийн чиг үүргээ хэрэгжүүлэх халдашгүй эрх хамгаалагдах ёстой, гэхдээ үүнд энгийн гэмт

хэргүүд (жишээ нь, хээл хахууль, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсоны улмаас зам тээврийн осол гаргах гэх мэт)-д үл хамаарна. Үндсэн хуулийн шүүхийн шүүгчид буруу санаа зорилго агуулаагүй шүүх ажиллагааны алдаа болон хуулийн тайлбарын зөрүүтэй байдалд хариуцлага хүлээх ёсгүй. Харин, Үндсэн хуулийн шүүхийн шүүгчдийн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ санаатай буюу хүсэл зорилготойгоор эрх мэдлээ урвуулан ашигласан үйлдэлд сахилгын арга хэмжээ авах хэрэгтэй бөгөөд хууль дээдлэх ёс хийгээд Үндсэн хуульд нийцсэн байдлын зарчмууд, стандартаас хэт хазайсан онцгой тохиолдолд л шийтгэл буюу эрүүгийн эсхүл иргэний эрх зүйн хариуцлага хүлээлгэх хэрэгтэй. Ердийн гэмт хэргийг холбогдох эрх бүхий шүүх шийдвэрлэх хэрэгтэй ч, Үндсэн хуулийн шүүхийн шүүгчдийн чиг үүргээ хэрэгжүүлэх явц дахь сахилгын хариуцлагын тухайд зөвхөн Үндсэн хуулийн шүүх өөрөө л шийдэх хэрэгтэй. Процедурын хувьд Үндсэн хуулийн шүүхийн шүүгчид халдашгүй байдал (тухайлбал хянан шалгах байгууллага эрүүгийн хэрэг үүсгэхээс өмнө Үндсэн хуулийн шүүхтэй зөвшилцөх ёстой)-аар хамгаалагдсан байдаг. Гэхдээ, Үндсэн хуулийн шүүх тухайн хэрэг нь шүүгчийн хуулийн саналын илэрхийлэл эсхүл яллах тал эрх мэдлээ илт урвуулан ашиглаж байгаагаас бусад тохиолдолд энэхүү халдашгүй байдлыг хүчингүй болгох үүрэгтэй.”

CDL-AD(2019)028 Бүгд Найрамдах Молдова Улс – Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийн эрүүгийн хариуцлагын тухай *Amicus Curiae* - санал, дүгнэлтийн товч, цогцолбор 33.

“Дүгнэж хэлэхэд, бүрэн эрхийн хугацаандаа Үндсэн хуулийн шүүхийн шүүгч бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ эдэлж байсан чиг үүргийн халдашгүй байдал нь түүний бүрэн эрхийн хугацаа нь дууссаны дараа ч үргэлжилдэг. Бүрэн эрхээ хэрэгжүүлэх хугацааны тухайд, Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийн бүрэн эрхийн хугацаанд үйлдэгдсэн ердийн гэмт хэрэгт энэхүү халдашгүй байдал хэрэглэгдэхгүй, угаасаа эдгээр нь чиг үүргийн халдашгүй байдалд хамаардаггүй.”

CDL-AD(2019)028 Бүгд Найрамдах Молдова Улс – Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийн эрүүгийн хариуцлагын тухай *Amicus Curiae* - санал, дүгнэлтийн товч, цогцолбор 38.

4.7 ШҮҮХИЙН ЕРӨНХИЙЛӨГЧ (ДАРГА)

“17 болон 36 дугаар зүйлд заасны дагуу, хоёр танхимд хэрэг хуваарилах нь шүүхийн даргын бүрэн эрхэд хамаарна. Гэхдээ, Венецийн комиссын зүгээс энэ асуудлын талаар объектив шалгууртай холбоотой заалтыг санал болгож байна. Энэхүү асуудлыг маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны дэгээр зохицуулж болох юм.”

CDL-AD(2002)005 Бүгд Найрамдах Азербайжан Улсын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн төсөлд өгсөн санал, хуудас 8.

“Үндсэн хуулийн шүүхийн даргыг шүүх өөрөө биш, улс төрийн этгээд сонгодог явдал нь нэлээд өргөн тархсан үзэгдэл. Гэсэн хэдий ч, шүүхийн даргыг шүүх өөрөө сонгодог байх нь шүүхийн бие даасан байдлын үүднээс мэдээжийн хэрэг илүүд үзүүштэй.”

CDL-AD(2008)029 Киргизийн (1) Үндсэн хуулийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (2) Үндсэн хуулийн шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 8.

“4(3) дугаар зүйлд, Шүүхийн дарга төсөв батлах асуудлаарх Парламентын чуулганд оролцох эрхтэй гэж заасан байдаг. Энэ заалтыг нааштайгаар хүлээн авах хэрэгтэй.”

CDL-AD(2008)030 Монтенегро улсын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 16.

“Гэхдээ, Унгар улсын одоогийн Үндсэн хуульд зааснаар шүүгчид шүүхийн даргыг өөрсдийн дундаас сонгож байгаа бөгөөд энэхүү тогтолцоо нь ерөнхийдөө Үндсэн хуулийн шүүхийн хараат бус байдлын илүү хүчтэй хамгаалалт гэж ойлгогдож байгааг энд тэмдэглэж байна.”

CDL-AD(2011)016 Унгарын шинэ Үндсэн хуулийн талаарх санал, цогцолбор 94.

“Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 19, 20 дугаар зүйлээр шүүхийн даргад олгогдсон тухайлсан онцгой бүрэн эрхүүд нь ийнхүү аналитик хийгээд тодорхой байдлаар шүүхийн даргын нэр төр болон Үндсэн хуулийн шүүхийн хараат бус байдлын талаарх олон нийтийн ойлголтод нөлөөлж болзошгүй юм. Гэхдээ, хуулийн түвшний зохицуулалт нь хараат бус байдлын баталгаа болж өгдөг.”

CDL-AD(2012)009 Унгарын Үндсэн хуулийн шүүхийн тухай 2011 оны CL I хуулийн талаарх санал, цогцолбор 54(6).

“Хуулийн төслийн 153 дугаар зүйлд Үндсэн хуулийн шүүхийн даргыг шүүхийн гишүүд сонгодог байхаар тусгасан бөгөөд энэ заалтыг Венецийн комисс сайшааж байна (CDL-AD(2012)024, §§ 37-38).

“8 дугаар зүйлд, Үндсэн хуулийн шүүхийн дарга, дэд дарга болон шүүгчдийг улсын Ерөнхийлөгч санал болгож, Парламентаас сонгохоор заасан. Улсын Ерөнхийлөгч нь зөвхөн ёслолын бус бодит гүйцэтгэх эрх мэдэлтэй байдаг ерөнхийлөгчийн тогтолцоо бүхий улсад Ерөнхийлөгч шүүгчийн бүх томилгоог хийдэг байх нь зохисгүй. Парламент өөрийн саналын дагуу ядаж шүүгчдийн нэгээхэн хэсгийг дийлэнх олонхын саналаар шууд сонгох боломжтой байх хэрэгтэй. Гэхдээ ийм өөрчлөлт оруулахын тулд эхлээд Үндсэн хуулийн 56.2, 69.9-д нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай. Түүнчлэн, шүүхийн дарга, дэд даргыг шүүгчид өөрсдөө сонгодог байх хэрэгтэй.”

CDL-AD(2014)017 Тажикстаны Үндсэн хуулийн шүүхийн талаарх Үндсэн хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 12.

“16.3 дугаар зүйлд Үндсэн хуулийн шүүхийн дарга нь Засгийн газар, Парламент, Улсын дээд шүүх болон төрийн бусад байгууллагын чуулган буюу хуралдаанд оролцох эрхтэй гэж заасан. Комиссын төлөөлөгчид, энэхүү заалт нь протоколын асуудлаар (protocol issues) Шүүхийг хангалттай хүндэтгэхэд тус дөхөм болж байгаа талаарх мэдээллийг хүлээн авсан. Олон улс оронд Үндсэн хуулийн шүүхийн дарга нь яг үнэндээ төрийн протоколд гурваас тавд эрэмбэлэгддэг бөгөөд энэ нь төрийн эрх мэдлийн дунд Үндсэн хуулийн шүүхийн ач холбогдлыг илтгэж байна. Протоколын шалтгааны улмаас дээрх 16.3 дугаар зүйл хэвээр хадгалагдан үлдсэн бол, шүүхийн дарга нь гүйцэтгэх, хууль тогтоох эрх мэдэлтэй ойр байгаа мэт сэтгэгдэл төрүүлэхгүйн тулд энэхүү эрхээ бага зэрэг ашиглаж, бусад төрийн эрх мэдлийн ёслолын шинжтэй чуулганд л түлхүү оролцох нь зүйтэй.

Мөн 16.3 дугаар зүйлд Шүүхийн дарга “бусад бүрэн эрх”-ийг хэрэгжүүлэхээр заасан байдаг. Энэхүү бүрэн эрхийн төрөл, эх сурвалжийг нарийвчлан тодорхойлохгүй юм бол дээрх заалтыг хасах хэрэгтэй.

18 дугаар зүйлд Шүүгчдийн аль нэг нь шүүхийн нарийн бичгийн даргын үүргийг гүйцэтгэхээр заасан. Энэ албан тушаал нь дэд даргын албан тушаалаас өөр юм. Нарийн бичгийн даргыг эхлээд шүүхийн дарга нэр дэвшүүлэх буюу санал гаргах (16.1.11 дугаар зүйл) бөгөөд үүний дараа нийт шүүгчид эцсийн байдлаар сонгодог (18 дугаар зүйл). Шүүхийн ажлын өндөр

ачааллаас үүдэн шүүгч гэхээсээ илүү албан хаагч нарийн бичгийн даргатай байх нь илүү үр дүнтэй байж болох юм. Гэхдээ, стандарттай холбоотойгоор ямар нэгэн асуудал байхгүй.”

CDL-AD(2014)017 Тажикстаны Үндсэн хуулийн шүүхийн талаарх Үндсэн хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 30-32.

“17 дугаар зүйлээр Үндсэн хуулийн шүүхийн даргад нийтлэг бүрэн эрхийг олгосон. Түүнд олгогдсон бүрэн эрхүүдийн дунд, 2 дугаар цогцолборт Шүүхийн дарга нь “төрийн эрх бүхий бүхий л албан тушаалтнуудтай холбогдуулан Үндсэн хуулийн шүүхийн бие даасан байдлыг хадгалахад анхаарч ажиллана” гэж заасан нь сайшаалтай.

CDL-AD(2014)033 Монтенегрогийн Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 26.

“... Венецийн комиссын зүгээс Үндсэн хуулийн шүүхийн даргыг шүүгчид өөрсдөө сонгодог байхыг сайн туршлага гэж үзэж байгаа хэдий ч, энэ талаар тодорхой Европын стандарт байхгүй байгааг харьцуулсан судалгаа харуулж байна.

(...)

Ийм тогтолцоонд маш цөөхөн сонгогч (өнөөгийн нөхцөлд арван хоёр, томилгооны асуудал шийдэгдсэний дараа 15) байгаа үед харьцангуй өндөр буюу гурван нэр дэвшигчийг (25 хувь эсвэл 20 хувь) сонгох ёстой. Шүүгч бүрийг ганц саналаар хязгаарлах нь Ерөнхий Ассамблейн хүсэл зоригтой харьцуулахад холбогдох үр дүнг ноцтой гажуудуулахад хүргэх магадлалтай байна. Гурав дахь, магадгүй хоёр дахь нэр дэвшигчийг маш цөөхөн эсвэл бүр ганц шүүгчийн, магадгүй өөрийнх нь саналаар нэр дэвшүүлэх нөхцөл байдал амархан үүсэхээр байна. Иймэрхүү нөхцөл байдлаас зайлсхийх хэрэгтэй бөгөөд шүүгч бүрд Польшийн Ерөнхийлөгчид танилцуулахад шаардлагатай нэр дэвшигчдийн тоотой тэнцэх хэмжээний санал өгөх арга замыг сонгох нь илүүд үзүүштэй. Гагцхүү тус систем _нь Ерөнхийлөгчид оруулж буй санал шүүгчдийн цөөнхийн хүсэл зоригийг тусгасан дур зоргын үр дүн гэхээс илүүтэй Ерөнхий Ассамблейн хүсэл зоригийг төлөөлж буй нь Үндсэн хуулийн 194 дүгээр зүйлд заасан зорилттой зөрчилдөж байгаа мэт болохыг баталж чадна.”

CDL-AD(2016)026, Польш - Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн талаарх санал, цогцолбор 27, 29.

“Шүүхийн даргад хэт их эрх мэдлийг өгчээ. Үүний нэг тод жишээ бол маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны дэг зэрэг норматив актуудыг гаргах эрх мэдлийг шүүхийн даргад өгсөн (17.4 дүгээр зүйлийн 7 хэсэг) бөгөөд үүнийг Үндсэн хуулийн шүүхийн хуралдаанд үлдээх хэрэгтэй.”

CDL-AD(2017)011 Армен - Үндсэн хуулийн шүүхийн талаарх Үндсэн хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 52.

4.8 ШҮҮХИЙН БИЕ ДААСАН БАЙДАЛ

“Шүүхийн бие даасан байдалд тавигдах үндсэн шаардлага нь ердийн болон Үндсэн хуулийн шүүхийн шүүгчдийн хувьд адилхан. Гэхдээ, Үндсэн хуулийн шүүхийн шүүгчид нь тэдгээрийн албан тушаалын онцлог байдлаас шалтгаалж төрийн бусад эрх мэдлүүдээс шүүмжлэл болон шахалтад өртөмтгий байдаг ба улс төрийн аливаа нөлөөллийн оролдлогоос хамгаалагдсан байх ёстой. Иймд, Үндсэн хуулийн шүүхийн шүүгчдийн хараат бус байдлыг хангахын тулд одоо мөрдөж буй III бүлэгт заасан тусгай баталгаа зайлшгүй шаардлагатай бөгөөд үүнийг хасах хэрэггүй юм.”

“Үндсэн хуулийн шүүх нь үндсэн хуулийн тусгай байгууллага болохынхоо хувьд Шүүгчдийн зөвлөл, эсхүл Засгийн газрын хөндлөнгийн оролцоогүйгээр төсвөө Парламентад шууд танилцуулах эрхтэй байх хэрэгтэй. Үндсэн хуулийн шүүхийн төсөв шүүхийн нэгдсэн төсвийн нэг хэсэг байж болохгүй.”

CDL-AD(2008)029 Киргизийн (1) Үндсэн хуулийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (2) Үндсэн хуулийн шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 14, 35.

“Шүүх өөрийн санаачилгаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлэх ерөнхий эрх мэдэл нь шүүхийг улс төрийн субъект болгож, шүүх өөрийн бие даасан байдлаа алдаж болзошгүй юм. Маргаан үүсгэх, эсхүл үүсгэхгүй байх шийдвэр бүрийг улс төрийн сонголт хэмээн шүүмжилж болно. Тиймээс, Шүүх үндсэн хуульд нийцсэн эсэхэд эргэлзсэн хэм хэмжээг хэрэглэх тохиолдолд л гагцхүү өөрийн санаачилгаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлдэг байхаар хязгаарлагдах хэрэгтэй.”

CDL-AD(2008)030 Монтенегро улсын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 50.

“Шүүх нь шүүхийн тамгын газрын дарга (а Chief Clerk) болон “хангалттай тооны” захиргааны ажилтантай байх ёстой бөгөөд тэдгээрийг Шүүхийн

дарга болон Хууль зүйн сайд нар “өөрсдийн бүрэн эрхийнхээ хүрээнд”, түүнчлэн Шүүхийн бүрэн эрхийн талаарх хуульд заасны дагуу удирдана. Хоёр эрх бүхий этгээдээс хэрэгжүүлэх энэхүү удирдлагын схем нь практикт удирдлага хуваарилалтын талаар маргаан үүсгэх аюултай байна. Үндсэн хуулийн шүүхийн захиргааны ажилтнуудыг Хууль зүйн сайд удирдаж байгаа нь шүүхийн хараат бус байдалд аюул учруулж байна.”

CDL-AD(2009)014 Палестин улсын Үндсэн хуулийн дээд шүүхийн тухай хуулийн талаарх санал, цогцолбор 42.

“Парламентын гишүүдийг эрх ямбатай элит гэж харагдуулахгүйн тулд тэдний цалинг бүрэн ил тод болгох хэрэгтэй: “Гишүүнд төлсөн цалингийн нийт дүнгийн талаарх мэдээллийг олон нийтэд нээлттэй байлгах ёстой. “Үндсэн хуулийн шүүхийн шүүгчид ч гэсэн ийм журам гаргах хэрэгтэй.”

“Өмнө нь шүүхэд ажиллаж байсан шүүгч нарт өмгөөлөгч, их дээд сургуулийн багш байсан Үндсэн хуулийн шүүхийн шүүгчдээс ялгаатайгаар буюу 2 долоо хоног хүртэлх нэмэлт амралтын хугацаа эдлэхээр тусгай давуу байдал тогтоосон нь шүүгчид хоорондын эрх тэгш байх зарчимд харшилж байх шиг байна.”

“Ерөнхийдөө, урамшууллын зохицуулалт (Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 39-р зүйл) нь үзэмжийн элементийг агуулдаг. Цалин хөлсийг шүүгчийн хувийн гүйцэтгэлийн үнэлгээнд бус ерөнхий стандартад үндэслэх ёстой. Ядаж, үзэмжийн элементийг агуулж байдаг урамшууллыг хасах хэрэгтэй.”

CDL-AD(2009)042 Латвийн Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд өгсөн санал, цогцолбор 24, 27, 29.

“Үндсэн хуульд тодорхой хориглосон заалт байхгүй бол онцгой нөхцөл байдал болон тусгай тохиолдолд л шүүгчийн цалинг бууруулахыг зөвтгөж болох бөгөөд үүнийг шүүхийн бие даасан байдалд халдсан гэж үзэж болохгүй. Эдийн засгийн хямралаас шалтгаалж шүүгчдийн цалинг бууруулах явцад цалин хөлс нь шүүгчийн мэргэжлийн нэр төр, түүний хүлээх үүрэг хариуцлагад нийцэж байгаа эсэхэд зохих анхаарлыг тавих хэрэгтэй.”

CDL-AD(2010)038 Сонгогдсон болон томилогдсон албан хаагчдын цалин хөлсний тогтолцоотой холбоотой хэд хэдэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн талаар “хуучин Югославын Бүгд Найрамдах Македон Улс”-ын Үндсэн хуулийн шүүхэд гаргасан Amicus Curiae - санал, дүгнэлт, цогцолбор 11.

“Шүүгчдийн хараат бус байдлыг хамгаалахын тулд, Үндсэн хуулийн шүүхийн дарга болон бусад шүүгчдийн (болон ердийн шүүхийн шүүгчдийн) цалинг хуулиар тогтоох хэрэгтэй бөгөөд тус төсвийн асуудлаар жил бүр Парламентын чуулганаар хэлэлцүүлэх хэрэггүй. Хэрэглэгдэх коэффициентийг Үндсэн хуулийн шүүхийн тухай хуульд өөрт нь тусгах хэрэгтэй.”

CDL-AD(2011)050 Сербийн Үндсэн хуулийн шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийн талаарх санал, цогцолбор 18.

“Үндсэн хуулийн шүүх, түүний шүүгчийн хараат бус байдлыг хуулийн төслийн 1.2 болон 8 дугаар зүйлд тусгасан. 1.2 дугаар зүйлд Үндсэн хуулийн шүүхийн бие даасан байдлын тухай Үндсэн хуулийн заалтыг давтаж, шүүхийн бие даасан байх шаардлагыг зөвхөн шүүхийн захиргаагаар хязгаарласан. Гэвч, шүүхийн бие даасан байдал нь захиргааны хийгээд санхүүгийн аспекттай гэдгийг санах нь зүйтэй. Хэдийгээр 5.6 дугаар зүйлд Үндсэн хуулийн шүүх бүрэлдэхүүнээ өөрөө бүрдүүлж, өөрийн санхүүгээ бие даан захиран зарцуулна гэж заасан ч, энэ нь захиргааны болон санхүүгийн хараат бус байдлыг бүхэлд нь хамрахгүй байна.”

CDL-AD(2017)011 Армен - Үндсэн хуулийн шүүхийн талаарх Үндсэн хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 8.

“Хууль зүйн тодорхой байдал болон шүүхийн хараат бус байдал нь Босни Герцеговин улсын дагаж мөрддөг олон улсын баримт бичиг, ялангуяа Хүний эрхийн тухай Европын конвенц, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын фактад тусгагдсан зарчмууд билээ. Хууль эрх зүйн тодорхой байдал болон шүүхийн хараат бус байдлын зарчмуудыг НҮБ болон Европын Зөвлөлөөс баталсан зөвлөмжийн чанартай баримт бичгүүдэд (soft law) илүү дэлгэрэнгүй тодорхойлж, олон улсын шүүхийн жишгээр төгөлдөржүүлж байна.”

(...)

А. Ерөнхий

Шүүхийн бие даасан байдал нь тухайн улсын тогтолцоо ямар байхаас үл хамаарч бүх улсад хамааралтай асуудал бөгөөд, энэ нь ардчилсан дэглэм болон эрх мэдлийн хуваарилалтыг хүндэтгэх явдалтай холбогддог. Шүүхийн бие даасан байдал нь хууль дээдлэх ёс, ардчилал, хүний эрхийг дээдлэх явдлын үндсэн баталгаа юм. Энэ нь шударга ёс нь төрийн бусад эрх мэдлийн салбар, шүүх эрх мэдлийн бусад байгууллага, бусад шүүгч эсвэл бусад этгээдийн зүй бус хөндлөнгийн оролцоогүйгээр хэрэгжих, хэрэгжиж

байна гэж харагдах нөхцөлийг хангадаг. Энэхүү бие даасан байдал нь объектив болон субъектив бүрэлдэхүүнтэй. Объектив бүрэлдэхүүн нь шүүхээс салгаж үл болох буюу зайлшгүй чанар бол, субъектив бүрэлдэхүүн нь хувь хүний эрх, эрх чөлөөгөө хараат бус шүүхээр шийдвэрлүүлэх эрх юм. Энэ зарчмыг Европын түвшинд ХЭЕК-ийн 6 дугаар зүйл болон Европын Холбооны суурь эрхийн дүрмийн 47 дугаар зүйлүүдээр хамгаалдаг.

Шүүхийн бие даасан, хараат бус байдлыг “институтийн” болон “хувь хүний” гэсэн хоёр хэлбэртэй гэж үзэж болох юм. Институтийн бие даасан байдал гэдэг нь төрийн эрх мэдлийн хуваарилалт болон шүүх эрх мэдэл нь хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлээс ямар нэгэн дарамтгүйгээр хэрэгжих чадамжийг хэлнэ. Хувь хүний хараат бус байдал гэдэг нь шүүгчид аливаа улс төрийн болон бусад дарамт шахалтгүйгээр хэрэг маргаануудыг шийдвэрлэх чадамжийг хэлнэ.

НҮБ-ын 1985 оны Шүүхийн бие даасан байдлын суурь зарчмуудад “Шүүхийн бие даасан байдлыг төр баталгаажуулах бөгөөд, үүнийг Үндсэн хууль болон бусад хуульд тусгах ёстой” гэж заасан байдаг. Шүүхийн бие даасан байдлыг хүндэтгэн сахих нь төрийн байгууллагуудын үүрэг мөн. Уг баримт бичигт шүүхийн үйл ажиллагаа зохисгүй, үндэслэлгүй хөндлөнгийн оролцооноос ангид байх, шүүхийн шинж чанартай бүхий л асуудлыг шүүх дангаар харьяалдаг байх, шүүхийн шийдвэрийг шүүхийн бус эрх мэдэл хянахаас ангид байх, шүүн таслах ажиллагааг шударга явуулах, талуудын эрхийг хүндэтгэх, шүүгчийн албаны хамгаалалт хийгээд хувь шүүгч нарын бүрэн эрхийн баталгаа зэрэг шүүхийн бие даасан байдлын хэд хэдэн нөхцөлийг жагсаасан байдаг.

Европын хүний эрхийн шүүх хэд хэдэн хэрэг дээр шүүхийн бие даасан байдлын асуудлыг авч хэлэлцсэн. Брайан эср. Нэгдсэн Вант Улс (Bryan v. The United Kingdom) (1995) хэргийг шийдвэрлэхдээ, шүүхээс “Аливаа байгууллагыг “бие даасан” гэж тооцож болох эсэхийг тогтоохын тулд, тухайлбал, түүний гишүүдийг томилох арга барил хийгээд тэдний бүрэн эрхийн хугацаа, гаднын дарамт шахалтаас хамгаалагдах баталгаа байгаа эсэх, тус байгууллага нь хараат бус байдлын дүр төрхтэй байгаа эсэх гэсэн асуултуудад анхаарал хандуулах ёстой” гэж үзсэн. Тус шүүхээс, Делкурт эср. Бельги (Delcourt v. Belgium) (1970) хэргийг шийдвэрлэхдээ, хараат бус байдал болон шударга байдлын зарчмууд нь шүүгчээс холбогдох хэрэг маргааны өмнөх шатанд оролцсон байдал, тухайн хэрэг маргааны талууд

эсхүл уг маргааны асуудалтай ямар нэгэн хувийн мөнгөний холбоо сүлбээ зэргээс шалтгаалж урьдчилсан холбоогүй байх эсхүл тийм үзэл бодолгүй байхыг шаарддаг, гэдгийг онцолсон.

В. Институтийн бие даасан байдал

Шүүх эрх мэдэл хараат бус хийгээд шударга байх ёстой. Шүүхийн институтийн бие даасан байдал нь шүүх эрх мэдэл төрийн бусад эрх мэдлүүдээс хараат бус байх явдалд төвлөрдөг (институтийн гадаад хараат бус байдал). Шүүхийн нэг тогтолцоо дахь шүүх хоорондын харилцааг ч мөн харгалзан үзэх шаардлагатай (институтийн дотоод хараат бус байдал).

Институтийн бие даасан байдлыг дөрвөн шалгуураар үнэлж болох юм. Нэгдүгээр шалгуур бол захиргааны асуудлын хүрээн дэх бие даасан байдал. Энэ нь шүүх эрх мэдэл захиргааны асуудлаа өөрөө зохицуулж, гаднын хөндлөнгийн оролцоогүйгээр шийдвэрээ гаргах боломжтой байхыг хэлнэ. Шүүх нь мөн хэргийн хуваарилалтын асуудлыг шийдэхдээ бие даасан байх хэрэгтэй. Хоёр дахь шалгуур бол шүүх эрх мэдэл санхүүгийн асуудлын хүрээн дэх бие даасан байдал юм. Шүүхэд чиг үүргээ зохих ёсоор хэрэгжүүлэхэд хангалттай хэмжээний хөрөнгө олгож, эдгээр хөрөнгийг хэрхэн хуваарилах талаарх асуудлыг шийдвэрлэхэд түүнийг оролцуулах ёстой. Гурав дахь шалгуур бол шүүх шийдвэрээ хараат бусаар гаргах эрх мэдэл. Шүүх эрх мэдэл аливаа хэргийг хөндлөнгийн оролцоогүйгээр чөлөөтэй шийдвэрлэх ёстой. Түүний шийдвэрийг хүндэтгэх (жишээ нь хэрэгжүүлэх) ёстой ба шүүхийн бус эрх мэдлээр хянах боломжгүй байх хэрэгтэй. Дөрөв дэх шалгуур бол хэргийн харьяаллыг хараат бусаар тодорхойлох явдал. Шүүх аливаа хэргийн хувьд харьяалалтай эсэхийг тогтоох эрх мэдлийг дангаараа эдлэх хэрэгтэй. Нэмж дурдахад, Босни Герцеговина улсын хувьд аливаа этгээд улс төрийн албан тушаалаас шүүх эрх мэдлийн албан тушаалд шилжих боломжтой байгаа нь санаа зовоосон асуудал үүсгэж болзошгүй тул үүнээс зайлсхийх хэрэгтэй.

С. Хувийн хараат бус байдал

Хувийн хараат бус байдал гэдэг нь хувь шүүгчид мэргэжлийн үүргээ гүйцэтгэхдээ эдлэх хараат бус байдлыг хэлнэ. Шүүгчид хараат бус хийгээд шударга байх ёстой. Эдгээр шаардлагууд нь төрийн эрх мэдлийг хуваарилах суурь ардчилсан зарчмын салшгүй хэсэг юм. Шүүгчид улс төрийн нөлөөнд автахгүй байж, шүүх эрх мэдэл нь үргэлж шударга байх хэрэгтэй.

Энэхүү шаардлага нь олон аспекттай бөгөөд дараах дөрвөн зүйл нь Босни Герцеговина улсын нөхцөлд онцгой ач холбогдолтой байж болох юм. Эхнийх нь шүүгчдийг томилох хийгээд (албан тушаал) ахиулах асуудал. Шүүгчийн мэргэжлийн карьертай холбоотой бүх шийдвэр нь бодит шалгуурт үндэслэсэн байх ёстой бөгөөд аливаа нэг талыг баримтлах, ялгаварлан гадуурхах явдлаас зайлсхийх ёстой. Шүүгчдийг сонгох, албан тушаал ахиулах сонголт нь мерит зарчим (мэргэжлийн ур чадвар, хувийн ёс зүй / personal integrity/) дээр тулгуурласан байх ёстой. Хоёр дахь нь шүүгчдийн албан тушаалын аюулгүй байдал болон санхүүгийн баталгаа юм. Шүүгчийн бүрэн эрхийн хугацаа нь хуулиар хангалттай баталгаажсан байх ёстой бөгөөд хамгийн хүсэмжит нь шүүгч тэтгэвэрт гарахаар дуусгавар болох хэрэгтэй. Зохих цалин хөлс, хөдөлмөрийн аятай нөхцөлийг мөн хангах ёстой. Дээрх баталгааны аливаа өөрчлөлт нь зөвхөн онцгой тохиолдолд л гарч болно. Гурав дахь аспект нь шүүхийн шийдвэр гаргах бүрэн эрхийн бие даасан байдал юм. Шүүгч бүхэн аливаа хөндлөнгийн нөлөөгүйгээр хэргийг шийдвэрлэх эрх чөлөөтэй байх ёстой. Дөрөв дэх нь шүүгчийн эдлэх (хүний) эрхтэй холбогдоно. Бусад хүмүүсийн нэгэн адил, шүүгчид олон төрлийн хүний эрхийг эдэлдэг ч, эдгээр эрхүүдийн зарим нь (эвлэлдэн нэгдэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө гэх мэт) нь тэдний хувьд онцгой ач холбогдолтой байдаг. Учир нь эдгээр эрхүүд нь хувь шүүгчийн хараат бус байдлыг хангахад тусалдаг. Нөгөөтээгүүр, шүүгчдийн үндсэн эрхүүд нь тодорхой хэмжээгээр хязгаарлагддаг. Жишээлбэл, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө нь төвийг сахих зарчмын нэг хэсэг болох нууцыг хадгалах үүргээр хязгаарлагддаг.»

CDL-AD(2012)014 Босни Герцеговина дахь хууль зүйн тодорхой байдал ба шүүхийн хараат бус байдлын талаарх санал, цогцолбор 7, 74-81.

“Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийг цагдан хорих, эсхүл баривчлах шийдвэрийг Парламентаас гаргах ёстой гэсэн санал гарсан. Энэ нь шүүхийн бие даасан байдлыг улстөржүүлж, шүүхийн бие даасан байдалд аюул учруулах тул мэдээж хүсээд байх зүйл биш.

Бүхий л тохиолдолд, шүүгчийн хараат бус байдал нь зөвхөн чиг үүргийн халдашгүй байдлаар хязгаарлагдах хэрэгтэй. Жирийн шүүгчдийн хувьд, тэдгээрийн халдашгүй байдлыг НСЖ-аас цуцлах байх хэрэгтэй. Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийн хувьд, тэдгээрийн халдашгүй байдлыг холбогдох шүүгчээс бусад шүүгч нараас бүрдсэн шүүхийн нэгдсэн хуралдаанаас цуцлах

хэрэгтэй. Аль аль тохиолдлын хувьд, шүүгчийг хилс хэрэгт буруутгасан илт шинж тэмдэг илрээгүй тохиолдолд HCJ болон Үндсэн хуулийн шүүх тус тус халдашгүй байдлыг цуцалсан шийдвэрийг гаргах хэрэгтэй. Эрүүгийн хэрэг, ялангуяа авлигын хэргүүдийг хараат бус шүүхэд үлдээх хэрэгтэй.”

CDL-AD(2013)014 Шүүгчийн хараат бус байдлыг бэхжүүлэх Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн тухай хуулийн төсөл (тайлбар, хүснэгт багтсан) болон Украины Үндсэн хуулийн ассамблейгаас өргөн мэдүүлсэн Үндсэн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 49.

“Нэг талаас шүүгчийг төрийн эрх мэдлүүд, эсхүл хувь этгээдийн зүй бус дарамт шахалт, халдлагаас хамгаалах хэрэгсэл болох халдашгүй байдал (immunity) болон, нөгөө талаас шүүгч нь хуулийн дээр байдаггүй гэх факт (accountability - хариуцлага) хоёрын хоорондын балансыг олох нь чухал юм. Венецийн комиссын зүгээс шүүгчдэд ерөнхийлсөн халдашгүй байх эрх бус, харин гагцхүү чиг үүргийн халдашгүй байх эрхийг олгох хэрэгтэйг байнга онцлон тэмдэглэж ирсэн. Учир нь зарчмын хувьд шүүгч нь хуулиар олгогдсон чиг үүргээ хэрэгжүүлэхдээ л халдашгүй байх эрхээ эдлэх хэрэгтэй. Иймд хуулийн төслийн 10.1 дэх заалтыг шинэчлэн найруулах хэрэгтэй.

Ямартай ч энэхүү заалтыг, зарчмын хувьд шүүгчийг хариуцлага хүлээхгүй, харин зарим тохиолдолд л Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрээр шүүгчийн халдашгүй байдлыг цуцлах боломжтой байхаар дахин найруулах хэрэгтэй байна. Нэмж дурдахад, халдашгүй байдлыг цуцлах нөхцөлүүд (доор байгаа эрүүгийн хариуцлага гэсэн хэсгийг үз) нь хатуу чанд бөгөөд ердөө «гэмт хэргийн эсвэл сахилгын зөрчлийн бүрэлдэхүүн»-ийг дурдахаас илүү нарийвчилсан байх хэрэгтэй.

CDL-AD(2017)011 Армен - Үндсэн хуулийн шүүхийн талаарх Үндсэн хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 36-37.

“11.1 дүгээр зүйлд Үндсэн хуулийн шүүхийн шүүгчид нь “албан үүргээ гүйцэтгэж, хэрэг маргаан хянан шийдвэрлэж байхдаа” гагцхүү Үндсэн хууль болон энэ хуулийг дагаж мөрдөнө гэж заасан. Энэ нь шүүн таслах ажиллагааны явцад шүүгчид бусад хуулийн баримт бичгүүдэд захирагдах явдлыг байхгүй болгосон. Хууль тогтоомжийн үндсэн хуульд нийцсэн байдлын талаас авч үзвэл, шүүгчийн “албан үүрэг үүргээ гүйцэтгэж байх үедээ” хуулийн бусад бичвэрт захирагдах явдлыг байхгүй болгож, тэрхүү хуулийн бичвэрүүдийн хууль зүйн хүчин чадал (жишээлбэл, албан томилолтын тухай журам гэх мэт)-ыг шууд үгүйсгэж болохгүй.

CDL-AD(2014)017 Тажикстаны Үндсэн хуулийн шүүхийн талаарх Үндсэн хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 17.

“Хуулийн төслийн 2 дугаар зүйлд, Үндсэн хуулийн шүүхийн бие даасан байдлыг хуульд тодорхой тусгах нь зүйтэй гэсэн Венецийн комиссын өмнөх зөвлөмжийг хүлээн авсан байна. Энэхүү 2 дугаар зүйлд Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрүүд болон маргаан бүхий хэм хэмжээний талаарх Үндсэн хуульд нийцсэн тайлбар нь төрийн бүх байгууллагуудад заавал биелэгдэх шинжтэй байна гэсэн заалтыг хавсаргах хэрэгтэй.”

“Хуулийн төслийн 104, 105 дугаар зүйлтэй холбогдуулж 4 дүгээр зүйлээр Үндсэн хуулийн шүүхийн санхүүгийн бие даасан байдлыг хангасан байгаа нь сайшаалтай. 4 дүгээр зүйлд мөн Үндсэн хуулийн шүүхийн төсөв болон “үйл ажиллагааны нөхцөл”-ийг төрөөс хангана гэж заасан. Эдгээр нөхцөлүүдийг бүхэлд нь Үндсэн хууль, Үндсэн хуулийн шүүхийн тухай хууль болон түүний маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны дэгээр зохицуулах ёстой.”

CDL-AD(2014)033 Монтенегрогийн Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 9, 11.

“Хуулийн төслийн 10.6 дугаар зүйлд зааснаар хайх, шинжилгээ хийх, баримт бичиг буюу эд зүйлсийг хураан авах зорилгоор Үндсэн хуулийн шүүхийн даргад мэдэгдсэнээр Үндсэн хуулийн шүүхийн байр руу нэвтэрч болно. Ердөө Үндсэн хуулийн шүүхийн даргад мэдэгдэх нь хангалттай гэж бодогдохгүй байна. Шүүгчийн хараат бус байдлыг харгалзан үзвэл, эдгээр арга хэмжээг авах үндэслэл, түүнчлэн Үндсэн хуулийн шүүхийн байранд хэн нэвтэрч болох, ямар бичиг баримт, эд зүйлд нэгжлэг хийх, шинжилгээ хийх, хураахыг хэн шийдэхийг тодорхой тусгах хэрэгтэй. Энд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаарх ерөнхий заалт нь хангалттай юу, эсвэл тусгайлсан заалтыг шинээр оруулах шаардлагатай юу гэдэг нь тодорхойгүй байна.”

CDL-AD(2017)011 Армен - Үндсэн хуулийн шүүхийн талаарх Үндсэн хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 44.

Хуулийн төслийн 13.2 дугаар зүйлд заасан “Сахилгын томоохон зөрчил”-д хүлээлгэх хариуцлагын хүнд шинж чанарыг харгалзан, мөн Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийн хараат бус байдлыг хангах үүднээс, сахилгын томоохон зөрчлүүдийг хуулийн төсөлд тусгах хэрэгтэй.”

CDL-AD(2017)011 Армен - Үндсэн хуулийн шүүхийн талаарх Үндсэн хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 49.

4.9 ШҮҮХИЙН ДОТООД БҮТЭЦ – ТАНХИМУУД

“Гэсэн хэдий ч шүүхийг хоёр танхимд хуваахад гарах аюулыг бид харж болохоор байна. Тэрээр бэрхшээлтэй асуудлууд нь юу байж болох вэ гэвэл: зөрүүтэй тайлбарууд болон шүүхийн шийдвэрийн зөрүүтэй урсгалууд бий болох, хоёр танхим хооронд хэрэг маргааныг хуваарилах асуудал, хоёр танхимын хоорондын харьяаллын зөрчлийг шийдвэрлэх явдлыг дурдаж болно. Хуулийн төслийг санаачлагчдын зүгээс танхимуудын шийдвэр хоорондын боломжит зөрчилдөөнт байдлыг шүүхийн дээд хуралдаанаар шийдвэрлэх боломжтой гэж үзсэн. Процедурын нарийвчилсан дүрмүүд нь хэргийн шударга хуваарилалтад анхаарлаа хандуулах хэрэгтэй. Нийт шүүгчийн хуралдааны хяналтын чиг үүрэг нь мөн тодорхой хэргийг аль танхим харьяалах эрхтэй вэ гэх асуудлын талаарх танхим хоорондын зөрчлийг шийдвэрлэх боломжтой.»

CDL-AD(2004)024 Үндсэн хуулийн шүүхийн талаарх Туркийн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд өгсөн санал, цогцолбор 13.

“Есөн шүүгчтэй (зургаан хүний хүчинтэй ирцтэй) Шүүхийн бүрэн эрхийг гурван шүүгчийн бүрэлдэхүүн бүхий панелд шилжүүлэх нь эргэлзээтэй хэвээр байна. 16(1), 17(2) болон 18 дугаар зүйлүүд нь “түр” хороог 11 дүгээр зүйл (амралтын өдрүүд)-д зааснаас бусад тохиолдолд шийдвэр гаргах эрхтэй учир түүнийг “байнгын ажиллагаатай” байна хэмээн таамагласан байж ч болохоор харагдаж байна. Ийм хороог байгуулахаас өмнө бусад харилцаа холбооны хэрэгслийг, жишээлбэл видео эсвэл бүр үүрэн холбооны хурлыг ашиглаж дууссан байх хэрэгтэй. Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны дэгд яаралтай буюу онцгой процедур нь шүүгчдийг хэрэг шийдвэрлэх ажиллагаанаас гаргахын тулд ашиглагдаж болохгүй гэдгийг тодорхой зааж өгөх хэрэгтэй.»

CDL-AD(2009)014 Палестин улсын Үндсэн хуулийн дээд шүүхийн тухай хуулийн талаарх санал, цогцолбор 17.

“Цаашилбал, Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 13.f-д заасны дагуу шүүхийн даргад “бодит эсхүл хууль зүйн боломжгүйн улмаас танхим хуралдаж чадахгүй байгаа тохиолдолд өөр танхимаас гишүүдийг томилж хуваарилах” эрх олгогдсон. Rec(2000)12, 24 дүгээр цогцолборт «Шүүх доторх хэргийн хуваарилалтыг хийхдээ хараат бус хийгээд шударга байх шүүгчийн эрхийг хангах үүднээс урьдчилан тогтоосон объектив шалгуурыг баримтлах хэрэгтэй» гэж дурдсаныг дахин сануулж болох юм. Үүнд тухайн хэргийн оролцогч болон тухайн хэргийн үр дүнд ашиг сонирхол бүхий

хэн нэгэн этгээдийн хүсэл сонирхол нөлөөлж болохгүй.” Тиймээс, нөгөө танхимаас гишүүдийг томилох шаардлагатай гэж үзвэл, үүнийг сугалаагаар эсвэл урьдчилан тохиролцсон жагсаалтаар явуулах хэрэгтэй.”

“Үндсэн хуулийн шүүхийн танхимын бүрэлдэхүүнийг, танхим бүрд өөр өөр салбарын гишүүдийг хуваарилах замаар шүүхийн холимог бүрэлдэхүүнийг харгалзаж тодорхой зохицуулах хэрэгтэй. Ad hoc буюу нэг удаагийн бүрэлдэхүүнээр аливаа хэрэгт нөлөөлөх боломжийг бий болгохгүйн тулд шүүхийн бүрэлдэхүүнийг урьдчилан тодорхой хугацааны өмнө тогтоох хэрэгтэй.”

“Өөр танхимд гишүүдийг томилохдоо үүнийг сугалаагаар эсвэл урьдчилан тохиролцсон жагсаалтын дагуу хийх хэрэгтэй.”

CDL-AD(2011)040 Туркийн Үндсэн хуулийн шүүхийн байгуулал, процедурын тухай хуулийн талаарх санал, цогцолбор 29, 104(3),104(5).

“129 дүгээр зүйлд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үндсэн зарчимд хэргийг автоматаар хуваарилах зарчмыг нэмж тусгана. “Шүүхийн тогтолцооны бие даасан байдлын тухай тайлангийн I хэсэг: Шүүгчдийн хараат бус байдал”-д дурдагдсан асуудлын талаар Венецийн комисс дараах үзэл бодолтой байна:

“80. Шүүхийн шударга байдал хийгээд хараат бус байдлыг нэмэгдүүлэхийн тулд шүүгчдийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дарааллыг ерөнхий шалгуурын үндсэн дээр тогтоохыг зөвлөж байна. Үүнийг жишээ нь цагаан толгойн үсгийн дарааллаар, компьютержсон системийн үндсэн дээр эсвэл хэргийн ангилал зэрэг объектив шалгуурын үндсэн дээр хийж болно. Энэхүү ерөнхий дүрмийг (үүнд онцгой тохиолдлуудыг оруулаад) хуулиар эсхүл хуульд үндэслэсэн тусгай дүрмүүдээр, жишээлбэл шүүхийн нийт шүүгчийн хуралдаан эсвэл шүүхийн даргын гаргасан шүүхийн журмуудаар хэлбэржсэн байх хэрэгтэй. Бүх тохиолдолд үйлчилдэг буюу хэрэг хуваарилах асуудлын талаар ямар нэгэн маргаан гаргахгүй байх бүрэн цогц абстракт тогтолцоог бий болгох нь үргэлж боломжтой байгаад байдаггүй. Шүүгчдийн ажлын ачаалал, мэргэшлийг харгалзан үзэх шаардлагатай нөхцөл байдлууд байж болно. Ялангуяа нарийн төвөгтэй хуулийн асуудлуудад тухайн чиглэлээр мэргэжисэн шүүгчид оролцох шаардлагатай болдог. Мөн, шинээр томилогдсон шүүгчдийг тодорхой хугацаанд илүү туршлагатай гишүүдтэй нэг бүрэлдэхүүнд оруулах нь оновчтой

байж болно. Түүнчлэн, шүүхээс ээдрээтэй, чухал асуудалд зарчмын шинжтэй дүгнэлт гаргах шаардлагатай тохиолдолд ахмад шүүгчдийг энэхүү хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах нь ухаалаг хэрэг байж болно. Гэхдээ, шүүхийн дарга эсхүл нийт шүүгчийн хуралдаанаар ийм шийдвэр гаргах шалгуурыг урьдчилж тодорхойлсон байх хэрэгтэй. Энэхүү хуваарилалтыг хяналттай болгох нь хамгийн хүсэмжит хувилбар байж болох юм.

81. Дүгнэж хэлэхэд, Венецийн Комиссын зүгээс шүүгч нарт хэргийг хуваарилахдаа хуулиар эсхүл хуульд үндэслэсэн тусгай журмуудад, жишээ нь шүүхийн дүрмүүдэд урьдчилан тусгасан бодитой хийгээд ил тод шалгуурыг аль болох дээд хэмжээнд баримтлахыг зөвлөж байна. Онцгой тохиолдлуудыг хэрэгцээтэй үед нь л тусгах хэрэгтэй.”

“Хэрэв шүүх бүрэн бүрэлдэхүүнээрээ хуралдах ёстой гэсэн шаардлага байнга тавигддаг бол энэ нь шүүхийн үйл ажиллагаанд ихээхэн дарамт учруулна. Хуулийн 26.1.1.г зүйлийг асуудалтай харагдуулж байгаа зүйл бол бусад шүүгч ийм хүсэлтээс татгалзах боломжгүй байгаа явдал юм. Шүүхийг бүрэн бүрэлдэхүүнээрээ хуралдах талаар санал тавьж болдог системтэй улсад (жишээ нь Австри), тус саналыг хүлээж авахгүй байх нэгдсэн хуралдааны чадамжийн талаар ямар нэгэн хязгаарлалт байдаггүй, эсхүл хэрэв [хэлэлцэх] хэрэг нь Үндсэн хуулийн хүрээнд ноцтой асуудал үүсгэхгүй гэж үзсэн тохиолдолд нэгдсэн хуралдаан тухайн хүсэлтийг шуурхай буюу түргэвчилсэн журмаар шийдвэрлэх боломжтой байдаг. Польшид үүнтэй төстэй арга барилыг баталсан нь эдгээр бэрхшээлээс зайлсхийх боломжтой нь харагдсан.

(...)

... Бусад шүүгчдийн хувьд шилжүүлэх хүсэлтээс татгалзах боломж байхгүй тохиолдолд улс төржих болон шүүх бүрэлдэхүүний үр дүнтэй ажиллахад нь саад учруулах эрсдэлтэй.”

“Үндсэн хуулийн шүүхийн үйл ажиллагааны зохион байгуулалтын талаарх 4 дүгээр бүлэгт нэмж оруулах бусад зүйлсийн талаар бодолцож болох юм. Жишээлбэл, Хэрэг хянан шийдвэрлэх дэгийн талаар, Үндсэн хуулийн шүүхийн бүтэц, үйл ажиллагааны журмыг Үндсэн хуулийн шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дэгд заах ба үүнийг нийт шүүгчдийн үнэмлэхүй олонхын саналаар батална гэж тайлбарласан зүйл заалт байж болох юм.”

CDL-AD(2017)011 Армен - Үндсэн хуулийн шүүхийн талаарх Үндсэн хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 57.

4.10 ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА, АЖИЛТАН, МЭРГЭЖИЛТЭН

“Хуулийн төслийн 21 дүгээр зүйлд нэр дэвшигч Ерөнхий нарийн бичгийн даргаар томилогдоход ямар шаардлагыг хангасан байх ёстойг тодорхойлсон. 24 дүгээр зүйлд Үндсэн хуулийн шүүхийн зөвлөхөд тавигдах шаардлагыг тодорхойлсон. Аль аль тохиолдолд нэр дэвшигчид хуулийн чиглэлээр төгссөн, мөн 7 жилийн ажлын туршлагатай байх ёстой. Үндсэн хуулийн шүүхийн үйл ажиллагааг зохион байгуулахад Ерөнхий нарийн бичгийн даргын үүрэг чухал байдаг тул Ерөнхий нарийн бичгийн даргыг томилохдоо илүү хатуу шаардлага тавих нь зүйтэй болов уу. Шүүхэд шаардлагатай уян хатан байдлыг хангахын тулд Ерөнхий нарийн бичгийн даргын бүрэн эрхийг хуулиар бус харин маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны дэгээр тодорхойлох хэрэгтэй.

23 дугаар зүйлд Үндсэн хуулийн шүүхийн зөвлөхүүд зөвлөх чиг үүргээ хэрэгжүүлэхдээ Ерөнхий нарийн бичгийн даргын зааврыг бус зөвхөн Үндсэн хуулийн шүүхийн шүүгчдийн зааврыг дагаж мөрдөнө гэж заах хэрэгтэй.

26-р зүйлд Шүүх “тухайлсан мэргэжлийн үйл ажиллагаа явуулахын тулд шинжээчдийг ажиллуулж болно” гэж заасан. Ийм шинжээчдийг ажиллуулах журмыг маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны дэгд тусгаж өгөх хэрэгтэй.”

CDL-AD(2014)033 Монтенегрогийн Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 27-30.

“Хуулийн төсөлд Засгийн газарт Үндсэн хуулийн шүүхэд хяналт тавих бүрэн эрхийг олгосон байх бөгөөд энэ нь шүүхийн бие даасан байдалд заналхийлж болзошгүй. Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох (Шүүхийн даргын санал болгосны үндсэн дээр байлаа ч гэсэн) Засгийн газрын бүрэн эрх (28 дугаар зүйл), Нарийн бичгийн газрын зохион байгуулалт (27.2) болон түүнийг Төрийн аудитор бүхий Сангийн сайд томилох (32-р зүйл) журмууд нь шүүхийг засгийн газрын хяналтад байлгах эрсдэлтэй: Ерөнхий нарийн бичгийн дарга болон төрийн аудиторыг Засгийн газрын хөндлөнгийн оролцоогүйгээр Шүүх эсвэл шүүхийн дарга шууд томилох хэрэгтэй...”

CDL-AD(2015)024, Тунисийн Үндсэн хуулийн шүүхийн талаарх Институтийн хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 36.

5 ШҮҮХЭД ХАНДАХ ЭРХ

5.1 ТӨРИЙН БАЙГУУЛЛАГААС ХАНДАХ

“46.2-т нийтийн хуулийн этгээдүүдээс гомдол гаргахыг хориглосон. Европын хэд хэдэн улсын дотоодын хууль тогтоомжийн хувьд, орон нутгийн захиргаа, өргөн нэвтрүүлгийн компани, их сургууль, сүм хийдүүд зэрэг нийтийн хуулийн этгээдийн гомдлыг/өргөдлийг/ тодорхой нөхцөлд зөвшөөрдөг. Жишээлбэл, Австри, Германы Үндсэн хуульд Үндсэн хуулийн шүүхэд хувь шинжтэй гомдол гаргах эрх нь хуулиар олгогдсон субъектив эрхтэй хамтдаа ирдэг. Энэ нь ихэвчлэн өмчлөх эрхийн хувьд ийм байдаг. Суурь эрхүүд нь хуулийн этгээдүүдэд ч мөн адил олгогддог бөгөөд тэдгээрийн мөн чанараас хамаарч бодитоор хэрэгждэг. Мөн энэ заалтад хамаарах нь цөөн тооны нийтийн хуулийн этгээдүүд. Тиймээс тэд Үндсэн хуулийн шүүхэд Үндсэн хуулиар олгогдсон эрхээ эдлэхээр гомдол гаргах боломжтой байх хэрэгтэй.”

“Нийтийн хуулийн этгээдүүд нь Үндсэн хуулиар олгогдсон эрхээ эдлэхээр Үндсэн хуулийн шүүхэд гомдол гаргах боломжтой байх хэрэгтэй (...)”

CDL-AD(2011)040 Туркийн Үндсэн хуулийн шүүхийн байгуулал, процедурын тухай хуулийн талаарх санал, цогцолбор 67, 104(17).

“Үндсэн хуулийн шүүхийн бүрэн эрхийг “Үндсэн хуулийн байгууллагуудын үндсэн хуулийн эрх мэдлийн талаарх маргааныг шийдвэрлэх” хүртэл өргөжүүлэхээр төлөвлөж байгаа бөгөөд энэ нь сайшаалтай зүйл юм.” (“Төрийн байгууллага хоорондын хуулийн маргаан” хэсгийг үзнэ үү).

CDL-AD(2014)027 Бүгд Найрамдах Армени улсын Үндсэн хуулийн шинэчлэлийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалын судалгаанд өгсөн санал, цогцолбор 73.

5.1.1 Парламентын цөөнх

“Парламентын цөөнх Үндсэн хуулийн шүүхэд холбогдох хэргийн талаар гомдол хүргүүлэх тухай Үндсэн хуульд тусгаагүй. Үндсэн хуулийн 130.III дахь хэсэгт парламент бүхлээрээ буюу түүний гишүүдийн олонхын шийдвэрээр холбогдох хэргийн талаар Үндсэн хуулийн шүүхэд гомдол гаргаж болно гэж заасан. Гэхдээ, Үндсэн хуулийн шүүх нь хууль дээдлэх ёс (the rule of law)-ыг бий болгоход, мөн парламент дахь цөөнхийн бүлгийн эрхийг хамгаалах

замаар хуулийн хэрэгжилтийг хангахад чухал үүрэг гүйцэтгэх боломжтой. Парламентын хэсэг гишүүдийн бүлгээс Үндсэн хуулийн шүүхэд тодорхой хэргийн талаар гомдол гаргасан тохиолдолд шүүхийн шийдвэр нь хуулийн төсөл батлах талаарх улс төрийн зөрчилдөөнөөс зайлсхийхэд хүргэж болзошгүй юм (жишээлбэл, Парламентын 60 гишүүн эсвэл Сенатын 60 гишүүнд Үндсэн хуулийн зөвлөлд гомдол гаргах эрхийг олгосон Францын Үндсэн хуулийн 1974 оны өөрчлөлт; Холбооны Зөвлөлийн гишүүдийн тавны нэг буюу Төрийн Думын гишүүдийн тавны нэгийг төлөөлсөн бүлэгт Үндсэн хуулийн шүүхэд гомдол гаргах эрхийг олгосон 1993 оны 12-р сарын 12-ны өдрийн ОХУ-ын Үндсэн хуулийг үзнэ үү.»

CDL-INF(1996)010 Бүгд Найрамдах Азербайжан Улсын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн төсөлд өгсөн санал, хуудас 3.

“Хэн үндсэн хуулийн шүүхэд норматив хэм хэмжээний актын талаар гомдол гаргах боломжтой байх эсэх асуулт эмзэг асуудал юм. Учир нь Үндсэн хуулийн шүүх болон хууль тогтоогч нарын дундын харилцааг хөнддөг.

Эх газрын хуулийн тогтолцоонд ерөнхийдөө төрийн холбогдох төв байгууллагуудад эсвэл тэдгээрийн ихээхэн хэсэгт энэхүү боломжийг хязгаарладаг (парламент дахь цөөнхийн сөрөг хүчин Үндсэн хуулийн шүүхэд хандах эрхтэй байх хэрэгтэй). Энэхүү хязгаарлалтын зорилго нь Үндсэн хуулийн шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зөвхөн Үндсэн хуулийн дээд эрх мэдэлд халдаж байгаа ноцтой хэргүүдээр хязгаарлахад оршдог. Молдав улсын парламентын депутатуудын тоог (Үндсэн хуулийн 60.2 дахь хэсэгт зааснаар парламент 101 гишүүнээс бүрддэг) харгалзан үзвэл, 5 депутатын тоо хэтэрхий бага байна. Босго ийнхүү бага байх нь Үндсэн хуулийн шүүхийг хэт ачаалахад хүргэж болзошгүй.”

CDL-AD(2002)016 Бүгд Найрамдах Молдав Улсын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн төсөл болон Үндсэн хуульд оруулах холбогдох нэмэлт, өөрчлөлтөд өгсөн санал, цогцолбор 46.

5.1.2 Омбудсмен

“Хүний эрхийн хамгаалагч (the Defender) нь хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн асуудлаар Үндсэн хуулийн шүүхэд хандах боломжийг цогцолбор 1-т тусгасан (Энэ асуудлын талаарх Үндсэн хуулийн өөрчлөлтийн дараах хувилбарыг 27 дугаар зүйлээс үзнэ үү). Хүний эрхийн хамгаалагчийн энэхүү шинэ эрх нь Комиссоос гаргасан зөвлөмж болон Европын стандартуудад нийцэж байна.”

CDL-AD(2003)006 Армени улсын хүний эрхийг хамгаалагчийн тухай хуулийн төсөлд өгсөн санал, хуудас 4.

“Онцгойлон сайшаах ёстой заалтууд бол Омбудсмений хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалахаас гадна, тэдгээрийг хөхүүлэн дэмжих бүрэн эрх, Омбудсмений Үндсэн хуулийн шүүхэд хандах эрх, холбогдох эрх чөлөөгөө хасуулсан хүмүүстэй ганцаарчлан уулзалт чөлөөтэй хийх эрх, Омбудсмений төсвийн хараат бус байдлын талаарх заалтууд байна.”

CDL-AD(2004)041 Сербийн Омбудсманы тухай хуулийн төсөлд Венецийн комисс, Европын зөвлөлийн Хүний эрхийн комиссар болон Хүний эрхийн ерөнхий газрын зүгээс өгсөн хамтарсан санал, цогцолбор 7.

“Омбудсмен буюу Хүний эрхийн хамгаалагчийн бүрэн эрхэд хүний эрх, эрх чөлөөг хөндсөн хууль тогтоомж, захиргааны ерөнхий актуудын Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх асуудлаар абстракт хяналт хийлгэхээр тухайн улсын Үндсэн хуулийн шүүхэд хандах боломжийг багтаасан байх нь зүйтэй гэж үзэж байна. Омбудсмен нь үүнийг өөрийн хүсэлтээр эсвэл тухайн байгууллагад ирсэн тодорхой гомдлын дагуу хийх боломжтой байх хэрэгтэй. Сүүлчийн тохиолдолд, гомдлын дагуу үүсэж буй асуудал нь Үндсэн хуулийн шүүхээр хянан шийдвэрлэхэд тохиромжтой байх, мөн гомдол гаргагчийн байр суурь асуудлыг шийдэх сонголтын хувьд шүүхэд хандах нь хамгийн эхний сонголт (энэ нь Үндсэн хуульд нийцсэн эсэх асуудлыг шүүх Үндсэн хуулийн шүүхэд хүргүүлэхэд хүрч ч болно, үгүй ч байж болно) биш байх гэсэн хоёр зүйлийн хоорондын зааг ялгааг олж харах нь чухал юм.”

CDL-AD(2007)020 Казахстан дахь Омбудсмений институцийн боломжит шинэчлэлийн талаарх санал, цогцолбор 14.

“Венецийн комиссын зүгээс Омбудсменийг хүний эрхийг хамгаалдаг ардчилсан нийгмийн чухал элемент гэж үзэж байна.”

Венецийн Комиссын зүгээс «Омбудсмен буюу Хүний эрхийн хамгаалагчийн бүрэн эрхэд хүний эрх, эрх чөлөөг хөндсөн хууль тогтоомж, захиргааны ерөнхий актуудын Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх асуудлаар абстракт шийдвэр гаргуулахаар тухайн улсын Үндсэн хуулийн шүүхэд хандах боломжийг багтаасан байх хэрэгтэй болохыг зөвлөж байна. Омбудсмен нь үүнийг өөрийн хүсэлтээр эсвэл тухайн байгууллагад ирсэн тодорхой гомдлын дагуу хийх боломжтой байх хэрэгтэй.»

“Эдгээр тогтолцоонд Омбудсмен нь шууд бусаар ч бай, хувь хүний шүүхэд хандах боломжит арга замыг олгодог. Венецийн комиссын зүгээс

омбудсмен бол хувь хүний эрхийг хүндэтгэн хамгаалдаг ардчилсан нийгмийн чухал бүрэлдэхүүн хэсэг гэж үздэг. Иймд, хэрвээ омбудсмен байгаа л бол, тэдэнд өөрийн санаачилгаар, эсхүл хувь хүмүүсийн хүсэлтийн дагуу норматив актуудын Үндсэн хуульд нийцэж буй талаарх хяналтыг эхлүүлэх боломжийг олгох нь зүйтэй.”

“Хувь хүн шууд бусаар шүүхэд хандахын давуу тал нь гомдол гаргах этгээдүүд нь ихэвчлэн сайн мэдээлэлтэй байдаг, мөн үндэслэл бүхий хүсэлтийг бэлтгэхэд шаардагдах хуулийн ур чадвартай байдаг явдал юм. Түүнчлэн, урвуулан ашигласан, эсхүл дахин давтан гаргасан хүсэлтүүдийг хэрэгсэхгүй үлдээх замаар Үндсэн хуулийн шүүхийг хэт их ачаалалд оруулахаас зайлсхийх шүүлтүүр болж чадна. Эцэст нь, шууд бусаар хандах нь үндсэн хууль зөрчсөн илэрхий нөхцөл байдлыг шаардлагагүйгээр сунжруулах явдлаас урьдчилан сэргийлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Гэхдээ шууд бусаар хандах нь илт сул талтай. Учир нь түүний үр нөлөөтэй байдал нь гомдол гаргах эдгээр байгууллагуудын үндсэн хууль зөрчсөн байж болзошгүй хэм хэмжээний актуудыг тодорхойлох чадавх, түүнчлэн үндсэн хуулийн шүүх болон түүнтэй адилтгах байгууллагад өргөдөл гаргах хүсэл эрмэлзлээс ихээхэн хамаардаг. Тиймээс, Венецийн комиссын зүгээс шууд бусаар хандахыг шууд хандах хэлбэртэй хослуулж, одоо байгаа ялгаа бүхий механизмуудыг тэнцвэржүүлэх нь илүү давуу талтай гэж үзэж байна.»

CDL-AD(2010)039rev Хувь хүний Үндсэн хуулийн шүүхэд хандах эрхийн талаарх судалгаа, цогцолбор 2, 64, 106,108.

“(Хүний эрхийн) Хамгаалагчид хууль тогтоомжийг Үндсэн хууль болон, баталж нийтэлсэн олон улсын гэрээнд нийцсэн эсэх, эсхүл бусад зохицуулалтууд болон ерөнхий актуудыг Үндсэн хууль болон бусад хуульд нийцсэн эсэх талаар дүгнэлт гаргуулахаар Монтенегро улсын Үндсэн хуулийн шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлэх (19 дүгээр зүйл)” (...) эрхийг олгосон. 18 болон 19 дүгээр зүйлд Хамгаалагч нь зөвхөн хувь хүний эрхийн зөрчлүүд бус, түүнээс илүү ерөнхий асуудлуудыг ч гэсэн зохицуулна гэсэн хүлээлт дор байгааг аль хэдийн илтгэж байна.

CDL-AD(2011)034 Монтенегро улсын хүний эрх, эрх чөлөөг хамгаалагчийн тухай хуулийн талаарх Венецийн комисс болон ЕАБХАБ-ын Ардчилсан институт, хүний эрхийн алба (ЕАБХАБ/ОДИХБ)-аас гаргасан хамтарсан санал, цогцолбор 11.

“Мөн Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 26-р зүйлд, хэрэв холбогдох этгээд эрхээ өөрөө биечлэн хамгаалах боломжгүй, эсхүл холбогдох эрхийн зөрчлүүд нь илүү олон хүмүүст нөлөөлж байгаа тохиолдолд Үндсэн хуулийн шүүхэд холбогдох зохицуулалтыг Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг шалгах хүсэлт гаргах эрхийг Улсын Ерөнхий прокурорт олгохоор заасан. Энэ нь нийтийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий Ерөнхий прокурорт хувь хүний эрх ашгийг хамгаалах дээр дурдсан эрхийг өгөх нь зөрчилдөөнтэй байна. Ерөнхий прокурор нь ашиг сонирхлын зөрчил бүхий нөхцөл байдалд амархан орох бөгөөд, хоёулыг нь ижил түвшинд авч явах боломжгүй. Энэхүү нөхцөл байдлыг Улсын ерөнхий прокурор зөвхөн тухайн хэргийн үндэслэл бүхий шүүх хуралдаанд оролцсон тохиолдолд л Үндсэн хуулийн шүүхэд гомдол гаргаж болно гэсэн фактаар хөнгөрүүлж байгаа нь ойлгомжтой байна. Ийм эрх мэдэл нь Европын стандартуудад харшлахгүй хэдий ч, Унгарын эрх баригчид тус эрх мэдлийг Үндсэн эрхийн комиссарт олгох асуудлыг авч үзэх хэрэгтэй.»

CDL-AD(2012)009 Унгарын Үндсэн хуулийн шүүхийн тухай 2011 оны CLI хуулийн талаарх санал, цогцолбор 29.

5.1.3 Шүүх (урьдчилсан хүсэлт)

“Ердийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгч (болон талууд) нь Үндсэн хууль зөрчсөн байж болохуйц, гэхдээ тухайн хэрэгтээ хэрэглэхгүй бол болохгүй хуулийн заалттай тулгарч болно. Үндсэн хууль зөрчсөн байж болзошгүй заалтад үндэслэн шүүхийн шийдвэр гаргахгүйн тулд ердийн шүүгч (judge a quo буюу эхний шүүгч) хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлж, уг заалт Үндсэн хуульд нийцэж буй эсэхийг хянуулахаар Үндсэн хуулийн шүүхэд хүсэлт гаргаж болно (judge ad quem буюу эцсийн шүүгч).

Үндсэн хуулийн шүүхэд хандсан ийм хүсэлтийг урьдчилсан хүсэлт, эсхүл зарим улсад үндсэн хуульд нийцээгүй байдлын онцгой тохиолдол буюу тодорхой (concrete) хяналт гэж нэрлэдэг. Тогтолцооноосоо хамаараад үндсэн хуультай нийцэх эсэх эргэлзээ нь ердийн шүүхийн шүүгчээс эсхүл холбогдогч талуудын хүсэлтэд тулгуурлаж үүссэн байж болно. Мөн тогтолцооноосоо хамаараад шүүгч холбогдох хүсэлтийг гаргах үүрэгтэй эсхүл Үндсэн хуульд нийцэж бус эсэх талаар бодит эргэлзээ бий гэж итгэсэн тохиолдолд л хүсэлт гаргах үүрэгтэй байж болно. Эхний шүүгч дээр хүлээгдэж байгаа хэрэг маргаан нь Үндсэн хуулийн шүүх шийдвэрээ

гаргах хүртэл түдгэлзэх бөгөөд Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр гарснаар үргэлжлэн шийдвэрлэгдэнэ.

Ихэнх тохиолдолд ердийн шүүх үндсэн хуулийн шүүх (сүүл шүүгч) -д шууд ханддаг боловч зарим улс оронд холбогдох хүсэлтийг эхлээд Дээд шүүхдээ илгээх ёстой байдаг ба энэ нь холбогдох заалтын Үндсэн хуульд нийцэж буй талаарх эргэлзээ хангалттай бодит эсэхийг шийдвэрлэх шүүлтүүрийн үүрэг гүйцэтгэдэг.

Ийм урьдчилсан хүсэлтийн тогтолцооны гол мөн чанар бол Үндсэн хуулийн шүүх тухайн маргаан бүхий заалтыг Үндсэн хуульд нийцээгүй гэж үзсэн тохиолдолд тус заалтыг одоогийн хэрэг маргаанд хэрэглэх боломжгүй болгож байгаад оршино. Энэ нь тухайн заалт хүчин чадлаа заавал *erga omnes* байдлаар алдана гэсэн үг биш. Цаашдын үр нөлөө нь одоо байгаа системээсээ хамаарна.»

CDL-AD(2018)012, Иргэний болон захиргааны хэргийн эцсийн шийдвэрүүд дэх Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийн үр дагаврын талаар Гүржийн Үндсэн хуулийн шүүхэд гаргасан *Amicus Curiae* - санал, дүгнэлтийн товч, цогцолбор 34-37.

“(...)Үндсэн хуулиар олгогдсон эрх нь хууль тогтоомжийн актын улмаас зөрчигдсөн гэж үзэж байгаа иргэд шууд бусаар ч гэсэн Үндсэн хуулийн шүүхэд хандах боломжийг хуулийн төсөлд олгосон эсэх талаар мөн асуудал үүссэн (хувь хүний өргөдөл, хэм хэмжээ Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх талаарх тодорхой хяналт).

Энэ шатанд Үндсэн хуулийн шүүхэд хэргийн талаар өргөдөл, хүсэлт гаргах ийм хэлбэрийг нэвтрүүлэх нь зүйтэй эсэхийг шийдэхийн тулд эхлээд шүүхэд маш олон тооны өргөдөл гаргах эрсдэлийг үнэлэх нь зүйтэй. Үндсэн хууль болон төслийн бичвэрийн дагуу зөвшөөрөгдөхүйц шийдэл нь Дээд шүүхэд (мөн Дээд шүүхээр дамжих бусад харьяалалд) түүний өмнө үүссэн Үндсэн хууль зөрчсөн тухай маргааныг Үндсэн хуулийн шүүхэд гаргах эрхийг олгох явдал юм. Энэ нь Үндсэн хуулийн шүүхэд хэм хэмжээ нь үндсэн хуульд нийцэж байгаа эсэхэд хийсвэр хяналт тавихаас гадна (Үндсэн хуульд аль хэдийн заасан хяналт) хэрэг маргаан хянан шийдвэрлэх замаар тодорхой хяналт тавих боломжийг олгоно. Өөрөөр хэлбэл, тодорхой тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн Үндсэн хуульд нийцэж буй эсэх талаарх маргаан гарсан Бүгд Найрамдах Азербайжан улсын бүхий л шүүхүүд Үндсэн хуулийн шүүх энэ асуудлаар шийдвэрээ гаргах хүртэл тухайн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлнэ.»

CDL-INF(1996)010 Бүгд Найрамдах Азербайжан Улсын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн төсөлд өгсөн санал, хуудас 4.

“Ердийн шүүхүүд зөвхөн хэргийн холбогдогч талуудаас хүсэлт гаргаснаар урьдчилсан хүсэлт гаргахаас гадна хэрэглэх ёстой хууль нь Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхэд өөрсдөө эргэлзэж байгаа тохиолдолд ч гэсэн хүсэлт гаргах хэрэгтэй.”

CDL-AD(2008)030 Монтенегро улсын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 55.

Хүний эрхийг хамгаалах үүднээс бүх шатны шүүхийг Үндсэн хуулийн шүүхэд хандах боломжийг олгох нь илүү оновчтой, үр дүнтэй юм.”

“Үндсэн хуулийн шүүхэд хэт ачаалал өгөх хэрэггүй, хэрэв ердийн шүүхүүд урьдчилсан хүсэлтийг явуулах боломжтой байгаа бол тэд үндэслэл бүхий асуултыг гаргасан байх хэрэгтэй.”

“Үндсэн хуулийн шүүхэд урьдчилсан хүсэлт тавигдсан тохиолдолд ердийн шүүхийн ажиллагааг түдгэлзүүлэх хэрэгтэй. Үүнийг хуулиараа (*ipso jure*) эсхүл эрх бүхий шүүхийн шийдвэрээр хийж болно. Ямартай ч, ердийн шүүхийн шүүгч Үндсэн хуульд нийцээгүй гэж үзэж байгаа хуулиа хэрэглэхгүй байх ёстой бөгөөд тухайн хэрэгт Үндсэн хуульд нийцсэн эсэхийг Үндсэн хуулийн шүүх эцэслэн шийдвэрлэх ёстой гэх нөхцөлөөр хангагдах ёстой.”

“Гэсэн хэдий ч, Венецийн Комиссын зүгээс Үндсэн хуулийн шүүхэд хувь хүн шууд хандах боломжгүй бол урьдчилсан хүсэлтийг ердийн шүүхийн шүүгч аливаа заалтын Үндсэн хуульд нийцээгүй байдлын талаар баттай итгэлтэй байх тохиолдолд л гаргаж болохоор хязгаарлах нь хэтэрхий өндөр босго болох бөгөөд шүүгчид бодитой эргэлзээ төрөхөд л хангалттай гэдгийг тэмдэглэж байна.”

“(…) Ердийн шүүх асуудлыг өөрийн үзэмжээрээ шийдвэрлэх тодорхой хэмжээний бүрэн эрх (*discretion*)-тэй байх хэрэгтэй. Тэд ямар нэг заалт Үндсэн хуульд нийцээгүй гэдэгт итгэлтэй байвал тухайн хэм хэмжээг эсэргүүцэн Үндсэн хуулийн шүүхэд урьдчилсан шийдвэр гаргуулах хүсэлт хүргүүлэх боломжтой байх хэрэгтэй. Хэрэв хувь хүн Үндсэн хуулийн шүүхэд шууд хандах боломжгүй байгаа бол Үндсэн хуулийн шүүхэд урьдчилсан хяналт тавихад шүүгчид ноцтой эргэлзээ төрсөн байхад л хангалттай байх хэрэгтэй.”

CDL-AD(2010)039rev Хувь хүний Үндсэн хуулийн шүүхэд хандах эрхийн талаарх судалгаа, цогцолбор 62, 126, 142, 216, 226.

“Хуулийн төслийн 25.9 тусгагдсан Үндсэн хуулийг хамгаалах үйл ажиллагаанд Үндсэн хуулийн бус үйлдэл хийхийг хориглоно гэх заалт нь ердийн шүүхийн шүүгч холбогдох хэм хэмжээ Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг хянан шийдвэрлэх боломжийг хааж байх шиг байна. Гэхдээ энэхүү хамгаалалтын үйл ажиллагаатай холбоотой ихэнх тохиолдолд, үндсэн хууль зөрчсөн хэм хэмжээг хэрэглэх нь тухайн зөрчигдсэн эрхийг сэргээхийг шаардаж буй үндсэн хуулийн бус нөхцөл байдлыг бий болгож байна. Үндсэн хуульд нийцээгүй гэж ойлгогдож буй хэм хэмжээг тухайн хэрэгт хэрэглэхгүй байх эрхийг ердийн шүүгчид олгох хэрэгтэй бөгөөд ийм хэргүүдийг эцэслэн шийдвэрлүүлэхээр Үндсэн хуулийн шүүхэд хүсэлт гаргах хэрэгтэй.”

CDL-AD(2011)038 Боливийн Үндсэн хуулийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 32.

5.2 ХУВЬ ХҮНИЙ ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ

“Үндсэн хуулийн процедурын хуулийн 14.8 дах хэсэгт (Хуулийн төслийн 14.10 дахь хэсэг) иргэд болон хуулийн этгээдүүдийг “Үндсэн хуулиар олгогдсон эрхийг нь шууд хөндөж байгаа асуудлаар хэрвээ энэ нь бусад шүүхийн харьяалалд хамаарахгүй бол” Үндсэн хуулийн шүүхэд хандахыг зөвшөөрсөн. Мэдээжийн хэрэг энэ эрх зөвхөн Киргизийн иргэдээр хязгаарлагдахгүйгээр, гадаадын иргэн, харьяалалгүй хүн гэх мэт Киргизийн харьяанд байгаа аливаа хувь хүн бүрд хамаарах хэрэгтэй.

Энэ төрлийн хувь хүмүүсийн гаргасан гомдол нь зөвхөн «бусад шүүхийн харьяалалд хамаарахгүй” хэргүүдээр хязгаарлагддаг. (...) Иймд Венецийн Комиссын зүгээс хувь хүний үйлдлийн эсрэг хувь хүмүүсийн гаргасан гомдлын процессыг нэвтрүүлэхийг зөвлөж байна.”

CDL-AD(2008)029 Киргизийн (1) Үндсэн хуулийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (2) Үндсэн хуулийн шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 22-23.

“Комиссын зүгээс үндсэн хуулийн гомдол нэвтрүүлж байгааг сайшааж байгаа ч, энэ нь Үндсэн хуулийн шүүхийн хэргийн ачааллыг нэмэгдүүлснээр шүүхийн хэрэг маргаан хянан шийдвэрлэх чиг үүргийг өөрчлөх магадлалтайг онцолж байна.”

CDL-AD(2009)024 Украины Ерөнхийлөгчийн өргөн мэдүүлсэн Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 102.

Венецийн комисс

“Тиймээс, Венецийн Комисс шууд бус болон шууд хандалтыг хослуулж, улмаар одоо байгаа өөр өөр механизмуудын хооронд тэнцвэрийг бий болгох нь давуу талтай гэж үзэж байна.”

“Венецийн комисс “Үндсэн хуулийн иж бүрэн гомдол”-ыг дэмжиж байна. Учир нь, энэ нь үндсэн хуулиар олгогдсон эрхийг иж бүрэн хамгаалж байгаа төдийгүй, Европын Хүний эрхийн шүүхээс үзүүлж буй эрх сэргээлтийн туслах шинж чанар болон хүний эрхийн асуудлыг үндэсний хэмжээнд шийдвэрлэх хүсэл эрмэлзлээс ч гэсэн шалтгаалж байна.”

“Үндсэн хуулийн иж бүрэн гомдол нь хувь хүний үндсэн хуулийн шүүхэд хандах хамгийн өргөн боломжийг олгож, улмаар хувь хүний эрхийг хамгийн бүрэн хамгаалах нөхцөлийг бий болгодог нь эргэлзээгүй.”

CDL-AD(2010)039rev Хувь хүний Үндсэн хуулийн шүүхэд хандах эрхийн талаарх судалгаа, цогцолбор 3, 79-80.

“Нэг талаасаа, хувь хүний Үндсэн хуулийн шүүхэд гомдол гаргах боломж Үндсэн хуулийн хяналтын тогтолцоонд нэвтэрсэнд Венецийн комисс сэтгэл хангалуун байна.”

CDL-AD(2011)016 Унгарын шинэ Үндсэн хуулийн талаарх санал, цогцолбор 97.

“Европын Хүний эрхийн шүүхээс тайлбарласан Европын конвенц рүү иш татсан тодорхой эх сурвалжийг хувь хүний гомдлын үндэслэл болгож нэмэх хэрэгтэй.»

CDL-AD(2011)040 Туркийн Үндсэн хуулийн шүүхийн байгуулал, процедурын тухай хуулийн талаарх санал, цогцолбор 63.

“Хувь хүний Үндсэн хуулийн шүүхэд хандах эрхийн талаарх Венецийн комиссын тайланд Үндсэн хуулийн шүүхэд гаргах “Үндсэн хуулийн иж бүрэн гомдол”-ыг “Урьдчилсан хүсэлт”-тэй хослуулах нь хүний эрхийг хамгаалах гэдэг үүднээс хамгийн бүрэн дүүрэн арга зам гэдгийг тогтоосон.”

CDL-AD(2018)012, Иргэний болон захиргааны хэргийн эцсийн шийдвэрүүд дэх Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийн үр дагаврын талаар Гүржийн Үндсэн хуулийн шүүхэд гаргасан Amicus Curiae - санал, дүгнэлтийн товч, цогцолбор 24.

5.2.1 Үндсэн хуулийн иж бүрэн гомдол

“Ерөнхийдөө үндсэн хуулийн иж бүрэн гомдлыг дараах зүйлтэй холбогдуулан гаргаж болно:

- ердийн шүүхийн эцсийн шийдвэр
- төрийн эрх бүхий байгууллагын шийдвэрүүд (энэ тохиолдолд тухайн шийдвэрүүд нь захиргааны хэргийн шүүхүүдээр хянагдах боломжгүй байх)
- шийдвэрийн формал шалгуурыг хангаагүй боловч хувь хүн, хуулийн этгээдүүдийн эрх, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхол эсхүл үүргийг шууд хөнддөг эрх бүхий албан тушаалтны хуулийн үйлдэл /legal act/ эсхүл бусад үйлдлүүд
- зарим тогтолцоонд хуулийн нэгэн адил нийтлэг хэм хэмжээ биш боловч зөвхөн нэг хүн эсвэл хэсэг фактуудыг тусгайлан зохицуулсан актууд (“нэг бүрчилсэн акт”).”

CDL-AD(2018)012, Иргэний болон захиргааны хэргийн эцсийн шийдвэрүүд дэх Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийн үр дагаврын талаар Гүржийн Үндсэн хуулийн шүүхэд гаргасан Amicus Curiae - санал, дүгнэлтийн товч, цогцолбор 25.

“Түүнчлэн, тухайлсан үйлдлүүдээр үйлдэгдсэн хүний эрхийн зөрчлийн бүх хэргийн эсрэг Үндсэн хуулийн шүүхэд иж бүрэн гомдол гаргах явдлыг нэвтрүүлэх хэрэгтэй. Украинд, Үндсэн хуулийн шүүхэд гаргах тухайлсан гомдлыг зөвхөн үндсэн хуульд нийцээгүй хууль тогтоомж²-ийн эсрэг л гаргаж болдог ба, харин үндсэн хуульд нийцээгүй тухайлсан үйлдлийн эсрэг гаргаж болдоггүй. Хэт удаан шүүхийн процедур зэрэг тухайлсан үйлдлүүдээр үйлдэгдсэн хүний эрхийн зөрчил нь Үндсэн хуулийн шүүхэд дуудагдахгүй. 2011 онд Парламентын дарга Үндсэн хуулийн иж бүрэн гомдлыг нэвтрүүлэх санал гаргаж байсан ч одоог хүртэл хэрэгжээгүй байна. Үндсэн хуулийн иж бүрэн гомдол гаргахад Улсын дээд шүүх дээр процессын хувьд хэт удаан үргэлжилсэн хэргүүд ч мөн адил хамаарна.”

CDL-AD(2013)034 Украины шүүгчийн хараат бус байдлыг бэхжүүлэх зорилгоор Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах саналд өгсөн санал, 11 дэх хэсэг.

“(…) ампаро арга хэмжээ нь зөвхөн хууль бус үйлдлээс хамгаалахаас гадна, үндсэн хуульд нийцээгүй үйлдэл буюу хууль ёсны боловч Үндсэн хуульд нийцээгүй үйлдлүүдээс ч гэсэн хамгаалах ёстой.»

² Үндсэн хуулийн хэм хэмжээний гомдол, Хувь хүний Үндсэн хуулийн шүүхэд хандах эрхийн талаарх судалгаа, CDL-AD(2010)039rev, цогцолбор 77-г үз.

CDL-AD(2011)038 Боливийн Үндсэн хуулийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 36.

“Үндсэн эрх, эрх чөлөөний шууд нөлөөллийг хангах” гэсэн доорх цогцолборт дурдсанчлан, Үндсэн хуулийн шүүхэд тухайлсан өргөдөл гаргах эрхийг, тухайлбал, бусад хуулийн актуудын Үндсэн хуульд нийцсэн эсэх байдлыг сорих эрхийг хамруулахаар өргөжүүлэх хэрэгтэй (Үндсэн хуулийн одоогийн 101 дүгээр зүйл).”

CDL-AD(2014)027 Бүгд Найрамдах Армени улсын Үндсэн хуулийн шинэчлэлийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалын судалгаанд өгсөн санал, цогцолбор 74.

Үндсэн хуулийн гомдол нь “хүн, иргэний” эрх чөлөө, эрхийг зөрчсөн тухай гомдлыг гаргахаар хуулийн нэмэлт, өөрчлөлтөд тусгасан. Гэхдээ энэхүү гомдлыг “натурал эсхүл хуулийн этгээд”-ээр гаргуулах хэрэгтэй. Үндсэн хуулийн шүүхэд гаргах тухайлсан гомдлууд нь зөвхөн иргэдийн эрхийн зөрчил бус, гадаадын иргэн, хуулийн этгээд зэрэг бусад хувь хүмүүсийн ч гэсэн эрхийг хамаарч байгааг ойлгож болно.

Цаашилбал, нэмэлт өөрчлөлтөөр «төрийн байгууллагын нэг бүрчилсэн акт, үйлдэл” гэж юу болохыг тайлбарлах ёстой. Зөвхөн захиргааны төдийгүй шүүхийн акт, тэр дундаа Дээд шүүхийн шийдвэрийн эсрэг Үндсэн хуулийн гомдол гаргаж болох эсэх нь тодорхой байх ёстой. Түүнчлэн Үндсэн хуулийн шүүх нь нэг бүрчилсэн актыг (захиргааны болон шүүхийн аль алиныг нь) хүчингүй болгох, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дахин эхлүүлэх, шаардлагатай тохиолдолд нөхөн төлбөр олгох эрх мэдэлтэй гэдгийг тодорхой хэлэх нь чухал юм. Үндсэн хуулийн гомдлыг шүүх хангалттай эрх мэдэлтэй байж, зөрчигдсөн эрхийг сэргээж чадсан тохиолдолд л ЕХ түүнийг “эрх зүйн үр дүнтэй арга хэмжээ” гэж үзэж болох юм. Төрийн байгууллага, албан тушаалтны эс үйлдэхүйн талаарх гомдлыг “үйл ажиллагаа”-ны хамт хянан хэлэлцэх эрх бүхий байгууллага байх ёстой юу гэдгийг эрх баригчид авч үзэх ёстой.”

CDL-AD(2014)026 “Хуучин Югославын Бүгд Найрамдах Македон Улс”-ын, ялангуяа, Шүүхийн зөвлөл, Үндсэн хуулийн шүүхийн бүрэн эрх, санхүүгийн тусгай бүсийн тухай Үндсэн хуулийн долоон нэмэлт, өөрчлөлтөд өгсөн санал, цогцолбор 87-89.

“Хувь хүний Үндсэн хуулийн шүүхэд хандах эрхийн талаарх Венецийн комиссын тайланд Үндсэн хуулийн иж бүрэн гомдлыг Үндсэн хуулийн

шүүхэд гаргах урьдчилсан хүсэлттэй хослуулах нь хүний эрхийг хамгаалах үүднээс хамгийн бүрэн гүйцэд хэлбэр гэж үзсэн.

Ихэвчлэн, Үндсэн хуулийн хувь хүний иж бүрэн гомдлыг дараах зүйлсийг шалгахад хэрэглэж болно: ердийн шүүхүүд болон нийтийн эрх бүхий байгууллагуудын эцсийн шийдвэрүүд (төрийн эрх бүхий байгууллагуудын хувьд тэдгээрийн шийдвэрийг захиргааны хэргийн шүүх хянах боломжгүй тохиолдолд); шийдвэрийн албан ёсны шалгуурыг хангаагүй боловч хувь хүн, хуулийн этгээдийн эрх, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхол, эсхүл үүргийг шууд хөндсөн буюу хөндөж болзошгүй холбогдох эрх бүхий байгууллагаас хийсэн хууль эрх зүйн болон бусад акт зэрэг арга хэмжээнүүд; мөн түүнчлэн зарим тогтолцоонд зөвхөн нэг хүн эсвэл хэд хэдэн фактуудад тухайлсан байдлаар чиглэсэн шинжтэй буюу нийтлэг хэм хэмжээ биш боловч хууль гэж тодорхойлогдох актууд (“тухайлсан хууль”).

Хувь хүн бусад бүх хууль эрх зүйн хамгаалалтыг бүрэн дуусгасны дараа л үндсэн хуулийн иж бүрэн гомдлыг гаргаж болно. Тиймээс, Үндсэн хуулийн шүүхийн бүрэн эрх нь субсидар зарчим (*principle of subsidiarity*)-аар хязгаарлагддаг, өөрөөр хэлбэл, Үндсэн хуулийн шүүх маргаан бүхий актын талаар ердийн шүүхийн бүх шатны шүүх холбогдох актыг хянан шийдвэрлэсний дараа, эсхүл тухайн ердийн шүүхэд давж заалдах гомдол гаргах боломжгүй тохиолдолд л шийдвэр гаргаж болно.

Үндсэн хуулийн иж бүрэн гомдлын давуу тал нь Үндсэн хуулийн шүүх хүний эрх зөрчигдсөн гэсэн дүгнэлтэд хүрсэн тохиолдолд тухайн үндсэн хууль зөрчсөн нөхцөл байдал нь аливаа хэм хэмжээнд, эсхүл түүний хэрэглээнд байгаа эсэхээс үл хамааран холбогдох шүүхийн эцсийн шийдвэр, эсхүл эцсийн шатны актыг шууд хүчингүй болгодогт байдаг. Тогтолцооноосоо хамаараад Үндсэн хуулийн шүүх тухайн хэргийг өөрөө шууд шийдвэрлэх, эсхүл нэмэлт ажиллагааны үүднээс ердийн шүүх, холбогдох эрх бүхий байгууллага руу буцаан шилжүүлэх боломжтой.

Үндсэн хуулийн шүүх нь, тухайн тогтолцоо, тодорхой нөхцөл байдлаас хамаараад хүний эрхийн үргэлжилсэн зөрчлийг хориглон зогсоох; эсхүл хэрэв боломжтой бол тухайн эрхийг зөрчсөн эрх бүхий байгууллагад зөрчил гарахаас өмнөх нөхцөл байдлыг сэргээн бий болгохыг даалгаж болно.

Үндсэн хуулийн иж бүрэн гомдлын сул тал нь Үндсэн хуулийн шүүхийн хэргийн ачааллын дийлэнх хэсгийг дээрх гомдлууд богино хугацаанд бүрдүүлдэгт, заримдаа хэргийн ачааллын 90 гаруй хувийг бүрдүүлдэгт

байдаг. Улмаар Үндсэн хуулийн шүүх нь үндсэн хуулийн ач холбогдолтой бус, зөвхөн ердийн шүүхийн шийдвэрт талууд сэтгэл дундуур байгаагаас гомдол гаргасан хэргүүдийн улмаас хэт ачаалалтай байх болдог. Үндсэн хуулийн иж бүрэн гомдол гаргадаг улс орнуудад шүүхийн хэргийн хэт ачааллыг даван гарахын тулд ерөнхийдөө жишээлбэл, цаг хугацааны хязгаарлалт, заавал хууль ёсны төлөөлөгчтэй байх, илт үндэслэлгүй хэргийн хувьд хялбаршуулсан шийдвэр гаргах гэх мэт олон шүүлтүүрүүдийг ашигладаг. Түүнчлэн Үндсэн хуулийн шүүхийн зохион байгуулалтыг боловсронгуй болгох ёстой, шүүгч нар илүү жижиг танхимуудад шийдвэр гаргадаг болох, шүүгчид хангалттай тооны хууль зүйн туслахуудтай байх шаардлагатай байна.”

CDL-AD(2018)012, Иргэний болон захиргааны хэргийн эцсийн шийдвэрүүд дэх Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийн үр дагаврын талаар Гүржийн Үндсэн хуулийн шүүхэд гаргасан Amicus Curiae - санал, дүгнэлтийн товч, цогцолбор 24-29.

5.2.2. Үндсэн хуулийн хэм хэмжээний (норматив) гомдол

“Хэд хэдэн улс орон хувь хүмүүсийг Үндсэн хуулийн шүүхэд шууд хандахыг зөвшөөрдөг боловч энэ нь зөвхөн үндсэн хуульд үл нийцсэн гэж үзсэн хэм хэмжээний заалтуудын эсрэг гомдол гаргахаар хязгаарлагддаг (“Үндсэн хуулийн хэм хэмжээний гомдол”). Энэ төрлийн гомдлоор тухайн хүн Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх нь маргаан бүхий хэм хэмжээний актад үндэслэсэн нэг бүрчилсэн актын улмаас зөрчигдсөн хүний эрхийн зөрчлийн хэргээр Үндсэн хуулийн шүүхэд хандах эрхтэй байдаг.”

“Үндсэн хуулийн хэм хэмжээний гомдлыг хэрэгжүүлдэг тогтолцоонд хэм хэмжээний актыг хэрэглэж буй нэг бүрчилсэн актыг Үндсэн хуулийн шүүх хянадаггүй. Үндсэн хуулийн шүүхийн хяналт нь тухайн хэм хэмжээний актын хэрэгжилтийг анхаарч авч үздэггүй. Тиймээс, Үндсэн хуулийн хэм хэмжээний гомдол нь, хэрвээ Үндсэн хуульд нийцээгүй байдал нь тухайн хэм хэмжээндээ бус, тухайн хэм хэмжээний хэрэгжилтэд байгаа тохиолдолд тийм ч үр дүнтэй эрх сэргээх арга биш байдаг.

“Үндсэн хуулийн хэм хэмжээний гомдол нь Зүүн Европын хэд хэдэн оронд байдаг. Сонирхолтой нэг тохиолдол бол сүүлийн үеийн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр үндсэн хуулийн хэм хэмжээний гомдлыг танилцуулсан Украйны тохиолдол юм. Үндсэн хуулийн шүүхийн тухай хуульд Үндсэн хуулийн шүүх маргаан бүхий хэм хэмжээ нь Үндсэн хуульд

нийцэж байгаа нь тогтоогдсон боловч ердийн шүүх тухайн хэм хэмжээний хэрэглээ нь Үндсэн хуульд үл нийцэж буйг олж тогтоосон тохиолдолд ердийн шүүхийн сүүлчийн шийдвэрийг тус шүүхэд нь буцаах боломжтой болгож, тус гомдлын үр нөлөөг нэмэгдүүлсэн.”

Украины Үндсэн хуулийн гомдол нь ийнхүү Үндсэн хуулийн иж бүрэн гомдолтой ижил төстэй байдлыг харуулж байгаа боловч зарим нэг хязгаарыг агуулж байна. Нэгдүгээрт, өргөдөл гаргагч нь ердийн шүүхийн хууль хэрэглээний асуудалд гомдол гаргах боломжгүй; гомдлыг зөвхөн тухайн хэм хэмжээний эсрэг гаргах ёстой. Өргөдөл гаргагч нь зөвхөн, хяналтын явцад Үндсэн хуулийн шүүхийн зүгээс Үндсэн хуульд үл нийцэх хэм хэмжээний хэрэглээг олж тогтоогоосой гэж найдах л боломжтой. Түүнчлэн, Үндсэн хуулийн шүүх нэг хуулийн заалтыг Үндсэн хуульд нийцэж байна гэж үзсэн тохиолдолд тухайн заалтын эсрэг дараагийн гомдлыг хүлээн авах боломжгүй болно. Энэ нь, Украины шинэ үндсэн хуулийн гомдол болон үндсэн хуулийн иж бүрэн гомдол хоёрын ижил төстэй байдал нь цаг хугацаа өнгөрөх тусам хуулийн заалтууд үндсэн хуульд нийцсэн гэдэг нь «тодорхой» болох бүрд алга болно гэсэн үг юм.

CDL-AD(2018)012, Иргэний болон захиргааны хэргийн эцсийн шийдвэрүүд дэх Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийн үр дагаврын талаар Гүржийн Үндсэн хуулийн шүүхэд гаргасан *Amicus Curiae* - санал, дүгнэлтийн товч, цогцолбор 30-33.

5.2.3 Эрх сэргээх арга хэмжээг шавхах

“Хувь хүмүүс Үндсэн хуулийн иж бүрэн гомдлыг эрхээ хамгаалуулах бусад бүх арга хэмжээг дуусгасны дараа л гаргах боломжтой. Тиймээс, Үндсэн хуулийн шүүхийн бүрэн эрх нь субсидар зарчим (*principle of subsidiarity*), өөрөөр хэлбэл Үндсэн хуулийн шүүх маргаан бүхий актуудын талаар ердийн бүх шатны шүүхийн шийдвэр гарсан эсхүл ердийн шүүхэд давж заалдах боломжгүй үед л шийдвэр гаргаж болно гэсэн зарчмаар хязгаарлагдана.”

CDL-AD(2018)012, Иргэний болон захиргааны хэргийн эцсийн шийдвэрүүд дэх Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийн үр дагаврын талаар Гүржийн Үндсэн хуулийн шүүхэд гаргасан *Amicus Curiae* - санал, дүгнэлтийн товч, цогцолбор 26.

“33 дугаар зүйлээр түр дүгнэлтэд дурдагдсан гурван асуудлыг шийдвэрлэсэн:

- Үндсэн хуулийн шүүх нь, хэрэв эрх сэргээх бусад арга хэмжээнүүд нь гомдол гаргагчид нөхөж баршгүй хохирол учрахаас сэргийлж чадахгүй бол эдгээр арга хэмжээг шавхаагүй байсан ч гэсэн холбогдох гомдлуудыг хүлээн авч болно;(...)”

CDL-AD(2002)005 Бүгд Найрамдах Азербайжан Улсын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 9.

“Хуулиар тогтоосон ердийн эрх сэргээх арга хэмжээ байсан хэдий ч, тэр нь ердийн шүүхүүдийн тогтсон жишгийн дагуу өргөдөл гаргагчид буцааж үл болох сөрөг үр дагавар бий болохоос зайлсхийхэд тохиромжгүй учир үр дүнгүй арга хэмжээ байж болно. Иймэрхүү ховор бөгөөд онцгой тохиолдлуудад Үндсэн хуулийн шүүх нь эдгээр үр дүнгүй арга хэмжээг дуусгахаас өмнө хувь хүний гомдлыг хүлээж авах боломжтой байх хэрэгтэй.”

CDL-AD(2008)03 Монтенегро улсын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн төслийн талаарх санал, цогцолбор 60.

“Энэхүү дүрмийг дагаж мөрдөх нь тухайн хувь хүнд нөхөж баршгүй хохирол учруулж болзошгүй бүхий л тохиолдолд эрхээ хамгаалуулах хууль эрх зүйн хэрэгслийг дуусгах шаардлага үл хамаарах нөхцөлийг тогтоож өгөх ёстой.”

CDL-AD(2012)009 Унгарын Үндсэн хуулийн шүүхийн тухай 2011 оны CLl хуулийн талаарх санал, цогцолбор 54(4).

“Урьдчилсан дүгнэлтэд Үндсэн хуулийн гомдлыг “эрх сэргээх дотоодын бүхий л арга хэмжээ дууссаны дараа” гаргаж болно гэдгийг тодруулахыг зөвлөсөн. Үүнийг одоо шинэчилсэн нэмэлт, өөрчлөлтүүдээр хийсэн бөгөөд сайшаах хэрэгтэй.”

CDL-AD(2015)027 2015 оны 9-р сарын 4-ний өдөр Үндсэн хуулийн комиссоос батлагдсан шүүхийн талаарх Украины Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд өгсөн санал, цогцолбор 32.

5.2.4 Хууль зүйн үнэ төлбөргүй туслалцаа

“Хүний эрхийг хамгаалах баталгаа болохынхоо хувьд, Үндсэн хуулийн шүүхэд хандах боломжийг хялбархан болгох хэрэгтэй. Хэрэв хэрэг үүсгэхэд хураамж төлөх бол энэ нь харьцангуй бага байх ёстой. Тэр ч байтугай шүүх нь илт үндэслэлгүй нэхэмжлэл гаргах боломжгүй хүмүүст үл хамаарах нөхцөл гаргах боломжтой байх ёстой.”

CDL-AD (2008)029 (1) Үндсэн хуулийн процедурын хууль болон (2) Киргизийн Үндсэн хуулийн шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн өгсөн санал, цогцолбор 45.

“Үндсэн хуулийн шүүхэд хандах эрхийг хангахын тулд, хэрвээ материаллаг нөхцөл байдал нь хангагдаж байвал өргөдөл гаргагчид хуулийн үнэ төлбөргүй туслалцаа үзүүлэх хэрэгтэй.”

“Венецийн Комиссын зүгээс Хүний эрхийг улам бүр иж бүрэн хамгаалах үүднээс хувь хүмүүсээр төлүүлэх шүүхийн хураамжийг харьцангуй бага байлгах, мөн өргөдөл гаргагчийн санхүүгийн байдалтай уялдуулан шүүхийн хураамжийг бууруулах боломжтой байхыг зөвлөж байна. Эдгээрийн гол зорилго бол илт зүй ёсны бус зүйлийг таслан зогсоох явдал юм.”

“Процессын эдийн засгийн шалтгааны улмаас уг асуудалд хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй бүхий л хүмүүс хүлээгдэж буй хэрэгт хөндлөнгөөс оролцох эрхтэй байж болно. Хэрэв ижил төстэй хэргүүд их байгаа бол шүүх нэг буюу хэд хэдэн ерөнхий жишээ болохуйц (парадигматик) хэргүүдийг шийдвэрлэх, ижил төстэй нэхэмжлэлүүдийн хувьд тэдгээрийг хүлээн авах боломжгүй байдал болон хуулийн үндэслэлийг хялбархан, ойлгомжтой болгох хэрэгтэй.»

CDL-AD(2010)039rev Хувь хүний Үндсэн хуулийн шүүхэд хандах эрхийн талаарх судалгаа, цогцолбор 113, 117, 129.

5.2.5 Гомдол хүлээн авах

“Үндсэн хуулийн шүүх үр дүнтэй байхын тулд хангалттай тооны шүүгчтэй байх, процедур нь хэтэрхий төвөгтэй биш байх, хувь хүмүүсээс ирүүлсэн Үндсэн хуулийн ноцтой асуудал хөндөөгүй агуулга бүхий гомдлыг шүүх өөрөө хэрэгсэхгүй болгох эрх эдэлдэг байхыг шаарддаг.”

CDL-STD(1997)020 Үндсэн хуулийн шүүхийн бүрэлдэхүүн – Шинжлэх ухаан болон Ардчиллын техник, no. 20 (1997), хуудас 22.

“Нэгэнт Үндсэн хуулийн гомдлын процедурыг хувь хүмүүс эхлүүлэх боломжтой учраас, Үндсэн хуулийн шүүх энэ төрлийн гомдлуудыг олноор хүлээн авахад хүрч болно. Бүх төрлийн процедурт хамаарах хуулийн төслийн 37 дугаар зүйлд зааснаар, Шүүх илт үндэслэлгүй хэргийг хүлээн авахаас татгалзаж болох бөгөөд энэ заалт нь хэргийн буюу шүүхийн хэт их ачааллаас зайлсхийх шүүлтүүр болж магадгүй.”

CDL-AD(2002)005 Бүгд Найрамдах Азербайжан Улсын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 8.

“Шүүхийн ажилтны шийдвэрлэсэн өргөдлийг “буцаах” шийдвэрийн эсрэг гаргасан давж заалдах гомдлыг зөвхөн Шүүхийн даргад бус, гурван шүүгчийн бүрэлдэхүүн бүхий хороонд гаргадаг байх хэрэгтэй.”

CDL-AD(2006)017 Армен улсын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөд өгсөн санал, цогцолбор 31.

“Өргөдөл гаргах хугацаа: Өргөдөл гаргахад тавигдах хугацааны шаардлагууд хэт урт байх хэрэггүй хэдий ч, энэ нь гомдол гаргагч хүн аливаа гомдлоо өөрөө биечлэн бэлтгэх, эсвэл өмгөөлөгчид тус гомдлыг гаргаж, хувь хүний эрхийг өмгөөлөхийг даалгах боломжийг олгохоор байх хэрэгтэй.”

(...). Венецийн Комиссын зүгээс, хувь хүмүүсийн үйлдлийн талаар өргөдөл гаргагч нь түүний болон өмгөөлөгчийн буруугаас болоогүй, эсхүл бусад хүндэтгэн үзэх шалтгаануудаас өргөдөл гаргах хугацааг мөрдөж чадаагүй тохиолдолд шүүх тус хугацааг сунгах боломжтой байхыг зөвлөж байна..”

CDL-AD(2010)039rev Хувь хүний Үндсэн хуулийн шүүхэд хандах эрхийн талаарх судалгаа, цогцолбор 112.

“Үндсэн хуулийн хяналтын ажиллагаа нь өргөдөл гаргагчийн нөхцөл байдлыг бүхэлд нь өөрчлөхгүй бол өргөдлөөс татгалзаж болно (...); Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр Үндсэн хуулийн шүүхийн үйлчилгээг үр дүнтэй хангах арга хэмжээ болж чадахгүй нь тодорхой болсон тохиолдолд л гомдлыг шүүх хянахаас татгалздаг байх хэрэгтэй.”

CDL-AD(2010)039rev Хувь хүний Үндсэн хуулийн шүүхэд хандах эрхийн талаарх судалгаа, цогцолбор 124.

“[Гомдлыг хүлээн авахаас татгалзсан шийдвэрийн эсрэг] давж заалдах нь гомдлыг хүлээн авахад баримтлах шалгуурын талаар нэгдсэн аргачлалыг бий болгоход ашигтай байж болох юм. Гэвч, иймэрхүү давж заалдах гомдлууд нь Шүүхийг хэт ачаалахад хүргэж болзошгүй нь бас үнэн. Тайлбар бичигт, гомдлыг хүлээн авахаас татгалзсан шийдвэрийг давж заалдсан гомдлын тоо болон тус гомдлуудаас шалтгаалсан Шүүхийн ачаалал нэмэгдсэн тохиолдлууд нь нэмэлт, өөрчлөлт оруулах бодит шалтгаан байсан эсэх талаар ямар ч мэдээлэл агуулаагүй байна.

Нэг - радикал - хувилбар бол иймэрхүү давж заалдах гомдлыг хүлээн авахгүй байж болох юм. Ирээдүйд гомдол, өргөдлийн тоо илүү их болж, Шүүхийн үйл ажиллагааг саатуулж болзошгүй үед энэ нь зайлшгүй шаардлагатай болж магадгүй юм. Шүүхийн хэт ачааллаас зайлсхийх өөр нэг хувилбар бол зөвхөн холбогдох хорооны шүүгчдийн нэгдсэн саналаар л өргөдлийг хүлээн авахгүй гэдгийг шийддэг байхаар зохицуулах юм. Хэрэв тухайн асуудлаар шүүгч нар санал нийлээгүй бол хэргийг Шүүх буюу шүүхийн танхимдаа шилжүүлдэг байх хувилбарыг бий болгож болно.»

CDL-AD(2014)020 Бүгд Найрамдах Киргиз улсын Дээд шүүхийн Үндсэн хуулийн танхимын талаарх Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд өгсөн санал, цогцолбор 15-16.

“Үндсэн хуулийн шүүхээс холбогдох өргөдлийг хүлээн авах эсхүл татгалзахдаа шийдвэрээ сайн үндэслэсэн байхыг шаардах хэрэгтэй.

29.3 дахь хэсгийн сүүлчийн хэсэгт Үндсэн хуулийн шүүхийн ажилтан өргөдлийг Үндсэн хуулийн шүүхийн даргын тогтоол гарснаас хойш тав хоногийн дотор буцаах ёстой талаар нэмэлт зүйл оруулах хэрэгтэй. Түүнчлэн, Үндсэн хуулийн шүүхийн ажилтны татгалзалд гаргасан шийдвэрийн талаар Шүүхийн даргад гомдол гаргах боломжтой тухай мэдээллийг заавал тусгасан байх хэрэгтэй гэдгийг онцлон тэмдэглэх нь зүйтэй.”

CDL-AD(2017)011 Армен - Үндсэн хуулийн шүүхийн талаарх Үндсэн хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 61-62.

5.2.6 Үндсэн хуулийн болон Ердийн шүүх хоорондын харилцаа

“Үндсэн хуулийн гомдлын хяналтыг хэрэгжүүлсэн зарим Үндсэн хуулийн шүүх ердийн шүүхүүдтэй хэрхэн харилцах талаар асуудалтай тулгарч байсан. Ердийн шүүхүүдийн шийдвэрүүдийг хянах боломж нь тэдгээр шүүхүүд болон Үндсэн хуулийн шүүхийн хооронд хурцадмал байдал, бүр зөрчилдөөн үүсгэж болзошгүй. Иймд Үндсэн хуулийн шүүхийг “супер/аугаа их - Дээд шүүх” гэж үздэг шийдлээс зайлсхийх хэрэгтэй байна. Үндсэн хуулийн шүүхийг “Ердийн” шүүхүүдийн Дээд шатны шүүхүүдтэй (Давж заалдах шатны шүүх) ямар түвшинд харилцах ёстойг тодорхой шийдвэрлэх хэрэгтэй.”

CDL-AD(2004)024 Үндсэн хуулийн шүүхийн талаарх Туркийн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд өгсөн санал, цогцолбор 44.

“(…) Венецийн комисс Герман, Испанийн заалтуудыг дэмжиж байна. Эдгээр заалтуудын дагуу, ердийн шүүхийн шийдвэрийн эсрэг Үндсэн

хуулийн гомдол гарсан тохиолдолд Үндсэн хуулийн шүүх өмнө нь тус шийдвэр гарсан талд мэдэгдэл хийх боломжийг олгох хэрэгтэй. (...)"

"(...) Үндсэн хуулийн шүүхийн тайлбарыг төрийн бусад бүх байгууллага, тэр дундаа доод шатны шүүхүүдэд заавал биелүүлэх ёстой гэсэн хууль тогтоомжийн шууд заасан заалт эсвэл бүүр Үндсэн хуулийн заалт нь Үндсэн хуулийн шүүх болон ердийн шүүх хоорондын харилцааг тодорхой болгоход чухал элемент болдог."

"Венецийн комиссын зүгээс, Үндсэн хуулийн шүүх нь ердийн шүүхийн энгийн хууль хэрэглээний асуудалд хөндлөнгөөс оролцдог "супер/аугаа их - Дээд шүүх"-ийн үүргийг гүйцэтгэх гэсэн сонголтоос зайлсхийхийг зөвлөж байгаа бөгөөд Үндсэн хуулийн шүүх нь хэргийн харьяаллаа хязгаарлахын зэрэгцээ өөрийн хэт ачааллаас зайлсхийх замаар зөвхөн Үндсэн хуулийн асуудлаа авч үздэг байхыг зөвлөж байна (...)"

CDL-AD(2010)039rev Хувь хүний Үндсэн хуулийн шүүхэд хандах эрхийн талаарх судалгаа, цогцолбор 132, 202, 226.

"Сахилгын хэрэг хянан шийдвэрлэсэн Шүүхийн Зөвлөлийн шийдвэрүүдийн эсрэг гаргасан гомдлыг хянан шалгах нь Үндсэн хуулийн шүүхийн үндсэн чиг үүргийн нэг хэсэг биш юм. Иймэрхүү хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хувьд, Үндсэн хуулийн шүүх нь Үндсэн хуулийн бус, харин давж заалдах шатны шүүх шиг харагдаж байна. Венецийн Комисс Сербийн талаар хэлж байсан шиг, "Үндсэн хуулийн шүүх бол шүүхийн болон прокурорын зөвлөлүүдийн холбогдох шийдвэрүүдийг хянан шалгадаг анхны бөгөөд цорын ганц шүүх юм. Тиймээс, Үндсэн хуулийн шүүх маргаантай байгаа фактуудыг Үндсэн хуулийн гомдлын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шаарддагаас илүү нарийвчлан хянан шалгах шаардлагатай болж байна.»

Түүнчлэн, Үндсэн хуулийн шүүхэд Үндсэн хуулийн гомдлууд дээр, сахилгын хэргүүдийн давж заалдах гомдлуудыг хариуцуулах нь Үндсэн хуулийн шүүхийн ачааллыг эрс нэмэгдүүлж болзошгүй гэдэг утгаараа асуудалтай байж болох юм. Дээр дурдсанаас үзвэл, давж заалдах шатны харьяаллыг Дээд шүүхэд хэвээр үлдээж, үүний зэрэгцээ Шүүхийн Зөвлөлийн гишүүд, Дээд шүүхийн давж заалдах шатны шүүхийн гишүүд, шүүгчийн сахилгын хэргийн процедурыг эхлүүлэх эрх бүхий этгээдүүд хооронд ашиг сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх дүрмийг боловсруулах нь илүү сайн сонголт болох болов уу."

CDL-AD(2014)026 “Хуучин Югославын Бүгд Найрамдах Македон Улс”-ын, ялангуяа, Шүүхийн зөвлөл, Үндсэн хуулийн шүүхийн бүрэн эрх, санхүүгийн тусгай бүсийн тухай Үндсэн хуулийн долоон нэмэлт, өөрчлөлтөд өгсөн санал, цогцолбор 93-95.

5.2.7 Иргэний мэдээлэл (Акцио популарис)

“Үндсэн хуульд нийцсэн эсэх асуудлыг шийдвэрлэхэд Акцио популарисыг ашиглах нь Европын стандарт гэж үзэх боломжгүй гэдгийг Венецийн Комисс онцлон тэмдэглэхийг хүсэж байна. Энэхүү механизм нь Үндсэн хуульд үл нийцэх хуулиуд, ялангуяа Үндсэн хуулиас өмнө батлагдсан хуулиудыг хуулийн тогтолцооноос хурдан авч хаях боломж олгодог бөгөөд Үндсэн хуулийн иж бүрэн хяналтын хамгийн өргөн баталгаа³ гэж үзсээр ирснийг хүлээн зөвшөөрч байна. Гэсэн хэдий ч харьцуулсан судалгаанаас харахад ихэнх улс орнууд энэхүү механизмыг Үндсэн хуулийн шүүхийн өмнө хуулийн актыг эсэргүүцэх зохистой арга хэрэгсэл гэж сонгон хэрэгжүүлдэггүй. Тиймээс, одоогоор Европ болон Венецийн комиссын гишүүн орнуудын дунд *actio popularis*-ыг ашиглаж байгаа улс нь онцгой тохиолдолд хамаарна. Түүнчлэн Монтенегро улсын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн төслийн талаарх санал дүгнэлтдээ (CDLAD(2008)030), Венецийн комиссын зүгээс *actio popularis*-ыг хасахыг зөвлөсөн. Энэ хүрээнд, Комисс “Үндсэн хуулийн шүүхэд хандах ийм өргөн боломж нь Шүүхийг бүхэлд нь хэт ачаалалд буюу хэт дарамтад оруулна (§ 51-ийг үзнэ үү)” гэдгийг харуулсан Хорватын туршлагыг дурдсан.”

CDL-AD(2011)001 Унгарын шинэ Үндсэн хуулийн төслийг боловсруулах явцад үүссэн хууль зүйн гурван асуудлын талаарх санал, цогцолбор 57-58.

“Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа 20.1 дэх хэсгийн 1 дэх цогцолборт зааснаар хувь хүн, эсхүл хуулийн этгээд нь хууль тогтоомж, бусад зохицуулалтын актууд Үндсэн хуулиар баталгаажуулсан түүний эрх, эрх чөлөөг зөрчсөн гэж үзвэл Үндсэн хуулийн шүүх буюу танхимд гомдол гаргах эрхтэй. Хуулийн төсөлд /Англи хувилбар/ хуулийн энэхүү заалтын “түүний” гэснийг хасахаар тусгажээ. Гэхдээ, уг хуулийн англи эх бичвэрт “түүний” гэсэн үг байхгүй байгаа нь редакцын эсхүл орчуулгын алдаа бололтой. Уг хуулийн орос хэл дээрх эх бичвэрүүд болон хуулийн төсөлд «эрх, эрх чөлөө» гэсэн үгийн ард «түүний» (оросоор “его”) гэсэн үг орсон

³ H. Kelsen, cit.in: R. Ben Achour, “Le contrôle de la Constitutionnalité des lois: quelle procédure?”, Actes du colloque international « L’effectivité des droits fondamentaux dans les pays de la communauté francophone », PortLouis (Ole Maurice), 29-30 septembre, 1er octobre 1993, p.401.

байгаа учир, эдгээр нь илүү нэгдмэл байна. Тайлбар бичгийн дагуу, энэхүү нэмэлт, өөрчлөлт нь зөвхөн редакцын шинжтэй байгаа боловч Үндсэн хуулийн шүүх буюу танхимд *actio popularis* байдлаар хандах боломжийг бий болгож, хийсвэр болон тодорхой хяналтын субъектүүдийн хооронд төөрөгдөл үүсгэж болзошгүй байгааг тэмдэглэх нь зүйтэй. «Эрх, эрх чөлөө» гэсэн үгийн өмнөх «тэдний» (эсвэл «түүний») гэсэн үгийг хассанаар Үндсэн хуулийг зөрчсөн гэж гомдол гаргаж буй аливаа хүн түүнд өөрт нь тухайн зөрчил шууд нөлөө үзүүлсэн эсэхээс үл хамаарч Үндсэн хуулийн шүүх буюу танхимд хандах боломжтой болно. Үүнд төсөл санаачлагчдын хүсэл зориг байсан эсэх нь тодорхойгүй байна. Венецийн комисс 2011 онд ийм дүгнэлтийг хийж байсан бөгөөд санал болгоод буй нэмэлт, өөрчлөлтийг одоо ч гэсэн дахин авч үзэхийг зөвлөж байгаа юм. Үндсэн хуулийн шүүхэд гомдол гаргах боломж эрх нь хөндөгдсөн тодорхой хүмүүсээр хязгаарлагдах хэрэгтэй. Эс бөгөөс аливаа хуулийн актын талаар гаргасан хүмүүсийн гомдлоор Үндсэн хуулийн шүүх буюу Танхим хэт ачаалалд орж болзошгүй.”

CDL-AD(2014)020 Бүгд Найрамдах Киргиз улсын Дээд шүүхийн Үндсэн хуулийн танхимын талаарх Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд өгсөн санал, цогцолбор 9-10.

“Мөн нэмэлт, өөрчлөлтөд зөвхөн эрх нь хөндөгдсөн хүн л гомдол гаргах эрхтэй гэдгийг тусгаж өгөх нь зүйтэй. Тухайн заалтыг уншигч нь ойлгохдоо нэг хүн нөгөө хүнийхээ эрхийн зөрчлийн талаар гомдол гаргаж болохоор ойлгогдож байх хэрэгтэй. Венецийн Комиссын зүгээс улс орнуудыг өөрсдийн хууль эрх зүйн системд *actio popularis*-ыг нэвтрүүлэхгүй байхыг үргэлж анхааруулсаар ирсэн бөгөөд зөвхөн эрх нь зөрчигдсэн хохирогчид л гомдол гаргах боломжтой гэдгийг тодорхой мэдүүлэх нь зөв гэж үздэг. Энэхүү тайлбар, зөвлөгөө нь зөвхөн Үндсэн хуулийн тухай гомдолд хамаарахаас биш хууль болон бусад холбогдох зохицуулалтад хийсвэр хяналтын төсөл, саналд хамаарахгүй юм.

CDL-AD(2014)026 “Хуучин Югославын Бүгд Найрамдах Македон Улс”-ын, ялангуяа, Шүүхийн зөвлөл, Үндсэн хуулийн шүүхийн бүрэн эрх, санхүүгийн тусгай бүсийн тухай Үндсэн хуулийн долоон нэмэлт, өөрчлөлтөд өгсөн санал, цогцолбор 87.

5.3 ЭРХИЙГ ҮР ДҮНТЭЙ СЭРГЭЭХ АРГА ХЭМЖЭЭ

“Хэрэв аль нэг улс Үндсэн хуулийн шүүхэд хувь хүний гомдол гаргах процессыг, Страсбургийн шүүхэд хүрэх боломжтой маргааны хувьд эрх сэргээх дотоодын арга хэмжээг олгож байх боломжийг баталгаажуулах (өөрөөр хэлбэл тус Конвенцын 13 дугаар зүйлд заасан үр дүнтэй эрх сэргээх арга хэмжээг олгож, мөн 35.1 дэх хэсэгт заасанчлан тэрхүү арга хэмжээг шавхсан байх нөхцөлийг тавих) -ын хамтаар, нэвтрүүлэхийг зорьж байгаа бол, тэрхүү процесс нь тухайн хэргийн хувьд заавал биелэх шинжтэй шийдвэр гаргуулах замаар эрх сэргээдэг байх хэрэгтэй. Шүүх нь хэргийг хянан шийдвэрлэх үүрэгтэй байх бөгөөд зардал эсхүл өмгөөллийн талаар үндэслэлгүй шаардлага гаргаж болохгүй.”

“Гэсэн хэдий ч шүүхэд хэт их ачаалал үүсэх эрсдэлтэй бөгөөд үүнийг хувь хүмүүсийн Үндсэн хуулийн шүүхэд хандах эрхийг үр дүнтэй хангах хэрэгцээтэй тэнцвэртэй байлгах нь зүйтэй байна. Хүний эрхийг хамгаалахад Үндсэн хуулийн асуудлыг хөндсөн өргөдлийг хэт хатуу сонгон шалгаруулж үр дүнд хүрнэ гэхийн оронд, ердийн бүх шүүхүүд Үндсэн хуулийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох боломжтой байх хэлбэрийг бүрдүүлэх хэрэгтэй.”

CDL-AD(2010)039rev Хувь хүний Үндсэн хуулийн шүүхэд хандах эрхийн талаарх судалгаа, цогцолбор 93, 226.

5.3.1 Процедурин үргэлжлэх хугацаа

“Иймэрхүү илүү хүндрэлтэй зүйл гарахгүй гэж үзсэн ч, холбогдох хуулийн заалт Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг шалгахад тавигдсан 30 хоногийн хугацааг, ялангуяа их хэмжээний нэмэлт ажлын ачаалал үүсгэдэг хувь хүмүүсийн гомдлын хувьд биелүүлэхэд туйлын хэцүү байна. Нэг талаас Унгарын эрх баригчдын ердийн шүүхийн өмнө хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түргэн шуурхай явуулах гэсэн хүслийг ойлгож байгаа хэдий ч, үүнийг хяналт хийгээд тэнцвэрийн үндсэн элемент болох Үндсэн хуулийн хяналтыг үр дүнгүй болгох байдлаар хийж болохгүй.

Засгийн газрын тайлбарт (цогцолбор 61), Унгарын Засгийн газар Суурь хуулийн 24.2.b заалтын 30 хоногийн хязгаарыг 90 хоног болгон сунгах тухай нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг өргөн мэдүүлнэ гэдгээ мэдэгдсэн. Венецийн Комисс энэхүү санал нь мэдээж сайн үр дүн авч ирнэ хэмээн сайшаан үзэж байгаа боловч, тус хугацааны хязгаар нь маш хатуу хэвээр байгаа бөгөөд үүнийг илүү бодитой, жишээлбэл 9 сар болгох хэрэгтэй байна.»

CDL-AD(2013)014 Шүүгчийн хараат бус байдлыг бэхжүүлэх Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн тухай хуулийн төсөл (тайлбар, хүснэгт багтсан) болон Украины Үндсэн хуулийн ассамблейгаас өргөн мэдүүлсэн Үндсэн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 117-118.

“Гурван сарын хугацааны хязгаарлалт нь тийм ч ноцтой сөрөг үр дагаврыг бий болгохгүй ба талуудыг өөрсдийн хэрэгтээ сайтар бэлтгэх боломжийг олгоно гэдэгт эргэлзээгүй юм. Ийм учраас, заавал хатуу минимум дүрэм тогтоохгүйгээр, шүүх хурлаа нэг эсхүл хоёр сарын өмнө зарлах нь нэлээд олон Үндсэн хуулийн шүүхүүдийн практик болжээ. Шүүхүүд хугацааны хязгаарын талаар шийдвэрлэхдээ шударга шүүх хуралдааны зарчим болон талуудын эрх тэгш байдлын хуулийн ерөнхий зарчмуудыг баримталдаг. Хугацааны хязгаарыг уртасгахад хүргэж болох хүчин зүйл нь, төрөл бүрийн шүүхүүд дээрх ESM/OMT proceedings-д байсан шиг хэргийн нарийн төвөгтэй байдал байж болно. Жишээлбэл, Австрийн Үндсэн хуулийн шүүх шүүх хурал болохоос хоёр долоо хоногийн өмнө, яаралтай тохиолдолд долоо хоногийн өмнө талуудад мэдэгддэг.”

CDL-AD(2016)001, Польшийн Үндсэн хуулийн шүүхийн тухай 2015 оны 6-р сарын 25-ны өдрийн актад оруулах нэмэлт, өөрчлөлтийн талаарх санал, цогцолбор 85.

“Зарчмын хувьд Венецийн Комиссын зүгээс уг хуулийн төсөлд “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удаашруулсан эсхүл төвөг уддаг ноцтой асуудлуудыг зохицуулж, шударга шүүхээр шүүлгэх эрхийг хамгаалж байгаа”, ялангуяа Үндсэн хуулийн шүүхэд гаргах хувь хүний гомдлыг хуулийн тогтолцоонд нэвтрүүлснээр хувь хүмүүсийн эрх шууд хамгаалагддаг болсныг сайшааж байна. ЕХЭК-ийн 6 болон 13 дугаар зүйлийн дагуу, “Хэлэлцэн тохирогч улсууд энэ талаар хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлэхээ сонгох эрх чөлөөтэй”. Гэхдээ, шүүхийн процедурын шатанд урьдчилсан байдлаар тодорхойлогдсон хугацааны хязгаарлалт нь нарийн төвөгтэй, анхааралтай авч үзэхэд цаг хугацаа шаардлагатай хэргүүд, эсвэл Украины Үндсэн хуулийн шүүхийн өмнө олон хэрэг хүлээгдэж буй нөхцөл байдалд эдгээр хэргүүд хуулийн шинжээ алдах аюулыг агуулж байдаг. Зургаан сар болон нэг сарын аль аль нь хуулийн (хүнд) асуултуудыг шалгахад хангалттай биш байж болох юм. Комиссын зүгээс Шүүхийн Их танхим зарим онцгой тохиолдлуудад эдгээр хугацааг сунгах боломжтой байх хэрэгтэй гэж зөвлөж байна.»

CDL-AD(2016)034, Украин - Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 48.

6 ШҮҮХИЙН ХАРЬАЛАЛ

“Венецийн комиссын үзэж байгаагаар, Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрүүд нь нийтээр хүлээн зөвшөөрөгдөхийн тулд нэгдмэл бөгөөд үндэслэл бүхий аргументүүд дээр тулгуурласан байх ёстой. Жишиг хууль (case law) дахь өөрчлөлт нь хуулийн тодорхой байдлыг алдагдуулахгүйн тулд сайн үндэслэлтэй, сайтар тайлбарлагдсан байх ёстой. Хуулийн тодорхой байдлын зарчим нь хууль дээдлэх ёсны гол элементүүдийн нэг болохынхоо хувьд аливаа үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг үндсэн хуульд нийцээгүй гэж тогтоохдоо тус нэмэлт, өөрчлөлт батлагдсанаас хойш өнгөрсөн цаг хугацааг харгалзан үзэхийг мөн шаарддаг. Түүнчлэн, тухайн шүүхийн шийдвэр зөвхөн хэлбэрийн буюу процессын үндэслэлд тулгуурласан бол, уг шийдвэрийн бодит үр нөлөөг харгалзан үзэх шаардлагатай байдаг. Өөрөөр хэлбэл, [Үндсэн хуулийн шүүхийн] энэхүү эцсийн шийдвэр Үндсэн хуульд нийцсэн байх шаардлагыг тухайн асуудал бүхий Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хүчингүй болгосноос үүсэх сөрөг үр дагавартай балансалдаг тохирсон байдлын тест (proportionality test) дээр үндэслэгдсэн байх хэрэгтэй.

Эцэст нь иймэрхүү шийдвэрт хоёрдмол утгагүй түр зуурын (transitory) заалтуудыг тусгаж, мөн доод эрэмбийн хэм хэмжээг бий болгох хийгээд төрийн байгууллагуудын үйл ажиллагааг одоо үйлчилж буй Үндсэн хуульд нийцүүлэхэд шаардагдах цаг хугацааны тодорхой хязгаарлалтыг тогтоох нь чухал юм.”

CDL-AD(2010)044 Украины Үндсэн хуулийн нөхцөл байдлын талаарх санал, цогцолбор 38-39.

“Хуулийн N заалтын 3 дахь цогцолборын дагуу, Үндсэн хуулийн шүүх “Төсвийн менежментийн тэнцвэртэй, ил тод, тогтвортой байх” зарчмыг хүндэтгэх үүрэг хүлээсэн. Энэхүү зохицуулалт нь үндсэн эрх зөрчигдсөн талаарх маргааны үед холбогдох ашиг сонирхлуудыг жинлэхдээ төсвийн менежментийг илүүд үзэхийг зохицуулсан байх шиг байна. Венецийн комиссоос санхүүгийн холбогдох шалтгаанууд нь хэм хэмжээний тайлбар болон хэрэглээнд холбогдох нөлөөг үзүүлж болох ч, эдгээр нь Үндсэн хуулийн шаардлага хийгээд хамгаалалтыг давахад хангалттай биш гэж үзэж байна. Санхүүгийн тэдгээр шалтгаанууд нь Үндсэн хуулийн шүүхийн төрийн аливаа актыг, хэрэв тус акт Үндсэн хуулийг зөрчсөн байвал, хянан шалгах, улмаар хүчингүй болгох ажил үүрэгт ямар нэгэн байдлаар саад болох ёсгүй.

CDL-AD(2011)016 Унгарын шинэ Үндсэн хуулийн талаарх санал, цогцолбор 51.

[Холбооны] Үндсэн хууль нь бүрэлдэхүүн улсуудын Үндсэн хууль хийгээд [ердийн] хууль тогтоомжуудаас дээд хүчин чадал бүхий байх нь тунхаглагдсан бөгөөд Босни Герцеговинагийн Үндсэн хуулийн шүүх бол бүрэлдэхүүн улсуудын Үндсэн хууль [Холбооны] Үндсэн хуультай нийцэж буй эсэхийг шалгах бүрэн эрхтэй. Тиймээс холбооны улсын ерөнхий шинжүүд одоо ч хэвээрээ байна.

CDL-AD(2011)030 Бүгд Найрамдах Серпскийн нутаг дэвсгэрт байрлах төрийн өмчийн статусын тухай болон захиран зарцуулахыг хориглосон тухай хуулийн талаар Босни Герцеговина улсын Үндсэн хуулийн шүүхэд гаргасан *Amicus Curiae* - санал, дүгнэлт, цогцолбор 21.

“Төсвийн асуудалд тавих Үндсэн хуулийн шүүхийн хяналтын эрх мэдлийг хязгаарласан хязгаарлалтыг цуцлах хэрэгтэй. Ядаж Шилжилтийн хуулийн 27-р зүйлд заасан хэт хязгаарлалтыг Үндсэн хуулийн 37.4-т нийцүүлэх хэрэгтэй байна.”

CDL-AD(2012)009 Унгарын Үндсэн хуулийн шүүхийн тухай 2011 оны CL1 хуулийн талаарх санал, цогцолбор 54(10).

“Энэхүү заалт нь Үндсэн хуулийн шүүх дээр хүлээгдэж байгаа маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг тус шүүхээс Шүүхийн дээд зөвлөл рүү хуулиар шилжүүлнэ гэсэн үг юм. Энэ нь эрх мэдэл хуваарилах зарчим, хууль дээдлэх ёсны талаар ноцтой эргэлзээг төрүүлж байна. Хууль тогтоогч нэгэнт эхэлсэн маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд хөндлөнгөөс оролцохоос татгалзах хэрэгтэй бөгөөд Үндсэн хуулийн шүүх холбогдох хууль тогтоомжийн өөрчлөлт нь тухайн гомдлыг дуусгавар болгох эсэхийг өөрөө шийдвэрлэдэг байх учиртай. Сербийн Үндсэн хууль (CDL-AD(2007)004), Шүүгчийн тухай болон шүүхийн зохион байгуулалтын тухай хуулийн төслүүдийн талаарх санал дүгнэлтдээ, Венецийн комиссын зүгээс [гомдлыг] дуусгавар болгохтой холбоотой шийдвэрийг тухайн шүүх эцэслэн гаргадаг байх хэрэгтэй гэж үзсэн.

Тиймээс Үндсэн хуулийн шүүх дээр эдгээр хэргийг дуусгавар болгохын оронд, Шүүхийн дээд зөвлөл болон Сербийн прокуророос явуулах шинэ хянан шалгах ажиллагааг хүлээж, өмнөх маргаан хянан шийдвэрлэх ажиллааг түдгэлзүүлэх нь илүү дээр юм. Гэхдээ, хэрэв тухайн шүүгч, эсхүл прокурортой холбоотой таагүй шийдвэр гарсан тохиолдолд давж заалдах

гомдлыг үргэлжлүүлэх боломжтой байх хэрэгтэй. Дуусгавар болгохоос түдгэлзүүлэх нь дуусгавар болсон тохиолдолд гарч болох шиг хүчтэй эсэргүүцлийг бий болгохгүй юм. Мөн энэхүү хувилбар нь аливаа хувь хүний хувьд таагүй үр дүнд хүрсэн тохиолдолд бодит байдал дээр Үндсэн хуулийн шүүхэд хандахтай тэнцэхүйц боломжийг хадгалах болно.”

“Хууль тогтоогч нэгэнт эхэлсэн маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд хөндлөнгөөс оролцохоос татгалзах хэрэгтэй бөгөөд Үндсэн хуулийн шүүх холбогдох хууль тогтоомжийн өөрчлөлт нь тухайн гомдлыг дуусгавар болгох эсэхийг өөрөө шийдвэрлэдэг байх учиртай. Сүүлийнх нь хувьд, нэгэнт эхэлсэн хэрэг маргааныг дуусгавар болгохын оронд, Шүүхийн дээд зөвлөл болон Сербийн прокуророос явуулах шинэ хянан шалгах ажиллагааг хүлээж, өмнөх маргаан хянан шийдвэрлэх ажиллааг түдгэлзүүлэх нь илүү дээр юм. Гэхдээ, хэрэв тухайн шүүгч, эсхүл прокурортой холбоотой таагүй шийдвэр гарсан тохиолдолд давж заалдах гомдлыг үргэлжлүүлэх боломжтой байх хэрэгтэй.”

CDL-AD(2011)015 Сербийн Шүүгчийн тухай болон Улсын яллах ажиллагааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн хэрэгжилтийн талаарх Шүүхийн дээд зөвлөл, Улсын прокурорын зөвлөлийн шийдвэрийн төсөлд өгсөн түр дүгнэлт, цогцолбор 18-19, 42.

“Үүнтэй холбогдуулан, Унгарын Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийн хариуд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр хариу үйлдэл гаргах гэсэн нэгдмэл хандлага сүүлийн үед Унгарт ажиглагдаж байгаа ба [Үндсэн хуулийн] IV нэмэлт, өөрчлөлт уг хандлагыг дагасан. Үндсэн хуулийн шүүхээс Үндсэн хууль зөрчсөн гэж үзээд хүчингүй болгосон заалтуудыг Үндсэн хуулийн түвшинд дахин оруулж ирсээр л байна: Ердийн хууль тогтоомжийн заалтуудыг “Үндсэн хуульчлах” энэхүү хандлага нь Үндсэн хуулийн шүүхийн хяналтаас бултах боломжийг бий болгож байна.

(...)

“Унгарын засгийн газрын төлөөлөгчид Үндсэн хууль баталж, мөн түүнд нэмэлт, өөрчлөлт (Унгарын парламентын гуравны хоёрын саналаар) оруулах нь бүрэлдүүлэх эрх мэдэл (the constituent power)-ийн бүрэн эрхт шийдвэр гэдгийг зөв зүйтэй онцолсон. Үндсэн хуулыг ардчилсан нийгэмд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах боломж нь хууль тогтоомжийг хянах эрх бүхий Үндсэн хуулийн шүүхийн эсрэг тавигддаг чухал тэнцвэржүүлэгч болохын дээр, Үндсэн хуулыг ардчиллыг тодорхойлж байдаг [төрийн эрх

мэдлийн] хяналт, тэнцвэрийн нарийн тогтолцооны чухал элемент болж байдаг. Гэсэн хэдий ч, энэхүү арга зам нь Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахад зайлшгүй шаардлагатай нарийн бэлтгэл ажил, олон нийтийн өргөн хэлэлцүүлэг, улс төрийн томоохон зөвшилцөлд тулгуурласан тодорхой тохиолдлуудад л зөвтгөгдөнө.

Будапешт дахь хэлэлцүүлгийн үеэр, Засгийн газрын олонхын төлөөлөгчид зарим тохиолдолд парламент Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрт хариу үйлдэл үзүүлж байсныг хүлээн зөвшөөрсөн. Гэхдээ, энэ нь жишээлбэл Австрали улсад парламент нь Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийг давахын тулд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах аргыг ашигласан гэдгийг ч онцолсон. Хэдийгээр дээрх жишээ маргаангүй үнэн боловч, 1988 онд Австрийн Үндсэн хуулийн шүүх “Үндсэн хууль зөрчсөн хуулийг дахин үндсэн хуульчлахыг Үндсэн хуулийг бүхэлд нь шинэчлэн найруулсан гэж үзэж болох ч, энэ нь Австрийн Үндсэн хуулийн 33.4-т заасны дагуу парламентын гишүүний гуравны хоёрын саналаар батлах боломжтой байдаг Үндсэн хуулийн энгийн нэмэлт, өөрчлөлттэй нэгэн адил батлагдах боломжгүй” гэж үзсэнийг онцлон тэмдэглэх хэрэгтэй. Үнэндээ, Австрийн Үндсэн хуулийн шүүх тус нэмэлт, өөрчлөлтийг дараа нь хүчингүй болгосон байдаг. Тиймээс Австрийн Үндсэн хуулийн шүүх Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт нь суурь зарчмуудыг зөрчсөн эсэхэд хяналт тавих эрхээ эцэстээ эргүүлэн олж авсан юм.

Европын стандартууд, тухайлбал Европын Зөвлөлийн дүрмийн дагуу, Унгар улс ардчиллыг тогтоон барих, хүний эрхийг хамгаалах, хууль дээдлэх ёсыг эрхэмлэх үүрэг хүлээсэн. Тиймээс Унгарын парламентын бүрэн эрх олон улсын эрх зүйгээр хязгаарлагдсан байдаг.

Ердийн хуулийг Үндсэн хуулийн хяналтаас хамгаалах арга нь системчлэгдэж байгаад Венецийн комисс санаа зовниж байна. Энэ нь Үндсэн хуулийн шүүхийн Үндсэн хуулийг хамгаалах үүргийг ноцтой бөгөөд санаа зовоохоор хэмжээнд алдагдуулах үр дүнд хүргэж байна. Энэ бол хууль дээдлэх ёсны талаасаа асуудал хэдий ч, ардчилсан зарчмын талаасаа бүр ч том асуудал юм. Хяналт хийгээд тэнцвэрт байдал бол ардчиллын салшгүй чухал хэсэг билээ. Ердийн хууль тогтоомжид хяналт тавих Үндсэн хуулийн шүүхийн бүрэн эрхийг бууруулах (төсвийн асуудал) болон зарим тохиолдолд бүрэн хасах (“Үндсэн хуульчлах” асуудал) нь ардчилсан хяналт хийгээд тэнцвэрт байдал, эрх мэдлийн хуваарилалт зөрчигдөхөд хүргэнэ.”

(...)

“Үндсэн хуулийн шүүх үндсэн хуулийн зүйл заалтуудын агуулгыг хянах боломжгүй байх хэрэгтэй гэсэн санаа нь Европын зөвлөлийн олон гишүүн орнуудын нийтлэг ойлголт юм. Бельгийн үндсэн хуулийн шинэчилсэн найруулгын талаар Комиссоос дараах байр суурийг илэрхийлсэн:

“49. [...] Бельги нь үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг шүүхийн хяналтад байлгахаас эрс татгалздаг Франц гэх мэт улсуудын уламжлалыг баримталдаг. Үндсэн хуулийн зөвлөл нь ‘Үндсэн хууль тогтоогч бол бүрэн эрхт учраас үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг бусад байгууллагаар (тэдгээр нь үндсэн хуулийн дагуу байгуулагдсан) хянуулж болохгүй’ гэж маргасан. Хэдийгээр Австри болон Германд тус хяналтыг хэрэгжүүлэх боломж байдаг ч, тэдгээр нь Европын нийтлэг стандартыг илэрхийлдэггүй.

50. Ихэнх үндсэн хууль тогтолцоонууд нь үндсэн хуулийн бүх заалтууд хэм хэмжээний ижил зэрэгтэй байх ба үндсэн хуулийг шинэчлэх бүрэн эрхт нь үндсэн хуулийн өмнөх заалтуудыг өөрчлөх эрхтэй гэсэн урьдчилсан нөхцөл (*assumption*) дээр суурилдаг. Гэж үзвэл ерөнхийдөө Үндсэн хуулийн нэг заалт нь бусад заалттайгаа зөрчилдөж болохгүй юм. *Үндсэн хуулийн* шинэчлэлтэд шүүхийн хяналтыг зөвшөөрөхгүй байгаа нь Үндсэн хуулийн шинэчлэлийг ард түмэн өөрсдөө хуульчилсан бөгөөд энэ нь ард түмний бүрэн эрхт байдлын илэрхийлэл гэсэн санаанаас үүдэлтэй. Ард түмнийг парламент төлөөлөх бөгөөд энэхүү парламент нь бүрдүүлэгч эрх мэдэлтэн (*constituante*)-ийн хувиар үйл ажиллагаа явуулна. *Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэр гаргах* энэхүү эрх бүхий байдал нь Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд тавигддаг тусгай шаардлага (дийлэнх олонх)-ийн улмаас илүү нэмэгддэг.

51. Үндсэн хуулийн шинэчлэлд хууль дээдлэх ёсноос урган гарах хязгаарлалтыг буюу Үндсэн хуулийн шүүхийн хяналтыг хүлээн зөвшөөрөх эсэх бол ард түмний бүрэн эрхт байдал болон хууль дээдлэх ёс гэсэн тодорхой нэг хэсгээрээ өөр хоорондоо зөрчилдөх Үндсэн хуулийн үнэт зүйлсийн балансыг олох асуудал юм. Энэ асуудлын хүрээнд ихэнх Үндсэн хуулиуд ард түмний бүрэн эрхт байдлыг илүүд үзсэн байдаг. Бельгийн процедур нь энэхүү балансжуулалтыг хийх талаарх Европын олон янзын хандлагын

нэгт тооцогдох бөгөөд хууль ёсны хуулийн шийдэл (*legitimate legal solution*)-ийн хязгаарыг хэтрүүлээгүй байна.”

(...)

“Үндсэн хуулийн шүүхийн хууль тогтоомжийг хянах эрх мэдлийг хязгаарлаж байгаад ноцтой санаа зовниж байгааг Венецийн комисс дахин илэрхийлж байна. Үндсэн хууль зөрчсөн байж болзошгүй хууль тогтоомжуудыг халхавчлах нь Унгарын Үндсэн хуулийн дээд эрх мэдэлд шууд халдаж байна. Комисс IV нэмэлт, өөрчлөлт нь үргэлжилсэн төсвийн хүндрэлээс болоод уг заалтыг оруулсан, улмаар энэхүү халхавчийг институтчилсанд онцгой санаа зовж байна. Энэ заалт IV нэмэлт, өөрчлөлт нь Үндсэн хуулийн шүүхийн Үндсэн хууль болон түүний ардчилал, хүний эрхийг хамгаалалт, хууль дээдлэх ёс зэрэг Европын стандартуудыг багтаасан зарчмуудыг бататгах хамгаалах үндсэн хууль сахиулагчийн байр суурийг унагаасан гэх үнэлгээг өгөхөөс өөр аргагүйд хүргэж байна.”

CDL-AD(2013)014 Шүүгчийн хараат бус байдлыг бэхжүүлэх Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн тухай хуулийн төсөл (тайлбар, хүснэгт багтсан) болон Украины Үндсэн хуулийн ассамблейгаас өргөн мэдүүлсэн Үндсэн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 84-87,103,113.

“XXXIX-ийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл нь Үндсэн хуулийн шүүхийн харьяаллыг хувь хүнээс тэдгээрийн өөрсдийн эрх зөрчигдсөн талаар гаргасан гомдлыг (цаашид “Үндсэн хуулийн гомдол” гэх) хянан шийдвэрлэдэг болгож, өргөжүүлсэн. Одоогийн байдлаар Үндсэн хуулийн шүүх нэлээд хязгаарлагдмал үндсэн эрхтэй холбогдох үндсэн хуулийн гомдлыг авч үздэг. Одоо тус эрхийн жагсаалт нь, хэдийгээр хаалттай жагсаалт хэвээрээ байгаа ч гэсэн, нэлээд өргөжсөн.

Ерөнхийдөө Үндсэн хуулийн шүүхийг үндсэн хуульд ардчиллын тулгын чулуу гэж үздэг. Венецийн комисс зарим улс хүний эрхийг зөрчсөний улмаас хувь хүн үндсэн хуулийн гомдол гаргах боломж бүрдүүлснийг сайшаасан. Тиймээс энэ чиглэлээр Үндсэн хуулийн шүүхийн эрх мэдлийг өргөжүүлэх нь сайшаалтай хэрэг юм.

Үндсэн хуулийн 110 дугаар зүйлийн 3 дахь цогцолборт жагсаасан үндсэн эрхийн нэлээд хязгаарлагдмал катологи болон 1992 оны Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дэгийн IV хэсгээс шалтгаалж, өнөөг хүртэл Үндсэн хуулийн шүүхэд хүний эрхийн зөрчлийн талаар маш цөөхөн тооны

л гомдол иржээ. Тухайлбал 2013 оны байдлаар нийт 22 гомдол иржээ. [Харин] тухайн хугацаанд Европын хүний эрхийн шүүх тус улсаас 500 гаруй гомдол хүлээн авсан байна. Энэ нь хүний эрхийн зөрчлийн эсрэг шинэ арга замыг үндэсний хэмжээнд нэвтрүүлбэл Үндсэн хуулийн шүүхийн хянан шийдвэрлэх хэргийн тоо эрс өсөх бодит эрсдэл байгааг харуулж байна. Комиссоос ийм төрлийн шинэ арга замыг нэвтрүүлэхдээ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дэгийг батлах, ажлын шинэ арга барилыг боловсруулах, хуулийн ажилтнууд болон нарийн бичгүүдийг сургах, ажилд авах гэх мэт нарийн бэлтгэл шаардлагатай гэж үзэж байна. Зарим улсад ийм арга замыг нэвтрүүлэхээс өмнө урт хугацааны (жишээ нь Турк, 2 жил хүртэл) бэлтгэл ажлыг хийсэн байдаг. Венецийн комиссын зүгээс энэхүү сайшаахуйц нэмэлт, өөрчлөлт нь шууд үр нөлөөтэй байх хэрэггүй бөгөөд ингэснээр хууль тогтоомжийн түвшинд шаардлагатай бэлтгэл, нэмэлт, өөрчлөлтүүдийг хийх боломж бүрдэнэ гэж зөвлөж байна.

Олон тооны гомдлыг хянан шийдвэрлэхийн тулд Үндсэн хуулийн шүүхийн дэргэд шийдвэр гаргадаг, ялангуяа илэрхий хүлээн авах боломжгүй гомдлыг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх, илүү жижгэвтэр байгууллагуудыг бий болох хэрэгтэй. Ийм зорилгоор Македон Улсын Засгийн газарт Үндсэн хуулийн 113-р зүйлийн хоёрдугаар шинэ цогцолборт холбогдох зохицуулалтыг оруулах талаар санал оруулсан.”

CDL-AD(2014)026 “Хуучин Югославын Бүгд Найрамдах Македон Улс”-ын, ялангуяа, Шүүхийн зөвлөл, Үндсэн хуулийн шүүхийн бүрэн эрх, санхүүгийн тусгай бүсийн тухай Үндсэн хуулийн долоон нэмэлт, өөрчлөлтөд өгсөн санал, цогцолбор 78-79, 81-82.

6.1 ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ДЭД АКТАД ТАВИХ ХЯНАЛТ

“Гүйцэтгэхэд төвөгтэй ажлаар шүүхэд хэт их ачаалал үүсгэхээс зайлсхийхэд онцгой анхаарал хандуулах хэрэгтэй. Шүүх хэт их ачаалалтай болох эрсдэл нь яг одоо үүссэн байгаа шиг, Үндсэн хуулийн шүүхээс үндсэн хуульд нийцсэн байдлын талаарх асуудлыг хариуцуулахаас гадна Азербайжаны эрх зүйн тогтолцоо дахь хэм хэмжээний шатлан захирах системийн дэг журамтай байдлыг хангахыг мөн шаардах (Европын эх газрын эрх зүйн тогтолцоонд энэ үүргийг захиргааны хэргийн шүүхэд илүүтэй хамааруулсан байдаг)-д үүсдэг.”

CDL-INF(1996)010 Бүгд Найрамдах Азербайжан Улсын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 3.

6.2 ХУУЛЬ ТОГТООМЖИЙН УРЬДЧИЛСАН ХЯНАЛТ

“Үндсэн хуулийн урьдчилсан хяналт (the ex ante constitutional review) нэлээд олон улсад байдаг бөгөөд энэ нь хууль батлагдахаас өмнө тухайн хуулийн Үндсэн хуульд нийцсэн байдлыг хангахад маш чухал хэрэгсэл болдог.

Гэсэн хэдий ч тус хяналтыг санаачлагч, хэрэгжүүлэх тодорхой хэв загварын талаар Европын нийтлэг стандарт байдаггүй. Улс орнууд өөрсдийн үндсэн хуулийн уламжлал, онцлог хэрэгцээ шаардлагад нийцүүлэн ямар байгууллага, ямар хэмжээгээр урьдчилсан хяналтыг хэрэгжүүлэх эрхтэй, түүнчлэн хэн үүнийг санаачлах эрхтэй болохыг шийддэг.”

CDL-AD(2011)001 Унгарын шинэ Үндсэн хуулийн төслийг боловсруулах явцад үүссэн хууль зүйн гурван асуудлын талаарх санал, цогцолбор 34-35.

“Үндсэн хуулийн шүүхийн дараах хяналт (ex post review) дахь үндсэн үүргээс гадна урьдчилсан хяналт дахь үүргийг цөөнгүй улсад хүлээн зөвшөөрдөг болохыг практик харуулж байна. Венецийн комисс Үндсэн хуулийн шүүхийг урьдчилсан хяналт хэрэгжүүлдэг цорын ганц бөгөөд хамгийн тохиромжтой байгууллага гэж үзэж байна. Гэсэн хэдий ч Үндсэн хуулийн шүүхийн үйл ажиллагаа, шүүх байгууллагын хувьд эдлэх бүрэн эрхийг хэт улс төржүүлэхээс зайлсхийхийн тулд урьдчилсан хяналтыг хэрэгжүүлэхээр санаачилга гаргах эрхийг хязгаарлагдмал байдлаар олгох хэрэгтэй.”

CDL-AD(2011)001 Унгарын шинэ Үндсэн хуулийн төслийг боловсруулах явцад үүссэн хууль зүйн гурван асуудлын талаарх санал, цогцолбор 37.

“Үндсэн хуулийн шүүхийн урьдчилсан (a priori) хяналтын илэрхий сул тал бол шүүхээс тухайн хуулийг практикт хэрхэн хэрэглэгдэх талаар мэдэлгүйгээр шууд шийдвэр гаргах ёстой байдагт оршдог. Үндсэн хуулийн зөрчил нь ихэвчлэн захиргааны болон шүүхийн байгууллагуудын зөвхөн практикаар л дамжин ил болдог. Эсрэгээрээ, ердийн шүүхээс үндсэн хууль зөрчсөн байж болзошгүй хуулийг үндсэн хуульд нийцсэн байдлаар тайлбарласан байх ч боломжтой.

Үндсэн хуулийн урьдчилсан хяналтыг өргөнөөр ашиглахын эсрэг хамгийн хүчтэй үндэслэл бол аливаа хуулийн үндсэн хуульд нийцээгүй байдал нь төрийн байгууллагуудын практик буюу бодит үйлдлээр дамжин үүсэх боломжтой байдаг ба тэр ч байтугай энэхүү боломж нь тухайн хуулийн үндсэн хуульд нийцсэн эсэх асуудлыг аль хэдийн Үндсэн хуулийн шүүх хийсвэр буюу урьдчилсан хяналтаараа оруулахаар болсон үед ч адилхан байдаг гэх үндэслэл юм.”

CDL-AD(2011)001 Унгарын шинэ Үндсэн хуулийн төслийг боловсруулах явцад үүссэн хууль зүйн гурван асуудлын талаарх санал, цогцолбор 49-50.

“Үндсэн хуульд нийцээгүй тул хүчин төгөлдөр бусад тооцуулахаар шаардагдсан акт нэгэнт хүчингүй болсон ч гэсэн, зарим онцгой тохиолдолд (нийтийн ашиг сонирхол өндөр байх тохиолдолд) [Дээд шүүхийн Үндсэн хуулийн] танхимд тухайн гомдлыг хүлээн авч, шийдвэрлэх эрх мэдлийг олгох нь зүйтэй.”

CDL-AD(2011)018 Киргизийн Дээд шүүхийн Үндсэн хуулийн танхимын талаарх Үндсэн хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 38.

“(...) Гэсэн хэдий ч зөвхөн “цөөн хэдэн улсад л үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн процедурын үед Үндсэн хуулийн шүүхэд [урьдчилсан хяналтыг хэрэгжүүлэх] албан ёсны ажил үүрэг олгогдсон” байдгийг Венецийн комисс цохон тэмдэглэж байна. Урьдчилсан хяналт бол “нэлээд ховор процедурын механизм” гэдгийг Комисс дурдаж байна. Үндсэн хуулийн шүүхийн дараах хяналт (a posteriori review) “хамаагүй илүү өргөн тархсан” байдаг ч, үүнийг нийтлэг практик гэж хараахан үзэж болохгүйг Комиссоос зарлаж байна. Тиймээс иймэрхүү хяналтыг хууль дээдлэх ёсны нэг шаардлага гэж үзэж болохгүй. Бельги нь Франц зэрэг үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг шүүхийн хяналтад оруулахаас эрс татгалздаг улсуудын уламжлалыг баримталдаг. Үндсэн хуулийн зөвлөл нь ‘Үндсэн хууль тогтоогч бол бүрэн эрхт учраас үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг бусад байгууллагаар (тэдгээр нь үндсэн хуулийн дагуу байгуулагдсан) хянуулж болохгүй’ гэж маргаж байсан. Австри болон Германд хянах боломж байдаг ч, тэдгээр нь Европын нийтлэг стандартыг илэрхийлдэггүй.”

CDL-AD(2012)010 Бельгийн Үндсэн хуулийн өөрчлөлтөд өгсөн санал, цогцолбор 49.

6.3 ОЛОН УЛСЫН ГЭРЭЭНИЙ УРЬДЧИЛСАН ХЯНАЛТ

“Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 135.1.с хийгээд Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн төслийн 115.2, 117 дугаар зүйлд “соёрхон батлах ёстой” олон улсын гэрээнд үндсэн хуулийн урьдчилсан хяналтыг хэрэгжүүлэх бөгөөд “Үндсэн хуульд нийцээгүй гэж үзсэн тухайн олон улсын гэрээ, эсхүл тэдгээрийн тодорхой заалтуудыг соёрхон батлахгүй буюу хүлээн зөвшөөрөхгүй ба тэдгээр нь Бүгд найрамдах Молдова Улсад хүчин төгөлдөр болохгүй» (117.2-р зүйл). “Үндсэн хуульд нийцээгүй байдлын онцгой тохиолдлын арга замаар (by the means of the exception of non-constitutionality)” болон хуулийн төслийн 115.3-т зааснаар нэгэнт хүчин төгөлдөр болсон олон улсын гэрээнд Үндсэн хуулийн хяналт тавьж болохыг онцлон хэлэх хэрэгтэй. [Үндсэн хуульд нийцээгүй гэж] зарласан ийм гэрээ, эсхүл түүний тодорхой хэсгийг (нэг талын хүсэл зоригоор) цуцлахад хүрнэ. Соёрхон баталсан (хүчин төгөлдөр) гэрээнүүд нь гэрээний нөгөө талтай харилцан хамааралтай байх нь ойлгомжтой ба Үндсэн хуулийн шүүхээс ийм гэрээг хүчингүй болговол энэ нь олон улсын маргааныг үүсгэж, олон улсын нийтийн эрх зүйн дагуу улсын хариуцлагын асуудлыг бий болгож болзошгүй. Олон улсын гэрээний тухай Венийн конвенцын 27 дугаар зүйлд: “Оролцогч нь гэрээг биелүүлэхгүй байгаагаа зөвтгөхийн тулд дотоодынхоо эрх зүйн заалтаас иш татаж болохгүй” гэж тодорхой заасан байдаг. Нэгэнт хүчин төгөлдөр болсон гэрээг Үндсэн хуульд нийцээгүй гэж үзэн цуцлах нь тухайн улсаас олон улсын эрх зүйн хүчин төгөлдөр хэм хэмжээ, түүнд тусгагдсан үнэт зүйлд хандах зохистой хандлага бол биш юм. Харин нийтлэг хандлага бол улс орнууд өөрсдийн эрх зүйн тогтолцоогоо (Үндсэн хууль багтана) олон улсын үүрэгтээ нийцүүлэх юм.”

CDL-AD(2002)016 Бүгд Найрамдах Молдова Улсын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн төсөл болон Үндсэн хуульд оруулах холбогдох нэмэлт, өөрчлөлтөд өгсөн санал, цогцолбор 9.

“Үндсэн хуулийн шүүхэд үндсэн хуулиар баталгаажсан эрхийг хамгаалахаас гадна Үндсэн хуулийн зөрчилд тооцогдохгүй хэм хэмжээний хэрэглээ, тайлбарын үйл ажиллагаа дахь алдааг хянах бүрэн эрхийг ч мөн шилжүүлэх замаар шүүхийн хэт ачааллыг бий болгохоос Венецийн комисс сэрэмжлүүлж байна.”

CDL-AD(2010)039rev Хувь хүний Үндсэн хуулийн шүүхэд хандах эрхийн талаарх судалгаа, цогцолбор 99.

“Хуулийн төслийн 4.1.2-т заасны дагуу Үндсэн хуулийн танхим нь “Бүгд Найрамдах Киргиз Улсын нэгдэн орсон, гэхдээ хүчин төгөлдөр болоогүй олон улсын гэрээ Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх талаар дүгнэлт гаргана”. Энд “Үндсэн хуульд нийцсэн байдал (constitutionality)” гэх нэр томъёог бус, “Үндсэн хуультай нийцтэй байдал (concordance with the Constitution)” гэх нэр томъёог хэрэглэх, мөн “Венийн конвенцод нийцүүлж “гарын үсэг зурсан улс» гэх нэр томъёог хэрэглэх нь зүйтэй юм.”

CDL-AD(2011)018 Киргизийн Дээд шүүхийн Үндсэн хуулийн танхимын талаарх Үндсэн хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 14.

6.4 ХУУЛИЙН ДЭД АКТАД ТАВИХ ХЯНАЛТ

“Үндсэн хуулийн шүүхэд ердийн хууль тогтоомжийг тайлбарлах бүрэн эрх олгох хэрэггүй. Түүнийг бүрэн эрхийг Үндсэн хуулийн тайлбараар хязгаарлах хэрэгтэй. Ердийн хууль тогтоомжийг тайлбарлах бүрэн эрхийг ихэвчлэн Дээд шүүхэд олгодог.”

CDL-AD(2009)014 Палестины Үндэсний эрх баригчдын Үндсэн хуулийн дээд шүүхийн тухай хуулийн талаарх санал, цогцолбор 25.

“30.2 зүйлээр, тодорхой нэг хууль Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны үед тус хуулийн талаарх парламентыг байр суурийг лавлах хүсэлт гаргах эрхийг (“Хүсэлт гаргаж ч болно, гаргахгүй байсан ч болно”) зөвхөн [Үндсэн хуулийн] шүүхэд олгосон. Парламент өөрийн байр суурийг илэрхийлэх энэхүү хязгаарлагдмал боломж нь маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны хувьд ч, парламентын өөрийнх нь хувьд ч тийм ч ашигтай зүйл биш. Парламентад түүний актууд Үндсэн хуулийн шүүхээр хянагдаж байх үед өөрийн холбогдох байр суурийг чөлөөтэй илэрхийлэх боломж үргэлж олгогдсон байх хэрэгтэй.”

CDL-AD(2008)030 Монтенегро улсын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 44.

“Үндсэн хуулийн хяналтад хамааруулж болох хэм хэмжээний төрлүүдийн тухайд, Үндсэн хуулийн шүүх нь хэт ачааллаас зайлсхийхийн тулд зөвхөн хууль тогтоомжуудын Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх асуудлыг хянан шалгах бүрэн эрхтэй байж, доод шатны хэм хэмжээнүүдэд тавих хяналтыг зарчмын хувьд ердийн шүүхүүдэд үлдээх хэрэгтэй гэж Венецийн комисс үзэж байна.”

CDL-AD(2010)039rev Хувь хүний Үндсэн хуулийн шүүхэд хандах эрхийн талаарх судалгаа, цогцолбор 6.

6.5 ҮНДСЭН ХУУЛИЙН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ

“Үндсэн хуулийн шүүхийн Үндсэн хуулийн холбогдох хэсгийг хянаж, хүчингүй болгох бүрэн эрх нь өөрөө, ялангуяа Үндсэн хуульд “мөнхийн заалт” байхгүй тохиолдолд маргаантай, туйлын төвөгтэй асуудал юм. Венецийн комисс Украины талаарх дүгнэлтдээ, Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ажиллагаанд Үндсэн хуулийн шүүх оролцох талаар харьцуулсан үндсэн хуулийн эрх зүйд нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн стандарт гэж байдаггүй гэдгийг дурдсан. Венецийн комисс Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн талаарх тайландаа, Европын зарим орнууд ийм [Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ажиллагаанд Үндсэн хуулийн шүүх оролцох] боломжийг тодорхой заасан байдаг боловч, нэгэнт батлагдсан Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дараа нь шүүхийн зүгээс хянан шалгах нь харьцангуй ховор механизм болохыг тэмдэглэсэн. Зарим улс оронд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг шүүхээр хянан шалгах нь онолын хувьд боломжтой байдаг ч практикт хэзээ ч хэрэгжиж байгаагүй. Харин бусад улсад шүүх төрийн байгууллага болохынхоо хувьд өөрийгөө үндсэн хууль тогтоогчоос дээгүүр байрлуулж болохгүй гэсэн үндэслэлээр татгалзсаар ирсэн. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг шүүхээр хянан шалгах аас эрс татгалздаг нь Францын тогтолцоо юм. Тус тогтолцоонд үндсэн хууль тогтоогч нь бүрэн эрхт байдаг учраас Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг бусад байгууллагаар (Үндсэн хуулиар бий болсон) хянуулах боломжгүй гэж үздэг. Тиймээс Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хянахыг Үндсэн хуулийн зөвлөл (эсвэл бусад шүүхүүдэд)-ийн бүрэн эрхэд хамааруулдаггүй. Австрийн Үндсэн хуулийн шүүх Үндсэн хуулийн суурь зарчмуудыг де-факто өөрчлөх боломжгүй (эсхүл, зөвхөн бүх нийтийн санал асуулгаар өөрчлөх боломжтой) гэж үздэг арай өөр арга замыг баримталдаг.

Ингэж үзвэл, Үндсэн хуулийн шүүхэд ядаж Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг батлах журмыг хянах (нэмэлт, өөрчлөлтийн агуулгыг хянахаас ялгаатай) эрх мэдлийг өгөх боломжтой юм. Эцсийн эцэст энэ удаагийн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл нь ард нийтийн Үндсэн хуульд өөрчлөлт оруулах тухай санал асуулга зэрэг ард нийтийн санал асуулгын Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг шалгах Үндсэн хуулийн шүүхийн

бүрэн эрх (Одоогийн Үндсэн хуулийн 131.л хэсгийг үз)-ийг хөндөөгүй. Аль нь ч байсан гэсэн, Үндсэн хууль нарийн тодорхой хийгээд ердийн хууль тогтоомжийн түвшинд ихэвчлэн зохицуулах ёстой асуудлуудыг өөртөө багтаасан байх тохиолдолд, Үндсэн хуулийн шүүхийн ажил үүрэг аль хэдийн нэлээдгүй хязгаарлагдмал болсон байх болно. Хэрэв Үндсэн хуулийн шүүхэд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын асуудалд хяналт тавих эрх олгогдсон бол, жишээлбэл холбогдох гомдлыг гаргах хугацаа ямар байх, хэн үүнийг гаргах эрхтэй байх гэх мэт илүү нарийвчилсан зохицуулалтууд шаардагдах болно.”

CDL-AD(2015)045, Албани улсын шүүх эрх мэдлийн тухай Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийн талаарх түр дүгнэлт, цогцолбор 20-21.

“[Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн] төслийн 91 зүйлийн 3 дугаар цогцолбороор Үндсэн хуулийн зөвлөлд үндсэн хуулийн бүх нэмэлт, өөрчлөлтийг батлагдахаас нь өмнө тус хуулийн 91 дүгээр зүйлийн 2 дахь цогцолборт заасан улсын нэгдмэл байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, тусгаар тогтнол хийгээд засаглалын хэлбэрийг өөрчилж болохгүй гэх шаардлагуудад нийцүүлж хянан шалгах эрхийг олгосон. Энэхүү нэмэлт, өөрчлөлт нь эерэг алхам юм. Гэхдээ энэхүү жагсаалтыг засаглалын ардчилсан хэлбэр, үндсэн хуулиар хамгаалагдсан хүний салшгүй эрхүүдийг нэмж дурдах замаар гүйцээхийг зөвлөж байна.”

CDL-AD(2017)010 Казахстаны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд өгсөн санал, цогцолбор 41.

6.6 АРД НИЙТИЙН САНАЛ АСУУЛГЫН АСУУЛТ

“[Үндсэн хуулийн] шинэчилсэн нэмэлт, өөрчлөлтөд «Дөчин таваас доошгүй Ардын депутатууд» Украины бүх нийтийн санал асуулгад тавигдах асуултууд нь Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх талаар Үндсэн хуулийн шүүхээс дүгнэлт гаргуулах боломжийг нэмж оруулсан. Үүнийг талархан хүлээж авах хэрэгтэй.”

CDL-AD(2015)027 2015 оны 9-р сарын 4-ний өдөр Үндсэн хуулийн комиссоос батлагдсан шүүхийн талаарх Украины Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд өгсөн санал, цогцолбор 31.

6.7 ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ҮНДСЭН ХУУЛИЙН ХЯНАЛТААС ГАРГАХ

“[Үндсэн хуулийн] шинэчилсэн төслийн 60(6)-д Үндсэн хуулийн шүүхээс тухайн сонгуулийн жилд сонгуулийн тухай хэм хэмжээнүүдийг, хэрэв тус сонгуулийн тухай хэм хэмжээ нь холбогдох сонгууль болохоос өмнөх нэг жилийн дотор батлагдаагүй бол, Үндсэн хууль зөрчсөн гэж тогтоохыг хориглосон заалт хэвээр үлдсэн. Сонгуулийн хуулийг, хэрэв тус сонгуулийн хууль нь холбогдох сонгууль болохоос өмнөх нэг жилийн дотор батлагдаагүй бол, Үндсэн хуулийн хяналтаас тухайн сонгуулийн жилд бүрэн гаргаж байгаа нь өмнөх дүгнэлтэд дараах үндэслэлээр шүүмжлэгдсэн: Хэдийгээр сонгуулийн үйл явцыг хөндлөнгийн оролцооноос урьдчилан сэргийлэх зорилгоор сонгууль болохоос өмнөх тодорхой хугацаанд хэд хэдэн хязгаарлах шинжтэй арга хэмжээ авахыг зөвтгөж болох ч, тухайн сонгуулийн жилд сонгуулийн хуулиудыг Үндсэн хуулийн хяналтаас гаргах агуулга бүхий санал болгож буй энэхүү тогтолцоо нь тохиромжтой бус (disproportionate) байна. Гүржийн эрх баригчид, тус улсын сонгуулиуд 10-р сард болдог учраас Үндсэн хуулийн шүүхээс сонгуулийн хуулиудыг Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг сонгуулийн жилийн өмнөх оны 10-с12-р сар хүртэлх 3 сарын хугацаанд хянах боломжтой гэж тайлбарласан. Сонгуулийн бэлтгэл ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай тодорхой хугацаанд Үндсэн хуулийн шүүхээс аливаа шийдвэр гаргах явдлыг урьдчилан сэргийлэх нь зүй ёсны хэрэг. Гэхдээ Үндсэн хуулийн шүүхээс сонгуулийн хуулийн талаар хяналт тавих боломжгүй байх хугацааг багасгах хэрэгтэй. Түүнчлэн төслийн 60(6)-д, Үндсэн хуулийн шүүх нэгэнт явагдсан сонгууль Үндсэн хуульд нийцсэн эсэх талаар шийдвэр гаргах бол бүх шүүгчдийн хуралдааны нэгдмэл саналаар шийдвэрээ гаргах, мөн Үндсэн хуулийн шүүх тухайн шийдвэрээ сонгуулийн дүн албан ёсоор нийтлэгдсэнээс хойш 7 хоногийн дотор гаргах гэсэн хоёр нэмэлт хязгаарлалтыг оруулжээ. Үндсэн хуулийн шүүх нэгэнт явагдсан сонгууль Үндсэн хуульд нийцсэн эсэх асуудлыг хянан шийдвэрлэхдээ бүх шүүгчдийн хуралдааны нэгдмэл саналаар шийдвэрийг гаргах гэсэн шаардлага нь асуудалтай байх бөгөөд үүнийг энгийн олонхын шаардлагаар солих хэрэгтэй.”

CDL-AD(2017)023 Гүржийн парламентын хоёр дахь хэлэлцүүлгээр баталсан Үндсэн хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд өгсөн санал, цогцолбор 44.

“Сонгуулийн үйл ажиллагааг будлиантуулахаас урьдчилан сэргийлэх гэдэг зорилго нь хууль ёсны байхын хирээр үндсэн хуулийн байгууллага болох Үндсэн хуулийн шүүх өөрийн үүргээ зохих ёсоор гүйцэтгэнэ гэдэгт итгэх хэрэгтэй. Сонгуулийн хуулийн тогтвортой байдлыг хангах хэрэгцээ шаардлага нь сонгуулийн өмнөх тодорхой хугацаанд Үндсэн хуулийн шүүхээс шийдвэр гаргахгүй байхыг зөвтгөж болно. Гэхдээ ямар ч хэм хэмжээ, дүрэм Үндсэн хуулийн хяналтаас бүрэн чөлөөлөгдөх ёсгүй. Хэрэв энэ заалтыг хэвээр үлдээнэ гэвэл хууль тогтоомжийн тухайд Үндсэн хуулийн шүүх 12 сарын хугацаанаас өмнө батлагдсан хууль тогтоомжийг хянах боломжтой байхаар өөрчлөлт найруулах шаардлагатай. Сонгууль болохоос 60 хоногийн өмнө гаргасан Сонгуулийн төв хорооны хэм хэмжээний актыг [Үндсэн хуулийн шүүхийн] хяналтаас гаргасан асуудлыг дахин бодолцох хэрэгтэй.”

CDL-AD(2017)013 Гүрж - Үндсэн хуулийн шинэчилсэн төсөлд өгсөн санал, цогцолбор 76.

“Үндсэн хуулийн шүүх одоогийнх шигээ Сайд нарын зөвлөлд хуулийн хүчин төгөлдөр тогтоол гаргах эрх мэдэл олгосон хуулиудыг хянан шалгах боломжоо алдахад хүрнэ. Нэмэлт, өөрчлөлтийн дараа Ерөнхийлөгч [зарлиг гаргахад] түүнд холбогдох эрх мэдлийг олгосон хууль шаардлагагүй болно. Тус нэмэлт, өөрчлөлтөөр Ерөнхийлөгчийн хууль тогтоох үйл ажиллагааны хязгаарыг аливаа хууль зарлигаас давуу байдалтай байх формал шаардлагаар тодорхойлсон ч, Үндсэн хуулийн шүүхэд энэ талаар зайлшгүй үүсэх зөрчилдөөнийг шийдвэрлэх тодорхой эрх мэдлийг олгоогүй байна.”

CDL-AD(2017)005 2017 оны 1 дүгээр сарын 21-ний өдөр Үндэсний Их Хурал баталж, 2017 оны 4 дүгээр сарын 16-ны өдөр бүх нийтийн санал асуулгад оруулах Туркийн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд өгсөн санал, цогцолбор 122.

6.8 ОЛОН УЛСЫН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙГ ДОТООДОД ХЭРЭГЖҮҮЛЭХ

“Хуулийн текстүүдийг олон улсын шүүхийн шийдвэрүүдийг, ялангуяа хүний эрхийн салбарын шийдвэрүүдийг хэрэгжүүлэхэд чиглэсэн зүйл заалтуудаар нэмж, өөрчлөх боломжтой. Мөн Хорват улс нэгдэн орсон хүний эрхийн, үндэстний цөөнхийн талаарх гэх мэт олон улсын баримт бичгүүдийн янз бүрийн хэм хэмжээний хэрэгжилт дэх Үндсэн хуулийн шүүхийн гүйцэтгэх

ажил үүргийг тодорхой зааж өгч болох юм. Энэ талаар тус хуульд тодорхой журмыг тусгах ч боломжтой.”

CDL-INF(2001)002 Үндсэн хуулийн шүүхийн талаарх Бүгд Найрамдах Хорват улсын Үндсэн хуулийн зохицуулалтад өгсөн санал, цогцолбор 9.

“Үндсэн хуулийн шүүх Европын хүний эрхийн конвенцын зарчмуудыг анхаарч үзэх тухай 68 дугаар зүйл нь сонирхолтой заалт бөгөөд Европ төвт байр сууринаас харвал үүнийг сайшаах хэрэгтэй юм.”

CDL-AD(2008)030 Монтенегро улсын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 70.

“(…) Аливаа улсын хувьд хүчин төгөлдөр болсон гэрээнээс бий болсон олон улсын үүргээ улсаараа, өөрөөр хэлбэл Үндсэн хуулийн шүүх зэрэг төрийн бүхий л байгууллага биелүүлэх ёстой байдаг. Хэрэв Үндсэн хуульд аль хэдийн дотоодын эрх зүйн тогтолцооны нэг хэсэг болчихсон гэрээнд харш заалт байгаа бол – Тухайн гэрээг дагаж мөрдөх талаар хүсэл зоригоо илэрхийлэх явцад (тухайн гэрээг соёрхон батлах, нэгдэн орох, хүлээн зөвшөөрөх замаар) шийдэх ёстой байсан нөхцөл байдал– гэрээний эдгээр заалтыг Үндсэн хуультай (жишээлбэл, Үндсэн хуулийг тайлбарлах, өөрчлөх замаар) нийцүүлэх тохиромжтой шийдлийг олох нь төрийн бүх байгууллагуудын үүрэг юм. Эс тэгвээс, төрийн хариуцлага (the state responsibility)-ын асуудал үүсэж, тухайн улсад хариу арга хэмжээ авах, санц ногдуулах зэрэг үр дагавар бий болно.”

“Төрийн байгууллагууд (Үндсэн хуулийн шүүх багтана) ‘Европын хүний эрхийн конвенцын дагуух хууль зүйн нөхцөлийг бий болгож, дагаж мөрдөхөөс гадна өргөдөл гаргагчийн нөхцөл байдлыг хангалттай хэмжээнд сайжруулахад саад учруулж болох дотоодын эрх зүйн тогтолцоо дахь бүх саад тотгорыг арилгах ёстой’(Шүүхийн шийдвэр Maestri эср. Italy, Дугаар 39748/98, 2004.02.17, цогцолбор 47).”

CDL-AD(2016)005 Оросын Холбооны улс - Үндсэн хуулийн шүүхийн тухай Холбооны Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд өгсөн түр дүгнэлт, цогцолбор 41 ба 53.

“Өнөөдөр Европт оршин байгаа олон давхаргат эрх зүйн тогтолцоонд эдгээр олон янзын тогтолцоо хоорондын зөрчилдөөнт байдлаас зайлсхийх боломжгүй юм. [Тиймээс] Европын хүний эрхийн шүүхийн шийдвэрүүд болон үндэсний (Үндсэн хууль) эрх зүйн тогтолцоо (үүнд үндэсний шүүхээс хийсэн тайлбарууд орно) хоорондын зөрчилдөөнийг намжаах арга механизмууд хэрэгтэй болдог.”

CDL-AD(2016)005 Оросын Холбооны улс - Үндсэн хуулийн шүүхийн тухай
Холбооны Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд өгсөн түр дүгнэлт,
цогцолбор 59

“..., Венецийн комиссын зүгээс Үндсэн хуулийн шүүх олон улсын шүүхийн шийдвэрийн гүйцэтгэлийн талаарх бүх арга хэрэгслийг тодорхойлох үүрэг хүлээх ёсгүй гэж үзэж байна. Олон улсын шүүхийн шийдвэрийг биелүүлэх хамгийн оновчтой аргыг сонгох нь үндсэн хуулийн бус улс төр, захиргааны асуудал бөгөөд энэ нь үндсэндээ засгийн газрын үүрэг юм. Хэрэв дээрх биелүүлэлтийн бүхий л асуудлыг Үндсэн хуулийн шүүхэд хариуцуулбал Үндсэн хуулийн шүүх нь олон улсын шийдвэрийг тойрсон бүх маргааны улс төрийн арбитр болох эрсдэлтэй болох юм. Үндсэн хуулийн шүүх нь олон улсын шийдвэрийг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулах боловч зөвхөн «сөрөг хууль тогтоогчийн» үүргийг гүйцэтгэдэг: Үндсэн хуулийн шүүх биелэлтийг хангах процесст шаардлагатай (хууль тогтоомжийн дэд акт, хууль тогтоомж, үндсэн хуулийн түвшин дэх) норматив актуудыг идэвхтэйгээр бий болгож болохгүй. Улмаар олон улсын шүүхийн шийдвэр биелүүлэх тодорхой хэлбэр Үндсэн хуульд нийцэхгүй байна гэсэн дүгнэлт гаргах нь бусад төрийн эрх мэдэл бүхий байгууллагуудын ажлын эхлэл болох ёстой. Тиймээс Үндсэн хуулийн шүүх зөвхөн гүйцэтгэлийн тодорхой хэлбэр, арга хэмжээ нь Үндсэн хуульд нийцсэн эсэх асуудлыг шийдвэрлэдэг байх (гэхдээ иймэрхүү тохиолдол нэлээд хязгаарлагдмал байх хэрэгтэй) хэрэгтэй ...

Венецийн комиссын түр дүгнэлтэд дурдсанчлан, шүүхийн шийдвэрийг тэр чигээр нь «гүйцэтгэх боломжгүй (non-executive)” гэж үзсэн нь асуудалтай байна. Үндсэн хуулийн хүрээнд гүйцэтгэх арга хэлбэр байхгүй гэсэн утгаараа “Гүйцэтгэх боломжгүй” байх нь тус улсын олон улсын үүрэгтэй зөрчилдөхгүй байх цорын ганц шийдэл болох Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах явдлыг илэрхийлнэ (Үүнийг Үндсэн хуулийн шүүхээс мэдээж зааварчлахгүй). Үр дүнд нь, төрийн бусад байгууллагуудын бүрэн эрх мэдэгдэхүйцээр багасахад хүрнэ ...

Дүгнэж хэлэхэд, олон улсын шийдвэрийг биелүүлэх асуудлыг бүхэлд нь Үндсэн хуулийн шүүхэд шилжүүлэх хэрэггүй гэж Венецийн комисс үзэж байна. Тиймээс Комиссын зүгээс, ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад Засгийн газрын төлөөлөгч (эсхүл төрийн бусад эрх бүхий байгууллага) өөрийн авах гэж байгаа [олон улсын шүүхийн шийдвэрийг] гүйцэтгэх тодорхой хэлбэр нь Оросын Үндсэн хуультай

зөрчилдөж болзошгүй гэдэгт эргэлзэж байгаа тохиолдолд энэ талаар Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийг гаргуулж болно гэсэн өөрчлөлт оруулахыг санал болгож байна.”

CDL-AD(2016)016 ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн тухай Холбооны Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай эцсийн дүгнэлт, цогцолбор 25– 27.

6.9 ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА ХООРОНДЫН ЭРХ ХЭМЖЭЭНИЙ ЗӨРЧИЛДӨӨН

“Комиссын зүгээс Украйны Үндсэн хуулийн талаарх дүгнэлтдээ (...) Украйнд Үндсэн хуульг ёсыг бэхжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэх боломжтой хэд хэдэн журмыг Үндсэн хуулийн эх бичвэрт тодорхой тусгагдаагүй байгааг аль хэдийн тэмдэглэсэн:

(...)

- төрийн байгууллага хоорондын эрх хэмжээний зөрчилдөөний талаарх заалт

Дээрх дүгнэлтдээ Комиссоос, Үндсэн хуулийн шүүхийн тухай хууль нь Үндсэн хуульд тусгагдсан журмуудыг тусгагдаагүй орхигдсон журмуудад ч гэсэн адилхан үр нөлөө үзүүлэхүйцээр ашиглах замаар эдгээр цоорхойг арилгахыг зорьж байгааг тэмдэглэсэн.”

CDL(1997)018rev Украйны Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн талаарх санал, цогцолбор 4.

“Киргиз улсад эрх хэмжээний зөрчилдөөний талаарх маргааныг эцэслэн шийдвэрлэх эрх бүхий байгууллага байхгүй тул, Үндсэн хуулийн шүүхийг төрийн эрх бүхий янз бүрийн байгууллагууд (Парламент, Ерөнхийлөгч, Засгийн газар, шаардлагатай бол прокурор зэрэг Шүүх эрх мэдлийн байгууллага)-аас Үндсэн хуулийн холбогдох зүйл заалтыг хэрхэн тайлбарлах талаар саналуудаа ирүүлэхийг шаарддаг байхаар хуулиар үүрэгжүүлэх хэрэгтэй. Ингэвэл цэвэр хийсвэр процедурын хүрээнд ч гэсэн Үндсэн хуулийн шүүх нь хагас адверсиал (a quasi adversial) процедураас ашиг гаргах боломжтой байх болно.”

CDL-AD(2008)029 Киргизийн (1) Үндсэн хуулийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (2) Үндсэн хуулийн шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 19.

“Үндсэн хууль зөрчсөн актыг хүчингүй болгох үүргийг Үндсэн хуулийн шүүхээс өөр байгууллагад өгсний давуу тал хаана байгааг ойлгоход бэрх байна. Цаашилбал, Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийг төрийн бусад байгууллага биелүүлэхгүй тохиолдолд үүсэж болох маргааны талаар зохицуулсан заалт байхгүй. Ямар нэгэн шалтгаанаар Үндсэн хууль зөрчсөн актыг шууд хүчингүй болгох нь тохиромжгүй байвал, Үндсэн хуулийн шүүх уг актыг Үндсэн хууль зөрчсөн гэж үзсэн шийдвэрийнхээ хүчинтэй байх хугацааг тухайн акт хуулийн хүчин чадлаа алдах хүртэл нь хойшлуулж болно. Энэ тохиолдолд тухайн акт хуулийн хүчин чадлаа алдах хүртлээ хүчинтэй хэвээр байна.”

CDL-AD(2017)011 Армен - Үндсэн хуулийн шүүхийн талаарх Үндсэн хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 85.

7 МАРГААН ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА

7.1 АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ - ШҮҮГЧИЙГ ХЭРГЭЭС ТАТГАЛЗАН ГАРГАХ

Үндсэн хуулийн шүүх нь Үндсэн хуулийн баталгаа гэдэг утгаараа Ардчилсан институтийн чиг үүргийг хэрэгжүүлэх явдлыг баталгаажуулах шаардлагатай. Шүүгчийг татгалзан гаргах боломж нь шүүхийг шийдвэр гаргах бололцоогүй байдалд хүргэж болохгүй. Иргэний процессын тухай хуулийн шүүгчийг татгалзан гаргах зохицуулалт нь шүүгчийг татгалзан гаргасан тохиолдолд түүний оронд өөр шүүгч оролцох боломжтой хэргийн ерөнхий харьяаллын хүрээнд тохиромжтой байх нь мэдээж. Харин, Үндсэн хуулийн шүүхийн хувьд асуудал арай өөр. Румын Улсад шүүгчийг татгалзан гаргах зайлшгүй шаардлагатай гэж үзсэн тохиолдолд оролцогчид тусгайлан Үндсэн хуулийн шүүхэд хүсэлт гаргах бөгөөд мөн Үндсэн хуулийн дээд эрэмбийн баталгааг хангагчийн хувиар Үндсэн хуулийн шүүхийн суурь зарчмыг хэрэглэн зохицуулалт байхгүй байх боломжийг (*non liquet*) үгүйсгэх шаардлагатай болдог.

CDL-AD(2006)006 Румын улсын Үндсэн хуулийн шүүхийн зохион байгуулалт, чиг үүргийн тухай №47/1992 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан хоёр хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 7.

Шинэчлэн найруулсан 36 дугаар зүйлийн 2 дах хэсэг нь талуудын шүүгчийг татгалзан гаргах хүсэлтийг шийдвэрлэх журмыг тодорхойлсон. Хэрэв ийм хүсэлт гарсан бол, шүүх “тухайн хэргийн талуудын үндэслэл, санал болон тухайн татгалзан гаргах хүсэлт чиглэсэн шүүгчийн саналыг сонссоны үндсэн дээр үндэслэлтэй шийдвэр гаргах ёстой.” Уг зохицуулалт нь шүүгч өөрөө татгалзан гаргах эрхийг хязгаарлаагүй бололтой. Гэсэн хэдий ч, улс төрийн эрх мэдэл, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дарамт шахалтад орвол шүүгч хэргийг шийдвэрлэхээс зайлсхийхийн тулд өөрөө хэргээс татгалзан гарах вий гэдэгт санаа зовниж байна. Ийнхүү “улс төрийн” үүднээс татгалзан гарах нь шүүхийн эрх мэдлийг ихээхэн сулруулах тул үүнээс зайлшгүй зайлсхийх ёстой. Шүүгчдийг гаднын дарамт шахалт, айлган сүрдүүлгээс хамгаалах нь эрх баригчдын үүрэг. Гаднын дарамтаас болж шүүгчид өөрөө хэргээс татгалзан гаргахаас өөр аргагүйд хүрсэн хэвийн бус нөхцөл байдлаас урьдчилан сэргийлэхийн тулд эрх баригчид шуурхай үр

дүнтэй ажиллах үүрэгтэй. Мөн хэвлэл мэдээллийн хэрэгслээр илэрхийлсэн шүүмжлэлтэй үзэл бодлыг шууд айлган сүрдүүлэлт гэж үзэх ёсгүй бөгөөд энэ нь шүүгчийг татгалзан гаргах үндэслэлд хамаарахгүй гэдгийг дурдах нь зүйтэй. Ийм байдлаар шүүгчийг татгалзан гаргах явдлаас зайлсхийхийн тулд, шүүгчийг татгалзан гаргах урьдчилсан нөхцөлүүдийг явцуу хүрээнд тайлбарлах, тэдгээрийг хязгаарлах шаардлагатай. Шүүгч тухайн хууль тогтоох үйл явцад оролцсон нь шүүгчийг татгалзан гаргах үндэслэл болохгүй. Учир нь, үлдсэн шүүгчдийн тоо шийдвэр гаргах ирцэд хүрэхгүй тул ийм төрлийн шүүгчийн татгалзал нь маргааныг шүүхийн харьяалалгүй байх эрсдэлд хялбархан хүргэнэ. Хэрэв шүүгч өөрийгөө хэргээс татгалзан гаргах юм бол, шүүгчийг татгалзан гаргах эсэхийг шийдвэрлэх шүүх хуралдааныг явуулах шаардлагагүй.

CDL-AD(2014)020 Бүгд Найрамдах Киргиз улсын Дээд шүүхийн Үндсэн хуулийн танхимын талаарх Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд өгсөн санал, цогцолбор 34.

“Шүүх тухайн маргааны зүйлтэй ашиг сонирхлын зөрчилтэй эсхүл ашиг сонирхлын зөрчилтэй байж болох тохиолдолд ашиг сонирхлын зөрчилтэй гэдэг үндэслэлээр шүүх тухайн маргааныг шийдвэрлэх үүргээс чөлөөлөгдөхгүй. Үндсэн хуулийн шүүх нь гомдол гаргасан хууль бүр Үндсэн хуульд нийцэж буй эсэхэд дүгнэлт хийх үүрэгтэй. Шүүхийн аль нэг гишүүн эсхүл хэд хэдэн гишүүд тодорхой хууль тогтоомжтой ашиг сонирхлын зөрчилтэй гэдэг үндэслэлээр шүүгчийг татгалзан гаргах боломжийг хүлээн зөвшөөрөх юм бол Үндсэн хуулийн шүүх шийдвэр гаргах үүргээ биелүүлэх боломжгүйд хүрнэ.

2002 оны Бангалорын Шүүхийн ёс зүйн зарчмууд нь ийм тохиолдол үүсэж болзошгүй гэдэг үүднээс тодорхой зохицуулалтуудыг тусгаж өгсөн байдаг. “Үнэт зүйл 2, Хараат бус байдал” гэх ерөнхий зарчмын хүрээнд хараат шүүгч эсхүл объектив байдлаар бусдаас хараат гэж тооцогдох шүүгч хэргийг хянан шийдвэрлэх ёсгүй боловч, хэрэв тухайн хэргийг шийдвэрлэх өөр шүүгч байхгүй бол шүүгчийг татгалзан гаргах шаардлагагүй гэдгийг тусгаж өгсөн байна. НҮБ-ын мансууруулах бодис болон гэмт хэрэгтэй тэмцэх албанаас гаргасан Бангалорын зарчмуудын тайлбарт дараах байдлаар тайлбарласан байдаг:

“Зайлшгүй байдлын номлол”

Онцгой нөхцөл байдал нь дээр дурдсан зарчмаас хазайхаас өөр аргагүй нөхцөл байдалд хүргэж болно. Зайлшгүй байдлын номлол нь хэргээс татгалзан гарах ёстой байсан шүүгчид тухайн хэргийг шийдвэрлэх боломжийг олгодог. Хэргийг шийдвэрлэх өөр тохирсон шүүгч байхгүй тохиолдол, эсхүл хэргийг хойшлуулах нь туйлын хүнд хэцүү байдалд хүргэх тохиолдол, эсхүл хэргээс татгалзан гарах ёстой шүүгч оролцохгүй бол шүүхийн ирц хүрэхгүй байх тохиолдлуудад дээрх онцгой нөхцөл байдал үүсэж болно. Ийм төрлийн кейс ховор байх нь мэдээж. Гэхдээ, өөр шүүгчид хэргийг шилжүүлэх боломжгүй дээд шатны шүүхүүд буюу Үндсэн хуулийн шүүх болон дээд шатны шүүхүүдэд ийм кейс үе үе гарж байдаг.”

Үндсэн хуулийн маргааныг харьяалан шийдвэрлэх ганц л шүүх байдаг болон/эсхүл цөөн тооны шүүгчидтэй, мөн шаардлага хангахгүй байх нь шударга ёсыг үгүйсгэхэд хүргэж болзошгүй бол энэ нь гарцаагүй асуудал юм.

Үндсэн хуулийн шүүхийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа, үндсэн хуулийн шүүхийн албан тушаалтанд тавигдах шаардлага, огцрох үндэслэл болон сахилгын шийтгэлийн асуудлуудыг зохицуулсан хууль тогтоомжийн хэм хэмжээ үндсэн хуулийг зөрчсөн эсэх тухай Үндсэн хуулийн шүүхэд маргаан үүсгэсэн тохиолдол нь дээрх онцгой нөхцөлд байдалд мөн хамаарч болно. Эдгээр тохиолдолд Үндсэн хуулийн шүүхийн шүүгчдийг хэргээс татгалзан гаргаж болохгүй.

Гэхдээ, Үндсэн хуулийн шүүхийн шүүгчид тавигдах шаардлагыг тусгасан хууль Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэх шүүгч тус хуулийн дагуу шүүгчид тавигдах шаардлагыг хангаагүй бөгөөд улмаар тус албан тушаалд тохирохгүй гэж үзэх үндэслэл байгаа бол шүүгч хэргээс өөрөө татгалзан гаргах эрхтэй төдийгүй зарим нөхцөлд огцрох шаардлагатай байж болох юм. Жишээ нь, зохион байгуулалттай гэмт бүлэглэлийн гишүүдтэй тохиромжгүй харилцаа холбоотойн улмаас шүүгчид тавигдах болзлыг хангахгүй гэдгээ тухайн шүүгч мэдэж байж болно. Гэхдээ, шүүхийн шүүгчид шударга ажиллаж байгаа гэсэн урьдчилсан таамаглал байдаг тул шүүгч хуульд заасан шаардлагууд нь үндсэн хууль зөрчсөн эсэхийг хянан шийдвэрлэж дүгнэлт өгөх боломжийг олгох ёстой.

CDL-AD(2016)036 Албани – Шүүгчид болон Прокуроруудын шилжилтийн дахин үнэлгээний хуулийн талаар Үндсэн хуулийн шүүхэд гаргасан Amicus Curiae - санал, дүгнэлтийн товч, цогцолбор 20-22, 24-25.

Венецийн комисс нь шүүхийн харьяалалгүй байх боломжтой хоёр Үндсэн хуулийн маргааны асуудалтай тулгарсан. 2006 онд Румын Улсын дүгнэлтэд Венецийн комисс нь шүүгчийг татгалзан гаргасны улмаас шүүгчдийн тоо шүүхийн ирцийн шаардлагыг хангахгүй болсон тохиолдолд үндсэн хуулийн шүүхийг гацааж болох эсэх асуултад хариулт өгөх болсон. Комисс нь “Үндсэн хуулийн шүүх нь Үндсэн хуулийн баталгаа гэдэг утгаараа Ардчилсан институт хэвээр чиг үүргээ хэрэгжүүлэх явдлыг баталгаажуулах шаардлагатай. Шүүгчийг татгалзан гаргах боломж нь шүүх шийдвэр гаргах бололцоогүй болоход хүргэж болохгүй. Иргэний процессын тухай хуулийн шүүгчийг татгалзан гаргах зохицуулалт нь шүүгчийг татгалзан гаргасан тохиолдолд түүний оронд өөр шүүгч оролцох боломжтой утгаараа хэргийн ерөнхий харьяаллын хүрээнд тохиромжтой байх нь мэдээж. Харин, Үндсэн хуулийн шүүхийн хувьд асуудал арай өөр. Румын Улсад шүүгчийг татгалзан гаргах шаардлагатай гэж үзсэн тохиолдолд оролцогчид тусгайлан Үндсэн хуулийн шүүхэд хүсэлт гаргах бөгөөд мөн Үндсэн хуулийн дээд эрэмбийн баталгааг хангагчийн хувиар Үндсэн хуулийн шүүхийн суурь зарчмыг хэрэглэн харьяаллын зохицуулалт байхгүй байх боломжийг (*non liquet*) үгүйсгэх шаардлагатай болдог” гэх дүгнэлтийг хийсэн.

Албанийн Үндсэн хуулийн шүүхэд өгсөн хөндлөнгийн шинжээчийн дүгнэлтэд, үндсэн хуулийн шүүхийн шүүгчдэд нөлөөлсөн бөгөөд жирийн үед тэднийг татгалзах боломжтой хуулийн үндсэн хуульд нийцэх эсэхийг Үндсэн хуулийн шүүх шалгаж болох эсэх асуудлыг хөндөх тухай Венецийн комисст хүссэн. Гэхдээ хэд хэдэн шүүгчдийг татгалзах тохиолдолд энэ нь шүүх бүрэлдэхүүний ирцийн шаардлагыг хангахгүй мөн Үндсэн хуулийн шүүх хэрэг шийдвэрлэх боломжгүй болох байсан. Энэ тохиолдолд, Венецийн комисс нь “Үндсэн хуулийн шүүхийн бүрэн эрх нь ямар ч хууль тогтоомж тэр дундаа шүүгчдийн маргаан шийдвэрлэх эрх хэмжээтэй холбоотой хууль тогтоомж Үндсэн хуулийн хяналтаас ангид байх ёсгүй гэдэг зарчмаас урган гардаг.” гэх дүгнэлтийг хийсэн.

CDL-AD(2016)001, Польш Улсын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт 37-38 дах цогцолбор

7.2 ХУУЛЬЧААР ЗААВАЛ ТӨЛӨӨЛҮҮЛЭХ

“Үндсэн хуулийн шүүх эрх зүйн асуудлыг тусгайлан шийдвэрлэнэ гэсэн хуулийн төслийн 7.3 дугаар зүйлтэй холбогдуулан, Үндсэн хуулийн шүүхийн өмнө талууд зайлшгүй хууль ёсны төлөөлөгчтэй байхыг үүрэг болгох нь зүйтэй.”

CDL-AD(2002)016 Бүгд Найрамдах Молдова Улсын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн төсөл болон Үндсэн хуульд оруулах холбогдох нэмэлт, өөрчлөлтөд өгсөн санал, цогцолбор 57.

“32 дугаар зүйлийн 2 дугаар хэсгийн шинэчлэн найруулсан төсөлд талууд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өөрсдөө шууд болон төлөөлөгчөөр дамжуулан оролцох эрхийг баталгаажуулсан байна. Ингэж зохицуулж мэдээж болно. Гэхдээ, шинэчилсэн найруулгад төлөөлөгчийг зайлшгүй хуульч байх шаардлага тавиагүй байх тул хуульч биш этгээдийг төлөөлөгчөөр томилох боломжтой болж байна. Венецийн комисс нь энэ зохицуулалтын зорилгыг тодруулахыг зөвлөж байна. Түүнчлэн, Үндсэн хуулийн танхимын өмнө хууль зүйн туслалцаа авах боломжтой байх ёстой гэдгийг Венецийн комисс зөвлөж байна.”

CDL-AD(2014)020, Киргизстаны Дээд шүүхийн Үндсэн хуулийн танхимын тухай Үндсэн хуулийн зүйл заалтад нэмэлт, оруулах тухай хуулийн төсөл.

7.3 ТАЛУУДЫН ЭРХ

“Түүнчлэн, маргаанд оролцогч талуудын процессын эрхийг тусгаж өгөөгүй нь маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой дутагдал юм. Тус хууль нь давж заалдах эрх (42 дугаар зүйл) болон шийдвэрийг давж заалдах этгээдэд хүргүүлэх тухай (70 дугаар зүйл) зохицуулалтыг агуулсан байна. Гэвч, талууд нэмэлт тайлбар гаргах эрхтэй эсэх түүнчлэн өөрөө болон хуульчийн тусламжтай эсвэл түүгээр төлөөлүүлэн өөрийнхөө хэрэг маргааны шүүх хуралдаанд оролцох боломжтой эсэхийг заасан зохицуулалт алга байна. Шүүхэд гомдол гаргасан этгээд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох эрхтэй байх зайлшгүй шаардлагатай. Европын Хүний эрхийн шүүх Европын Холбооны Конвенцын 6 дугаар зүйлийг мөн хувь хүнтэй холбоотой үндсэн хуулийн шүүхийн маргаанд хэрэглэх хандлагатай байдгийг дурдах нь зүйтэй. Тиймээс, шүүхийг аль болох уян хатан байр суурийг баримтлах нь зүйтэй. Гэхдээ аливаа тохиолдолд хувь хүний эрх хөндсөн ийм чухал асуудлыг хуульд тусгалгүйгээр шүүхийн дотоод

журам эсхүл шүүхийн эрх хэмжээнд даатгах явдлыг хүлээн зөвшөөрөхөд хүндрэлтэй байна.”

CDL(1997)018rev, Украины Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн дүгнэлт, 11 дах цогцолбор

7.4 ХЭРГИЙН ХУВААРИЛАЛТ

“Туркийн Үндсэн хуулийн шүүхэд илтгэгч шүүгч чухал үүрэг гүйцэтгэдэг. Тэдгээрийг хамгийн багадаа таван жил шүүгчээр ажилласан туршлагатай шүүгч, эрх зүйн профессор эсхүл туслах илтгэгчээр таван жил ажилласан эрх зүйн судлаачдаас сонгодог (24.2 дугаар зүйл) бөгөөд шүүгчийн баталгаат байдлыг эдэлдэг (24.4 дүгээр зүйл). Захиргааны зохион байгуулалтын хувьд тэд Үндсэн хуулийн шүүхийн гишүүдийн дор бус зөвхөн Үндсэн хуулийн шүүхийн даргын удирдлага дор ажиллана. Хэрэг маргааныг Үндсэн хуулийн шүүхийн дарга гишүүдэд биш илтгэгч шүүгчдэд хуваарилдаг. Турк Улсын Үндсэн хуулийн шүүхийн илтгэгч шүүгчид тухайн шүүхийн шүүгчидтэй адил баталгааг эдэлдэггүй тул, хэргийг автоматаар хуваарилах системийг оруулж ирэх нь зүйтэй. Энэ систем хэрэглэгдэхгүй байх онцгой тохиолдлуудыг хэргийн материалд тусгаж өгөхөд болно.”

“Хэргүүдийг илтгэгч шүүгчид автомат системээр дамжуулан хуваарилах хэрэгтэй. Энэ систем хэрэглэгдэхгүй байх онцгой тохиолдлуудыг хэргийн материалд тусгаж өгөхөд болно.”

CDL-AD(2011)040, Турк Улсын Үндсэн хуулийн шүүх байгуулах, маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль 39 дэх цогцолбор, 104(9).

4 дүгээр нэмэлт өөрчлөлтийн 14 дүгээр зүйл нь Үндсэн хуулийн 27 дугаар зүйлийг нөхөж байна:

“Шүүхэд мэдүүлэх үндсэн эрхийг тодорхой хугацаанд хэрэгжүүлэх, шүүх хоорондын хэргийн ачааллыг тэнцвэртэй хуваарилах үүднээс Үндэсний шүүхийн тамгын газрын дарга тодорхой хэрэг маргааныг ерөнхий шүүхийн харьяаллаас бусад тухайн маргааныг хянан шийдвэрлэх боломжтой шүүхийн харьяалалд шилжүүлж болно.”

Үндсэн хуулийн шүүх нь 2011/166 шийдвэрээр Ерөнхий прокурор нь хэргийг өөр харьяалалд шилжүүлэх явдлыг Европын Хүний эрхийн конвенцыг зөрчсөн байна гэж дүгнэсэн. Уг Үндсэн хуулийн шийдвэртэй холбогдуулан, хэргийг өөр харьяалалд шилжүүлэх явдлыг Үндсэн хуулийн

шилжилтийн заалтын 11.4 дүгээр зүйлд хуульчилсан байна. Үүний 4 дүгээр нэмэлт өөрчлөлт нь шилжилтийн заалтын 11.3 дугаар зүйлд тусгагдсан байсан ба ПНЖО-оор дамжуулан хэргийг шилжүүлэх зохицуулалтыг Үндсэн хуульд тусгаж өгсөн. Хороо нь Ерөнхий прокуророор дамжуулан хэргийг шилжүүлэхгүй байх зохицуулалтыг тусгаж өгсөнд сайшаалтай хандаж байна.

Хэргийг шилжүүлэх явдалд Венецийн хороо шүүмжлэлтэй хандсаар ирсэн: “Хэргийг шилжүүлэх тогтолцоо нь эрх зүйт ёсны мөн чанар болсон хууль ёсны шүүхийн зарчмыг хангахгүй байна. Үүнийг дахин шинэчлэн найруулах шаардлагатай. Энэ асуудлыг шийдэхээс нааш ямар ч хэргийг шилжүүлж үл болно.”

Унгарын засгийн газар 2013 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн тайлбартаа (44 дөх цогцолбор) Үндсэн хуулийн болон хууль тогтоох түвшинд хэргийг шилжүүлэх явдлыг үгүй хийнэ гэж мэдэгдсэн. Венецийн хороо нь Засгийн газрын уг зорилтыг дэмжиж байгаа бөгөөд энэхүү зорилтыг аль болох хурдан батлаасай гэж хүсэж байна.

CDL-AD(2013)014, Шүүгчийн бие даасан байдлыг сайжруулах Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн төслийн талаарх дүгнэлт болон Украин Улсын Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн төсөл 72-75.

129 дугаар зүйлд заасан хэргийг автоматаар хуваарилах систем нь Венецийн хорооны зөвлөмжүүдтэй нийцэж байна. Энэхүү өөрчлөлтийг сайшаалтайгаар хүлээж авч байна.

CDL-AD(2013)014, Шүүгчийн бие даасан байдлыг сайжруулах Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн төслийн талаарх дүгнэлт болон Украин Улсын Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн төсөл 31-32.

Шүүхийн даргаар дамжуулан хэргийн хуваарилалтыг хийхийн оронд, ЛСЛП-ийн 17 дугаар зүйл нь илтгэгч шүүгчдэд хэргийг хуваарилах автомат системийг хуульчилж өгсөн байна. Шүүхийн даргын эрх мэдлийг хязгаарлах замаар шүүгчдийн бие даасан, хараат бус байдлыг дэмжиж өгч байх тул уг өөрчлөлтийг сайшаалтайгаар хүлээн авч байна. Хууль зүйн яамны дарга энэхүү систем нь тохиолдлоор хэргийг хуваарилах систем биш бөгөөд шүүгч болгоны хэргийн ачааллыг анхаарч авч үзэж хуваарилдаг систем гэдгийг Венецийн хороонд мэдэгдсэн. Шүүх тухайн системийн программ хангамжийг өөрөө бүрэн удирдаж, хянадаг байх шаардлагатай.

CDL-AD(2016)017, Гүрж - Үндсэн хуулийн шүүхийн тухай органик хууль болон Үндсэн хуулийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөд өгсөн санал, цогцолбор 35.

“Журам эсхүл хуулийн төсөл нь шүүгчдэд хэргийг хуваарилдаг автомат системийг хуульчлах шаардлагатай.”

CDL-AD(2017)011, Армен - Үндсэн хуулийн шүүхийн талаарх Үндсэн хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор

Энэ асуудлыг шийдвэрлэх өөр нэгэн арга зам нь шүүхийн даргад хэргийг хуваарилах эрх мэдлийг өгөхийн оронд, хэргийг хуваарилах урьдчилсан шалгууруудыг тогтоож өгөх явдал юм. Жишээ нь, хэргийн ачаалал болон тухайн эрх зүйн асуудлаар мэргэшсэн байдал зэргээс хамаарч хэргийг хуваарилж болно.

CDL-AD(2017)011, Армен - Үндсэн хуулийн шүүхийн талаарх Үндсэн хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 66.

7.5 ШҮҮГЧИЙН ПАНЕЛ (ЗӨВЛӨЛ) БОЛОН МЭРГЭШСЭН ТУСЛАХУУД

Иргэдийн Үндсэн хуулийн шүүхэд мэдүүлэх эрх болон үндсэн хуулийн шүүхийн ачаалал хоорондын тохиромжтой тэнцвэрийг олохын тулд Үндсэн хуулийн шүүхийн шүүгчид нь хэргийн ачааллаас хамаарсан шаардлага хангасан туслахуудтай байх ёстой.

Венецийн хороо шүүгчид шүүгчийн туслахтай байх шаардлагатай мөн тэдгээрийн тоо хэргийн ачааллаас хамаардаг байх ёстой гэдгийг зөвлөж байна.

Хэргийн ачааллыг бууруулах оновчтой арга зам нь хувь иргэдээс ирсэн гомдлыг бага тооны шүүгчдээс бүрдэх бүрэлдэхүүнээр шийдэж, онцгой чухал асуудлыг шүүх үндсэн бүрэлдэхүүнээр шийдэх явдал юм. Гэхдээ анхаарах ёстой зүйл нь тухайн асуудлын талаар хоорондоо зөрчилдөөнтэй шийдвэрийг урьд нь гаргасан байх юм бол, шүүх үндсэн бүрэлдэхүүнээрээ тухайн асуудлыг шийдвэрлэх боломжийг хангаж өгөх ёстой. Эс тэгвээс, Үндсэн хуулийн шүүхийн нэгдмэл байдал алдагдаж Үндсэн хуульг ёс аюулд өртөх болно. Хэргийг хувь шүүгчдэд хуваарилах уу эсхүл шүүхийн үндсэн бүрэлдэхүүнд хуваарилах уу гэдгийг шийдвэрлэхэд хувь хүний үзэмж байж болохгүй бөгөөд маш тодорхой дүрэм журмуудаар тогтоож өгөх шаардлагатай.

Иргэдийн Үндсэн хуулийн шүүхэд мэдүүлэх эрх болон үндсэн хуулийн шүүхийн ачаалал хоорондын тохиромжтой тэнцвэрийг олохын тулд Венецийн хороо нь шүүхийн хэргийн ачааллаас хамаарсан шүүгчид дэмжлэг үзүүлэх шаардлага хангасан туслахуудтай байхыг зөвлөж байна. Шүүхийн үр дүнтэй үйл ажиллагааны хүрээнд шүүгчдийг зохистой танхимуудад хуваарилах нь зүйтэй. Гэхдээ энэхүү танхимын хуваарилалт нь Үндсэн хуульт ёсны нэгдмэл байдлыг алдагдуулж болохгүй.

CDL-AD(2010)039rev, Хувь хүний Үндсэн хуулийн шүүхэд хандах эрхийн судалгаа цогцолбор 11, 224, 225, 227

“Хэргийн ачааллыг бууруулах оновчтой арга зам нь хувь иргэдээс ирсэн гомдлыг бага тооны шүүгчдээс бүрдэх бүрэлдэхүүнээр шийдэж, онцгой чухал асуудлыг шүүх бүрэн бүрэлдэхүүнээр шийдэх явдал юм” Энэ өөрчлөлт нь Европын холбооны стандартуудтай нийцэж байна.

CDL-AD(2011)010, Монтенегрогийн Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн төслийн дүгнэлт болон Монтенегрогийн Шүүхийн тухай хууль, Улсын Прокурорын тухай ууль болон Шүүхийн ерөнхий зөвлөлийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн төсөл, 25 дах цогцолбор

7.6 НИЙТ ШҮҮГЧДИЙН ХУРАЛДААН БОЛОН ТАНХИМУУД ХООРОНДЫН ХАРИЛЦАА

Өөр нэг асуудал нь Словак Улсын Үндсэн хуулийн 131 дүгээр зүйл хэргийг нэг бол шүүхийн үндсэн бүрэлдэхүүнд эсхүл гурван шүүгчээс бүрдэх бүрэлдэхүүнд тухайн маргааны хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг баримтлан хуваарилж байна. Улмаар, хувь иргэдийн гаргасан гомдол нь үргэлж гурван шүүгчээс бүрдэх бүрэлдэхүүнээр шийдэгдэж байна. Хууль тогтоогч Үндсэн хуульд ялгаатай тайлбарууд байж болох асуудлыг урьдчилан харж байсан бололтой. Словакийн БНУ-ын Үндсэн хуулийн шүүхийн зохион байгуулалтын тухай хуулийн Үндэсний зөвлөлийн 6 дугаар зүйл нь Үндсэн хуулийн шүүхийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа болон шүүгчдийн эрх зүйн байдлын талаар дараах тайлбарыг хийсэн байна: Хэрэв гурван шүүгчийн бүрэлдэхүүн нь урьд гарсан Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрээс ялгаатай хууль зүйн дүгнэлтэд хүрсэн бол Үндсэн хуулийн шүүхийн нэгдмэл байдлыг хангах үүднээс асуудлыг шүүхийн үндсэн бүрэлдэхүүнээр шийдвэрлүүлэх хүсэлтийг гаргаж болно. Үндсэн хуулийн шүүхийн үндсэн бүрэлдэхүүний шийдвэрийг гурван шүүгчээс бүрдэх бүрэлдэхүүн заавал

дагаж мөрдөнө. Гэхдээ, энэ дүрэм асуудлыг шийдвэрлэхэд хангалттай биш юм.

Гурван шүүгчийн томилгоог ерөнхийлөгч батлаагүй гэх асуудлыг Үндсэн хуулийн шүүх шийдвэрлэхэд, Үндсэн хуулийн 127 дугаар зүйлийн дагуу шүүгчдийн гомдол нь хувь иргэдийн гомдол гэж тооцогдсон учир Үндсэн хуулийн 131.2-т заасны дагуу гурван шүүгчээс бүрдэх бүрэлдэхүүнээр шийдвэрлэсэн. Энэ хэрэг Үндсэн хуулийн маш чухал ач холбогдолтой асуудал байсан хэдий ч, гурван шүүгчийн бүрэлдэхүүнээр шийдвэрлэгдсэн.

Венецийн хороо нь Үндсэн хуулийн маш чухал ач холбогдолтой асуудлын тухайд хэргийг гурван шүүгчийн бүрэлдэхүүнээс үндсэн хуулийн шүүхийн үндсэн бүрэлдэхүүнд шилжүүлэх боломжийг тусгаж өгөх нь зүйтэй гэдгийг зөвлөж байна. Шүүхийн үндсэн бүрэлдэхүүн нь хэргийг хүлээн авахаас татгалзах боломжтой байх ёстой.

CDL-AD (2017)001, Словакын БНУ-ын Үндсэн хуулийн шүүхийн шүүгчдийг томилох асуудлын дүгнэлт, 40-42 цогцолбор

7.7 АМААР/ БИЧГЭЭР ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА

Шүүх Европын хүний эрхийн Конвенцын 6 дугаар зүйл зааснаар иргэний болон эрүүгийн хэргээс бусад хэрэгт бичгээр шийдвэр гаргахдаа талуудаас хамаарах ёсгүй.

CDL-AD(2002)005, Азербайжан Улсын Үндсэн хуулийн шүүхийн хуулийн нэмэлт өөрчлөлтийн төсөл, хуудас 7.

Шүүх хуралдааныг амаар явуулахыг хэд хэдэн үндэслэлээр зөвтгөж болно. Энэ нь талуудын шууд оролцоог хангаж, шүүгчидтэй шууд харилцах боломжийг олгож, мөн маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг түргэсдэг. Шүүх хуралдааныг амаар явуулах нь Ардчиллын үнэт зүйл болох ил тод байдлын илрэн гарах нэг хэлбэр юм. Шүүгчид хэргийн үйл баримт болон хууль зүйн ялгаатай тайлбаруудын талаар шууд мэдээлэл олж авах боломжтой тул аман шүүх хуралдаан нь шүүхийн шийдвэр гаргах ажиллагааны чанарыг сайжруулдаг. Үүний зэрэгцээ, аман шүүх хуралдаан нь олон нийт ардчилсан журмаар шүүгчдийг хянах хэлбэр болдог. Улмаар, шүүх хуралдааныг амаар явуулах нь шүүх бие даасан, хараат бусаар шударга ёсыг хэрэгжүүлж байна гэсэн иргэдийн итгэлийг баталгаажуулдаг. Шүүх шийдвэрээ нууцаар эсхүл хэн нэгний зааварчилгаагаар гаргадаг гэсэн өмнөх үеийн бараан туршлагыг саармагжуулж байдаг. Тийм ч учраас аль 20-р зууны эхэн үед, шүүгч, талууд

Венецийн комисс

болон гэрчүүд хоорондын шууд харилцааг бий болгох зорилготой аман шүүх хуралдааны загварыг чухалчилсан шинэчлэлийн хөдөлгөөн өрнөсөн байдаг. Энэхүү хөдөлгөөний зорилго нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг энгийн, зардал багатай болон түргэн шуурхай болгоход чиглэсэн юм.

CDL-AD(2004)035 Оросын Холбооны улсын Үндсэн хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 4.

Үндсэн хуулийн шүүх нь бичгээр явагдах ажиллагаанд илүү өргөн сонголттой байх ёстой. Ялангуяа энэ нь хувь иргэдийн гаргасан гомдлын улмаас шүүхийн ачаалал хэт их нэмэгдэхээс сэргийлэх ач холбогдолтой.

CDL-AD(2008)029, Киргизстан Улсын Үндсэн хуулийн шүүхийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн төсөл, 44 дэх цогцолбор

Хүний эрхийн хамгаалалт гэдэг талаас нь авч үзвэл, ядаж л хувь хүний үндсэн эрхтэй холбоотой маргаануудад шүүх хуралдааныг олон нийтэд нээлттэй байдлаар явуулах шаардлагатай. Тиймээс, Үндсэн хуулийн шүүхийн аман шүүх хуралдаан нь нийтэд нээлттэй байх шаардлагатай бөгөөд зөвхөн тодорхой тохиолдлуудад л хязгаарлагддаг байх нь зүйтэй.

Венецийн хороо нь Үндсэн хуулийн шүүх маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны үр ашигтай байдал зэрэг нийтийн ашиг сонирхол болон талуудын аюулгүй байдлыг хамгаалах үүднээс танхимын шүүх хуралдааныг түдгэлзүүлэх, хязгаарлах боломжтой байх хэрэгтэй гэдгийг хүлээн зөвшөөрч байна.

CDL-AD(2010)039rev, Хувь хүний Үндсэн хуулийн шүүхэд хандах эрхийн талаарх судалгаа, 135, 138 дах цогцолбор

23 дугаар зүйл болон бусад заалтууд (31 болон 47 дүгээр зүйл) хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг амаар явуулахад маш их ач холбогдол өгчээ. Эдгээр зохицуулалтууд нь нотлох баримтыг бүрдүүлэх явдал маш чухалд тооцогддог иргэний болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас санаа авсан бололтой. Гэвч, Үндсэн хуулийн шүүхийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны мөн чанар нь маш ялгаатай. Тухайн маргааны суурь болсон хэргийн үйл баримтууд нь тийм ч ач холбогдолтой биш. Үндсэн хуулийн шүүхийн өмнө тулгарах асуудал нь тодорхой хэм хэмжээ Үндсэн хуулийг зөрчсөн үү үгүй юу гэдэг хийсвэр асуудал байдаг. Хэргийн үйл баримт нь тухайн хэргийн өнгийг л тодорхойлдог. Маш олон Үндсэн хуулийн шүүхүүд шүүх хуралдаан явуулалгүйгээр хэргийг шийдэж, олон нийтэд

зөвхөн шийдвэрээ л ил зарладаг. Хууль мөн бичгээр явуулах ажиллагааны тухай хуульчилж өгөх хэрэгтэй. Шүүхийн үйл ажиллагааг нээлттэй байлгах үүднээс шүүх хуралдааныг амаар явуулахад эсэргүүцээд байх зүйл байхгүй хэдий ч, зарим тохиолдолд шүүхийн ачааллыг нэмэгдүүлэх эрсдэлтэй байдаг. Аль ч тохиолдолд, 23 дугаар зүйл бүхий л баримт бичгийг уншиж сонсгохыг шаардаж байгаа нь шүүхийн ачааллыг хэт их нэмэгдүүлэхээр байгаа тул тус зүйлийг хасах шаардлагатай.

CDL-AD(2014)017, Тажикстан Улсын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн төсөл 36 дах цогцолбор

Энэ бүхнээс авч үзвэл, Венецийн хороо нь Үндсэн хуулийн шүүх 2015 оны нэмэлт өөрчлөлтийн хүрээнд шүүх хуралдааныг явуулалгүйгээр хэргийг шийдвэрлэх нь гомдол гаргагчийн тайлбар гаргах эрхийг зөрчсөн гэх үндэслэлийг олж харахгүй байна. Гэсэн хэдий ч, Үндсэн хуулийн шүүхийн зүгээс гаргасан тайлбаруудын хүрээнд авч үзвэл, Венецийн хороо нь гомдол гаргагчийн тайлбар гаргах эрхийг хангахын тулд аман шүүх хуралдаан явагдаагүй тохиолдолд гомдол гаргагчийн оролцоог хангах боломжийг Үндсэн хуулийн шүүхийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд зохих зохицуулалтуудыг тусгаж өгөх шаардлагатай гэж үзэж байна.

CDL-AD(2016)016 ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн тухай Холбооны Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай эцсийн дүгнэлт, цогцолбор 37.

Дүгнэж хэлэхэд, шүүх хуралдааныг цаг хугацааны дарааллаар заавал хуралдуулахыг үүрэг болгох нь Европын холбооны стандартуудыг зөрчих эрсдэлтэй байна. Зарим хэргийн хувьд хэргийг түргэн шуурхай шийдвэрлэх боломжийг Үндсэн хуулийн шүүхэд олгох нь зүйтэй. Үндсэн хуулийн шүүхэд ийм төрлийн эрх хэмжээг олгох нь ТФЕУ-ийн 47 дүгээр зүйл болон Европын холбооны хүний эрхийн Конвенцын 6 дугаар зүйлтэй нийцнэ.

Хэргийг овоорохоос сэргийлэх нь зүйтэй гэж үзвэл, илүү тохирсон дүрмүүдийг хуульчилж болно. Жишээ нь, Бельги Улсад хэргийг бүртгэснээс хойш зургаан сарын дотор шийдвэрлэх ёстой байдаг. Энэ хугацааг дээд тал нь нэг жил хүртэл сунгаж болно. Хэргийг шийдвэрлэх дарааллын талаар ямар нэгэн эргэлзээ төрүүлэхгүйн тулд, хэргийг автоматаар хуваарилах системийн үйл явц болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шатны талаарх бүхий л мэдээлэл вэбсайт зэргээр дамжуулан нийтэд ил тод байх ёстой.

Венецийн комисс

CDL-AD(2016)001, Польш Улсын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн төслийн дүгнэлт 2015 оны 6 дугаар сарын 25, 65-66 цогцолбор

а) Шүүх хуралдааныг амаар зайлшгүй явуулах шаардлагатай б) Шүүх хуралдааныг амаар явуулах эсэхийг шүүх шийдвэрлэх С) Шүүх хуралдааныг зөвхөн бичгээр явуулах хэргүүдийг тодорхой ялгаж зохицуулсан ерөнхий заалтуудыг тусгаж өгөх нь зүйтэй. Үүнийг зайлшгүй тодорхой болгох нь чухал юм.

CDL-AD(2017)011, Армен - Үндсэн хуулийн шүүхийн талаарх Үндсэн хуулийн төсөлд өгсөн санал, 75 дах цогцолбор

Үндсэн хуулийн шүүхэд гаргах гомдлыг зайлшгүй бичгээр гаргах ёстой бөгөөд зарим тохиолдолд маш нарийн дүрэм журмыг мөрдөх шаардлагатай болдог. Эдгээр дүрмүүд нь ил тод байдал болон нотолгоотой байдлыг хангахад чиглэдэг. Гэхдээ, гомдол гаргагчид хуульд заасан үндэслэл болон хугацаанд гомдлоо нөхөх, өөрчлөх боломжийг олгох ёстой. Ялангуяа хэлбэрийн шаардлага маш хатуу тохиолдолд энэ нь чухал юм. Түүнчлэн, хууль ёсны төлөөлөгч томилохыг үүрэг болгоогүй тохиолдолд энэ нь бүүр ч ач холбогдолтой.

CDL-AD(2010)039rev, Хувь хүний Үндсэн хуулийн шүүхэд хандах эрхийн талаарх судалгаа, 125 дугаар цогцолбор

Дур зоргын хязгаарлалт болон зохистой байх явдлыг хангах үүднээс шүүх хуралдааныг зураг авалт болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулахгүй байх үндэслэлүүдийг тодорхой хуульчилж өгөх хэрэгтэй.

CDL-AD(2017)011, Армен - Үндсэн хуулийн шүүхийн талаарх Үндсэн хуулийн төсөлд өгсөн санал, 74 дэх цогцолбор

7.8 ТУСГАЙ (ЭСЭРГҮҮЦЭХ) САНАЛ

Тусгай (эсэргүүцэх) саналууд нь Үндсэн хуулийн шүүхийг сулруулдаггүй бөгөөд эсрэгээрээ олон тооны давуу талыг үүсгэдэг. Шинжлэх ухааны үндэслэлтэйгээр шийдвэрийг хэлэлцэх, шүүгчдийн хараат бус байдлыг бэхжүүлэх болон хэргийг хянан шийдвэрлэхэд үр дүнтэйгээр оролцох боломжийг дээрх саналууд нь олон нийтэд олгодог.

Тиймээс, нэмэлт өөрчлөлтийн хүрээнд тусгай (эсэргүүцэх) саналыг аль болох эрт хэвлэн нийтлэх нь зүйтэй гэж үзэж байна. Гэсэн хэдий ч,

тус нэмэлт өөрчлөлт нь шийдвэрийн үндсэн хэсгийг хэвлэл нийтэлсний дараагаар ч тусгай (эсэргүүцэх) саналыг хэвлэн нийтлэх боломжийг олгож байна. Эдгээр хэсгүүд шийдвэрийн цогц байдлыг бүрдүүлдэг тул хамтад нь хэвлэн нийтлэх шаардлага үүснэ.

CDL-AD(2009)042, Латви Улсын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн төслийн дүгнэлт, 20-21 цогцолбор

Тусгай (эсэргүүцэх) саналыг үргэлж шүүхийн шийдвэртэй хамтад нь хэвлэх шаардлагатай.

CDL-AD(2011)018, Киргизстан Улсын Дээд шүүхийн Үндсэн хуулийн танхимын тухай Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн төслийн дүгнэлт, 51 дэх цогцолбор

Үндсэн хуулийн шүүхийн тухай органик хуулийн 43.13 болон 47.2 дах заалтууд нь тусгай (эсэргүүцэх) санал болон давхацсан саналыг тухайн саналыг гаргасан шүүгч шаардсан эсэхээс үл хамааран шүүхийн шийдвэртэй хамтад нь хэвлэн нийтлэхийг хуульчилсан нь маш оновчтой болсон байна. Мэдээж түдгэлзүүлэх болон тусгай (эсэргүүцэх) саналаа тухайн шүүгч өгөхөөс татгалзах нь шүүхийн шийдвэрийг олон нийтэд хэвлэн нийтлэх явдлыг сунжруулах үндэслэл болохгүй гэдгийг анхаарах нь зүйтэй.

CDL-AD(2016)017, Гүрж - Үндсэн хуулийн шүүхийн тухай органик хууль болон Үндсэн хуулийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөд өгсөн санал, цогцолбор 61.

Дээрх үйл явцыг тусгай (эсэргүүцэх) саналын “логик зөрчилдөөн” гэж нэрлэдэг. Шүүгчийн тусгай (эсэргүүцэх) санал нь шүүхийн шийдвэрийн нэр хүндийг бууруулж байдаг боловч нөгөөтээгүүр шүүхийн легитм чанарыг бэхжүүлэхэд чухал үүргийг гүйцэтгэдэг. Тусгай (эсэргүүцэх) саналын дэмжигчдийн үздэгээр, шүүхийн нэр хүнд болон шүүхэд итгэх итгэл нь шүүхийн шийдвэрийн нэгдмэл байдалтай холбоогүй гэдгийг бодит жишээнүүд харуулж байдаг. Түүнчлэн, түдгэлзүүлэх болон тусгай (эсэргүүцэх) санал нь олонхын үндэслэлийг яагаад хүлээн зөвшөөрөхгүй вэ гэдгээ тайлбарлах ёстой болдог тул шүүхийн шийдвэрүүдийн үндэслэлийг сайжруулж байдаг.

CDL-AD(2018)030, Үндсэн хуулийн шүүхийн эсэргүүцэх болон давхацсан саналын судалгаа, 20 дох цогцолбор

Хэрэв эсэргүүцэх болон давхацсан санал нь зөвхөн зайлшгүй тохиолдолд, мөн олонхын дүгнэлттэй уялдан бэлтгэгдэх юм бол, эсэргүүцэх болон давхацсан саналаас бий болох эрсдэлийг үгүй хийж чадна. Эсэргүүцэх

болон давхацсан санал нь хувь хүний үзэмжээр ашиглагддаг арга хэрэгсэл байж болохгүй. Эсэргүүцэх болон давхацсан санал нь улс төрийн ялагдлын хариуд үзүүлэх эсрэг арга хэмжээ байж болохгүй. Тэдгээрийн чиг үүрэг нь хууль зүйн өөр дүгнэлт болон саналын хувилбарыг санал болгох замаар эрх зүйн хөгжилд хувь нэмэр оруулах явдал юм.

Эсэргүүцэх болон давхацсан саналыг дэмжигчид ч хүртэл эсэргүүцэх болон давхацсан санал нь зорилгогүй байх нь үнэ цэнгүй бөгөөд шүүгчид хоорондын харилцаа болон шүүхийн итгэлд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй гэж хүлээн зөвшөөрдөг. Гэвч, үнэхээр шүүгчид хоорондын санал зөрөлдөөн байх юм бол, шүүгчид өөрсдийн санал, дүгнэлтээ илэрхийлэх үүрэгтэй. Энэ хүрээнд, шүүгчдийн хараат бус байдлыг хангах үүднээс эсэргүүцэх болон давхацсан санал бичсэн шүүгчийн нэрийг зарлахгүйгээр эсэргүүцэх болон давхацсан саналыг хэвлэн нийтлэх нь зүйтэй юу гэх асуулт маргаан дагуулдаг. Үүнийг дор авч үзэх болно.

Үндсэн хуулийн шүүх болон түүнтэй төсөөтэй шүүхийн эсэргүүцэх болон түдгэлзүүлэх саналыг дэмжигчид болон түүнийг эсэргүүцэгчдийн аргуудыг дээрх байдлаар авч үзэв.

Энэ судалгаа нь Венецийн хорооны гишүүн улсуудын эсэргүүцэх болон давхацсан саналын зохицуулалтуудыг авч үзэх болно.

CDL-AD(2018)030, Үндсэн хуулийн шүүхийн эсэргүүцэх болон давхацсан саналын судалгаа, 30, 31, 32 дох цогцолбор

Ёс зүйн кодыг зөрчсөн, үл хүндэтгэсэн тусгай (эсэргүүцэх) саналыг тухайн тусгай (эсэргүүцэх) саналыг бичсэн шүүгчид арга хэмжээ авсан эсэхээс үл хамааран олон нийтэд хэвлэн нийтэлж байх нь чухал юм. Румын улсын Үндсэн хуулийн шүүхийн дарга олон нийтийн шүүмжлэлээс сэргийлэх, шүүхийн нэр хүндийг хамгаалахын тулд улс төрийн болон олонхыг доромжилсон шинжтэй тусгай (эсэргүүцэх) саналыг хэвлэн нийтлэх явдлыг хориглож буй нь маргаан дагуулсан жишээ тул ийм арга хэмжээнээс зайлсхийх шаардлагатай.

CDL-AD(2018)030, Үндсэн хуулийн шүүхийн эсэргүүцэх болон давхацсан саналын судалгаа, 46 дах цогцолбор

Шүүхийн шийдвэрийн чанарыг сайжруулах, шүүхийн нэгдмэл байдлыг хадгалахын тулд шүүгчдийн олонх нь тусгай (эсэргүүцэх) саналыг анхаарч үзэн, шаардлагатай тохиолдолд өөрсдийн үндэслэл болон дүгнэлтдээ засвар оруулж байх нь чухал юм. Олонхын дүгнэлт нэгэнт эцэслэгдсэн бол

шүүгчдийн олонх тусгай (эсэргүүцэх) саналын агуулгыг зайлшгүй анхаарч үзэх шаардлагагүй. Хэрэв шүүгчдийн олонх тусгай (эсэргүүцэх) саналаас үүдэн өөрсдийн үндэслэл болон дүгнэлтээ өөрчлөх бол, тусгай (эсэргүүцэх) санал бичсэн шүүгч богино хугацааны дотор өөрийн саналаасаа түдгэлзүүлэх, түүнийгээ өөрчлөх боломжтой байх ёстой. Ингэхийн тулд, олонх шүүгч шүүхийн шийдвэрээ эцэслэн батлахаасаа өмнө тусгай (эсэргүүцэх) саналыг бичгээр хүлээн авах боломжтой байх шаардлага үүснэ (Герман Улсын Үндсэн хуулийн шүүхийн процессын тухай хууль, Словени Улсын Үндсэн хуулийн шүүхийн процессын тухай хууль 72 дүгээр зүйл 3 дах хэсэг). Хэрэв боломжтой бол, шүүхийн шийдвэр болон тусгай (эсэргүүцэх) санал нь адил цаг хугацаанд бэлтгэгдэж байх нь зүйтэй. Улмаар, тусгай (эсэргүүцэх) санал нь алдаа гаргасан илтгэгч шүүгч болон олонхын алдааг буруушаах нэг хэлбэр гэж ойлгогдохгүй юм. Тусгай (эсэргүүцэх) санал нь тодорхой хууль зүйн асуудал, ялангуяа үнэт зүйл хоорондын зөрчилдөөн буюу жишээ нь яагаад цөөнх болсон шүүгч Үндсэн хуулийн үнэт зүйлд илүү их ач холбогдол өгөх болсныг харуулах хууль зүйн ялгаатай тайлбар байх ёстой.

CDL-AD(2018)030, Үндсэн хуулийн шүүхийн эсэргүүцэх болон давхацсан саналын судалгаа, 47 дох цогцолбор

Шүүгчдийн саналын тооны мэдээлэл нь тухайн маргааны хууль зүйн асуудлыг шийдвэрлэсэн шийдлийн үндэслэлийн тогтвортой байдлыг талуудад мэдээлэх, түүнчлэн тухайн асуудлын талаар ирээдүйд бий болох жишгийн эрх зүйг урьдчилан таамаглах боломжийг олон нийтэд олгодог. Энэ нь мөн олон нийтийн зүгээс шүүгч болон шүүхийн шийдвэр гаргалтын залгамж чанарыг хянах арга зам болж байдаг. Саналын тооны мэдээллийг ил болгох нь жишгийн эрх зүйн хөгжил болон тогтвортой байдалд ихээхэн хувь нэмэр оруулах боломжтой байхыг үгүйсгэхгүй.

Шүүгчдийн саналын тоог ил болгохыг эсэргүүцэгчид нь тусгай (эсэргүүцэх) саналын зорилго нь олонх шүүгчээс өөр үндэслэлийг танилцуулах явдал бөгөөд ирээдүйн жишгийн эрх зүйн хөгжил болон олонх шүүгчийн үндэслэл хэр хүчтэй вэ гэдгийг харуулахыг зорьдоггүй гэж маргадаг. Шүүхийн аргументийн үндэслэл л чухал болохоос биш саналын тоо хамааралгүй.

Венецийн хороо нь тусгай (эсэргүүцэх) санал болон олонхын шийдвэр нь хамтдаа шүүхийн шийдвэрийг бүрдүүлдэг тул тухайн тусгай (эсэргүүцэх)

санал бичсэн шүүгч шаардсан эсэхээс үл шалтгаалан хамтад нь хэвлэн нийтлэх ёстой гэж үзсээр ирсэн. Хэвлэн нийтлэх хэлбэр болон хэвлэгдэх цаг хугацаа нь ч мөн адил байх шаардлагатай.

CDL-AD(2018)030, Үндсэн хуулийн шүүхийн эсэргүүцэх болон давхацсан саналын судалгаа, 54, 55, 57 дох судалгаа.

Тусгай (эсэргүүцэх) саналыг хүлээн зөвшөөрсөн гишүүн улсуудад, Венецийн хороо нь тусгай (эсэргүүцэх) саналыг хүлээн зөвшөөрөх логик уялдаа холбоонд үндэслэн дараах зөвлөмжүүдийг хүргүүлж байна.

- a) Хуулийн хүрээнд тусгай (эсэргүүцэх) санал бичих нь шүүгчдийн эрх байх ёстой бөгөөд тусгай (эсэргүүцэх) саналаа ил болгохыг шүүгчдэд үүрэг болгож болохгүй.
- b) Шүүх болон түүний институтийн чиг үүрэгт үнэнч тусгай (эсэргүүцэх) санал нь л шүүхийн шийдвэр гаргалтын легимт чанарыг хангаж чадна. Тиймээс, тусгай (эсэргүүцэх) санал нь шүүгчдийн олонхын шийдвэр чанар муутай байсан гэдэгт бус харин тухайн хэргийн асуудлыг өөр арга замаар шийдвэрлэх боломжтой байсан эсэхэд төвлөрөх ёстой.
- c) Тусгай (эсэргүүцэх) санал нь эцсийн арга байх ёстой. Тиймээс, тусгай (эсэргүүцэх) санал бичихээс өмнө, шүүгчид хоорондоо хэлэлцэж, шүүгчдийн олонхын шийдвэрт нөлөө үзүүлэхийг оролдох нь хамгийн чухал юм.
- d) Шүүхийн шийдвэрийн чанар болон шүүгчдийн эвтэй харилцааг хадгалахын тулд, шүүгчдийн олонх тусгай (эсэргүүцэх) саналд хариу үзүүлж, шаардлагатай бол өөрсдийн үндэслэл, дүгнэлтээ өөрчлөх боломжтой байх ёстой. Хэрэв шүүгчдийн олонх тусгай (эсэргүүцэх) саналаас үүдэн өөрсдийн үндэслэл дүгнэлтээ өөрчлөх тохиолдолд, тухайн тусгай (эсэргүүцэх) санал бичсэн шүүгч богино хугацаанд өөрийн саналаас татгалзах эрхтэй байх ёстой. Ингэхийн тулд, шүүхийн эцсийн шийдвэр гарахаас өмнө олонх шүүгчид тусгай (эсэргүүцэх) саналыг бичгээр хүлээж авах шаардлагатай.
- e) Шүүгчийн ёс зүйн дүрэм нь шүүгчийн хараат бус байдалд сөрөг нөлөө үзүүлэлгүйгээр тусгай (эсэргүүцэх) саналыг зохицуулж, тодорхой стандартыг тогтоож өгөх шаардлагатай. Шүүгчийн ёс зүйн дүрмийг зөрчсөн тусгай (эсэргүүцэх) саналыг тухайн шүүгчид арга хэмжээ авсан эсэхээс үл хамааран олон нийтэд хэвлэж нийтэлж байх нь чухал юм.

- f) Тусгай (эсэргүүцэх) санал нь шүүхийн шийдвэрийн нэг хэсэг болдог тул тухайн саналыг бичсэн шүүгч шаардсан эсэхээс үл хамааран олонхын шийдвэртэй хамт нийтлэгдэж байх ёстой.

CDL-AD(2018)030, Үндсэн хуулийн шүүхийн эсэргүүцэх болон давхацсан саналын судалгаа, 61 дэх цогцолбор

7.9 ТҮР ТҮДГЭЛЗҮҮЛЭХ ШИЙДВЭР

Хэрэв тодорхой хэм хэмжээний актыг цаашид хэрэгжүүлэх нь тухайн хэм хэмжээний актыг үндсэн хуульд нийцээгүй гэж үзсэний дараа нөхөж баршгүй хохирол болон зөрчлийг бий болгох тохиолдолд, шүүх тухайн хэм хэмжээний актын үйлчлэлийг түр түдгэлзүүлэх шийдвэр авах боломжтой байх ёстой гэж Венецийн хороо үзэж байна.

Шүүх хэм хэмжээний актын үйлчлэлийг түр түдгэлзүүлэх бүрэн эрхтэй байх ёстой. Үйлчлэлийг түр түдгэлзүүлэх урьдчилсан нөхцөл нь хэт хатуу байж болохгүй. Гэхдээ, хэм хэмжээний актын хэрэгжилтийг түдгэлзүүлсний үр дүнд бий болох хохирол болон зөрчлийг ч мөн анхаарч үзэх шаардлагатай.

CDL-AD(2010)039rev, Хувь хүний Үндсэн хуулийн шүүхэд хандах эрхийн талаарх судалгаа, 9, 130 дэх цогцолбор

Хуулийн төслийн 78.2 дугаар зүйл нь Үндсэн хуулийн шүүхэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа эхэлсэнтэй холбогдуулан тухайн хэм хэмжээний актын үйлчлэлийг түр түдгэлзүүлэх бүрэн эрхийг Сенатад олгож байна. Энэхүү шийдвэрийг яаралтай гаргах шаардлагатай. Маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа эхлүүлэх үгүйг удирдах зөвлөл шийддэг. Тийм учраас, удирдах зөвлөл ч мөн хэм хэмжээний актын үйлчлэлийг түр түдгэлзүүлэх шийдвэр гаргах бүрэн эрхтэй байх ёстой. Нөгөөтээгүүр, төслийн 78.5 дугаар зүйл нь шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсноор түр түдгэлзүүлэх шийдвэр дуусгавар болох тухай зохицуулж өгсөн байна. Гэсэн хэдий ч, тухайн хэм хэмжээний актыг үндсэн хуульд нийцээгүй гэж үзсэн тохиолдолд, түр түдгэлзүүлэх шийдвэрийг дуусгавар болгоход хэт эртдэнэ. Учир нь ердийн шүүх хэргийг дахин сэргээж, шинээр шийдвэрлэх шаардлагатай болдог. Үндсэн хуулийн шүүх шүүхийн шийдвэртээ ердийн шүүх хэргийг дахин шийдвэрлэх хүртэл түр түдгэлзүүлэх шийдвэрийг сунгах бүрэн эрхтэй байх ёстой.

CDL-AD(2016)034, Украин - Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн төсөлд өгсөн санал, 62 дах цогцолбор

Үндсэн хуулийг зөрчсөн эсэх эцсийн шийдвэрийг удирдах зөвлөл гаргах бүрэн эрхтэй байхад, тухайн хэм хэмжээний актын үйлчлэлийг түр түдгэлзүүлэх асуудлыг зөвхөн шүүх үндсэн бүрэлдэхүүнээрээ хэлэлцэн шийдвэрлэх эрхтэй байгаа нь уялдаагүй гэж үзэж үндэстэй. Түүнчлэн, шүүхийн бүрэлдэхүүнд удирдах зөвлөлд багтдаггүй шүүгчид ч мөн байдаг тул, хэрэгтэй танилцахын тулд зайлшгүй цаг хугацаа шаардагдах бөгөөд шийдвэр гарах хугацааг хойшлуулах шаардлагатай болно.

CDL-AD(2016)017, Гүрж - Үндсэн хуулийн шүүхийн тухай органик хууль болон Үндсэн хуулийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөд өгсөн санал, цогцолбор 33.

Хэм хэмжээний актын үйлчлэлийг түр түдгэлзүүлэхийн өмнө бусад этгээдүүдийн эрх ашиг болон нийтийн эрх ашгийг Үндсэн хуулийн шүүх харгалзаж үзэж байх нь маш чухал юм.

CDL-AD(2017)011, Армен - Үндсэн хуулийн шүүхийн талаарх Үндсэн хуулийн төсөлд өгсөн санал, 70 дах цогцолбор

7.10 МАРГААНЫГ НЭГТГЭХ

Шүүх гомдлыг тухайн маргааны зүйлээр аль хэдийн хэрэг үүсгэсэн гэдэг үндэслэлээр хүлээн авахаас татгалзахын оронд, өмнөх хэрэгтэй тухайн гомдлыг нэгтгэх нь зүйтэй.

CDL-AD(2006)017, Армени Улсын Үндсэн хуулийн шүүхийн нэмэлт, өөрчлөлтийн төслийн дүгнэлт, 25 дах цогцолбор

32.1(5) дугаар зүйл нь тухайн гомдолтой төсөөтэй хэрэг аль хэдийн Үндсэн хуулийн шүүхэд хянан шийдвэрлэгдэж байгаа бол гомдлыг хүлээн авахаас татгалзаж болно гэж заасан. Энэ заалт нь маргааны зүйл төсөөтэй хэргүүдийг хооронд нь нэгтгэж болно гэж заасан 39.1 дүгээр зүйлтэй зөрчилдөж буй мэт санагдаж байна. 39.1 дүгээр зүйл Европ шаардлагад нийцэж байна.

CDL-AD(2017)011, Армен - Үндсэн хуулийн шүүхийн талаарх Үндсэн хуулийн төсөлд өгсөн санал, 64 дэх цогцолбор

7.11 ГОМДЛООС ТАТГАЛЗАХ

Гомдлоос татгалзсаны дараа ч гэсэн, тухайн гомдлыг нийтийн ашиг сонирхлын үүднээс шүүх үргэлжлүүлэн хянан шийдвэрлэж болно. Энэ нь Үндсэн хуулийн шүүхийн бие даасан байдал болон түүний Үндсэн хуулийг сахиулах чиг үүргийн илэрхийлэл юм.

Хэргийг зөвхөн хянан шийдвэрлэх нь бодит хяналтын хувьд хүний эрхийг хамгаалах хангалттай арга хэмжээ болж чадахгүй байж болох юм. Гэвч, хүний эрхийг зөрчсөнтэй холбогдуулан шүүх хохирлын мөнгөн нөхөн төлбөр гаргуулах эрхтэй эсэх нь мөн маргаан дагуулдаг.

Гомдлоос татгалзсан тохиолдолд Үндсэн хуулийн шүүх нийтийн эрх ашгийг хамгаалах үүднээс гомдлыг хянан шийдвэрлэх эрхтэй байх ёстой. Харин, маргаан дагуулсан хэм хэмжээний акт хүчин төгөлдөр бус болсон тохиолдолд, шүүх тухайн хэргийг үргэлжлүүлэн хянан шийдвэрлэх ёстой юу үгүй юу гэдэг дээр санал зөрөлддөг.

CDL-AD(2010)039rev, Хувь хүний Үндсэн хуулийн шүүхэд хандах эрхийн талаарх судалгаа, 144, 148 дах цогцолбор

Гомдлоос татгалзсаны дараа ч гэсэн, бүх төрлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүх нийтийн эрх ашигт нийцэж байгаа гэж үзвэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлэх боломжтой байх ёстой.

CDL-AD(2011)050, Серби Улсын Үндсэн хуулийн шүүхийн нэмэлт өөрчлөлтийн төслийн дүгнэлт, 41 дэх цогцолбор

33.2 дугаар зүйл нь “Үндсэн хуулийн шүүх тухайн маргааны зүйл нь нийтийн эрх ашгаас урган гарсан гэж үзвэл гомдлын татгалзлыг хүлээн авахаас татгалзаж болно.” Гомдол гаргагч гомдлоосоо татгалзсан тохиолдолд ч гэсэн, хэргийг хянан шийдвэрлэнэ гэдэг ердийн бус хэдий ч, эерэг үр дүн авчрах болно. Энэ нь Үндсэн хуулийн шүүхэд нийтийн эрх ашгийн үүднээс хэргийг үргэлжлүүлэн хянан шийдвэрлэх боломжийг олгож байна.

Ийм төрлийн зохицуулалтын үндэслэл нь гомдол гаргагч улс төрийн дарамт шахалтын улмаас гомдлоосоо татгалзах явдлаас зайлсхийх явдал байж болох юм. Гэвч, Үндсэн хуулийн шүүх тодорхой хүсэлт, гомдолгүйгээр хэм хэмжээний актын хүчин төгөлдөр байдлыг хянан шийдвэрлэнэ гэдэг ердийн бус тохиолдол гэдгийг анхаарах хэрэгтэй. Нөгөөтээгүүр, өнөөгийн нөхцөл байдалд, анхны гомдол зайлшгүй шаардлагатай. Өөрөөр хэлбэл,

Венецийн комисс

Үндсэн хуулийн шүүх хэргийг өөрийн эрх хэмжээний хүрээнд эхлүүлж байна гэж ойлгож болохгүй.

Гэсэн хэдий ч, нийтийн ашиг сонирхол гэдэг тодорхой бус, мөн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь мөрдөн шалгах ажиллагаа шиг болох боломжтой тул, нийтийн ашиг сонирхол гэдэг нь ямар утгатай болохыг тодруулахыг зөвлөж байна.

CDL-AD(2017)011, Армен - Үндсэн хуулийн шүүхийн талаарх Үндсэн хуулийн төсөлд өгсөн санал, 67-69 дэх цогцолбор

7.12 МЭТГЭЛЦЭХ ЖУРАМ

22 дугаар зүйл нь мэтгэлцэх журмыг хуульчилж өгсөн байна. Мэдээж энэхүү журам нь иргэний болон эрүүгийн хэрэгт шууд хамааралтай боловч, Үндсэн хуулийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны мөн чанар нь ялгаатай байдаг. Гомдол гаргагч нь маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд тодорхой ашиг сонирхолтой байдаг бол хэргийн нөгөө талыг шууд тогтооход хүндрэлтэй. Хэм хэмжээний актыг тодорхой төрийн байгууллага гаргасан байлаа гээд тухайн төрийн байгууллага нь хариуцагч болно гэсэн үг биш юм. Улс төрийн шалтгааны улмаас, тухайн хэм хэмжээний актын үндсэн хуулийн зохицлын асуудалд тухайн төрийн байгууллага шууд ашиг сонирхолгүй байж болох юм. Тийм учраас, зарим Үндсэн хуулийн шүүхүүд мөрдөн шалгах зарчмаар ажилладаг. Тодруулбал, Үндсэн хуулийн шүүх өөрөө тухайн хэм хэмжээний акт Үндсэн хуулийг зөрчсөн эсэх талаарх үндэслэл болон эсэргүүцлийг бэлтгэдэг. Бусад мэтгэлцэх журмыг хуульчилсан улсуудад, прокурор нийтийн эрх ашгийг хамгаалж маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцдог.

CDL-AD(2014)017, Тажикстан Улсын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн төслийн дүгнэлт, 35 дах цогцолбор

Киргиз Улсад, Үндсэн хуулийн бүрэн эрхийн маргаанд төрийн байгууллагууд тохиролцоонд хүрж чадаагүй бол, шүүх төрийн байгууллагуудыг (Парламент, Ерөнхийлөгч, Засгийн газар, Шүүх, Прокурор) өөрсдийн тайлбараа өгөхийг шаардах үүрэгтэй байдаг. Ингэснээр, шүүх хийсвэр түвшинд ч гэсэн бүрэн бус мэтгэлцэх журмаас тодорхой ойлголтыг олж авах сайн талтай.

CDL-AD(2008)029, Киргиз Улсын Үндсэн хуулийн шүүхийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн төслийн дүгнэлт, 19 дэх цогцолбор

7.13 НОТЛОХ БАРИМТЫГ ҮНЭЛЭХ

Түүнчлэн, Венецийн хороо өмнө нь Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн төслийн дүгнэлтдээ дурдсанчлан, Үндсэн хуулийн маргаанд эд мөрийн баримт нотлох баримт болох нь маш онцгой тохиолдол гэдгийг анхаарч үзэх шаардлагатай. Үндсэн хуулийн хяналт нь тодорхой үйл баримт гэхээсээ илүүтэйгээр хууль зүйн аргумент, тайлбарт төвлөрдөг бөгөөд зарим тохиолдолд хууль зүйн тайлбарыг дэмжих үүднээс нотлох баримт ач холбогдолтой байж болох юм. Тийм учраас, талуудад нотлох баримт гаргаж өгөхийг үүрэг болгож болохгүй бөгөөд нотлох баримт гаргаж өгөх боломжийг олгох нь зүйтэй..

CDL-AD(2014)020, Киргиз Улсын Дээд шүүхийн Үндсэн хуулийн танхимын нэмэлт өөрчлөлтийн төслийн дүгнэлт, 12 дох цогцолбор

Төслийн 51.5 буюу талуудын тухай заалт нь “Хэргийн үйл баримттай холбоотой талуудын тайлбарт өгсөн мэдээлэл нь ямар нэгэн нотолгооны ач холбогдолтой байх ёсгүй. Талууд нь зөвхөн энэ хуулийн 52 дугаар зүйлд заасан журмын дагуу хэргийн үйл баримтыг нотлох мэдээллийг гаргаж өгч болно.”

Энэ заалт нь Үндсэн хуулийн шүүхэд нотлох баримтыг үнэлэх хатуу журмыг тогтоож өгсөн байх тул тийм ч нийтлэг харагддаг зохицуулалт биш байна. Тодруулбал, Үндсэн хуулийн шүүх нотлох баримтыг үнэлэх маш өргөн хүрээний эрх мэдэлтэй байх ёстой. Тиймээс, дээрх заалтыг хасах нь зүйтэй.

CDL-AD(2017)011, Армен - Үндсэн хуулийн шүүхийн талаарх Үндсэн хуулийн төсөлд өгсөн санал, 72-72 дах цогцолбор

7.14 АГУУЛГААР ДАХИН СЭРГЭЭСЭН МАРГААН (ДАХИН ГОМДОЛ ГАРГАХ)

Өөрөөр хэлбэл, шүүх бүрэлдэхүүн (гомдлыг хүлээж авах шатанд) эсхүл шүүх хуралдаан (хэргийг хэлэлцэх явцад) гомдол гаргагчийн гомдол нь аль хэдийн шийдвэрлэгдсэн маргаантай төсөөтэй гэдгийг ойлгосон бол маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг дуусгавар болгох ёстой.

Венецийн хороо нь уг заалт Үндсэн хуулийн шүүхийн бүрэн эрхийг хязгаарлаж байна гэдэг үндэслэлээр дахин өөрчлөн найруулахыг санал болгож байна. Тухайн асуудлаар шийдвэр гарсан байлаа гээд хэргийг дуусгавар болгох, гомдлыг хүлээж авахгүй байх үндэслэл болох ёсгүй юм.

Жишээ нь, Шүүх хэм хэмжээний актыг Үндсэн хуульд нийцсэн гэж үзсэн тохиолдолд, тухайн хэм хэмжээний актын талаарх ирээдүйд гарах гомдлуудыг онцгой нөхцөл байдал байхгүй тохиолдолд хүлээж авах боломжгүй гэж зарлах ёстой. Онцгой нөхцөл байдал гэдэгт жишээ нь Үндсэн хуулийн шүүхээс ялгаатай тайлбарыг ердийн шүүх тогтмол хийх явдал байж болох юм. Гэвч, тодорхой хэм хэмжээний актыг Үндсэн хуульд нийцээгүй гэж өмнө нь шүүх үзсэн хэдий ч, тухайн хэм хэмжээг дахин баталсан тохиолдолд, тухайн хэм хэмжээний талаарх гомдлыг шүүх хүлээн авч дахин хянан шийдвэрлэх боломжтой. Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр заавал дагаж мөрдөх шинжтэй байх, хууль тогтоогч шийдвэрийг дагаж мөрдөхгүй тохиолдолд асуудлыг шийдвэрлэх үр дүнтэй арга хэрэгслээр Үндсэн хуулийн шүүх хангагдах ёстой.

CDL-AD(2014)020, Киргиз Улсын дээд шүүхийн Үндсэн хуулийн танхимын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн төслийн дүгнэлт, 35-38 дах цогцолбор

7.15 ШИЙДВЭРИЙГ ЗАРЛАХ

Словак Улсын үндсэн хуулийн шүүх нь албан ёсны шийдвэр хэвлэн нийтлэгдэхээс өмнө дүгнэлтүүдээ зарладаг цорын ганц шүүх биш юм. Зарим тохиолдолд, албан ёсны шийдвэрийн хэвлэн нийтлэл болон шийдвэрийг зарлах явдлын хооронд хэдэн долоо хоног, хэдэн сарын зай байж болно. Венецийн хороо зарим орнуудад шүүх дүгнэлтийг зарласны дараа шүүхийн шийдвэрийг хэрхэн боловсруулах талаар шүүгчид санал зөрөлддөг мөн дүгнэлтийг зарласны дараа шийдвэрийг боловсруулахад хүндрэлтэй байдаг гэдгийг олж мэдсэн.

Гэвч, талуудад шүүх хэрхэн дүгнэлтдээ хүрсэн бэ? гэдэг мэдээллийг өгөхгүй тул, шийдвэрийн дүгнэлтийг зарлах явдлыг албан ёсны шийдвэрийн хэвлэл нийтлэлээс салгах нь бүүр ч маргаан дагуулах юм. Олон нийт хууль тогтоох байгууллага болон гүйцэтгэх байгууллага шүүхийн шийдвэрийг зарлагдсан даруйд шууд хэрэгжүүлнэ гэсэн хүлээлттэй байдаг боловч тухайн байгууллагууд нь шийдвэрийн үндэслэлийг мэдэхгүй тул шийдвэрийг хэрэгжүүлэх боломжгүйд хүрдэг. Украин Улсын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн төслийн дүгнэлтдээ, Венецийн хороо нь Украин Улсын үндсэн хуулийн шүүх шийдвэрийн дүгнэлтийг зарласан даруйд шийдвэрийг бүтнээр нь хэвлэх үүрэг хүлээлгэснийг сайшаалтайгаар хүлээн авч байна. Венецийн хороо нь Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 30.6 дугаар

зүйлд өөрчлөлт оруулахыг зөвлөж байна. Шийдвэр бүрэн эхээрээ, бичгээр бэлэн болсон тохиолдолд л шийдвэрийн дүгнэлтийг олон нийтэд зарлах нь зүйтэй юм.

CDL-AD (2017)001, Словак Улсын Үндсэн хуулийн шүүхийн шүүгч томилох тухай асуудлын талаарх дүгнэлт, 38-39 дэх цогцолбор

Хамгийн эхний алхам бол маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа дууссан даруйд шийдвэрийг хэвлэн нийтлэх явдал юм. Хэвлэгдсэн шүүхийн шийдвэр нь шүүхийн дүгнэлтийг оновчтойгоор тусгасан байх шаардлагатай. Шүүхийн шийдвэр бичгээр бэлэн болсон, мөн хэвлэн нийтлэгдэхэд бэлэн болсон үед л, шүүхийн шийдвэрийг зарлах ёстой.

CDL-AD(2017)011, Армен - Үндсэн хуулийн шүүхийн талаарх Үндсэн хуулийн төсөлд өгсөн санал, 77 дох цогцолбор

7.16 МАРГААНЫ ДАРААЛАЛ

38.3 дугаар зүйл нь шүүх хэргийг хүлээж авсан он цагийн дарааллаар хэргийг хэлэлцэнэ гэж заасан. Тус зүйл нь мөн дараах хэргүүдэд он цагийн дараалал хамааралгүй гэдгийг тусгаж өгсөн. Эдгээр нь Олон Улсын гэрээ, хэлэлцээрийг соёрхон батлахаас өмнө Үндсэн хуультай нийцэж буй эсэх асуудал, Төсвийн тухай хууль, Үндсэн хуулийн шүүхийн тухай хууль, Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд саад болсон хэргүүд, төрийн байгууллагуудын бүрэн эрхийн маргаан болон улс төрийн намуудын үйл ажиллагааг зохицуулах тухай хууль зэрэг (38.4 дүгээр зүйл) болно. Түүнчлэн, 38.5 дугаар зүйлд зааснаар иргэдийн эрх, эрх чөлөө, үндэсний аюулгүй байдал болон үндсэн хуульт ёсыг хамгаалах шаардлагатай гэж үзвэл, Үндсэн хуулийн шүүхийн дарга он цагийн дарааллыг тооцолгүйгээр шүүх хуралдааны товыг тогтоож болно. Таван шүүгчид хүсэлт гаргавал, Үндсэн хуулийн шүүхийн дарга өөрийн шийдвэрээ дахин хянан үзэх боломжтой.

Он цагийн дарааллаар хэргийг хэлэлцэх журмыг хассан байгаа нь Үндсэн хуулийн шүүхийн уян хатан байдлыг хангаж буй гэдэг утгаараа эерэг өөрчлөлт юм. Түүнчлэн, энэ нь Европын холбооны шударга ёсны шүүхэд урьдчилан шийдвэрлүүлэх хүсэлт гаргасан онцгой асуудлыг ч мөн шийдвэрлэж байна.

CDL-AD(2016)026, Польш - Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн талаарх санал, цогцолбор 43-48.

7.17 МАРГААНЫГ ХОЙШЛУУЛАХ

Шүүгч төвөгтэй хэрэгт бэлдэх илүү хугацаатай байх нь тохиромжтой юм. Энэ утгаар 68.4 дүгээр зүйл нь хэрэг хэлэлцэх хугацааг хоёр долоо хоногоор сунгах боломжийг аль хэдийн тусгаж өгсөн байна. Мөн 68.5-7 дугаар зүйл нь хэргийн төвөгтэй байдалд хамааралгүй боловч олонх шүүгч болон дөрвөн эсэргүүцэх шүүгч байх тохиолдолд хэргийг хэлэлцэх хугацааг сунгах боломжийг хуульчилж өгсөн. Энэ тохиолдолд, дөрвөн эсэргүүцэх шүүгч өөр хувилбар бэлтгэх шаардлагагүй тул, хэрэг хэлэлцэх хугацааг гурван сараар сунгах явдлыг зөвтгөх боломжгүй байна. Аль ч тохиолдолд, шүүгчдийн санал зөрөлдөөнийг хэрхэн шийдвэрлэх шийдлийг Шүүх бүрэлдэхүүний эрх хэмжээнд үлдээсэн нь зүйтэй. Хууль тогтоогчийн баталсан хатуу дүрэм журмуудаас аль болох зайлсхийх ёстой бөгөөд эдгээр дүрэм журмууд нь шүүгчдэд тохиролцоонд хүрэх сэдлийг бус санал зөрөлдөх сэдлийг бий болгож байдаг.

Тиймээс, дөрвөн эсэргүүцэх шүүгчийн хүсэлтээр хэргийг хэлэлцэх хугацааг 6н сар хүртэл сунгах нь ямар ч үндэслэлгүй байна. Аль ч тохиолдолд, Үндсэн хуульт ёсыг сахин хамгаалах үр дүнтэй шүүхийн ойлголтыг тусгаж өгөөгүй байна. Маргаан дагуулсан хэргүүдийг хянан шийдвэрлэх хугацааг сунжруулахын тулд амархан урвуулан ашиглагдах эрсдэлтэй байна. Түүнчлэн, талуудыг хүсээгүй байхад хэргийг хойшлуулах нь бусад хэргүүдийн хянан шийдвэрлэх ажиллагааг ч мөн хойшлуулна. Мөн, ийм зохицуулалт нь Үндсэн хуулийн шүүх болон түүний дарга шүүгчдийн санал өгөх хугацааг хүндэтгэхийн зэрэгцээ маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг шуурхай явуулах зохистой арга хэмжээнүүдийг авч чадахгүй байна гэсэн таамаглалаас үүдэлтэй. Улмаар, шүүгчдэд буулт хийж зөвшилцөлд хүрэхийн оронд өөрсдийн байр сууриндаа бат зогсох сэдлийг төрүүлж байдаг. Тиймээс, шүүхийн үр дүнтэй үйл ажиллагаа болон бие даасан байдал улам алдагдаж болзошгүй юм.

Үндсэн хуулийн шүүх үндсэн хуулийн шүүхийн дөрвөн шүүгчид хэргийг зургаан сараар сунгах боломж олгосон заалтыг хүчингүй болгосон нь Үндсэн хуулийн шүүхийн үйл ажиллагаа болон бие даасан байдалд учирсан аюулыг арилгасан явдал юм.

CDL-AD(2016)026, Польш - Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн талаарх санал, цогцолбор 57-61.

7.18 ШИЙДВЭР ГАРГАХ ИРЦ БОЛОН ОЛОНХ

Төрийн байгууллага гомдол гаргасан хийсвэр маргаанд шүүх харьцангуй олонхоор харин иргэдийн гомдол гаргасан маргаанд шүүх энгийн олонхоор шийдвэр гаргана гэдэг уялдаа холбоогүй байна. Хийсвэр маргааныг шүүх үндсэн бүрэлдэхүүнээрээ хянан шийдвэрлээд, нийт шүүгчдийн олонх нь тухайн хуулийг үндсэн хууль зөрчсөн гэж үзсэн хэдий ч нийт шүүгчдийн 3-ны 2-ын саналыг аваагүй тул тухайн хууль хүчин төгөлдөр хэвээр үлдэнэ гэсэн үг. Харин, тухайн хуулийг иргэний гомдлоор хянан хэлэлцэхэд долоон шүүгчийн дөрвийн саналаар хүчингүйд тооцож болно гэсэн үг. Хийсвэр маргааныг илүү ярвигтай гэж үздэг тул хуулийг хүчингүй болгоход илүү өндөр шаардлага тавьж болох юм. Гэсэн хэдий ч, нэг хуулийн зүйл заалт нь өөр өөр шалгууруудаар хянагдах боломжтой байх бөгөөд түүнийг хүчингүй болгох эсэх нь тухайн заалтад гомдол гаргасан маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны төрлөөс хамаарч байна. Энэхүү зөрчилдөөнтэй байдлыг шүүхийн бүрэн бүрэлдэхүүний харьцангуй олонх гэдгээс энгийн олонх болгож бууруулах замаар шийдвэрлэж болно.

CDL-AD(2016)001, Польш Улсын Үндсэн хуулийн шүүхийн тухай хууль нэмэлт өөрчлөлт оруулах төслийн дүгнэлт, 83 дах цогцолбор

Энгийн олонхоор шийдвэр гаргах Үндсэн хуулийн шүүхийн тогтсон жишгийг хууль тогтоогч өөрчлөх боломжгүй бөгөөд зөвхөн Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөөр тусгаж өгөх боломжтой. Шүүх шийдвэр гаргах хэт өндөр шаардлага тавьж өгөх нь шүүхийн шийдвэр гаргалтад саад хийж, хууль тогтоомжийн Үндсэн хуулийн нийцлийг хангах үндсэн чиг үүргээ Үндсэн хуулийн шүүх үр дүнтэйгээр хэрэгжүүлэх боломжгүйд хүргэж байна (79 дөх цогцолбор).

CDL-AD(2016)026, Польш - Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн талаарх санал, цогцолбор 63.

Польш Улсын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн талаарх дүгнэлтдээ, Венецийн хороо нь харьцуулсан судалгааны хүрээнд Европын ихэнх улс орнууд Үндсэн хуулийн шүүх шийдвэр гаргах энгийн олонхын дүрмийг баримталсан байна гэдгийг цохон тэмдэглэсэн.

Мэдээж зарим тохиолдолд харьцангуй олонхоор шийдвэр гаргах боломжтой боловч энэ нь Европын Улс орнуудын үндсэн хуулийн шүүхийн ялангуяа шүүхийн бүрэн бүрэлдэхүүнээр шийдвэр гаргах ерөнхий дүрэм биш юм. Ийм төрлийн дүрэм нь шүүхийн шийдвэр гаргалтад саад хийж,

хууль тогтоомжийн Үндсэн хуулийн нийцлийг хангах үндсэн чиг үүргээ Үндсэн хуулийн шүүх үр дүнтэйгээр хэрэгжүүлэх боломжгүйд хүргэж байна.

CDL-AD(2016)017, Гүрж - Үндсэн хуулийн шүүхийн тухай органик хууль болон Үндсэн хуулийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөд өгсөн санал, цогцолбор 48.

7.19 ШИЙДВЭРТ ГАРЫН ҮСЭГ ЗУРАХ

Өөр шийдэл нь шүүхийн шийдвэрт шүүхийн бүх шүүгчид гарын үсэг зурахын оронд шүүхийн дарга болон нарийн бичгийн дарга гарын үсэг зурах явдал юм. Харьцуулсан судалгааны хүрээнд авч үзвэл, шүүхийн шийдвэрт гарын үсэг зурах 2 төрлийн загвар байна. Эхний загварт тухайн шийдвэрт оролцсон бүх шүүгчид гарын үсэг зурдаг. Энэхүү загварт Албани, Алжир, Андора, Бразил, Чил, Эстони, Герман, Казакстан, Киргизстан, Литва, Перу, Польш, Солонгос, Румын, Орос, Турк болон Украин багтаж байна. Хоёрдох загвар нь зөвхөн Үндсэн хуулийн шүүхийн дарга болон нарийн бичгийн дарга гарын үсэг зурах явдал юм. Энэхүү загварт Армени, Австри, Азербайжан, Бельги, Босни Герцеговиа, Хорват, Македони, Франц, Итали, Косово, Латви, Лихтенштайн, Люксембург, Мексик, Молдова, Монако, Монтенегро, Португал, Серби болон Словени багтдаг. Гүрж Улс эхний загварт багтаж байгаа нь тодорхой байна.

CDL-AD(2016)017, Гүрж - Үндсэн хуулийн шүүхийн тухай органик хууль болон Үндсэн хуулийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөд өгсөн санал, цогцолбор 158.

Энэ утгаар зөрчилдөөнүүдийг шийдвэрлэх илүү тохирсон нэмэлт арга зам байж болно. Аль ч замыг сонгосон байсан шийдвэрийг ил болгох хүртэл тодорхой хугацаа шаардагдах тул, зөвхөн Үндсэн хуулийн шүүхийн дарга болон нарийн бичгийн дарга гарын үсэг зурахад хангалттай гэсэн шаардлага нь энэ гацааг арилгаж болох юм. Гэхдээ, энэ шийдэл нь хуулиар тогтоох боломжгүй шүүхийн дарга болон шүүгчид хоорондын тодорхой хэмжээний итгэлцэлд тулгуурладаг.

CDL-AD(2017)011, Армен - Үндсэн хуулийн шүүхийн талаарх Үндсэн хуулийн төсөлд өгсөн санал, 82 дах цогцолбор

Дээр дурдсан харьцуулсан судалгааны хүрээнд авч үзвэл шүүхийн нийт 15н шүүгчээс 13н шүүгч нь шүүгч оролцож байж шүүхийн бүрэн бүрэлдэхүүнд тооцогдоно гэсэн шалгуур нь Европын бусад улс орнуудаас өндөр байна.

Европын Улсуудын стандартын дагуу, Үндсэн хуулийн шүүхийн ирц нь нийт шүүгчдийн талаас илүү байх ёстой бөгөөд нийт 15н шүүгчээс 13 гэдэг хэт өндөр шалгуур байна. Ялангуяа, Австри болон Европын хүний эрхийн шүүх шиг орлох шүүгч байгүй тохиолдолд энэ шалгуур хэт өндөр байна. Европын бусад улс орнуудад яагаад ийм өндөр шүүхийн ирцийг тогтоож өгөөгүй нь ойлгомжтой. Ийм хатуу шаардлага нь шүүхийн шийдвэр гаргах үйл явцыг гацааж, шүүх шийдвэр гаргах чадамжгүй болж, улмаар шүүх хууль тогтоомжийн Үндсэн хуулийн нийцлийг хангах үндсэн чиг үүргээ биелүүлэх боломжгүй хүргэнэ.

Европын улсуудын харьцуулсан судалгааны хүрээнд авч үзвэл дээрх харьцангуй олонхын шаардлага нь ерөнхий зарчим биш байна. Ийм хатуу шаардлага нь шүүхийн шийдвэр гаргах үйл явцыг гацааж, шүүх шийдвэр гаргах чадамжгүй болж, улмаар шүүх хууль тогтоомжийн Үндсэн хуулийн нийцлийг хангах үндсэн чиг үүргээ биелүүлэх боломжгүй хүргэнэ.

CDL-AD(2016)001, Польш Улсын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн дүгнэлт, 71-79 дэх цогцолбор

8 ШИЙДВЭРИЙН ҮР ДАГАВАР

“Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийг биелүүлэх нь хууль дээдлэх ёсны чухал шаардлага юм. Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийг дагах эсэх сонголтыг Парламентад үлдээх нь уг шаардлагад нийцэхгүй.

Үндсэн хуулийн шүүхээс Үндсэн хууль зөрчсөн гэж үзсэн аливаа хуулийн заалт тус шүүхийн шийдвэрийг нийтлэх үед хүчин төгөлдөр бус болж байх нөхцөлийг хангахуйцаар Үндсэн хуульдаа нэмэлт, өөрчлөлт оруулахыг Венецийн комиссоос зөвлөж байна. Хуулийн хийдлээс зайлсхийхийн тулд, Үндсэн хуулийн шүүхэд Үндсэн хууль зөрчсөн гэж үзсэн заалтыг хүчингүй болгохыг тодорхой хугацаагаар (ихэвчлэн нэг жил хүртэл) хойшлуулах эрх олгож болох юм. Энэ нь Үндсэн хууль зөрчсөн заалтууд хүчин төгөлдөр бус болохоос өмнө Парламентад шинэ хууль тогтоомжийг үе шаттайгаар боловсруулах боломжийг олгодог.”

CDL-AD(2018)028 Мальта – Үндсэн хуулийн тохиролцоо, эрх мэдэл хуваарилалт, шүүхийн бие даасан байдал болон хууль хэрэгжилтийн талаарх санал, цогцолбор 77-78.

“(…)Үндсэн хууль зөрчсөн нөхцөл байдал нь ердийн шүүхүүд буюу ердийн шүүхүүдийн хамгийн сүүлчийн шатны шүүхийн ердөө хууль тайлбарлах ажиллагаанаас бий болсон бөгөөд (...) нэмэлт нотлох баримт цуглуулах, шалгах шаардлагагүй тохиолдолд, Үндсэн хуулийн шүүхэд тухайн хэргийг тэрхүү сүүлчийн шатны шүүхэд буцаадаг байхыг зөвшөөрөх хэрэгтэй.”

“(…)Үндсэн хуулийн шүүхээс ердийн шүүхэд өгсөн энэхүү зааварчилгааны хэрэгжилтийг хангахын тулд ердийн шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох хэрэгтэй.”

CDL-AD(2011)040 Туркийн Үндсэн хуулийн шүүхийн байгуулал, процедурын тухай хуулийн талаарх санал, 81-82 дахь хэсэг.

8.1 ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙГ НИЙТЛЭХ

“2015 оны хуулийн 105.2 зүйл (мөн 1997 оны хуулийн 79.3 зүйл)-ийн дагуу Шүүхийн ерөнхийлөгч шүүхийн шийдвэрийг нийтлэх тухай “тушаал” өгдөг байсан. Харин шинэ хуулийн 80 дугаар зүйлд Ерөнхий сайдад зөвхөн “хүсэлт гаргах”-аар заасан байна. Шүүхийн шийдвэрийг нийтлэхтэй холбогдсон 2016 оны 3-р сарын 9 мөн 8-р сарын 11-ний өдрийн асуудлууд (түүнчлэн удаан хугацаагаар хойшлогдож, хууль тогтоох байгууллага акт

үйлдсэний дараагаар нийтлэгдсэн 3-р сарын 9-өөс хойших 21 хэргийн шүүхийн шийдвэр)-ээс үзвэл, ийм өөрчлөлт нь шүүхийн шийдвэрийг нийтлэхээс татгалзах боломжийг Ерөнхий сайдад олгосноор шүүхийн шийдвэрүүд цаг тухайдаа нийтлэгдэхгүй байх эрсдэлийг, мөн шүүхийн шийдвэрийг нэн даруй нийтлэх ёстой гэсэн Үндсэн хуулийн 190.2 зүйлийг зөрчих эрсдэлийг улам нэмэгдүүлэхээр харагдаж байна.

“2016 оны 3-р сарын 9-ний өдрийн 47/15 тоот шүүхийн шийдвэрийг нийтлэхээс татгалзах нь хууль дээдлэх ёсонд харшлаад зогсохгүй, энэхүү урьд өмнө нь гарч байгаагүй тохиолдол нь 2015 оны намрын шүүгчдийн сонгууль ба 2015 оны 12-р сарын 22-ны өдрийн нэмэлт өөрчлөлтөөс үүдэлтэй Үндсэн хуулийн хямралыг улам гүнзгийрүүлэхээр байна. Польшийн Үндсэн хууль төдийгүй Европын болон олон улсын стандартууд нь Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийг хүндэтгэхийг шаарддаг. Шүүхийн шийдвэрийг хэвлэн нийтлэх, эрх баригчид түүнд хүндэтгэлтэй хандах нь уг Үндсэн хуулийн хямралаас гарах гарцыг олох урьдчилсан нөхцөл юм” гэж тайланд тусгагджээ (цогцолбор 143).

Хууль дээдлэх, ялангуяа шүүхийн хараат бус байдлын зарчмын үүднээс, шүүхийн шийдвэрийн хүчин төгөлдөр байдал хийгээд заавал биелэгдэх шинж нь гүйцэтгэх болон хууль тогтоох эрх мэдлийн байгууллагуудын шийдвэрээс хамаарч болохгүй. Тухайлбал, Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийг нийтлэхээс ямар нэгэн үндэслэлгүйгээр татгалзах нь Үндсэн хуулийн асуудлын талаар эцсийн арбитрч болох Үндсэн хуулийн шүүхийн бүрэн эрх хийгээд хараат бус байдалд томоохон сорилтыг үүсгэнэ.“

CDL-AD(2016)026, Польш - Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн талаарх санал, цогцолбор 75–77.

“Австри улсад хууль Үндсэн хуулийг зөрчсөн гэж гаргасан Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр нь Холбооны канцлер эсхүл тухайн бус нутгийн эрх бүхий захирагчид тус шийдвэрийг цаг алдалгүй нийтлэх үүргийг хүлээлгэдэг (Холбооны Үндсэн хуулийн 140.5-р зүйл). Юу ч гэсэн, шүүхийн шийдвэр нь өөрөө Үндсэн хууль зөрчсөн заалтыг хүчингүй болгох үр дагавартай байдаг. Тиймээс Австри улсад Үндсэн хуулийн шүүхээс аливаа хууль Үндсэн хууль зөрчсөн гэх үндэслэлээр тухайн хуулийг хүчингүй болгох явдал нь, шүүхийн шийдвэрийг албан ёсны сэтгүүлд нийтэлсэн огнооноос үл хамаарч, талуудад гардуулсан өдрөөс эхлэн тухайн талуудын хувьд нөлөөтэй байх ба заавал биелэгдэх шинжтэй болдог.

АНУ-д Холбооны Дээд Шүүхийн бүх шийдвэр “Нэгдсэн Улсын Тайлан (the United States Reports)” сэтгүүлд хэвлэгддэг бөгөөд үүнийг Конгрессын бий болгосон албан тушаалтан болох Тайланч хариуцдаг. Тайланч аль шийдвэрийг нийтлэх талаар ямар нэгэн эрх мэдэл эдлэхгүй ба бүхий л шийдвэрүүд заавал дагаж мөрдөгдөх хүчин чадалтай, мөн шүүхээс гарсан тэр мөчөөсөө заавал дагаж мөрдөх шинжтэй жишиг гэж эшлэгдэх боломжтой болдог.

Шийдэл нь бусад улсуудад арай өөр өөр байж болно. Жишээлбэл, Бельгид аливаа хуулийг хүчингүй болгож буй шийдвэр нь зөвхөн албан ёсны сэтгүүлд нийтлэгдсэн тохиолдолд л хууль ёсны хүчин чадалтай болдог. Тус сэтгүүлийн нийтлэл нь автомат байх бөгөөд гагцхүү шүүхийн харьяанд байдаг. Ямартай ч, шүүхийн шийдвэрийн хүчин төгөлдөр байдал нь улс төрийн эрх баригчдын хүсэл зоригоос хамаарал бүхий Үндсэн хуулийн шүүхийн зүй зохистой тогтолцоог төсөөлөх боломжгүй юм.

Шүүхийн шийдвэрийн хуулийн хүчин чадал нь тус шийдвэрийг тухайн шүүхээс өөр хэн нэгэн этгээд нийтлэх үү, үгүй юу гэдгээс хамаардаг байж болохгүй. Шүүхийн шийдвэрийн хуулийн хүчин чадалд ийм хязгаарлалт тавих нь шүүхийн хараат бус байдал, хууль дээдлэх ёсыг ноцтой зөрчих болно. Энэ нь Үндсэн хуулийн шүүхтэй холбоотой тохиолдолд Үндсэн хуулийн асуудлуудын хувьд эцсийн арбитрч болох Үндсэн хуулийн шүүхийн бүрэн эрхийг үгүйсгэх болно.»

CDL-AD(2016)026, Польш - Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн талаарх санал, цогцолбор 79–82.

“Үндсэн хуулийн шүүхийн тухай органик хуулийн 43.10 зүйлд Үндсэн хуулийн шүүхийн акт (шийдвэр, магадлал, тэмдэглэл, дүгнэлт) үйлдэгдсэнээс хойш түүнийг 15 хоногийн дотор тус шүүхийн цахим хуудсанд нийтэлж, “Гүржийн хууль тогтоомжийн мэдээ (Legislative Herald of Georgia)” сэтгүүлд илгээх бөгөөд тус сэтгүүл тухайн актыг дараагийн хоёр өдрийн дотор нийтлэх тухай заасан. Үндсэн хуулийн шүүхийн актыг “Хууль тогтоомжийн мэдээ”-д нийтлэхийн зэрэгцээ, Үндсэн хуулийн шүүхийн тухай органик хуулийн 25.6 зүйлд “Үндсэн хуулийн шүүхийн акт нь тус шүүхийн цахим хуудсанд бүхлээрээ нийтлэгдсэн бол түүнийг хүчин төгөлдөр болсонд тооцно” гэж тодорхой заасныг Венецийн Комиссын зүгээс сайшааж байна. Шүүх өөрийн актаа цахим хуудсандаа нийтлэх талаар онцгой бүрэн эрх эдэлдэг байх нөхцөлийг хангасан байх ёстой. Энэ нь гүйцэтгэх засаглалын

зүгээс шүүхийн шийдвэрийг нийтлэхээс татгалзах замаар шүүхийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох явдлаас сэргийлдэг.”

CDL-AD(2016)017, Гүрж - Үндсэн хуулийн шүүхийн тухай органик хууль болон Үндсэн хуулийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөд өгсөн санал, цогцолбор 59–60.

“Шүүхийн шийдвэрүүд нийтлэгддэг байх нь Үндсэн хуулийн шүүхийн үр дүнтэй байх урьдчилсан нөхцөл юм. Харьцуулсан судалгаанаас үзэхэд зарим улсад Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийн хууль ёсны бүрэн эрх (legal authoritative) нь түүнийг нийтлэхээс хамаардаг бол, бусад улсад Үндсэн хуулийн шүүхээс гаргасан шийдвэр нь нийтлэгдээгүй ч хуулийн үр дагавар бүхий байдаг.”

“Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийн хууль ёсны бүрэн эрх нь түүнийг Бүгд Найрамдах Армен улсын албан ёсны сэтгүүлд нийтлэхтэй хамааралгүй байдаг гэдгийг онцлон тэмдэглэх хэрэгтэй бөгөөд шүүхийн шийдвэрийг нийтлэх нь гүйцэтгэх засаглалын үүрэг гэж ойлгогдож байх шиг байна. Гүржийн нэгэн адил, Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийг тус шүүхийн цахим хуудас эсхүл сэтгүүлд нийтлэх нь өөрөө хууль зүйн ач холбогдол бүхий гэж тооцогдож, үүний дараагаар төрийн албан ёсны сэтгүүлд нийтлэгдэх хэрэгтэй байдаг гэдгийг тодруулж хэлэх нь зүйтэй болов уу.”

CDL-AD(2017)011 Армен - Үндсэн хуулийн шүүхийн талаарх Үндсэн хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 94, 97.

8.2 EX TUNC V. EX NUNC ҮР ДАГАВАР

“[Хуулийн] 53-56 дугаар зүйлд шүүхийн шийдвэрийн үр дагаврын талаар тодорхой тусгаагүй байна. [Үндсэн хуулийн] шүүхээс Үндсэн хуульд нийцээгүй хэм хэмжээг хэзээ «хүчингүй болгох» нь тодорхойгүй байна. Тиймээс түүний шийдвэрийн үр дагавар “ex tunc⁴” эсвэл “ex nunc⁵” байх эсэх нь тодорхойгүй байна. Боломжит нэг хувилбар бол Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийн үр дагаврыг “ex tunc” гэж үзээд, хүчингүй болгосон актын үр дагаврыг тодорхой нөхцөл байдалд түр хадгалж болох онцгой тохиолдлыг урьдчилан тооцох явдал юм.”

CDL-INF(2001)002 Үндсэн хуулийн шүүхийн талаарх Бүгд Найрамдах Хорват улсын Үндсэн хуулийн зохицуулалтад өгсөн санал, цогцолбор 22.

⁴ Орчуулагчийн тайлбар: Бүр анхнаасаа гэсэн утгатай латин үг.

⁵ Орчуулагчийн тайлбар: Одоогоос эхлэн гэсэн утгатай латин үг.

“Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн төслийн 14 дүгээр зүйлийн 3 дахь цогцолбороор, ердийн шүүхийн эцсийн хүчин чадал бүхий шийдвэрийг холбогдох гомдлыг хүлээн авснаар ердийн шүүхээр дахин хэлэлцэж болно гэж тусгах замаар *ex tunc* үр дагаврыг тодруулсан. *Ex tunc* үр дагаврыг хэт хатуу хэрэглэх нь нийгэмд ноцтой үр дагаврыг бий болгож болзошгүй ба нэлээд өнгөрсөн рүү буцаж олон тооны хэргийг дахин сэргээвэл улсын төсөвт их хэмжээний дарамт учруулж болох юм. Одоогийн хууль тогтоомжид уг үр дагаврыг Үндсэн хуулийн шүүх сулруулах талаар, жишээлбэл Португалид Үндсэн хуулийн шүүх өөрөө шийдвэрийнхээ *ex tunc* үр дагаврыг хязгаарлах боломжтой байдаг шиг, тусгаагүй байна. Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийн үр дагаврыг ирээдүйн хэргүүд болон эцсийн шатны шүүхээр шийдвэрлэгдээгүй байгаа хэргүүдээр хязгаарлах нь хуулийн тодорхой байдлын үүднээс давуу талтай байдаг.”

CDL-AD(2008)029 Киргизийн (1) Үндсэн хуулийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (2) Үндсэн хуулийн шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 26.

“56-р зүйлд Үндсэн хууль зөрчсөн гэж тогтоогдсон ерөнхий хэм хэмжээнд үндэслэж бий болсон бүхий л тухайлсан актуудын хувьд тухайн акт батлагдан гарснаас хойш 2 жилийн дотор түүнийг шүүхэд дахин хэлэлцүүлэх хүсэлт гаргахыг зөвшөөрсөн. Ийм хүсэлтийг Үндсэн хуулийн шүүх ерөнхий хэм хэмжээ Үндсэн хууль зөрчсөн гэсэн шийдвэр гаргаснаас хойш 6 сараас илүүгүй хугацаанд гаргах ёстой. Энэ нь буцаж үйлчлэх үр дагаврыг бий болгох бөгөөд нийгэмд ноцтой үр дагаврыг бий болгож болзошгүй. Тиймээс Үндсэн хуулийн шүүхэд өөрийнх нь гаргасан шийдвэрийн үр дагаврыг даатгах нь оновчтой гэж харагдаж байна. Хэдийгээр хоёр жилийн хугацаагаар хязгаарласан ч, энэхүү буцан үйлчлэх байдал нь маш их зардалтай, эсвэл сөрөг үр дагавартай (гуравдагч этгээдэд ч гэсэн) байдаг бөгөөд үүнээс зайлсхийх хэрэгтэй.”

“Дээр дурдсан 56 дугаар зүйлийн нэгэн адил, 62 дугаар зүйлд хувь хүний гомдлын үр дагаврыг ерөнхий байдлаар тусгасан (бүр хоёр жилийн хязгаарлалтгүйгээр). Дахин хэлэхэд энэ нь нийгэмд ноцтой бөгөөд гэнэтийн үр дагаврыг бий болгож болзошгүй юм. Эрх ашиг нь зөрчигдсөн гэж гомдол гаргаж буй өргөдөл гаргагчийг эс тооцвол ерөнхий *ex nunc* үр дагавартай байх, гомдол гарсан тохиолдолд тухайн гомдлын буцаж үйлчлэх боломжит үр дагаврыг тодорхойлох асуудлыг шүүхэд үлдээх нь илүү аюулгүй гэж

харагдаж байна. Өөрөөр хэлбэл, Үндсэн хууль зөрчсөн гэж тогтоогдсон актын улмаас хорих ял хүлээсэн хүмүүс Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр, түүний буцаж үйлчлэх үр дагавраас ашиг хүртдэг байх хэрэгтэй.”

CDL-AD(2008)030 Монтенегро улсын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 58, 67.

“Заримдаа *ex tunc* болон *ex nunc* шийдвэрүүдийг аль алиныг нь сулруулах шаардлагатай байдаг. Нэг боломж нь Үндсэн хуулийн шүүхэд шийдвэр нь хэзээ хүчин төгөлдөр болохыг шийдэх эрхийг олгох (хүчингүй болгох болон хэсэгчлэн өөрчлөх хоёрын дундын хувилбарыг баримталж өнгөрсөнд, эсвэл ирээдүйн хэзээ нэг үед, бүр эсвэл хоёуланд нь) явдал юм. Өөр нэг боломж нь Үндсэн хуулийн зохимжит хамгаалалт болон хуулийн тогтолцооноос бүх заалтыг шууд хасаж болохгүй буюу хуулийн тогтолцооны нэгдмэл байдлыг хослуулах (эрх бүхий) тайлбарын техникийг ашиглах явдал юм.”

CDL-AD(2010)039 Хувь хүний Үндсэн хуулийн шүүхэд хандах эрхийн талаарх судалгаа, цогцолбор 192.

“[Дээд шүүхийн Үндсэн хуулийн] танхимын шийдвэрийн *ex tunc* үр дагаврыг зөвхөн онцгой нөхцөл байдалд л үйлчлэхээр маш болгоомжтой хэрэглэх хэрэгтэй. Шүүхүүдэд танхимын шийдвэрийн *ex tunc* үр дагаврын талаар тодорхой чиглэл өгөх зайлшгүй шаардлагатай.”

CDL-AD(2011)018 Киргизийн Дээд шүүхийн Үндсэн хуулийн танхимын талаарх Үндсэн хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 61.

“Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр, дүгнэлт хэзээ хүчин төгөлдөр болох тухай хуулийн төсөлд тусгаагүй. (Зөвхөн 57-р зүйлд хууль тогтоомж Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх талаар Үндсэн хуулийн шүүх Үндсэн хууль зөрчсөн тухай шийдвэрийнхээ хууль зүйн үр дагаврыг тодорхой зааж өгөх ёстой гэж тусгасан - энэ талаар доороос үзнэ үү). Шүүх аливаа хууль, эсхүл түүний зүйл заалтыг хүчингүй болгосны улмаас үүсэх хуулийн хийдлээс зайлсхийхийн тулд Үндсэн хууль зөрчсөн гэсэн шийдвэрийнхээ үр дагаврыг хойшлуулах эрхтэй байх хэрэгтэй. Хүчингүй болгохыг хойшлуулснаар Шүүх Ардын Төлөөлөгчдийн Хуралд Үндсэн хуульд нийцсэн шинэ хууль батлах хангалттай хугацаа олгож чадна. Хэрэв хуульд энэ тухай заагаагүй бол шүүх шийдвэрийнхээ үр дагаврын талаар өөрийн жишгээрээ хөгжүүлж болно.”

CDL-AD(2015)024, Тунисийн Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн төслийн талаарх санал, цогцолбор 11.

“Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийн үр дагаврыг авч үзсэн [хуулийн] шинэ 6 дугаар цогцолбор нь зөв алхам болсон. Одоогийн хуулийн болон бусад бичвэрт энэ талаар тодорхой зүйл байхгүй байна. Шинэ бичвэрт Үндсэн хууль зөрчсөн заалтуудын “хуулийн үйлчлэл нь шүүхийн шийдвэр нийтлэгдсэний дараах өдрөөс эхлэн зогсоно” гэж заасан. Энэ бол Шүүхийн чиг үүрэг дэх бодит өөрчлөлт бөгөөд үүнийг тодруулах зайлшгүй хэрэгтэй байсан. Люксембургийн эрх баригчдын өгсөн мэдээллээр бол, тухайн хуулийг хэрэглэх боломжгүй болж байгаа боловч энэ нь хүчингүй болоогүй тул хуулийн тогтолцооноос бүрмөсөн алга болоогүй гэсэн. Венецийн комиссоос хуулийн тодорхой байх зарчмыг хамгаалахын тулд Үндсэн хууль зөрчсөн гэж үзсэн заалтыг хүчингүй болгох зохицуулалт хийх хэрэгтэй гэж зөвлөж байна.”

“Мөн шинэ цогцолборт шүүхийн шийдвэрийн үр дагаврыг 12 сараас илүүгүй хугацаагаар хойшлуулах боломжийг танилцуулсан. Одоо шүүхийн шийдвэрийг *erga omnes* буюу бүгдэд хамааруулан хэрэглэнэ гэж үзэж байгаа тул уг боломж нь сайшаалтай хэдий ч, үүнийг зайлшгүй гэж бол хэлэхгүй. Эс бөгөөс Үндсэн хууль зөрчсөн гэж үзсэн заалтыг албан ёсоор хүчингүй болгоогүй нөхцөлд Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр *ex nunc* эсвэл *ex tunc* үр дагавартай байсан эсэхийг өргөдөл гаргагчид хэрэглэх байх хуулийн заалтын хамт тодорхой зааж өгөх ёстой.

CDL-AD(2019)003, Люксембургийн Үндсэн хуулийн шинэчилсэн төсөлд өгсөн санал, цогцолбор 115, 116.

“Е. Цаг хугацааны үр дагавар (Temporal effects)

41. Үндсэн хуулийн шүүхийн үндсэн үүрэг бол Үндсэн хуультай зөрчилдөж буй хуулийн зүйл заалтыг олж тогтоох, тэдгээр заалтыг хуулийн тогтолцооноос хасах явдал юм (‘негатив хууль тогтоогч’). Үндсэн хуульд нийцээгүй хууль, эсвэл тус хуулийн нэгээхэн хэсгийг илүү дээд эрэмбийн хууль болох Үндсэн хуультай зөрчилдөж байна гэсэн үндэслэлээр [эрх зүйн тогтолцооноос] хасах буюу хүчингүй болгох хэрэгтэй. [Аливаа хууль] Үндсэн хуульд нийцээгүй болохыг тогтоосон шийдвэрийн цаг хугацааны үр дагаврын талаар хэд хэдэн асуулт үүсдэг.

42. (...) Нэлээдгүй Үндсэн хуулийн шүүхээс Үндсэн хуульд нийцээгүй гэж тогтоогдсон эдгээр зүйл заалтуудыг хүчингүй болгосноос үүсэх үр дагавар зөвхөн ирээдүйд (Ихэнхдээ Үндсэн хуулийн шүүхийн холбогдох шийдвэр хүчин төгөлдөр болсноос хойш 1 жил эсвэл 18 сар хүртэлх хугацаанд)

үүснэ гэж шийдэж болох юм. Энэ нь холбогдох заалт түүний Үндсэн хуульд нийцэхгүй байдал аль хэдийн тогтоогдсон ч гэсэн, урьдын адил хэрэглэгдсээр л байна гэсэн үг юм.

43. Цорын ганц онцгой тохиолдол бол “тухайн хэргийн дүрэм (Rule of the instant case)” юм (доороос үзнэ үү). Үндсэн хуульд нийцэхгүй гэдэг нь тогтоогдож, тодорхой болсон зүйл заалтыг хэрэглэх нь магадгүй хууль зүйн тодорхой байдлыг хадгалах, тэгш байдлыг хангах, хэрэглэж болохуйц зүйл заалт байхгүйгээс үүдэх хуулийн хийдлээс зайлсхийх шаардлагуудын улмаас зөвтгөгдөж болно. Энэхүү хугацаа нь хууль тогтоогчид Үндсэн хуульд нийцэхгүй нь тогтоогдсон зүйл заалтыг орлох шинэ зүйл заалтыг батлах цаг хугацааг олгодог. Үндсэн хуульд нийцэхгүй зүйл заалт нь Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийн дагуу хуулийн үйлчлэлээ алдах бөгөөд хэрэв энэ хугацаанд хууль тогтоогч идэвхгүй хэвээр байсаар л байвал хуулийн хийдэл бодит утгаар бий болох болно.

44. Үндсэн хуульд нийцэхгүй зүйл заалтын хүчин төгөлдөр байдлын тухайд хоёр үзэл баримтлал байдаг: Хэрэв Үндсэн хуульд нийцэхгүй аливаа хуулийг [анхнаасаа] хүчин төгөлдөр бус гэж үзэж байгаа бол, тухайн хуулийг Үндсэн хуульд нийцээгүй гэж тогтоосон Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр *ex tunc* (тухайн өмнөх үеэсээ эхлээд) үр дагавартай байна гэсэн үг. Үүнийг мөн “хүчингүй болгох номлол (the doctrine of nullity)” гэж нэрлэдэг. [Харин] хэрэв Үндсэн хуульд нийцэхгүй аливаа хуулийг түүнийг [эрх зүйн тогтолцооноос] авч хаях хүртэл үйлчлэлтэй хэвээр байна гэж үзэж байгаа бол, тухайн хуулийг Үндсэн хуульд нийцээгүй гэж тогтоосон Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр *ex nunc* (одоогоос эхлээд ирээдүйд) үр дагавартай байна гэсэн үг.

CDL-AD(2018)012 Иргэний болон захиргааны хэргийн эцсийн шийдвэрүүд дэх Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийн үр дагаврын талаар Гүржийн Үндсэн хуулийн шүүхэд гаргасан *Amicus Curiae* - санал, дүгнэлтийн товч, цогцолбор 41-44.

«1. Дунд зэргийн *ex tunc* үр дагавар (Moderate *ex tunc* effects)

46. Харьцангуй цөөн хэдэн улсад л Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр нь *ex tunc* үр дагавартай байдаг. Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр нь *ex tunc* үр дагавартай байдаг олонд сайн танигдсан жишээ бол Германы эрх зүйн тогтолцоо юм. Энд *ex tunc* гэдэг нь Үндсэн хуульд нийцэхгүй зүйл заалтууд анх батлагдсан үеэсээ л хүчин төгөлдөр бус байсан гэж тооцогдоно

гэсэн утгатай. [Аливаа зүйл заалтуудыг] Үндсэн хуульд нийцээгүй гэж үзэж буй Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр нь тэдгээр зүйл заалтыг хүчингүй болгож байгаа тогтоох шинжтэй акт биш юм. Энэ нь зүгээр л Үндсэн хуульд нийцэхгүй бөгөөд аль хэдийн хүчингүй болсон зүйл заалтуудыг тодорхойлж байгаа хэрэг. Энэхүү үзэл баримтлалын давуу тал бол түүний абстракт тодорхой байдал юм. Үндсэн хуулийн дээд эрх мэдэл бүхий байдал нь маш чухал бөгөөд Үндсэн хуульд нийцэхгүй зүйл заалтууд угаасаа хүчин төгөлдөр бус юм.

47. Гэхдээ бодит байдал дээр энэ үзэл баримтлалыг хэт чанд хатуугаар баримтлах нь Үндсэн хуульд нийцэхгүй тухайн зүйл заалтууд дээр үндэслэгдээд аль хэдийн шийдэгдчихсэн хэргүүдэд урьдчилан таамаглах боломжгүй үр дүнг бий болгох болно.

CDL-AD(2018)012 Иргэний болон захиргааны хэргийн эцсийн шийдвэрүүд дэх Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийн үр дагаврын талаар Гүржийн Үндсэн хуулийн шүүхэд гаргасан Amicus Curiae - санал, дүгнэлтийн товч, цогцолбор 46-47.

«2. Чанд хатуу ех нунс үр дагавар (Strict ex nunc effects)»

49. Онолын нөгөө нэг үзэл баримтлал болох ех нунс үр дагавар нь дараах агуулгатай: Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр бол Үндсэн хуульд нийцэхгүй аливаа зүйл заалтуудыг анх батлагдсан үеэсээ хүчин төгөлдөр бус байсан гэдгийг тодорхойлоод зогсохгүй, тухайн зүйл заалтуудыг Үндсэн хуульд нийцэхгүй гэдгийг тогтоож, хүчингүй болгодог.

50. Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийн үр дагаврын талаарх асуудлын хувьд Үндсэн хуульд нийцэхгүй зүйл заалтуудыг ех нунс хэлбэр (доор дурдсан шиг дотроо өөр өөр хувилбаруудтай)-ээр хүчингүй болгох нь хамгийн түгээмэл тогтолцоо юм.

51. [Ех нунс]-ийн чанд хатуу хувилбараар нь авч үзвэл, Үндсэн хуульд нийцэхгүйгэжтогтоогдсон хуулийн зүйл заалтыг түүнийг хүчин төгөлдөр бусад тооцохоос өмнө нь үүссэн хэргийн баримтуудад бүр хэрэглэх боломжтой байдаг. “Тухайн хэргийн дүрэм” (дор дурдах)-ийн онцгой тохиолдлыг эс тооцвол, Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр нь уг шийдвэрийг нийтлэхээс өмнө нь эцэслэгдсэн хууль зүйн харилцаанд үр дагавар үзүүлэхгүй. Үүнийг зөвтгөж буй логик бол хууль зүйн тодорхой байдлыг эрх сэргээх тухайлсан арга хэмжээнээс илүүд үзэж буй явдал юм. (...)”

CDL-AD(2018)012 Иргэний болон захиргааны хэргийн эцсийн шийдвэрүүд дэх Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийн үр дагаврын талаар Гүржийн Үндсэн хуулийн шүүхэд гаргасан Amicus Curiae - санал, дүгнэлтийн товч, цогцолбор 49-51.

«3. Тухайн хэргийн дүрэм

53. Хэрэв ех пипс үр дагаврыг чанд хатуугаар хэрэглэвэл, Үндсэн хуульд нийцэхгүй зүйл заалтыг хүчингүй болгох нь зөвхөн ирээдүйд үйлчлэх учраас Үндсэн хуулийн шүүхээс холбогдох зүйл заалтыг хүчингүй болгосон боловч Үндсэн хуулийн гомдол (хэм хэмжээний эсвэл иж бүрэн гомдол) гаргагчийн эрх хамгаалагдаж чадахгүй юм. Үндсэн хуулийн шүүхийн [холбогдох зүйл заалт Үндсэн хуульд нийцэхгүй талаар] шийдвэр гарахаас өмнө үүссэн тухайн хэргийн үйл баримтад тэрхүү зүйл заалтыг хэвээр хэрэглэх ёстой.”

CDL-AD(2018)012 Иргэний болон захиргааны хэргийн эцсийн шийдвэрүүд дэх Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийн үр дагаврын талаар Гүржийн Үндсэн хуулийн шүүхэд гаргасан Amicus Curiae - санал, дүгнэлтийн товч, цогцолбор 53.

«4. Дунд зэргийн ех пипс үр дагавар

58. Зарим улс орнууд ех пипс үр дагаврын дунд зэргийн хувилбарыг ашигладаг. Энэ хувилбараар ех пипс үр дагавар нь аливаа зүйл заалтыг хүчингүй болгоход зөвхөн шүүхийн эцсийн шатны шийдвэрүүдэд үр дагавар үзүүлэхгүй гэсэн утгыг илэрхийлнэ. Үндсэн хуулийн шүүхээс [Үндсэн хуульд нийцээгүй тухай] шийдвэрээ зарласан үеэс тухайн заалт хүчингүй болно. Зарчмын хувьд уг заалт шүүхийн шийдвэр гарах хүртэл хууль зүйн тогтолцооныхоо нэг хэсэг хэвээр байна. Гэхдээ яг одоо үргэлжилж байгаа хэрэг болон шинээр гарч буй хэрэг нь Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийн үр дүнд тулгуурлан шийдэгдэх ба тус Үндсэн хуульд нийцэхгүй заалт нь тухайн шийдвэр гарахаас өмнө үүссэн үйл баримттай холбоотой хэргүүдэд хүртэл хэрэглэгдэхгүй. Тиймээс тухайн хэргийн тусгай дүрэм шаардлагагүй болно. Учир нь хүсэлт гаргагчийн ердийн шүүхийн эцсийн шийдвэр хүчингүй болох бөгөөд [ирээдүйд гарах] шинэ шийдвэр нь хүчингүй болсон зүйл заалтыг үндэслэхгүй юм.”

CDL-AD(2018)012 Иргэний болон захиргааны хэргийн эцсийн шийдвэрүүд дэх Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийн үр дагаврын талаар Гүржийн Үндсэн хуулийн шүүхэд гаргасан Amicus Curiae - санал, дүгнэлтийн товч, цогцолбор 58.

“5. Ex nunc тогтолцоо Үндсэн хуулийн шүүхэд шийдвэрүүдийнхээ буцаж үйлчлэх үр дагаврыг тодорхойлохыг зөвшөөрдөг.

62. Зарим улсад Үндсэн хуулийн шүүх тодорхой хуулийн заалтыг Үндсэн хуульд нийцээгүй гэж үзсэн шийдвэрийнхээ үр дагаврыг өөрөө шийдэх боломжтой байдаг.

63. Бүгд Найрамдах Чех улсад Үндсэн хуулийн хийсвэр хяналтын хуулийн зүйн асуудлуудын талаар ихээхэн жишиг хууль байдаг. Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрүүд нь хууль зүйн тогтоосон шинжтэй акт (constitutive legal act) гэж ойлгогддог бөгөөд зарчмын хувьд ex nunc үр дагавартай байдаг.

64. Гэхдээ энэхүү зарчмыг туйлын, хэт формалист байдлаар ойлгож болохгүй. Зарим онцгой тохиолдолд Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрүүд буцаж үйлчлэх үр дагавартай байдаг. Энэ нь дараах тохиолдолд зөвшөөрөгдөнө: хэрэв Үндсэн хуульд нийцсэн байдлыг хамгаалахын тулд зайлшгүй эцсийн арга хэмжээ болж байгаа бол, мөн хууль зүйн тодорхой байдалд шаардлагагүй, зохисгүй хэмжээнд халдахгүй байгаа бол, ялангуяа босоо харилцааны хувьд Үндсэн хууль зөрчсөн холбогдох зүйл заалт нь эрх бүхий албан тушаалтан болон тухайн хуулийн зүйл заалтыг хүчингүй болгох ашиг сонирхол бүхий хувь хүн хоорондын харилцааг зохицуулж байгаа бол.

65. Бүгд Найрамдах Чех Улсын Үндсэн хуулийн шүүхийн жишиг хууль Үндсэн хууль зөрчсөн гэж үзсэн шийдвэр нь, тухайн шийдвэр босоо харилцаа (төр болон хувь хүн хоорондын харилцаа)-нд хамаарч байгаа тохиолдолд буцаж үйлчлэх үр дагавартай байхыг зөвшөөрдөг. Учир нь энэхүү босоо харилцааны хувьд хууль зүйн тодорхой байдал, хуульд итгэх итгэлээс илүүтэйгээр үндсэн эрхийг хамгаалахыг чухалчлан үзэх шаардлагатай байдаг. (...)

66. Тиймээс Үндсэн хуулийн шүүх шийдвэрийнхээ үр дагаврыг өөрөө шийдэх боломжтой байх үед гуравдагч этгээдийн эрх нь Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийг буцаан хэрэглэхэд хязгаарлалт болдог гэж үзэж болох юм.”

CDL-AD(2018)012 Иргэний болон захиргааны хэргийн эцсийн шийдвэрүүд дэх Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийн үр дагаврын талаар Гүржийн Үндсэн хуулийн шүүхэд гаргасан Amicus Curiae - санал, дүгнэлтийн товч, цогцолбор 62-66.

«6.Буцаж үйлчлэх үр дагаврыг цаг хугацааны хувьд хязгаарласан Ex nunc тогтолцоо

67. Армени улс энэ талаар онцгой байр суурь баримталдаг. Учир нь, Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн 68 дугаар зүйлийн 14 дэх цогцолборт “Үндсэн хуульд нийцээгүй хэмээн хүчингүй болсон ерөнхий актууд дээр үндэслэж (...) Үндсэн хуулийн шүүхийн тухайн шийдвэр гарахаас өмнөх гурван жилийн дотор батлагдан гарч, хэрэгжсэн захиргааны болон шүүхийн холбогдох актууд нь эдгээр актуудыг батлан гаргасан тухайн захиргааны болон шүүхийн байгууллагуудаараа хуульд заасан журмын дагуу шинэчлэгдэх ёстой” гэж тусгажээ. Энэ нь Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрүүд нь тухайн шийдвэрүүд гарахаас өмнөх сүүлийн жилүүдэд батлагдан гарсан ердийн шүүхийн болон захиргааны бүх шийдвэрт буцаж үйлчлэх үр дагавартай байна гэсэн үг юм.”

CDL-AD(2018)012 Иргэний болон захиргааны хэргийн эцсийн шийдвэрүүд дэх Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийн үр дагаврын талаар Гүржийн Үндсэн хуулийн шүүхэд гаргасан Amicus Curiae - санал, дүгнэлтийн товч, цогцолбор 67.

8.3 ХЭРГИЙГ ДАХИН СЭРГЭЭХ ЕРДИЙН ШҮҮХИЙН ҮҮРЭГ (ДАХИН ХЯНАХ?)

Редакторын тэмдэглэл: “reopen the case” гэсэн нэр томъёо нь энд өгүүлж буй агуулгын хүрээнд урьд нь нэгэнт шийдвэрлэгдсэн хэрэг (res judicata)-ийг Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийн үндсэн дээр дахин сэргээх ажиллагааг илэрхийлж байна. Маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа дахин сэргээсний (reopen the case) дараа хэрэв шаардлагатай бол шүүхээр эцэслэн шийдвэрлэсэн хэргийг агуулгаар нь дахин хянах (re-examination) боломжийг олгодог процессын арга хэрэгслийг илэрхийлэх retrial гэсэн хэллэг мөн бий. Reopen the case ерөнхийдөө өргөн утгаар ба re-examination, retrial хоёроо агуулна. Монгол Улсын иргэн, эрүү, захиргааны процессын хуулиуд дахь хэргийг дахин хянах “re-examination” ойлголт бий, харин reopen the case, retrial гэсэн зэргэлдээ нэр томъёонууд байхгүй. Тус материалд “хэрэг дахин сэргээх” гэж хэрэглэв.

“33 дугаар зүйлээр түрдүгнэлтэд дурдсан гурван асуудлыг шийдвэрлэсэн:
(...)”

- Ердийн шүүхүүд Үндсэн хуульд нийцэхгүй хэм хэмжээний акт дээр үндэслэн шийдвэрлэгдсэн өмнөх хэргүүдийг эрүү, иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хуулиуд (эдгээр хуулиуд одоо хүчин төгөлдөр үйлчилж буй [Үндсэн хуулийн шүүхийн тухай] хуулийг нөхөж, нэмэн дэлгэрүүлэх шаардлагатай)-ын дагуу дахин сэргээнэ.

Үндсэн хуулийн гомдол гаргах процедур нь, хүний эрхийг зөрчсөн гэж маргаж буй нэг бүрчилсэн актыг зохицуулсан хэм хэмжээний актын Үндсэн хуульд нийцсэн эсэх, ялангуяа тухайн Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийн үр дагаврын талаар илүү тодорхой зохицуулалтыг шаарддаг (Хүний эрхийн талаарх Үндсэн хуулийн төслийн 6 дугаар зүйл). [Ердийн шүүхээс өмнө нь гаргасан] тухайн шийдвэр хүчингүй болсон уу, эсхүл зөвхөн Үндсэн хуульд нийцээгүй ерөнхий хэм хэмжээнд үндэслэгдсэн гэдэг нь тогтоогдож, тус шийдвэрийг гаргасан эрх бүхий байгууллага (ихэнх тохиолдолд дээд шүүх) дээрээ буцаж очих уу? 33 дугаар зүйлд хоёр дахь хувилбарыг нь тусгасан бололтой. Үүнийг энэ хуулийн төсөлд, мөн захиргааны, иргэний болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиудад бүгдэд нь тодорхой тусгах хэрэгтэй. Өмнөх шийдвэрийг гаргахад үндэслэл болсон хэм хэмжээний акт нь хүчингүй болсон гэх үндэслэлээр тус хэргийг хянан шалгах үүргийг тухайн эрх бүхий байгууллагад нь оногдуулах хэрэгтэй. Иймд 33 дугаар зүйлийн холбогдох хэсгийг ‘(...) [хэргийн талаар] эцсийн шийдвэрийг гаргасан шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь Үндсэн хуулийн шүүхээс холбогдох хэм хэмжээний актыг хүчингүй болгосон гэх үндэслэлээр эрүүгийн болон иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиудын дагуу үргэлжилнэ’ гэж ойлгох боломжтой.”

CDL-AD(2002)005 Бүгд Найрамдах Азербайжан Улсын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 9-10.

“[Өмнөх] шийдвэрийн үндэслэл болсон хуулийн заалт Үндсэн хуульд нийцэхгүй гэдэг факт нь тус хэргийн нөгөө талын эсрэг байна гэсэн зүйл бол байхгүй. [Гэхдээ мэдээж] хэргийг нэг тал нь ялах боломжит үр дагавартай байдлаар дахин сэргээх нь нөгөө талынхаа эрхийг хөндөнө. Гэвч энэ нь ямар ч тохиолдолд хэргийг дахин сэргээх ёсгүй гэсэн үг бус, харин хэргийг дахин сэргээх эсэх, хэрхэн дахин сэргээх нь холбогдох тогтолцооноосоо шалтгаална гэсэн үг. Шүүхийн анхны шийдвэрээс үүссэн холбогдох эрх, [эрх ашиг]-г тухайн тохиолдол бүрд нухацтай авч үзэх хэрэгтэй. Аливаа хуулийг хүчингүй болгох маш олон хэрэгт нөлөөлөх нь мэдээж юм.”

CDL-AD(2018)012 Иргэний болон захиргааны хэргийн эцсийн шийдвэрүүд дэх Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийн үр дагаврын талаар Гүржийн Үндсэн хуулийн шүүхэд гаргасан Amicus Curiae - санал, дүгнэлтийн товч, цогцолбор 22.

“Үндсэн хуулийн шүүх хэргийг ердийн шүүхэд буцаах үед (жишээлбэл, Үндсэн хуулийн иж бүрэн гомдлын үр дүнд) хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн холбогдох заалтууд нь ердийн шүүхэд энэ чиглэмжийн дагуу үйл ажиллагаа явуулах боломжийг олгох хэрэгтэй (мөн ийнхүү явуулахыг үүрэг болгох хэрэгтэй).

Иймэрхүү заалтууд нь ихэвчлэн Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрүүдэд шууд чиглэсэн байдаг ч, холбогдох хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн тайлбараас хамаарч ерөнхий заалтуудынхаа салшгүй нэг хэсэг болж түүнээс урган гарсан байх ч боломжтой. Европын олон оронд хэрэглэгдэж буй иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дахин сэргээх ерөнхий үндэслэлүүд нь хэрэв [(1)-т] анхны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой тодорхой, маш тухайлсан үйл баримтууд байгаа бол, [2-т] анхны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой шийдвэр эсвэл нотлох баримт байгаа бөгөөд эдгээр нь гомдол гаргагчийн буруугүйгээр дээрх ажиллагаанд үнэлэгдэж чадаагүй бол, [3-т] дээрх элементүүд нь энэ удаад гомдол гаргагчийн хувьд илүү таатай шийдвэр гаргуулах боломжтой байх зэрэг юм. Тус дүрмийг хэрхэн тайлбарлахаас хамаараад, өмнөх шүүхийн шийдвэрийн үндэслэл болсон хуулийн заалтыг хүчингүй болгосон Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр хүртэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дахин сэргээх үндэслэл болж болно. Гэхдээ ихэнх улсад шинэ шийдвэр [буюу Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр] нь тухайн хэрэгтэй шууд холбоо хамааралтай байх ёстой гэсэн шаардлага тавигддаг.

Дараагаар нь ердийн шүүхээс Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр өргөдөл гаргагчийн хувьд илүү таатай үр дүнг гаргаж чадах эсэхийг шалгах болно. Энэ нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дахин сэргээх асуудал ердийн шүүхээр хянан шалгагдаж, зөвшөөрөгдөх ёстой гэсэн үг юм. Нэмж хэлэхэд, Үндсэн хуулийн шүүхээс тогтоосон хүний эрхийн зөрчил бүр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дахин сэргээх үндэслэл болдоггүй. Тухайн Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр тодорхой хэрэгт ямархуу үр дагаврыг үзүүлэх талаар ердийн шүүхээс шалгана.”

CDL-AD(2018)012 Иргэний болон захиргааны хэргийн эцсийн шийдвэрүүд дэх Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийн үр дагаврын талаар Гүржийн Үндсэн хуулийн шүүхэд гаргасан Amicus Curiae - санал, дүгнэлтийн товч, цогцолбор 38, 39, 40.

8.4 ҮНДСЭН ХУУЛИЙН ШҮҮХИЙН ЧИГ ҮҮРЭГ

“Үндсэн хуулийн шүүхийн үндсэн үүрэг бол Үндсэн хуультай зөрчилдөж буй хуулийн заалтуудыг олж тогтоох, эдгээр заалтуудыг хуулийн тогтолцооноос хасах явдал юм (‘негатив хууль тогтоогч’) (...)”

CDL-AD(2018)012 Иргэний болон захиргааны хэргийн эцсийн шийдвэрүүд дэх Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийн үр дагаврын талаар Гүржийн Үндсэн хуулийн шүүхэд гаргасан Amicus Curiae - санал, дүгнэлтийн товч, цогцолбор 41.

“Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн төслийн 11.2-т, Үндсэн хуулийн 85 дугаар зүйлтэй нийцүүлж Үндсэн хуулийн талаар албан ёсны тайлбар гаргах [Үндсэн хуулийн] шүүхийн шинэ бүрэн эрхийг танилцуулсан (...)”

(...) Шинэ ардчилсан улс орнуудад Үндсэн хуулийн хяналтын байгууллагын уг эрх мэдэл нь Үндсэн хуулийн тогтвортой байдлыг хадгалах нөхцөлийг бүрдүүлдэг гэх фактыг Комисс ойлгож байна. Гэсэн хэдий ч эдгээр тохиолдолд, [Үндсэн хуулийн] шүүхээс хоёр талын аль алиныг сонсолгүйгээр шийдвэр гаргахаас өөр аргагүй байдаг. Цаашлаад Үндсэн хуулийн тодорхой заалтын талаарх заавал биелэгдэх шинж бүхий тайлбарын үүднээс тухайн заалтад үндэслэсэн хууль нь Үндсэн хуульд нийцээгүй байх тохиолдол гарч болох юм. Шүүхээс зөвхөн Үндсэн хууль тайлбарлахыг хүссэн учраас энэхүү мэдээжийн Үндсэн хуульд нийцэхгүй хэм хэмжээ хуулийн хүчинтэй хэвээр үлдэнэ. Тиймээс ийм бүрэн эрх бий болгож танилцуулахыг Венецийн комиссоос зөвлөдөггүй (...)”

CDL-AD(2008)029 Киргизийн (1) Үндсэн хуулийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (2) Үндсэн хуулийн шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 17-18.

“Шүүх өөрийн хүсэлтээр маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлэх боломжтой байх гэдгээс илүүтэйгээр, 110 дугаар зүйл Үндсэн хуулийн шүүхийг улс төрийн талбарт авч ирж байна. [Үндсэн хуулийн шүүхийн тухай] хуулиар шүүхийн чиг үүргийг шүүхээс өөрийн шийдвэрүүдийн биелэлтэд

тавих ерөнхий хяналт шалгалтаас Үндсэн хуульт ёс, хууль зүйт ёсны хэрэгжилтэд тавих хяналт рүү шилжүүлж хязгаарлах хэрэгтэй.”

CDL-AD(2008)030 Монтенегро улсын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 80.

“Үндсэн хуулийн шүүх Үндсэн хуультай зөрчилдөж байгаа хуулийн заалтыг цуцлах эсвэл хүчингүй болгох эрхтэй байх хэрэгтэй.”

CDL-AD(2009)014 Палестины Үндэсний эрх баригчдын Үндсэн хуулийн дээд шүүхийн тухай хуулийн талаарх санал, цогцолбор 27.

“(...)Үндсэн хуулийн шүүх ямар ч тохиолдолд өөрт нь илгээгдсэн харьяаллын асуултуудад бүгдэд нь хариу өгөх ёстой (...)”

“Ямар ч тохиолдолд Үндсэн хуулийн шүүхэд ноцтой бус, урвуулан ашигласан (abusive) буюу дахин давтан гаргасан гомдлуудаас урьдчилан сэргийлэх арга хэрэгслийг өгөх ёстой.”

CDL-AD(2010)039 Үндсэн хуулийн хяналтад хувь хүн хандах боломжийн талаарх судалгаа, цогцолбор 155, 221.

8.5 ҮНДСЭН ХУУЛИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙГ БИЕЛҮҮЛЭХ

“Европ дахь Үндсэн хуулийн шүүхүүдийн хэргийн харьяалал, институтын зохион байгуулалт нэлээд харилцан адилгүй байна. Тухайлбал шүүхийн шийдвэрийг биелүүлэх журам (хэрэв ийм журам байдаг бол) Үндсэн хуулийн шүүх болгонд өөр өөр байна. Үүнээс үзвэл Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийг биелүүлэх талаар нэгдсэн хатуу стандарт байхгүй байна.”

“Дээр дурдсан харьцуулсан судалгаа нь шүүхийн шийдвэрийг биелүүлэх талаар зарим ялгаа байгааг харуулж байна. Европын эрх зүйн тогтолцооны нэг хэсэг нь Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийг биелүүлэх талаар зохицуулдаггүй бол, нөгөө хэсэг нь энэхүү үүргийг төрийн бусад эрх мэдэлд даалгаж байна. Зөвхөн Молдова улсад л Үндсэн хуулийн шүүх захиргааны торгууль ногдуулж болохоор байдаг. Үүнээс үзвэл Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийн биелэлтийг хэн хариуцах талаар Европт нэгдсэн стандарт байхгүй байна.”

“[Үндсэн хуулийн шүүхэд] 92-р зүйлээр шийдвэрийнхээ биелэлтийг хангах үүргийг даалгасан нь нэмэлт, өөрчлөлтийн гол цөм юм. Харьцуулсан судалгаа харуулж байгаачлан, энэхүү үүрэг нь Европын Үндсэн хуулийн шүүхүүдийн хувьд нэлээд онцгой зүйл юм. Шүүхүүдийн зарим нь

шийдвэрийнхээ биелэлтэд хяналт тавих үүрэгтэй эсвэл тэрхүү үүргээ тодорхой эрх бүхий байгууллагад шилжүүлсэн байж болдог хэдий ч, өөр ямар ч шүүх шийдвэрийнхээ биелэлтийг хангах бүрэн үүргийг хариуцаж аваагүй байх шиг байна.”

CDL-AD(2017)003, Испани - Үндсэн хуулийн шүүхийн Органик хуулийн нэмэлт, өөрчлөлтөд өгсөн санал, цогцолбор 15, 26, 38.

“66-67 дугаар зүйл Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийн биелэлтийг баталгаажуулахад хангалттай үр дүнтэй байх эсэх нь эргэлзээтэй байж болох юм. Ялангуяа Үндсэн хууль хийгээд Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийг хүндэтгэн биелүүлдэг соёлын хөгжил, төлөвшилт зэрэг нэмэлт арга хэрэгслүүд шаардлагатай байж болох юм.”

“Шийдвэрийн биелэлтэд хяналт тавих илүү практикал механизмууд, түүнчлэн холбогдох шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд үүсэх хууль зүйн арга хэмжээ зайлшгүй шаардлагатай гэж харагдаж байна.”

“Венецийн комиссын төлөөлөгчдийн Ереванд хийсэн айлчлалын үеэр хөндөгдсөн өөр нэг асуудал бол Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийн аль хэсэг нь заавал биелэгдэх шинжтэй вэ гэдэг асуудал байсан. Хэлэлцүүлэгт оролцогчдын зарим нь шүүхийн шийдвэрийн зөвхөн шийдвэрлэх хэсэг (the conclusive part) нь л заавал биелэгдэх шинжтэй байх ёстой бөгөөд шүүхийг тухайн дүгнэлтэд хүргэсэн үндэслэгээ (the reasoning) нь бол биш юм гэх үндэслэлийг дэвшүүлсэн. [Харин] Үндсэн хуулийн шүүхээс шүүхийн шийдвэрийн шийдвэрлэх хэсэгт хүргэдэг үндэслэгээ нь тухайн шийдвэрийн оператив хэсэг (the operative part)-т багтах бөгөөд улмаар нэгэн адил заавал биелэгдэх шинжтэй гэх эсрэг үндэслэлийг гаргасан. Хуулийн төслийн 61.5-д “Хэрэг маргааны агуулгын талаар гаргасан Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр заавал биелэгдэх шинжтэй байх ёстой” гэж тусгасан нь энэ талаар бага зэрэг тодорхойгүй байдлыг бий болгосон. [Тиймээс] дараах шийдлийг харгалзан үзэж болох юм: Үндсэн хуульд нийцээгүй гэж шийдвэр гарсан тохиолдолд шүүхийн шийдвэрийн зөвхөн шийдвэрлэх хэсэг нь л заавал биелэгдэх шинжтэй байх хэрэгтэй. Харин үндсэн хуульд нийцсэн гэж шийдвэр гарсан тохиолдолд шийдвэрлэх хэсэг болон тухайн шийдвэрийн шийдвэрлэх хэсэгт дурдагдсан холбогдох хэм хэмжээний тайлбар нь ч гэсэн заавал биелэгдэх шинжтэй байх хэрэгтэй.”

CDL-AD(2017)011 Армен - Үндсэн хуулийн шүүхийн талаарх Үндсэн хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 86, 88, 91.

“Шийдвэрийг төрийн аливаа эрх бүхий этгээд, ажилтанд мэдэгдэх (мэдээлэл хүргүүлэх) бүрэн эрх нь Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийн эцсийн хийгээд заавал биелэгдэх шинж чанартай нийцдэг. Шүүхийн шийдвэрийг биелүүлэх үүрэг бүхий байгууллага, хувь хүмүүст мэдэгдэх шаардлагатай байдаг бөгөөд ингэснээр тэд өөрсдийн үүргийн талаар анхаарал болгоомжтой байж, холбогдох үүргээ үр дүнтэй, хурдан шуурхай биелүүлэх боломжтой болно. Ийм мэдэгдэл нь аль бүрэн эрх бүхий этгээд буюу хүн тухайн шүүхийн шийдвэрийн биелэлтийг хариуцаж байгаа талаарх эргэлзээг арилгаж, улмаар шийдвэр биелүүлэлт дэх эрх мэдлийн позитив, эсхүл негатив зөрчилдөөнөөс зайлсхийх боломжтой болдог. Ийм мэдэгдлийг Үндсэн хуулийн шүүхээс зөвхөн сайн дурын үндсэн дээр явуулдаг бус, түүнд үүрэг болгосон байх хэрэгтэй.”

CDL-AD(2017)003, Испани - Үндсэн хуулийн шүүхийн Органик хуулийн нэмэлт, өөрчлөлтөд өгсөн санал, цогцолбор 33.

“92 дугаар зүйлийн 1 дэх цогцолборт, Үндсэн хуулийн шүүхээс шүүхийн шийдвэрийн биелэлтийг хэн хариуцах талаарх асуудлыг өөрийн шийдвэр, эсхүл дараа дараачийн актуудынхаа хүрээнд тодорхойлж болох заалтыг хэвээр хадгалсан. Энэхүү заалт нь Үндсэн хуулийн шүүхийн жишиг хуулийн үр дүнтэй байдлыг хангах, улмаар шийдвэрийн биелэлтийг хангахад ач тустай арга хэрэгсэл юм.”

“92 дугаар зүйлд өөрийн шийдвэртэй зөрчилдсөн ‘ямар ч’ шийдвэрийг хүчингүй болгох [Үндсэн хуулийн шүүхийн] бүрэн эрх аль 2007 оноос хойш байсаар ирсэн. Үндсэн хуулийн шүүхийг төвийг сахисан арбитрч гэсэн ойлголтыг хангахын тулд тус эрх мэдлийг зөвхөн маргааны аль нэг талын хүсэлтээр л хэрэгжүүлэх хэрэгтэй (92.3-т заасан шиг). Ямар ч байсан гэсэн, ердийн шүүхийн шийдвэрийг [Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийг] биелүүлэх ажиллагааны явцад хүчингүй болгож болохгүй ба гагцхүү тодорхой хэрэг маргааны агуулгыг шийдвэрлэсэн хянан шийдвэрлэх ажиллагааны явцад л хүчингүй болгож болно.

Энэ эрх мэдэл нь [Үндсэн хуулийн] шүүхэд дарамт учруулж болзошгүй юм. Нэмэлт, өөрчлөлт нь, Үндсэн хуулийн шүүхийн холбогдох шийдвэр гаргахаас өмнө нь гарсан шийдвэр болон тус шүүхийн дараачийн шийдвэр (үүнийг өөрийнхөө өмнөх шийдвэртэй зөрчилдөнө гэдгийг мэдсээр байж гаргасан) хоёрын ялгааг гаргаагүй. Үндсэн хуулийн шүүхийн тодорхой нэг шийдвэртэй зөрчилдсөн олон нэг бүрчилсэн шийдвэр гарч болно. Үндсэн

хуулийн шүүхийн шийдвэртэй зөрчилдөж байгаа шийдвэрийг хүчингүй болгох бүрэн эрхийн цаг хугацааны (*ratione temporis*) хязгаарыг тодорхой болгох хэрэгтэй.”

CDL-AD (2017)003, Испанийн Үндсэн хуулийн шүүхийн Органик хуулийн нэмэлт, өөрчлөлтийн талаарх санал, цогцолбор 40-42.

“Шүүхээс тогтоосон хугацаа үндэслэлтэй байхын хэрээр (...) Үндсэн хуулийн шүүхэд тайлагнах үүрэг асуудалгүй байх болно.”

“(...) Европын хүний эрхийн конвенцын 6-р зүйлд заасан шударга шүүхийн баталгаа нь хувь хүмүүст оногдуулах торгуулийн шийтгэлийг шаарддаг. Маргаантай-захиргааны харьяаллын тухай хуулийн хэрэглээ болон, ялангуяа шүүх хуралдаан болон нотлох баримтын талаарх тус хуулийн заалтууд нь ийм баталгааг олгож болох юм. Эдгээрийг тусгайлсан хэргүүдэд зөв хэрэглэх нь Үндсэн хуулийн шүүхийн үүрэг юм.”

CDL-AD (2017)003, Испанийн Үндсэн хуулийн шүүхийн Органик хуулийн нэмэлт, өөрчлөлтийн талаарх санал, цогцолбор 45, 50.

“Үндсэн хуулийн шүүх шийдвэргаргачаад байхад түүнийг хэрэгжүүлэхээс татгалзсан тохиолдолд Үндсэн хууль хийгээд Үндсэн хуулийн шүүхээ хамгаалах зорилгоор бусад байгууллагууд оролцох хэрэгтэй. Үндсэн хуулийн шүүхэд өөрт нь шүүхийн шийдвэрүүдийн биелэлтийг хариуцуулж, холбогдох эрх мэдлийг олгох нь хальт харахад сайн зүйл мэт санагдаж болох юм. Гэвч төрийн эрх мэдэл хуваарилагдсан тогтолцооны хувьд, [Үндсэн хуулийн шүүхийн] хэрэг маргаан хянан шийдвэрлэх эрх мэдэл болон түүний үр дүн болох шүүхийн шийдвэрийг биелүүлэх эрх мэдэл хоорондын ялгарал нь [төрийн эрх мэдлийн] хяналт, тэнцвэрийн тогтолцоог бүхэлд нь бэхжүүлж, эцсийн дүндээ хууль дээдлэх ёсны голлох хүчин зүйл болох Үндсэн хуулийн шүүхийн бие даасан байдлыг ч мөн бэхжүүлдэг. Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийг хууль зөрчигчөөр заавал биелэлтийг нь хангуулах хэрэгтэй. Гэвч үүнийг шүүхийн шийдвэрийн биелэлтийг холбогдох албан тушаалтнаас шүүхийн шийдвэрийг хангуулахаар албадах бодит арга хэрэгсэл байхгүй Үндсэн хуулийн шүүхэд хариуцуулах хэрэгтэй гэсэн үг биш юм.”

“Үндсэн хуулийн шүүх өөрийн шийдвэрүүдийнхээ биелэлтийг хангах талаар хариуцан ажиллах нь онцгой тохиолдол гэдгийг харьцуулсан судалгаа харуулж байна. Энэ үүрэг нь ихэвчлэн төрийн бусад эрх мэдлүүдэд олгогддог. Үндсэн хуулийн шүүх зөвхөн дундыг барьсан арбитрч, хууль тогтоомжийн талаарх шүүгчийн хувиар үйл ажиллагаа явуулдаг

гэсэн ойлголтыг урагшлуулахын тулд, Үндсэн хуулийн шүүхэд өөрийнхөө шийдвэрүүдийн биелэлтийг хангах асуудлыг шууд хариуцан ажиллах, нэгдмэл бүрэн эрхийг олгох тухай дахин авч үзэхийг санал болгож байна.”

CDL-AD(2017)003, Испани - Үндсэн хуулийн шүүхийн Органик хуулийн нэмэлт, өөрчлөлтөд өгсөн санал, цогцолбор 53, 71.

“(...) Хувь хүмүүст ногдуулах дахин давтсан шинжтэй, албадлагын торгууль болон шүүхийн шийдвэрийг биелүүлэхээс татгалзсан албан тушаалтныг холбогдох албан тушаалаас нь түдгэлзүүлэх гэсэн хоёр арга хэмжээ асуудал үүсгэдэг.

Албан тушаалаас нь түдгэлзүүлэх арга хэмжээг ямар албан тушаалтанд хэрэглэж болох эсэх талаарх хүрээ хязгаар тодорхойгүй хэвээр байгаа бөгөөд үүнийг тодорхой зааж өгөх хэрэгтэй. Хэрэв энэхүү арга хэмжээг 92 дугаар зүйлд тусгагдсан шууд сонгогддог албан тушаалуудад ч гэсэн хэрэглэхээр болбол энэ нь нэлээд асуудалтай байж болох юм. Торгуулийг нийтийн эрх бүхий этгээд, албан тушаалтан, хувь хүмүүст ногдуулах эсэхээс хамаараад холбогдох хууль, эсхүл түүний хэрэглээнд ялгаатай зохицуулалтыг оруулах хэрэгтэй.

Үндсэн хуулийн шүүх бол төвийг сахисан арбитрч гэсэн ойлголтыг улам баталгаажуулахын тулд нэмэлт, өөрчлөлтийн дагуу шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангахдаа шүүх өөрийн хүсэлтээр биш зөвхөн аль нэг талын хүсэлтээр ажиллах хэрэгтэй.”

CDL-AD(2017)003, Испани - Үндсэн хуулийн шүүхийн Органик хуулийн нэмэлт, өөрчлөлтөд өгсөн санал, цогцолбор 73-75.

“Өөр нэг асуудал бол түдгэлзүүлэх арга хэмжээний үр дагавар юм. Түдгэлзүүлэх арга хэмжээ авсан хугацаанд холбогдох албан тушаалтан бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болно. Түдгэлзүүлэх арга хэмжээ нь холбогдох албан тушаалтныг өөр этгээдээр солих үр дагаварт бол хүргэхгүй. Нэмэлт, өөрчлөлтийн оршил хэсэг хийгээд [төрийн эрх бүхий байгууллагын] байр суурь илэрхийлсэн бичиг (the position paper)-т заасны дагуу, түдгэлзүүлэх арга хэмжээ нь, торгуультай нэгэн адилаар, түдгэлзэгдсэн албан тушаалтныг Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийг биелүүлэхэд түлхэц болох хэрэгтэй бөгөөд энэхүү арга хэмжээ нь зөвхөн тухайн албан тушаалтан Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийг биелүүлэхээс татгалзсан хугацаанд л үргэлжлэх хэрэгтэй. Гэхдээ тухайн албан тушаалтан нэгэнт бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болчихсон бол [Үндсэн хуулийн]

шүүхийн шийдвэрийг яаж биелүүлэх юм бэ? Шүүхийн STC 215/2016 дугаар тогтоолд түдгэлзүүлэх арга хэмжээг эрх бүхий этгээд, нийтийн албан тушаалтан шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй байх “хүсэл зоригоо орхисон” бол цуцална гэж заасан. Уг асуудлыг шийдвэрлэхийн тулд, тухайн албан тушаалтан эхлээд шүүхийн шийдвэрийг биелүүлэхээ амлах бөгөөд дараа нь шүүхээс тухайн албан тушаалтнаар шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангуулахын тулд түдгэлзүүлэх арга хэмжээг зогсоох хэрэгтэй болно. Нэмэлт, өөрчлөлтөөр энэхүү практикал (practical) асуудлыг зохицуулахыг санал болгож байна .”

“Хэрвээ түдгэлзүүлсэн албан тушаалтны алба буюу ажлын байрыг зохицуулах журмаар тухайн албан тушаалтныг (түүний орлогчоор) сольж, тэрхүү шинээр солигдсон этгээдээр Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангуулах тухай зохицуулсан бол энэ нь нэлээд маргаантай асуудалд хүргэх болно. [Хэрэв шинээр солигдсон этгээд шүүхийн шийдвэрийн биелүүлчихвэл] тухайн албан тушаалтныг түдгэлзүүлэх арга хэмжээ дуусгавар болно. Харин гэхдээ шинээр солигдсон этгээд нь шүүхийн шийдвэрийг биелүүлэхээс татгалзвал түүнийг ч мөн түдгэлзүүлэх хэрэг гарах байх. Энэхүү процесс нь шүүхийн шийдвэрийг биелүүлэх хүртэл давтагдаж болно. [Гэхдээ] ийнхүү дахин давтагдсан түдгэлзүүлэх арга хэмжээ нь утгагүй (absurd) нөхцөл байдалд хүргэж болзошгүй юм.”

“Эцэст нь торгуулийн арга хэмжээний талаар ч гэсэн адилхан асуудал гардаг. Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй, улмаар холбогдох албан тушаалтанд түдгэлзүүлэх арга хэмжээ авсан хэдий ч тэрээр тус арга хэмжээг ч мөн үл тоомсорлож, албан тушаалдаа байсаар байх боломжтой юм. Хэрэв ийм зүйл тохиолдвол энэ нь Үндсэн хуулийн шүүхийн бүрэн эрхт байдлыг ноцтойгоор зөрчих болно.”

CDL-AD(2017)003, Испани - Үндсэн хуулийн шүүхийн Органик хуулийн нэмэлт, өөрчлөлтөд өгсөн санал, цогцолбор 59-61.

“Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийн биелэлтийг хангах талаар шүүхийн шийдвэрийг орлуулах арга хэмжээ нь ямар нэгэн асуудалгүй гэж Венецийн комисс үзэж байна. Үндсэн хуулийн шүүх энэ арга хэмжээг өөрөө бараг хэрэгжүүлдэггүй ба, харин энэ талаар Испанийн Засгийн газраас хамтран ажиллахыг хүсдэг. Тиймээс уг арга хэмжээг авснаас үүсэх шаардлагатай актуудыг гаргаж хэрэгжүүлэх асуудлын талаар Үндсэн хуулийн шүүх өөрөө ямар нэгэн үүрэг хүлээдэггүй.”

“Маргааны талуудыг сонсохгүйгээр холбогдох актуудыг түдгэлзүүлэх нь, ялангуяа холбогдох маргаан нь Европын хүний эрхийн конвенцын 6-р зүйлд хамаарсан тохиолдолд асуудал үүсгэж болзошгүй юм. Гэсэн хэдий ч энэхүү арга хэмжээг авснаас хойш гурав хоногийн дараа холбогдох шүүх хурал болох бөгөөд тус шүүх хуралдаанд маргааны талууд өөрсдийн үзэл бодол, байр сууриа илэрхийлэх боломжтой байдаг. Ихэнх тохиолдолд Үндсэн хуулийн шүүх, эсхүл Ерөнхийлөгч хүртэл яаралтай нөхцөл байдалд түр арга хэмжээнүүд (interim measures)-г авах боломжтой. Тиймээс тус арга хэмжээг авсны дараахан холбогдох шүүх хурал явагддаг байдлаас үзвэл энэхүү арга хэмжээг эсэргүүцэх зүйлгүй байхгүй байна. Гэхдээ шүүх өөрийн үзэмжээр бус зөвхөн хүсэлтийн дагуу ажиллах хэрэгтэй.”

CDL-AD(2017)003, Испани - Үндсэн хуулийн шүүхийн Органик хуулийн нэмэлт, өөрчлөлтөд өгсөн санал, цогцолбор 64, 68.

8.6 ҮНДСЭН ХУУЛИЙН ШҮҮХИЙН ТАЙЛБАРЫГ ДАГАЖ МӨРДӨХ ҮҮРЭГ

“Үндсэн хуулийн шүүхийн үндэслэгээ (reasoning) нь ердийн шүүхүүдэд чиглэмж болох учиртай бөгөөд түүний ач холбогдлыг онцлон тэмдэглэх нь чухал юм. Үндсэн хуулийн шүүхийн үндэслэгээг ердийн шүүхүүд хүндэтгэн дагах нь тус шүүхүүд Үндсэн хуульд нийцсэн тайлбар гаргах гол түлхүүр юм. Учир нь зөвхөн Үндсэн хуулийн шүүхийн тайлбарыг л Үндсэн хуульд нийцсэн гэж үздэг. Ердийн шүүхүүд, эсхүл төрийн байгууллагууд Үндсэн хуулийн шүүхийн тайлбарыг дагаж, үйл ажиллагаагаа түүнд үндэслэж л байж, аливаа хууль тогтоомжийг Үндсэн хуульд нийцсэн байдлаар хэрэглэх боломжтой болно.”

“Үндсэн хуулийн шүүхээс гаргасан шийдвэрийг тайлбарлахын тулд Үндсэн хуулийн шинэ процедур бий болгох нь хэвийн бус зүйл биш юм. Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийн үндэслэгээ нь өөрөө тухайн шийдвэрийнхээ агуулгыг тайлбарласан байх ёстой бөгөөд энэ нь өөр ямар нэг нэмэлт шийдвэрээр хийгдэх ёсгүй. Хэд хэдэн оронд иймэрхүү процедур байдаг нь үнэн ч, эрх зүйн соёл хараахан төлөвшөөгүй байгаа шинэ ардчилсан орнуудад иймэрхүү заалт нь Үндсэн хуулийн шүүхэд өмнөх шийдвэрүүдийнхээ агуулгыг өөрчлөх шахалт үзүүлэхэд хүртэл ашиглагдаж болох юм.”

“Шүүхийн шийдвэрүүд шууд ойлгомжтой байх хэрэгтэй бөгөөд нэмэлт тайлбарыг шаарддаггүй байх хэрэгтэй. Гэсэн хэдий ч Үндсэн хуулийн шүүх өөрийн шийдвэрээрээ Үндсэн хуулийн холбогдох асуудлыг шийдвэрлэж чадаагүй, эсхүл өөр шинэ асуудлыг бий болгочих тохиолдол гарч болох юм. Иймэрхүү тохиолдолд шинэ процедураар шинэ шийдвэрийг гаргах хэрэгтэй (гэхдээ энэ нь өмнөх шийдвэрийн тайлбар байж болохгүй).”

CDL-AD(2007)036 Азербайжан улсын Үндсэн хуулийн шүүхийн тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдэд өгсөн санал, цогцолбор 22, 24, 25.

“69 дүгээр зүйлээр төрийн бусад байгууллагуудыг тухайлсан шинэ акт гаргахдаа Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийн хууль зүйн үндэслэгээг харгалзан үзэхийг үүрэг болгосон нь эерэг зүйл юм. Бусад шүүхүүдтэй холбогдон үүсдэг асуудлууд нь ихэнхдээ тэдгээр шүүхүүд Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийн үндэслэгээг бус оператив хэсэг (the operative part)-г дагаж мөрддөгөөс үүдэлтэй байдаг.”

CDL-AD(2008)030 Монтенегро улсын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 71.

“Төрийн бусад бүхий л байгууллагууд (үүнд ердийн шүүхүүд багтана)-ыг Үндсэн хуулийн шүүхээс гаргасан тайлбарыг дагаж мөрдөхийг ердийн хууль тогтоомж (эсхүл Үндсэн хуулиар байвал бүр сайн)-оор шууд үүрэгжүүлэх нь Үндсэн хуулийн шүүх болон ердийн шүүх хоорондын харилцааг тодруулахад чухал үүрэг гүйцэтгэх бөгөөд энэ нь мөн хувь хүмүүс шүүхэд хандаж эрхээ хамгаалуулах үндэслэл болж чадна.”

“Урьдчилсан шийдвэр гаргах журам (preliminary ruling procedures)-ыг нэлээд ниуанстай авч үзэх шаардлагатай. Нэгдүгээрт, Үндсэн хуульд нийцэхгүй байдлын онцгой тохиолдлууд (exceptions of unconstitutionality) болон урьдчилсан асуултууд нь хэм хэмжээний актын хяналтыг эхлүүлдэг. Үндсэн хуульд нийцэхгүй байдлын онцгой тохиолдлын дагуу гарсан шийдвэр нь маргааны талуудад заавал биелэгдэх үр дагавартай байдаг, мөн ердийн шүүх Үндсэн хуулийн шүүхийн тухайн шийдвэрийг тодорхой хэрэг маргаанд хэрэглэх үүрэгтэй байдаг талаар ямар нэгэн маргаан байхгүй.”

CDL-AD(2010)039 Үндсэн хуулийн хяналтад хувь хүн хандах боломжийн талаарх судалгаа, цогцолбор 192.

“Үндсэн хуулийн шинэчилсэн найруулга нь Бельгийн Үндсэн хуулийн шүүхийн 2003 оны 5-р сарын 26-ны өдрийн 73/2003 тоот шийдвэр зэргийн дараа хийгдсэн. Энэхүү шинэчилсэн найруулга нь Үндсэн хуулийн шүүхийн ялангуяа дээрх шийдвэрийн зарим үр дагаврыг буцаах зорилгоор хийгдсэн байж болох юм. Гэхдээ Үндсэн хуулийн шинэчилсэн найруулга нь Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийн эсрэг байж болохгүй гэсэн нийтлэг жишиг байхгүй. Энэ нь Үндсэн хуулийн шүүхээс тайлбарладаг Үндсэн хуулийг бодит хүчгүй болгоно. Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрүүдийг буцаахад чиглэсэн нэмэлт, өөрчлөлтүүдийг ойр ойрхон оруулах нь Үндсэн хуульт соёл, Үндсэн хуулийн шүүхийн бүрэн эрхт байдал, улмаар Үндсэн хуулийг сахин биелүүлэх явдлыг алдагдуулах болно.”

CDL-AD(2012)010 Бельгийн Үндсэн хуулийн өөрчлөлтөд өгсөн санал, цогцолбор 67.

“Чиг үүргийн үүднээс авч үзвэл, Үндсэн хуулийн шүүхийн үүргийг Үндсэн хуулийг тайлбарлах (энэ нь Үндсэн хуульд тусгагдсан зарчмуудын үндсэн дээр эрх зүйн нэгдмэл хөгжил рүү хөтөлдөг) замаар Үндсэн хуулийн дээд эрх мэдэл бүхий байдал (the supremacy)-г хамгаалах явдал гэж тодорхойлж болох юм. Үндсэн хуулийн зүйл заалт дээр үндэслэгдэн гарч байсан ч одоо нэгэнт хүчингүй болсон өмнөх жишиг хууль нь энэхүү эрх зүйг нэгдмэл байдлаар хөгжүүлэх явдалд чухал эх сурвалж болдог. Унгар улсад хүний эрхийн нэлээдгүй зарчмууд олон жилийн турш бүрэлдэн бий болж, Үндсэн хуулийн шүүхийн практикт өөрсдийн илэрхийллийг олсоор ирсэн (шүүхийн практикаар баталгаажсаар ирсэн). Унгарын Үндсэн хуулийн шүүхийн цаазаар авах ялыг халах тухай шийдвэр нь тус ялыг халах талаарх хувьсгалын эхийг тавьсан бөгөөд дэлхий дахины хүндэтгэлийг хүлээсэн шийдвэр байсан. Энэхүү шийдвэр нь Өмнөд Африк, Литва, Албани, Украин улсуудын Үндсэн хуулийн шүүхүүд цаазаар авах ялыг халахад урам зориг болсон юм.

Үндсэн хуулийн шүүх хэрэг маргааныг өөрийн хүссэнээр шийдэх өргөн эрх мэдэлтэй (a wide margin of appreciation) байх нь сайн хэрэг гэдэг нь төөрөгдөл юм. Үндсэн хуулийн шүүх дур зоргын шийдвэр гаргалгүйгээр, зөвхөн Үндсэн хууль хийгээд өмнөх жишиг хуульд үндэслэсэн шийдвэр гаргах замаар үндсэн хуульт нэгдмэл байдлыг хангах хэрэгтэй. Түүнчлэн аливаа Үндсэн хуулийн шүүх өмнөх шийдвэрүүдээсээ хазайж болох хэдий ч, энэ нь үндэслэл бүхий байх ёстой.

Үндсэн хууль тогтоогч эрх мэдэл (the constituent power) Үндсэн хуулийн шүүхээс өөрийнхөө өмнөх жишиг хуульд тулгуурлах замаар хуучин Үндсэн хуулийг мөнхжүүлэх, улмаар шинэ Үндсэн хуулийн үр нөлөөг бууруулах явдлаас сэргийлсэн байсан ч гэсэн, өмнөх жишиг хуулийг бүр мөсөн устгах нь оновчтой ч биш, тохирсон ч биш юм. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дараа Үндсэн хуулийн шүүхийн үүрэг бол нэмэлт, өөрчлөлтөд өртөөгүй зүйл заалтууд болон зарчмуудыг аль болох дурдахгүй байх явдал юм.”

(...)

“Тиймээс Үндсэн хуулийн шүүх илүү чөлөөтэй шийдвэр гаргах ёстой гэсэн Унгарын эрх баригчдын үндэслэлийг Венецийн комисс дэмжих боломжгүй байна. Үүнээс харагдаж байгаачлан, Үндсэн хуулийн шүүхэд шаардлагатай тохиолдолд өмнөх жишгүүдээ шинэчлэх боломжийг олгохын тулд тэрхүү өмнөх жишиг хуулиудыг хүчингүй болгохыг зөвтгөх ямар ч үндэслэл байхгүй юм. Үндсэн хуулийг түүний заалт, зарчмууд дээр үндэслэж тайлбарлах нь Үндсэн хуулийн шүүхийн арга барилд шингэсэн байдаг. Эдгээр зарчмууд нь Үндсэн хуулиас өөрөөс нь давдаг бөгөөд Европын зөвлөлийн суурь зарчмууд болох ардчилал, хүний эрхийг хамгаалах, хууль дээдлэх ёстой шууд холбогддог. Энэ бол Үндсэн хуулийн шүүх байгуулагдсан цагаас хойших түүний жишиг хуульд тусгалаа олсон эдгээр зарчмууд юм.”

CDL-AD(2013)014 Шүүгчийн хараат бус байдлыг бэхжүүлэх Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн тухай хуулийн төсөл (тайлбар, хүснэгт багтсан) болон Украины Үндсэн хуулийн ассамблейгаас өргөн мэдүүлсэн Үндсэн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 92- 94, 96.

“21.2-т зааснаар Ерөнхий нарийн бичгийн дарга нь Үндсэн хуулийн шүүхийн актуудын биелэлтэд “санаа тавьж, тэдгээрийн биелэлтийг хариуцна”. “Хариуцна” гэх нь, жишээлбэл Парламентын эс үйлдэхүй зэрэг хариуцах боломжгүй хэтийдсэн зүйлсийг тухайн албан хаагчаас шаардаж байна. Ерөнхий нарийн бичгийн даргын хариуцаж чадах зүйл бол Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийг биелүүлэхэд зөвхөн дэмжлэг үзүүлэх л юм.”

CDL-AD(2014)033 Монтенегрогийн Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 28.

“Үндсэн хуулийн шүүх нь Үндсэн хуулийн дээд эрх мэдэл бүхий байдлыг хангах ёстой (Үндсэн хуулийн 167.1 зүйл). Тиймээс хэрэг маргааны агуулгыг шийдвэрлэсэн Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрүүд нь төрийн болон нутгийн өөрөө удирдах ёсны бүх байгууллагууд, тэдгээрийн албан хаагчид,

түүнчлэн Бүгд Найрамдах Армен Улсын нутаг дэвсгэр дэх хувь хүн, хуулийн этгээдүүдийн хувьд заавал биелэгдэх шинжтэй байх ёстой (Хуулийн төслийн 61.5-р зүйл). Парламент хууль батлах, өөрчлөхдөө Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийг үл тоомсорлохгүй байх нь чухал юм. Үндсэн хуулийн шүүх нь шүүх эрх мэдлийн нэг хэсэг эсэх, эсхүл түүний талаар Үндсэн хуульд тусдаа бүлгээр зохицуулж байгаа эсэхээс үл хамаарч, Үндсэн хууль хийгээд эрх мэдэл хуваарилалтын зарчмыг хангаж байдаг хамгийн гол институтийн баталгаа байх нь түүний үүрэг юм. Үндсэн хуулийн шүүхийн гол зорилго нь хууль тогтоогч, төрийн бусад эрх мэдлийн байгууллагуудын хуулиас хэтэрсэн үйлдлүүдийг хязгаарлах явдал юм. [Тиймээс] Парламент Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийг биелүүлэхээс татгалзахын тулд ‘эрх мэдлийн хуваарилалт’-ыг эш татаж ярьж болохгүй.

Гэхдээ энэ нь Үндсэн хуулийн шүүхийн харьяалал (эрх мэдэл) хязгааргүй гэсэн үг биш юм. Түүний харьяалал (эрх мэдэл) нь Үндсэн хуулиар хязгаарлагддаг.”

CDL-AD(2017)011 Армен - Үндсэн хуулийн шүүхийн талаарх Үндсэн хуулийн төсөлд өгсөн санал, цогцолбор 89, 90.

8.7 ҮНДСЭН ХУУЛИЙН ШҮҮХЭЭС МАРГААНЫГ ДАХИН СЭРГЭЭХ

“Шинэ нөхцөл байдлын улмаас хэргийг дахин сэргээх нь Үндсэн хуулийн шүүхийн хувьд ихээхэн ховор зүйл юм. Мөн 96 дугаар зүйл нь Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн 135.3 дахь хэсэгт тусгагдсан ‘Үндсэн хуулийн шүүх үйл ажиллагаагаа Үндсэн хуулийн шүүхийн тухай хуульд заасан субъектүүдийн санаачилгаар явуулна’ гэсэн заалттай зөрчилдөж байна. Эдгээр субъектүүдийн дунд Шүүх өөрөө байж болохгүй. Хэрвээ шинэ нөхцөл байдал үүсэх, эсхүл шүүх өмнөх шийдвэрээ гаргахдаа үндэслэл болгосон заалтуудад өөрчлөлт орох тохиолдол болгонд өмнөх шийдвэрүүдээ дахин хянах эрхийг Үндсэн хуулийн шүүхэд олговол энэ нь Үндсэн хуульд тогтолцоо дахь тус шүүхийн чиг үүргийг эрсдэлд оруулах болно. Нэмж хэлэхэд, энэ боломж [шинэ нөхцөл байдлын улмаас хэргийг дахин сэргээх]-ийг хэрэглэх нөхцөл нь юу болох, Үндсэн хуулийн шүүхийн ‘шинэ’ шийдвэр нь өмнөх шийдвэртэйгээ ямар харилцаатай байх, res judicata татгалзлыг хэрхэх вэ гэх мэт хэд хэдэн асуудлыг тодруулах шаардлагатай байна.”

CDL-AD(2002)016 Бүгд Найрамдах Молдова Улсын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн төсөл болон Үндсэн хуульд оруулах холбогдох нэмэлт, өөрчлөлтөд өгсөн санал, цогцолбор 66.

“Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр эцсийнх гэж тооцогддог, түүнчлэн түүний шийдвэрийг хүндэтгэн сахих нь Үндсэн хуулийн дэг журам (the constitutional order) хийгээд хуулийн тодорхой байдлын зарчмын шаардлагад нийцдэг тул Үндсэн хуулийн шүүхээс [өмнөх] аливаа шийдвэрээ дахин хянах нь зөвхөн онцгой тохиолдолд л зөвшөөрөгдөх ёстой. Энд Шүүгчийн гэмт хэргийн үйл ажиллагаа (жишээлбэл, шүүгч авлига авч, улмаар тодорхой нэг шийдвэр гаргааа амлаж байгааг буулгасан дүрс бичлэг байж болно) болон шүүхээс гарсан шийдвэр (the adopted decision)-ийг хооронд нь ялгаж салгаж авч үзэх хэрэгтэй. Тухайн шүүгч үйлдсэн гэмт хэргийнхээ төлөө хариуцлага хүлээх хэрэгтэй. Шүүгчийн чиг үүргийн халдашгүй байдалд ердийн гэмт хэрэг хамаарахгүй тул шүүгчид эрүүгийн хариуцлага хүлээлгэх хэрэгтэй.

Хэрэв Үндсэн хуулийн шүүхээс гаргасан хууль зүйн дүгнэлт эсвэл шийдвэр нь авилга авсан шүүгчээс болж сэвтчихвэл яах вэ – тус хуулийн дүгнэлт эсвэл шийдвэрийг шинэчлэх боломжтой юу гэсэн асуулт улмаар үүснэ. Тодорхой хэрэг маргаан дахь шүүхийн шийдвэрийн иймэрхүү шинэчлэл болон шүүхийн жишиг хуулийн (case law) ерөнхий өөрчлөлт (сүүлийнх нь бол энэхүү *Amicus Curiae* - санал, дүгнэлтэд хамааралгүй) хоёрыг хооронд нь ялгаж салгаж авч үзэх хэрэгтэй.

Ерөнхий зарчмын хувьд, шүүхийн шийдвэр гармагцаа хуулийн хүчин төгөлдөр болж, улмаар [Үндсэн хуулийн] шүүхийг өөрийг нь ч гэсэн захирдаг учир шүүхээс процессын шинэ ажиллагааг эхлүүлэх боломжгүй байдаг. [Гэхдээ] зарим тохиолдолд шүүхийн шийдвэрийг дахин сэргээх тухай заалт шаардлагатай байж болох юм. Энэхүү шаардлага нь жишээлбэл Европын Зөвлөлийн гишүүн улсууд Европын хүний эрхийн шүүхээс ‘тухайн гишүүн улс нь Европын Хүний эрхийн тухай конвенцод заасан үүргээ зөрчсөн бөгөөд тус улсын Үндсэн хуулийн шүүх нь энэхүү зөрчлийг лавшруулсан шийдвэр гаргасан’ гэх шийдвэрт хариу үйлдэл үзүүлэх үед ихэвчлэн үүсдэг.

Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийн ажил үүргээ гүйцэтгэх үедээ үйлдсэн, жишээ нь хээл хахууль гэх мэт гэмт хэрэг (үүнээс болж холбогдох шүүхийн шийдвэр сэвтэхэд хүрсэн)-г үндэслэж, тухайн шүүхийн шийдвэрийг дахин сэргээх буюу дахин хянахыг зөвшөөрсөн хуулийн зохицуулалт ерөнхийдөө байдаггүй. Гэхдээ Үндсэн хуулийн шүүхийн шүүгч хээл хахууль авсан тухай нотлох баримт (шүүхээр гэм буруутай нь тогтоогдсон байдал) нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ерөнхий журмын дагуу шүүхийн шийдвэрийг дахин сэргээх шинэ элемент болох боломжтой. Үндсэн хуулийн шүүхийн

хуулиудад Үндсэн хуулийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд ерөнхий (ихэвчлэн иргэний) хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулиудыг нэмэлт эх сурвалжаар хэрэглэх боломжтой талаар дурддаг.

Дүгнэж хэлэхэд, Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийг гаргахад гэмт хэрэг үйлдэгдсэн тохиолдолд (шүүгчийн гэм буруу нь шүүхээр тогтоогдсон бол) зөвхөн Үндсэн хуулийн шүүх л өөрийн шийдвэрүүдээ шинэчлэх боломжтой байдаг байх нь чухал юм. Шүүхийн шийдвэрийг шинэчлэх эрх мэдлийг төрийн бусад эрх бүхий байгууллагад олгож болохгүй. Хэрэв Үндсэн хуулийн шүүхийн актыг Үндсэн хуульд нийцсэн эсэх, эсхүл хууль ёсны эсэхийг хянан шалгах, ялангуяа Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийн албан үүргээ гүйцэтгэх үедээ үйлдсэн гэмт үйлдлүүд (гэхдээ ердийн гэмт хэрэгт хамаарах үйлдлүүд биш)-г мөрдөн шалгах талаар, эрхийг төрийн бусад байгууллагад олгогчигвол Үндсэн хуулийн шүүхийн хараат бус байдал алдагдахад хүрнэ. Олон улсын байгууллагууд тухайн улсын Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр нь тус улсын олон улсын үүрэг хариуцлагатай нийцэж байгаа эсэхийг дүгнэж болох боловч, тэдгээр дүгнэлтүүд нь Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийг шууд өөрчлөх, эсхүл тэрхүү шийдвэрийг гаргасан шүүгчийг гэмт хэрэгтэн болгож чадахгүй. Эдгээр олон улсын байгууллагууд зөвхөн Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийн нөлөөгөөр аливаа хувь хүнд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх үүргийг тухайн улсад ногдуулсан бол л [Үндсэн хуулийн шүүхийн] шүүгчид “хохирлыг нөхөн төлөх (regression damage)” үүргийг ногдуулах боломжтой. Гэхдээ иймэрхүү журам нь холбогдох улсад энэ талаар хууль зүйн үндэслэл байгаа тохиолдолд л, тухайлбал хэрэв энэ талаар шууд зохицуулсан хуулийн тодорхой заалт байгаа тохиолдолд л хэрэгжих боломжтой болно. Тиймээс Парламент, эсхүл Дээд шүүх зэрэг төрийн бусад эрх бүхий байгууллагаас явуулах хянан шалгах процедур (Энэ нь аль хэдийн Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийн ялимгүй болон захиргааны зөрчлийг авч хэлэлцэж байгаа. 317-XIII дугаар хуулийн 16.2 дахь хэсэг) бус, Үндсэн хуулийн шүүхийн өөрийн буюу дотоод дахин-хянан шалгах ажиллагааны процедур нь хэрэгтэй болж байгаа юм. Ийм боломж байхгүй [буюу энэ талаар зохицуулсан хуулийн зүйл заалт байхгүй] бол Үндсэн хуулийн шүүхийн аль нэг шүүгчийн гэмт үйлдлийн оролцоотой гарсан Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийг даван туулахын тулд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай байж болох юм.

Эцэст нь хэлэхэд, Үндсэн хуулийн шүүхийн тухай 317-XIII дугаар хуулиар шүүгчид эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үүсгэхийн

тулд шүүхээс зөвшөөрөл авахыг шаардаж байгаа эсэх, мөн зөвшөөрөл өгөх тохиолдолд ямар нөхцөлүүдийг хангасан байх ёстой эсэхийг Үндсэн хуулийн шүүх шийднэ (дээрээс үзнэ үү). Гэхдээ Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийн хувьд тэдгээр нь эцсийнх байх ба тэдгээрийг онцгой тохиолдолд л дахин хянах хэрэгтэй бөгөөд үүнийг Үндсэн хуулийн шүүх өөрөө гүйцэтгэх хэрэгтэй. Энэхүү үүргийг төрийн бусад эрх бүхий байгууллагад өгөх нь Үндсэн хуулийн шүүхийн хараат бус байдлыг алдагдуулах болно.”

CDL-AD(2019)028 Бүгд Найрамдах Молдова Улс – Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийн эрүүгийн хариуцлагын тухай Amicus Curiae - санал, дүгнэлтийн товч, цогцолбор 45-50.

9 ҮНДСЭН ХУУЛИЙН ШҮҮХИЙН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛТЭЙ ХАРИЛЦАХ ХАРИЛЦАА

“Хуулийн төслийн 20 дугаар зүйлд зааснаар олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэл Үндсэн хуулийн шүүхийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, шүүхийн шүүгчдэд шууд болон шууд бусаар нөлөөлөх эрхгүй. Ийм үйлдэл хийсэн хүмүүс хуульд заасан журмын дагуу хариуцлага хүлээнэ. Заримдаа хэвлэл мэдээллийн дайсагнасан шинжтэй кампанит ажил нь шүүх эрх мэдэлд тодорхой хэмжээгээр нөлөө үзүүлдэг гэдгийг Комисс хүлээн зөвшөөрч байна. Мөн 20 дугаар зүйлийн заалт нь шүүх эрх мэдлийг ийм хөндлөнгийн оролцооноос хамгаалах зорилготой гэдгийг хүлээн зөвшөөрч байна. Гэхдээ, шүүх эрх мэдлийн үйл ажиллагаа болон Азербайжаны Үндсэн хуулийн 47, 50-р зүйлээр хамгаалсан үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө хоёрын хоорондох шударга тэнцвэрийг бий болгохын тулд маш болгоомжтой хандах шаардлагатай. Энэ салбарын талаарх Европын Хүний эрхийн шүүхийн жишиг хууль нь энэ асуудлаар удирдамж өгч чадна.»

CDL-INF(1996)010 Бүгд Найрамдах Азербайжан Улсын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн төсөлд өгсөн санал, хуудас 5.

“Үндсэн хуулийн шүүхийн үйл ажиллагааг олон нийтэд мэдээлэх нь тус шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд олон нийт чөлөөтэй оролцох, шүүхийн шийдвэрүүдийг нийтлэх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэх зэргээр аль хэдийн баталгаажсан боловч, нэмэлт, өөрчлөлтийн 1 дүгээр зүйлд Шүүхийн шийдвэр болон хуралдааны мэдэгдлүүдийг Үндсэн хуулийн шүүхийн цахим хуудсанд нийтлэхээр зохицуулсан нь маш сайшаалтай байна. Энэ нь шүүхийн шийдвэр нийтлэхийг хойшлуулахтай холбогдуулан үзвэл бүр ч чухал юм (доорх L хэсгийг үзнэ үү). Шүүхийн бүх шийдвэрүүдийг, хэдийгээр тэднийг албан ёсны сэтгүүлд нийтлэх нь хойшлохоор болсон байлаа ч гэсэн, шүүхийн цахим хуудсандаа нэн даруй нийтлэх хэрэгтэй.»

CDL-AD(2011)050corr Сербийн Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд өгсөн санал, цогцолбор 12.

ХАВСРАЛТ – ЭШИЛСЭН МАТЕРИАЛУУД

1. CDL-INF(1996)010 Бүгд Найрамдах Азербайжан Улсын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн төсөлд өгсөн санал, Венецийн Комиссын 29 дэх их хурлаар батлагдсан (Венец, 1996 оны 11 сарын 15-16).
2. CDL-INF(1997)002 Украйны Үндсэн хуулийн талаарх санал, Венецийн Комиссын 30 дах их хурлаар батлагдсан (Венец, 1997 оны 03 сарын 7-8).
3. CDL(1997)018rev Украйны Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн талаарх санал, Венецийн Комиссын 31 дэх их хурлаар батлагдсан (Венец, 1997 оны 06 сарын 20-21).
4. CDL-STD(1997)020 Үндсэн хуулийн шүүхийн бүрэлдэхүүн – Шинжлэх ухаан болон Ардчиллын техник, no. 20 (1997).
5. CDL-INF(2001)002 Үндсэн хуулийн шүүхийн талаарх Бүгд Найрамдах Хорват улсын Үндсэн хуулийн зохицуулалтад өгсөн санал, Венецийн Комиссын 45 дах их хурлаар батлагдсан (Венец, 2000 оны 12 сарын 15-16).
6. CDL-AD(2002)005 Бүгд Найрамдах Азербайжан Улсын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн төсөлд өгсөн санал, Венецийн Комиссын 50 дах их хурлаар батлагдсан (Венец, 2002 оны 03 сарын 8-9).
7. CDL-AD(2002)016 Бүгд Найрамдах Молдова Улсын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн төсөл болон Үндсэн хуульд оруулах холбогдох нэмэлт, өөрчлөлтөд өгсөн санал, Венецийн Комиссын 51 дэх их хурлаар батлагдсан (Венец, 2002 оны 07 сарын 5-6).
8. CDL-AD(2003)006 Армени улсын хүний эрхийг хамгаалагчийн тухай хуулийн төсөлд өгсөн санал, Венецийн Комиссын 54 дэх их хурлаар батлагдсан (Венец, 2003 оны 03 сарын 14-15).
9. CDL-AD(2004)023 Азербайжан улсын Үндсэн хуулийн шүүхийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны дэгийн талаарх санал, Венецийн Комиссын 59 дэх их хурлаар батлагдсан (Венец, 2004 оны 06 сарын 18-19).
10. CDL-AD(2004)024 Үндсэн хуулийн шүүхийн талаарх Туркийн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд өгсөн санал, Венецийн Комиссын 59 дэх их хурлаар батлагдсан (Венец, 2004 оны 06 сарын 17-18).
11. CDL-AD(2004)035 Оросын Холбооны улсын Үндсэн хуулийн төсөлд өгсөн санал, Венецийн Комиссын 60 дах их хурлаар батлагдсан (Венец, 2004 оны 10 сарын 8-9).
12. CDL-AD(2004)041 Сербийн Омбудсмений тухай хуулийн төсөлд Венецийн комисс, Европын зөвлөлийн Хүний эрхийн комиссар болон Хүний эрхийн

- ерөнхий газрын зүгээс өгсөн хамтарсан санал, Венецийн Комиссын 61 дэх их хурлаар батлагдсан (Венец, 2004 оны 12 сарын 3-4).
13. CDL-AD(2004)043 Бүгд Найрамдах Молдова улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай саналд өгсөн санал (Үндсэн хуулийн шүүхэд хувь хүний гаргасан гомдлыг нэвтрүүлэх нь), Венецийн Комиссын 61 дэх их хурлаар батлагдсан (Венец, 2004 оны 12 сарын 3-4).
 14. CDL-AD(2005)005 Гүрж улс дахь шүүхийн шинэчлэлтэй холбогдох Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд өгсөн санал, Венецийн Комиссын 62 дах их хурлаар батлагдсан (Венец, 2005 оны 03 сарын 11-12).
 15. CDL-AD(2005)015 Украин улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд өгсөн санал, Венецийн Комиссын 63 дах их хурлаар батлагдсан (Венец, 2005 оны 06 сарын 10-11).
 16. CDL- AD(2005)039 Босни Герцеговина улсын Үндсэн хуулийн шүүхэд санал хураах талаар өргөн барьсан журамд өгсөн санал, Венецийн Комиссын 64 дэх их хурлаар батлагдсан (Венец, 2005 оны 10 сарын 21-22).
 17. CDL-AD(2006)006 Румын улсын Үндсэн хуулийн шүүхийн зохион байгуулалт, чиг үүргийн тухай №47/1992 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан хоёр хуулийн төсөлд өгсөн санал, Венецийн Комиссын 66 дах их хурлаар батлагдсан (Венец, 2006 оны 03 сарын 17-18).
 18. CDL-AD(2006)016 Украины Үндсэн хуулийн шүүхийн тасралтгүй үйл ажиллагааг хангахын төлөөх Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийн шинэчлэлд өгсөн санал, Венецийн Комиссын 67 дах их хурлаар батлагдсан (Венец, 2006 оны 06 сарын 9-10).
 19. CDL- AD(2006)017 Армен улсын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөд өгсөн санал, Венецийн Комиссын 67 дах их хурлаар батлагдсан (Венец, 2006 оны 06 сарын 9-10).
 20. CDL-AD(2007)020 Казахстан дахь Омбудсмений институтийн боломжит шинэчлэлийн талаарх санал, Венецийн Комиссын 71 дах их хурлаар батлагдсан (Венец, 2007 оны 06 сарын 1-2).
 21. CDL-AD(2007)036 Азербайжан улсын Үндсэн хуулийн шүүхийн тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдэд өгсөн санал, Венецийн Комиссын 72 дах их хурлаар батлагдсан (Венец, 2007 оны 10 сарын 19-20).
 22. CDL-AD(2008)015 Украины Үндсэн хуулийн төсөлд өгсөн санал, Венецийн Комиссын 75 дах их хурлаар батлагдсан (Венец, 2008 оны 06 сарын 13-14).

Венецийн комисс

23. CDL-AD(2008)029 Киргизийн (1) Үндсэн хуулийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (2) Үндсэн хуулийн шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд өгсөн санал, Венецийн Комиссын 76 дах их хурлаар батлагдсан (Венец, 2008 оны 10 сарын 17-18).
24. CDL-AD(2008)030 Монтенегро улсын Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн төсөлд өгсөн санал, Венецийн Комиссын 76 дах их хурлаар батлагдсан (Венец, 2008 оны 10 сарын 17-18).
25. CDL-AD(2009)014 Палестины Үндсэн хуулийн дээд шүүхийн тухай хуулийн талаарх санал, Венецийн Комиссын 78 дах их хурлаар батлагдсан (Венец, 2009 оны 03 сарын 13-14).
26. CDL-AD(2009)024 Украины Ерөнхийлөгчийн өргөн мэдүүлсэн Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд өгсөн санал, Венецийн Комиссын 79 дэх их хурлаар батлагдсан (Венец, 2009 оны 06 сарын 12-13).
27. CDL-AD(2009)042 Латвийн Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд өгсөн санал, Венецийн Комиссын 80 дах их хурлаар батлагдсан (Венец, 2009 оны 10 сарын 9-10).
28. CDL-AD(2010)038 Сонгогдсон болон томилогдсон албан хаагчдын цалин хөлсний тогтолцоотой холбоотой хэд хэдэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн талаар “хуучин Югославын Бүгд Найрамдах Македон Улс”-ын Үндсэн хуулийн шүүхэд гаргасан *Amicus Curiae* - санал, дүгнэлт, Венецийн Комиссын 85 дах их хурлаар батлагдсан (Венец, 2010 оны 12 сарын 17-18).
29. CDL-AD(2010)039rev Хувь хүний Үндсэн хуулийн шүүхэд хандах эрхийн талаарх судалгаа, Венецийн Комиссын 85 дах их хурлаар батлагдсан (Венец, 2010 оны 12 сарын 17-18).
30. CDL-AD(2010)044 Украин улс дахь Үндсэн хуулийн нөхцөл байдлын талаарх санал, Венецийн Комиссын 85 дах их хурлаар батлагдсан (Венец, 2010 оны 12 сарын 17-18).
31. CDL-AD(2011)001 Унгарын шинэ Үндсэн хуулийн төслийг боловсруулах явцад үүссэн хууль зүйн гурван асуудлын талаарх санал, Венецийн Комиссын 86 дах их хурлаар батлагдсан (Венец, 2011 оны 03 сарын 25-26).
32. CDL-AD(2011)010 Монтенегрогийн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хуулийн төсөл, түүнчлэн Шүүхийн тухай хууль, Улсын Прокурорын тухай хууль, Шүүхийн зөвлөлийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хуулиудын төсөлд өгсөн санал, Венецийн Комиссын 87 дах их хурлаар батлагдсан (Венец, 2011 оны 06 сарын 17-18).
33. CDL-AD(2011)015 Сербийн Шүүгчийн тухай болон Улсын яллах ажиллагааны

- тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн хэрэгжилтийн талаарх Шүүхийн дээд зөвлөл, Улсын прокурорын зөвлөлийн шийдвэрийн төсөлд өгсөн түр дүгнэлт, Венецийн Комиссын 87 дах их хурлаар батлагдсан (Венец, 2011 оны 06 сарын 17-18).
34. CDL-AD(2011)016 Унгарын шинэ Үндсэн хуулийн талаарх санал, Венецийн Комиссын 87 дах их хурлаар батлагдсан (Венец, 2011 оны 06 сарын 17-18).
 35. CDL-AD(2011)017 Киргизийн “Шүүгчийн статусын талаарх” Үндсэн хуульд өөрчлөлт оруулах танилцуулгад өгсөн санал, Венецийн Комиссын 87 дах их хурлаар батлагдсан (Венец, 2011 оны 06 сарын 17-18).
 36. CDL-AD(2011)018 Киргизийн Дээд шүүхийн Үндсэн хуулийн танхимын талаарх Үндсэн хуулийн төсөлд өгсөн санал, Венецийн Комиссын 87 дах их хурлаар батлагдсан (Венец, 2011 оны 06 сарын 17-18).
 37. CDL-AD(2011)030 Бүгд Найрамдах Серпскийн нутаг дэвсгэрт байрлах төрийн өмчийн статусын тухай болон захиран зарцуулахыг хориглосон тухай хуулийн талаар Босни Герцеговина улсын Үндсэн хуулийн шүүхэд гаргасан *Amicus Curiae* - санал, дүгнэлт, Венецийн Комиссын 88 дах их хурлаар батлагдсан (Венец, 2011 оны 10 сарын 14-15).
 38. CDL-AD(2011)034 Монтенегро улсын хүний эрх, эрх чөлөөг хамгаалагчийн тухай хуулийн талаарх Венецийн комисс болон ЕАБХАБ-ын Ардчилсан институт, хүний эрхийн алба (ЕАБХАБ/ОДИХБ)-аас гаргасан хамтарсан санал, Венецийн Комиссын 88 дах их хурлаар батлагдсан (Венец, 2011 оны 10 сарын 14-15).
 39. CDL-AD(2011)038 Боливийн Үндсэн хуулийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн төсөлд өгсөн санал, Венецийн Комиссын 88 дах их хурлаар батлагдсан (Венец, 2011 оны 10 сарын 14-15).
 40. CDL-AD(2011)040 Туркийн Үндсэн хуулийн шүүхийн байгуулал, процедурын тухай хуулийн талаарх санал, Венецийн Комиссын 88 дах их хурлаар батлагдсан (Венец, 2011 оны 10 сарын 14-15).
 41. CDL-AD(2011)041 Santiago Bryson de la Barra et Al (Хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг) кэйсийн талаар Перу улсын Үндсэн хуулийн шүүхэд гаргасан *Amicus Curiae* - санал, дүгнэлтийн товч, Венецийн Комиссын 88 дах их хурлаар батлагдсан (Венец, 2011 оны 10 сарын 14-15).
 42. CDL-AD(2011)050cогг Сербийн Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд өгсөн санал, Венецийн Комиссын 89 дэх их хурлаар батлагдсан (Венец, 2011 оны 12 сарын 16-17).
 43. CDL-AD(2012)001 Унгарын Шүүгчийн эрх зүйн байдал, цалин хөлсний тухай

Венецийн комисс

- 2011 оны CLXII хууль, Шүүхийн зохион байгуулалт, удирдлагын тухай 2011 оны CLXI хуулиудын талаарх санал, Венецийн Комиссын 90 дэх их хурлаар батлагдсан (Венец, 2012 оны 03 сарын 16-17).
44. CDL-AD(2012)008 Унгарын Прокурорын үйлчилгээ болон үйл ажиллагааны тухай 2011 оны CLXIII хууль, Ерөнхий прокурор, прокурорууд болон бусад прокурорын ажилтан хийгээд прокурорын карьерын тухай 2011 оны CLXIV хуулиудад өгсөн санал, Венецийн Комиссын 91 дэх их хурлаар батлагдсан (Венец, 2012 оны 06 сарын 15-16).
 45. CDL-AD(2012)009 Унгарын Үндсэн хуулийн шүүхийн тухай 2011 оны CLII хуулийн талаарх санал, Венецийн Комиссын 91 дэх их хурлаар батлагдсан (Венец, 2012 оны 06 сарын 15-16).
 46. CDL-AD(2012)010 Бельгийн Үндсэн хуулийн өөрчлөлтөд өгсөн санал, Венецийн Комиссын 91 дэх их хурлаар батлагдсан (Венец, 2012 оны 06 сарын 15-16).
 47. CDL-AD(2012)014 Босни Герцеговина дахь хууль зүйн тодорхой байдал ба шүүхийн хараат бус байдлын талаарх санал, Венецийн Комиссын 91 дэх их хурлаар батлагдсан (Венец, 2012 оны 06 сарын 15-16).
 48. CDL-AD(2013)014 Шүүгчийн хараат бус байдлыг бэхжүүлэх Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн тухай хуулийн төсөл (тайлбар, хүснэгт багтсан) болон Украины Үндсэн хуулийн ассамблейгаас өргөн мэдүүлсэн Үндсэн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд өгсөн санал, Венецийн Комиссын 95 дах их хурлаар батлагдсан (Венец, 2013 оны 06 сарын 14-15).
 49. CDL-AD(2013)028 Монтенегрогийн Үндсэн хуулийн шүүх, Улсын дээд прокурор, Шүүхийн зөвлөлтэй холбоотой Үндсэн хуулийн гурван заалтад нэмэлт, өөрчлөлт оруулах төсөлд өгсөн санал, Венецийн Комиссын 96 дах их хурлаар батлагдсан (Венец, 2013 оны 10 сарын 11-12).
 50. CDL-AD(2013)034 Украины шүүгчийн хараат бус байдлыг бэхжүүлэх зорилгоор Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах саналд өгсөн санал (Венец, 2013 оны 12 сарын 6-7).
 51. CDL-AD(2014)005 Хүүхдийн эрхийн хамгаалалтын талаарх тайлан: Олон улсын стандартууд болон Дотоодын Үндсэн хуулиуд (Венец, 2014 оны 03 сарын 21-22).
 52. CDL-AD(2014)010 Румины Үндсэн хуулийн шинэчлэлийн талаарх хуулийн төсөлд өгсөн санал (Венец, 2014 оны 03 сарын 21-22).
 53. CDL-AD(2014)014 Нийтийн нэвтрүүлэгчдийн хувь гомдлын талаар Гүрж улсын Үндсэн хуулийн шүүхэд гаргасан *Amicus Curiae* - санал, дүгнэлтийн товч, (Венец, 2014 оны 03 сарын 21-22).

54. CDL-AD(2014)015 Бүгд Найрамдах Словак улсын Ерөнхийлөгчийн шилжилтийн үеийн Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийг томилох журамд өгсөн санал (Венец, 2014 оны 06 сарын 13-14).
55. CDL-AD(2014)017 Тажикстаны Үндсэн хуулийн шүүхийн талаарх Үндсэн хуулийн төсөлд өгсөн санал (Венец, 2014 оны 06 сарын 13-14).
56. CDL-AD(2014)020 Бүгд Найрамдах Киргиз улсын Дээд шүүхийн Үндсэн хуулийн танхимын талаарх Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд өгсөн санал (Венец, 2014 оны 06 сарын 13-14).
57. CDL-AD(2014)026 “Хуучин Югославын Бүгд Найрамдах Македон Улс”-ын, ялангуяа, Шүүхийн зөвлөл, Үндсэн хуулийн шүүхийн бүрэн эрх, санхүүгийн тусгай бүсийн тухай Үндсэн хуулийн долоон нэмэлт, өөрчлөлтөд өгсөн санал (Венец, 2014 оны 10 сарын 10-11).
58. CDL-AD(2014)027 Бүгд Найрамдах Армени улсын Үндсэн хуулийн шинэчлэлийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалын судалгаанд өгсөн санал (Венец, 2014 оны 10 сарын 10-11).
59. CDL-AD(2014)033 Монтенегрогийн Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн төсөлд өгсөн санал (Венец, 2014 оны 10 сарын 10-11).
60. CDL-AD(2014)043 Бүгд Найрамдах Азербайжан улсын нэмэлт, өөрчлөлт орсон Төрийн бус байгууллагууд (Нийтийн холбоо, сан)-ын тухай хуулийн талаарх санал (Венец, 2014 оны 12 сарын 12-13).
61. CDL-AD(2015)024 Тунисийн Үндсэн хуулийн шүүхийн институтын тухай хуулийн төсөлд өгсөн санал, Венецийн Комиссын 104 дэх их хурлаар батлагдсан (Венец, 2015 оны 10 сарын 23-24).
62. CDL-AD(2015)027 2015 оны 9-р сарын 4-ний өдөр Үндсэн хуулийн комиссоос батлагдсан шүүхийн талаарх Украины Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд өгсөн санал, Венецийн Комиссын 104 дэх их хурлаар батлагдсан (Венец, 2015 оны 10 сарын 23-24).
63. CDL-AD(2015)045 Шүүхийн талаарх Албанийн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд өгсөн түр дүгнэлт, Венецийн Комиссын 105 дах их хурлаар батлагдсан (Венец, 2015 оны 12 сарын 18-19).
64. CDL-AD(2016)001 Польшийн 2015 оны 6-р сарын 25-ны өдрийн Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөд өгсөн санал, Венецийн Комиссын 106 дах их хурлаар батлагдсан (Венец, 2016 оны 03 сарын 11-12).
65. CDL-AD(2016)005 Оросын Холбооны улс - Үндсэн хуулийн шүүхийн тухай Холбооны Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд өгсөн түр дүгнэлт, Венецийн Комиссын 106 дах их хурлаар батлагдсан (Венец, 2016 оны 03 сарын

Венецийн комисс

- 11-12).
66. CDL-AD(2016)007 Хууль дээдлэх ёсны шаардлагын жагсаалт, Венецийн Комиссын 106 дах их хурлаар батлагдсан (Венец, 2016 оны 03 сарын 11-12).
 67. CDL-AD(2016)009 Албанийн шүүхийн талаарх Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн шинэчилсэн төсөлд өгсөн эцсийн дүгнэлт, Венецийн Комиссын 106 дах их хурлаар батлагдсан (Венец, 2016 оны 03 сарын 11-12).
 68. CDL-AD(2016)016 ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн тухай Холбооны Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай эцсийн дүгнэлт, Венецийн Комиссын 107 дах их хурлаар батлагдсан (Венец, 2016 оны 06 сарын 10-11).
 69. CDL-AD(2016)017 Гүрж - Үндсэн хуулийн шүүхийн тухай органик хууль болон Үндсэн хуулийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөд өгсөн санал, Венецийн Комиссын 107 дах их хурлаар дэмжигдсэн (Венец, 2016 оны 06 сарын 10-11).
 70. CDL-AD(2016)026 Польш - Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн талаарх санал, Венецийн Комиссын 108 дах их хурлаар батлагдсан (Венец, 2016 оны 10 сарын 14-15).
 71. CDL-AD(2016)034, Украин - Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулийн төсөлд өгсөн санал, Венецийн Комиссын 109 дэх их хурлаар батлагдсан (Венец, 2016 оны 12 сарын 9-10).
 72. CDL-AD(2016)036 Албани – Шүүгчид болон Прокуроруудын шилжилтийн дахин үнэлгээний хуулийн талаар Үндсэн хуулийн шүүхэд гаргасан *Amicus Curiae* - санал, дүгнэлтийн товч, Венецийн Комиссын 109 дэх их хурлаар батлагдсан (Венец, 2016 оны 12 сарын 9-10).
 73. CDL-AD(2017)001 Бүгд Найрамдах Словак улс - Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийн томилгоотой холбоотой асуултуудын талаар өгсөн санал, Венецийн Комиссын 110 дах их хурлаар батлагдсан (Венец, 2017 оны 03 сарын 10-11).
 74. CDL-AD(2017)003 Испани - Үндсэн хуулийн шүүхийн Органик хуулийн нэмэлт, өөрчлөлтөд өгсөн санал, Венецийн Комиссын 110 дах их хурлаар батлагдсан (Венец, 2017 оны 03 сарын 10-11).
 75. CDL-AD(2017)005, 2017 оны 1 дүгээр сарын 21-ний өдөр Үндэсний Их Хурал баталж, 2017 оны 4 дүгээр сарын 16-ны өдөр бүх нийтийн санал асуулгад оруулах Туркийн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд өгсөн санал, Венецийн Комиссын 110 дах их хурлаар батлагдсан (Венец, 2017 оны 03 сарын 10-11).
 76. CDL-AD(2017)011 Армен - Үндсэн хуулийн шүүхийн талаарх Үндсэн хуулийн төсөлд өгсөн санал, Венецийн Комиссын 111 дэх их хурлаар батлагдсан (Венец, 2017 оны 06 сарын 16-17).

77. CDL-AD(2017)013 Гүрж - Үндсэн хуулийн шинэчилсэн төсөлд өгсөн санал, Венецийн Комиссын 111 дэх их хурлаар батлагдсан (Венец, 2017 оны 06 сарын 16-17).
78. CDL-AD(2017)010 Казахстаны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд өгсөн санал, Венецийн Комиссын 111 дэх их хурлаар батлагдсан (Венец, 2017 оны 03 сарын 10-11).
79. CDL-AD(2017)023 Гүржийн парламентын хоёр дахь хэлэлцүүлгээр баталсан Үндсэн хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд өгсөн санал, Венецийн Комиссын 112 дах их хурлаар батлагдсан (2017 оны 10 сарын 6-7).
80. CDL-AD(2018)012 Иргэний болон захиргааны хэргийн эцсийн шийдвэрүүд дэх Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийн үр дагаврын талаар Гүржийн Үндсэн хуулийн шүүхэд гаргасан *Amicus Curiae* - санал, дүгнэлтийн товч, Венецийн Комиссын 115 дах их хурлаар батлагдсан (2018 оны 06 сарын 22-23).
81. CDL-AD(2018)030 Үндсэн хуулийн шүүхийн эсэргүүцэх болон давхацсан саналын судалгаа, Венецийн Комиссын 117 дах их хурлаар батлагдсан (Венец, 2018 оны 12 сарын 14-15).
82. CDL-AD(2018)028 Мальта – Үндсэн хуулийн тохиролцоо, эрх мэдэл хуваарилалт, шүүхийн бие даасан байдал болон хууль хэрэгжилтийн талаарх санал, Венецийн Комиссын 117 дах их хурлаар батлагдсан (Венец, 2018 оны 12 сарын 14-15).
83. CDL-AD(2019)003 Люксембургийн Үндсэн хуулийн шинэчилсэн төсөлд өгсөн санал, Венецийн Комиссын 118 дах их хурлаар батлагдсан (Венец, 2019 оны 03 сарын 15-16).
84. CDL-AD(2019)028 Бүгд Найрамдах Молдова Улс – Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийн эрүүгийн хариуцлагын тухай *Amicus Curiae* - санал, дүгнэлтийн товч, Венецийн Комиссын 121 дэх их хурлаар батлагдсан (2019 оны 12 сарын 6-7).

Венецийн комисс

